

СОЦИАЛ-ДЕМОКРАТ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 8

Николе Ренберт, Майкл Херкенделл, Ёохон Даам болон бусад зохиогчид

ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА СОЦИАЛ-ДЕМОКРАТ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



FRIEDRICH
EBERT 
STIFTUNG



*“Хөөрхийс минь, шинэ дайнд бүү татагдан ороорой.
Хууччуул чинь зорьсон газраа хүрч чадсан бишдээ.
Та нараас өөрсдийгөө энхрийлж байхыг гуйя.”*

(Бертолд Брехтийн “Нутаг нэгтнүүддээ” бүтээлээс
Хауптманн 2003 онд ишлэл татсан. 965-р хуудас)

ISBN 978-9919-9927-6-7



Фридрих-Эбертийн Сангийн Улс төрийн академийн хэлтсээс эрхлэн гаргав.
Бонн хот, 2017 оны 12-р сар

Редакц: Ёохон Даам, Томас Хартман, Мариус Мюллер-Хенниг, Майкл Херкенделл, Николе Ренберт,
Бодо Шүлце, Маркус Троммер, Мартин Вайнерт, Инкен Виезе

Холбоо барих хаяг: Jochen.dahm@fes.de/markus.trommer@fes.de

Лэй-оут ба өрөлт: DIE.PROJEKTOREN, Берлин

Дугтуй: Frederic Cirou-PhotoAlto, Irochka-fotolia

Герман хэлнээс орчуулсан: Чогдонгийн Оюунгэрэл

Орчуулгын редактор: Монгол улсын үндэсний аюулгүй байдлын стратегийн судалгааны хүрээлэнгийн
олон улсын аюулгүй байдал судлалын төвийн дарга Нямжавын Соёлгэрэл

Хэвлэлийн газар: Мөнхийн Үсэг ХХК

Хэсэг бүрийн агуулгын хариуцлагыг зохиогчид өөрсдөө хүлээнэ. Энд илэрхийлсэн санаа бүр Фридрих-Эбертийн Сангийн байр суурьтай нийцэх албагүй. ФЭС-гийн хэвлэн нийтэлсэн хэвлэмэл болон хэвлэмэл бус нийтлэлүүдийг ФЭС-гаас бичгээр зөвшөөрөл авалгүйгээр арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно.

СОЦИАЛ-ДЕМОКРАТ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Сурах бичгийн 8-р дэвтэр

Николе Ренберт, Майкл Херкенделл, Ёохон Даам болон бусад зохиогчид

ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА СОЦИАЛ-ДЕМОКРАТ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

АГУУЛГА

Өмнөх үг	4
1. Оршил	6
2. Онол, ойлголт, үзэл баримтлал	9
2.1. Олон улсын харилцааны онолууд	9
2.2. Энх тайвны ойлголтууд	21
2.3. Аюулгүй байдлын ойлголтууд	27
2.4. Төрөл бүрийн загварууд: Дайны эсрэг үзэл, иргэний ба цэргийн хүч	35
3. Социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужин	45
3.1. Үнэт зүйлс	46
3.2. Үндсэн эрхүүд	49
3.3. Энх тайван, аюулгүй байдлын бодлогын зарчмууд	51
3.4. Түүхэн замнал	54
3.5. Энх тайван, аюулгүй байдлын бодлогын чиглүүлэгч луужин	82
3.6. Газрын зургийг өнгөцхөн харахад: Энх тайвнаар зэрэгцэн орших нь үл гүйцэлдэх санаа юу?	84
4. Энх тайвныг цогцлоох нь: Стратегиуд болон шийдлүүд	87
4.1. Социал-демократ олон улсын энх тайвны стратегийн тулгын чулуунууд	87
4.2. Шударга ёсны үнэт зүйлээр дамжуулан энх тайвныг тогтоох нь	97
4.3. Хөгжлөөр дамжуулан энх тайвныг тогтоох нь	100
4.4. Жендэр, зэвсэгт мөргөлдөөн ба энх тайвныг тогтоох	108
4.5. Цөмийн зэвсэглэл ба үл дэлгэрүүлэх бодлого	114

5. Оролцогч талууд ба байгууллагууд	119
5.1. Германы гадаад бодлогын оролцогч талууд	120
5.2. Нэгдсэн Үндэстний Байгууллага	129
5.3. НАТО	138
5.4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)	143
5.5. Европын Холбоо (ЕХ)-Энх тайвны гүрнээс цэрэгжсэн гүрэн рүү шилжих гэж үү?	148
5.6. Африкийн холбоо-АХ	153
6. Улс төрийн намуудын бодлого хөтөлбөртөө дэвшүүлсэн байр суурь	159
7. Хэлэлцүүлэгт	163
7.1. Атлантын далай дамнасан буюу транс-атлантын харилцаа	163
7.2. Арабын хавар	169
7.3. Дайны тоглоомууд: Кибер дайн аюулгүй байдлын бодлогод тулгамдаж буй сорилт гэдэг талаас нь	173
7.4. R2P: Хөндлөнгөөс оролцохгүй байх уу? эсвэл хамгаалах уу?	177
8. Ургуулан бод	183
Ном зүй	184
Зохигчид, редакторууд, хамтран ажиллагсдын тухай	189

ӨМНӨХ ҮГ

“Энх тайван бүх юм биш, гэхдээ энх тайвангүй бол бүх юм юу ч биш.”

Билли Брандт (Ж,Х,В, Диетц Нахф хэвлэлийн газраас ишлэл татав.

1982 он, 20-р хуудас)

Билли Брандтын энэ ишлэлээс өөр энх тайвны ач холбогдлыг ингэтэл тодорхой, голыг нь олоод хэлчихсэн ишлэл байхгүй гээд хэлчихэд буруудахгүй болов уу. Энх тайван бол эрх чөлөөтэй, шударга, эв санааны нэгдэлтэй нийгмийн урьдач нөхцөл юм. Тэгээд ч үнэт зүйлс ба үндсэн эрхүүд нь дайн, алан хядлага, амьд үлдэхийн төлөөх айдасгүй нийгэмд л хэрэгждэг.

Тэгвэл энх тайванд яаж хүрэх вэ? Энх тайвныг яаж баталгаажуулах вэ? Энх тайвныг түгээн дэлгэрүүлэхийн тулд хэрүүл маргаан үүссэн байх ёстой юу? Эдгээр асуулт нь улс төрийн том, үндсэн асуудалд хамаардаг. Эдгээр асуултын эргэн тойронд социал-демократуудын дунд байнга ширүүхэн маргаан өрнөж байсан, өрнөсөөр ч байгаа.

Энэхүү сурах бичгээр эдгээр асуултад эцсийн хариултыг өгөх боломжгүй. Аливаа асуултад эцсийн хариулт өгөх нь социал-демократ үзэл баримтлалын цуврал сурах бичгийн зорилт ч биш, угаас эцсийн хариулт өгөх ч боломжгүй юм. Харин манай академийн сурах бичгүүд ойлголтуудыг тайлбарлаж, цаад учир шалтгаануудыг тайлж, байр суурийг тодорхой, онолыг ойлгомжтой болгож, ингэснээр уншигчдад өөрийн байр сууриа тодорхойлох, өөрийн хариултыг олоход нь туслах зорилготой.

Түүх, үндэснүүд, эдийн засаг, нийгмийн баримжаат төр, европ, нийгмийн нэгдэл ба цагаачлал, төр ба иргэний идэвх санаачилга, даяаршил сэдэвт бусад сурах бичгүүдийг бид та бүхэнд санал болгож байна. Эдгээр сурах бичиг нь дижитал, хэвлэмэл, сонсдог ном зэрэг олон хэлбэрээр нийтлэгдэн гарсан. Мөн товч бөгөөд тодорхой цуврал сурах бичгүүдээр манай академийн сурах бичгүүдийн үндсэн агуулга өдөр тутмын ярианы хэлээр энгийн

бөгөөд ойлгомжтойгоор хэвлэгдэн гарсан.

Эдгээр эсрэг, тэсрэг сэдвээр ном бичихэд цаг хугацаа их шаардагддаг. Түүнчлэн сурах бичгүүдийг бичиж байх явцад тохиосон цаг үеийн үйл явдлууд номын үндсэн агуулгад нөлөөлж ахин дахин шинэчлэх, нягтлан тунгаах шаардлага тулгардаг. Тэр тусмаа бид номын эхний хэвлэлийг ийнхүү бэлэн болгож, уншигч танаа өргөн барьж байгаадаа нэн баяртай байна.

Нэн тэргүүнд бид номын үндсэн зохиогчид болох Николе Ренберт, Михаел Херкендел нарт талархал илэрхийлье. Мөн ФЭС-гийн хамтран зүтгэгчид Томас Хартман, Мартин Вайнерт, Бодо Шульце, Константин Бербалд, Мариус Мюллер-Хеннинг нартаа номын эхийг боловсруулах явцад ухаалаг зөвлөгөө өгч хамтран ажилласанд талархал илэрхийлье.

Эцэст нь номын бусад зохиогчид болох Хайдемарие Виесзорек-Цойл, Ролф Мюйтцених нарт болон нэн ялангуяа Карстен Бойгт, Олибер Траенерт, Михаел Херолд, Гуидо Штайнберг болон оролцогсдод талархал илэрхийлье. Та бүхний үнэтэй туслалцаагүйгээр энэ ном хэвлэгдэн гарахгүй байлаа.

Нийгмийн ардчиллын академийн бэлэг тэмдэг бол луужин. ФЭС академийн бүтээлүүдээр дамжуулан та бүхэнд аливаа байр суурь, чиг хандлагыг тайлбарлах ерөнхий хүрээ тогтоож өгөхийг хүсдэг билээ. Улс төрийн замналаа тодорхойлоход тань манай академийн сурах бичгүүд тус болох аваас бид баярлах болно. Иргэд социал-демократ үзэл санаатай ахин дахин танилцаж хэрэгжүүлэхийн төлөө идэвх санаачилга гарган ажиллаж байвал хөгжиж байдаг билээ.



Ёоахен Даам

*Нийгмийн ардчиллын
академийн Захирал*

2017 оны 12-р сар Бонн хот



Др. Маркус Троеммер

*Социал-демократ үзэл
баримтлал цуврал сурах
бичгүүд төслийн удирдагч*

1. ОРШИЛ

Хүйтэн дайн хүч хэрэглэлгүйгээр төгсгөл болох үед дэлхий дахинд энх тайван тогтох итгэл өндөр байлаа. Харамсалтай нь энэ итгэл биеллээ олоогүй билээ.

Югослав, Руанда, Ирак, Афганистан, Украин, Ливи, Сири, Сомали: Эдгээр орны нэрийг бид өнгөрсөн жилүүдэд, өнгөрсөн хэдэн арван жилд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан байнга сонссоор ирлээ. Нэр бүр олон хүний амь эрсэдсэн, хүч хэрэглэсэн зөрчил мөргөлдөөнтэй холбоотой, зарим нь одоо ч үргэлжилсээр байна.

*Энх тайванд яаж
хүрэх вэ?*

Дайн эсвэл зөрчилдөөн гарах бүрд: Яаж дайн эсвэл зөрчилдөөнд хүргэхгүйгээр шийдэх вэ? Яаж намжаах вэ? Яавал энгийн иргэдийг дайн, зөрчилдөөний золиос болгохгүй байх вэ? Германы гадаад бодлого энд ямар хувь нэмэр оруулж чадах вэ?, Оруулах ёстой вэ? Холбооны арми ямар хувь нэмэр оруулж чадах, оруулах ёстой вэ? Хүчирхийлэл төгсгөл болсны дараагаар тухайн орнуудын төрийг яаж дахин шинээр байгуулах вэ? Зөрчилдөөнийг шийдвэрлэх механизмуудыг яаж бэхжүүлэх вэ?

*Дэлхий: 1989
оноос хойш улам
ойлгомжгүй
болсон*

Дээрх асуултуудад хялбархан хариулт өгөх хэцүү. 1989 оноос дэлхий хойш илүү төвөгтэй, улам ойлгомжгүй болсон. Энд тэнд олон зөрчилдөөн зэрэг гарч байна. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд ихэнхдээ урт хугацаа шаардаж байхад цэргийн оролцоотой, шат ахин хурцдаж буй зөрчил мөргөлдөөнүүд ямагт ноцтой үр дагаварт хүргэж байдаг. Идэвхтэй үйл ажиллагаа, хүлээцтэй хандах аль аль нь сул талтай, таамаглахад бэрх, сөрөг үр дагавар ихтэй.

Ямар ч найдваргүй байдал гэж хэзээ ч байдаггүй, улс төр нөхцөл байдлыг өөрчилж чаддаг. Хүйтэн дайныг төгсгөл болгоход зарим талаар хувь нэмрээ оруулсан Билли Брандт, Эгон Баар нарын удирдлага дор явуулсан намжмал байдлын бодлого нь үүний нэгэн чухал жишээ юм.

Дээр дурдсан зөрчлүүдэд тодорхой үнэлгээ өгөх асуудлаар социал-демократуудын дунд ширүүн маргаан өрнөсөн. Эдгээр хэлэлцүүлэг, маргаанууд уг сэдэв социал-демократ үзэл баримтлалд ямар чухал болохыг харуулж байна. Энх тайван-аюулгүй байдлын бодлогын асуудлаар зөвхөн улс төрийн намууд бус, юуны өмнө олон нийт өргөн хэлэлцдэг байх ёстой. Чин сэтгэлээсээ, бүтээлчээр, ажил хэрэгчээр хэлэлцэх ёстой. Чухам эдгээр хэлэлцүүлэгт гарын авлага болгож, сэдвийн талаарх суурь мэдлэгийг олгохын тулд энэ номыг бид та бүхэндээ зориулан бүтээлээ.

*Зөрчилдөөн:
Маргаантай
үнэлгээ*

Оршлын дараах **хоёрдугаар бүлэгт** эхлээд олон улсын харилцааны онолуудыг танилцуулна. Эндээс олон улсын харилцаанд гарч буй шийдвэрүүдийг агааргүй хоосон орчинд бус, харин аль нэг онолд суурилан гаргадаг болохыг мэдэж авах болно. Дараагаар нь энх тайван, аюулгүй байдлын төрөл бүрийн ойлголтуудын талаар хэлэлцэж эцэст нь бодлогын боломжит гурван өөр загварыг танилцуулж эдгээрийг хооронд нь зааглах болно.

*Бүлэг 2:
Онол ба
ойлголтууд*

Гуравдугаар бүлэгт: Социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын норматив сууриудыг тоймлон зураглана. Социал-демократ үзэл баримтлалын үнэт зүйлс ба үндсэн эрхүүдийн тухай ойлголт дээр суурилан эхлээд энх тайван, аюулгүй байдлын бодлогын зарчмуудыг боловсруулна. Боловсруулсан зарчмууд дээрээ суурилан 1870-аад оны дайны зээллэгүүдээс эхлээд “Иракийн дайнд үгүй гэж хэлсэн” хүртэл энх тайван, аюулгүй байдлын бодлогын түүхэн замналын талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Гуравдугаар бүлгийг социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужингийн тулгын чулууг тулах оролдлогоор төгсгөнө.

*Бүлэг 3:
Үнэт зүйлс, үндсэн
эрхүүд, түүх,
луужин*

Дөрөвдүгээр бүлэгт урьдчилан сэргийлэх, зэвсэг хураах, хөгжих гэсэн тулгуур баганууд дээр суурилсан социал-демократ энх тайвны стратегийн шийдлүүдийг тодорхойлж, шударга ёсыг бэхжүүлэх замаар энх тайванд хүрэх, хөгжлөөр энх тайванд хүрэх, зэвсэгт мөргөлдөөний үеийн жендерийн үүрэг, цөмийн зэвсгийг хураах ба цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх зарчим дөрвөн сэдвийг нарийвчлан авч үзнэ.

*Бүлэг 4: Энх
тайван тогтоох
стратегууд*

Бүлэг 5:
Оролцогч талууд

Тавдугаар бүлэгт: үндэсний болон олон улсын оролцогч талуудыг танилцуулж, тэдгээрийн үүсэл, ач холбогдол, эдүгээ явагдаж буй шинэчлэлийн тухай хэлэлцүүлгийн талаар товч ойлголт өгнө.

Бүлэг 6:
Хөтөлбөрүүд

Зургаадугаар бүлэгт германы улс төрийн намуудын мөрийн хөтөлбөртөө илэрхийлсэн энх тайван, аюулгүй байдлын бодлогын үндсэн асуудлуудаар баримталж буй байр суурийг хооронд нь харьцуулна.

Бүлэг 7:
Хэлэлцүүлэгт

Долоодугаар бүлэгт атлант дамнасан харилцаа, аль нэг улс оронд гарч буй хүний эрхийн зөрчлөөс хамгаалах олон улсын хариуцлага, “Арабын хавар”, болзошгүй кибер дайн зэрэг өнөөгийн асуудлуудын талаарх хэлэлцүүлэгт баримт нотолгоо болох, санаа сэдэл өгөх материалуудыг санал болгоно.

Бүлэг 8:
Ургуулан бодох

Энэхүү номын маань **наймдугаар бүлэг** хэтийн төлөв, ирээдүйн талаар дор бүрнээ ургуулан бодоорой гэсэн урилгаар төгсөх болно.

2. ОНОЛ, ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Энэхүү бүлэгт:

- Олон улсын харилцааг тодорхойлдог таван чухал онолыг танилцуулна.
- “Эерэг энх тайван” ба “Сөрөг энх тайван” гэдэг ойлголтуудын ялгааг тайлбарлаж хооронд нь зааглана.
- Аюулгүй байдлын талаарх ойлголтууд хоорондоо ямар ялгаатай болохыг тайлбарлана.
- Гадаад бодлогын өөр өөр загваруудын талаар хэлэлцэнэ.

Та идеалист хүн үү? эсвэл реалист хүн үү? Та энх тайван бол дайнгүй байхаас илүү өргөн утгатай гэж боддог хүн үү? Та Холбооны Герман Улсын гадаад бодлого ямар загварыг чиг баримжаа болгох ёстой гэж үздэг вэ? “Хүний аюулгүй байдал” нь юугаараа “сүлжээгээр холбогдсон аюулгүй байдал”-аас ялгаатай вэ?, эдгээр ойлголтуудыг улс төрийн өөр өөр урсгал, чиглэлүүд яагаад өөр өөрөөр ашигладаг вэ?

Энх тайван, аюулгүй байдлын бодлогын талбараас олон асуулт урган гарч байна. Энэхүү бүлэгт бид хамгийн чухал зарим онол, ойлголт, үзэл баримтлалын талаар хэлэлцэнэ. Энэ хэлэлцүүлэг дээрээ суурилан 3-р бүлэгт социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужингийн төслийг боловсруулах болно.

2.1. Олон улсын харилцааны онолууд

Та “Шилдэг ялалт” эсвэл “Хөзрийн байшин” зэрэг телевизийн олон ангит кино үзэж байсан уу? Хэрвээ үзээгүй бол: Эдгээр үйл явдал нь АНУ-ын ерөнхийлөгчийн өдөр тутмын улс төрийн амьдралын эргэн тойронд өрнөдөг Америкийн телевизийн олон ангит кинонууд болохыг сануулъя.

Та өөрийгөө АНУ-ын ерөнхийлөгч гээд төсөөлөөд үз дээ. Ерөнхийлөгчийн хувиар та олон улсын нэгэн зөрчилдөөний үеэр

Кино зохиол: Ямар үйл ажиллагаа явуулах вэ?

АНУ-ын явуулах үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах ёстой болно. Кинонд өмнө нь амар тайван байсан нэгэн оронд иргэний дайн дэгдэж дайны байдал шат ахин хурцадсаар байгаа тухай гарна. Кинонд гардаг шиг таны зөвлөхүүд олон бодлогын шийдлийг санал болгоно.

Таван өөр санал

Зөвлөхүүдийн дэвшүүлсэн санал:

1. “Миний бодлоор бид харилцан ойлголцлыг эрхэмлэж, сөргөлдөгч талуудыг Вашингтонд урьж ярилцах хэрэгтэй.”
2. “Бид өөрсдөө цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцох болно, шаардлага гарвал цэргийн хүчээр дайныг зогсооно хэмээн сүрдүүлэх нь чухал.”
3. “Миний бодлоор энэ бол олон улсын байгууллагуудын шийдэх ёстой асуудал. Бид энэ асуудлыг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөр хэлэлцүүлэх тал дээр санаачилга гарган ажиллах ёстой.”
4. “Хэрвээ бид амжилтад хүрэхийг хүсэж байгаа бол тус бүс нутгийн төрөл бүрийн Төрийн бус байгууллагуудыг нэг завин дээр татан гаргаж ирэх ёстой.”
5. “Бид дайныг зогсоосны дараа ардчилсан хүчнүүдийг бэхжүүлэх ёстой. Тэгвэл энх тайван аажмаар тогтох болно.”

Та эдгээр таван саналаас алинтай нь санал нийлж байна вэ? Энэ бол мэдээж бэрх шийдвэр, магадгүй та төрөл бүрийн арга хэмжээнүүдийг хооронд нь хослуулах нь зүйтэй гэж бодож байж ч магадгүй. Энд гайхаад байх зүйл огт байхгүй.

Олон улсын харилцааны онолын таван сургууль

Дээрх таван санал нь олон улсын харилцааны таван өөр алсын харааг илэрхийлж байна. Эдгээрийн аль нь ч эхнээсээ бусдаасаа илүү биш, эсвэл аль нэг нь бусдаасаа муу биш. Харин эдгээр нь харилцан адилгүй таамаглалаас эхтэй, тийм ч учраас харилцан адилгүй дүгнэлтэд хүрч байгаа юм.

*Өөр өөр
алсын хараа*

Эдгээр таван алсын хараа тус бүрийг түүхэн онцгой нөхцөлд үүсэн бий болсон “онолууд” эсвэл “сэтгэлгээний сургуулиуд” гэж нэрлэж болно. Тухайн цаг үеийнхээ онцлог асуудлуудад эдгээр онол, сэтгэлгээг дэмжигчид хариулт өгөхийг хүсэж байлаа. Иймээс эдгээр онолууд нь өнөөдөр ч зарим нөхцөл байдалд илүү сайн тохирдог, заримд нь төдийлөн сайн тохирдоггүй.

Олон улсын харилцааг илүү сайн ойлгохын тулд сэтгэлгээний төрөл бүрийн сургуулиуд ба тэдний нотолгоонуудыг мэддэг байх нь чухал. Ингэснээр улс төрийн хэлэлцүүлэгт эсрэг байр суурь баримтлагчийнхаа юун дээр маргалдаад байгааг нь, яагаад ийм байр суурь баримтлаад байгааг нь илүү сайн мэдэж, ойлгож чадна.

Олон улсын харилцааны хамгийн чухал сэтгэлгээний таван сургуулиуд:

1. Идеализм
2. Реализм
3. Институционализм
4. Конструктивизм
5. Либерализм

Эдгээр үндсэн чиглэлүүдийг дараах асуултуудад өгч буй хариултаар хооронд нь ялгах боломжтой.

- Ямар учир шалтгаануудын улмаас үүссэн бэ?
- Эдгээр нь хүний тухай ямар төсөөлөл дээр суурилсан бэ?
- Энэ онол хэнийг чухал оролцогч талуудаа гэж үздэг вэ?
- Энэ онол олон улсын системийн бүтцийг хэрхэн үнэлдэг вэ?
- Энх тайван, аюулгүй байдалд хүрэхийн тулд ямар хэрэгслүүдийг эрхэмлэдэг вэ?

Сэтгэлгээний сургуулиуд дотроо ялгаатай. Жишээлбэл, хүмүүс неолиберализм, эсвэл неоконструктивизм гэж ярьцгаадаг. Өмнө нь “нео” гэдэг үе залгаснаар уг онолыг түүхийн болон улс төрийн шинэлэг хөгжилд нийцүүлэн шинэчлэн тодорхойлж, шинэ цаг үед нийцүүлсэн гэсэн утга гарч ирдэг.

*Сэтгэлгээний
таван сургуулиуд*

*Хооронд нь ялгах
онцлог шинжүүд*

Идеализм

Идеализм нь соён гэгээрүүлэгч Эммануэл Кантын үзэл санааны түүхээс эхтэй. Тэрээр 1795 онд “Мөнхийн энх тайванд хүрэх. Философийн төсөл” нэртэй нийтлэлдээ улс орнуудын энх тайвнаар зэрэгцэн оршихуйд тустай хамгийн чухал санаануудаа тодорхойлсон юм.

Кант эрүүл ухаанд
найдаж байв.

Дэлгэрүүлэн унших:
Эммануэл Кант
(2008 он) | 1795 он |
Мөнхийн энх
тайванд хүрэх.
Философийн төсөл,
Штуттгарт

Кант хүмүүний эрүүл ухаанд гол найдлага тавьж байв. Анархи, эмх замбараагүй байдлын гэгээрэлгүй, харанхуйг эрүүл ухаанаар даван туулах боломжтой, ардчилсан үндсэн хууль зэрэг зохицуулалт, дүрэм, журмын тусламжтайгаар энх тайванд хүрэх боломжтой хэмээн тэрээр үзэж байлаа. Хувь хүний болон нийтийн сайн сайхан байдал нь нэг зүйл юм. Философийн хувьд байгалийн анархи нөхцөлийг нийгмийн гэрээгээр даван туулах боломжтой гэж үзсэн Жон Локкийн сэтгэлгээтэй төстэй.¹

Эммануэл Кант (1724-1804) нь Германы философич бөгөөд соён гэгээрлийн үеийн хамгийн нэрд гарсан сэтгэгчдийн нэг байлаа. Тэрээр “Цэвэр ухаалаг байдлын шүүмж” нэртэй бүтээлээрээ соён гэгээрлийн үеийг голлон тодорхойлсон юм.

Идеализм нь хүн төрөлхөөсөө эрүүл ухаантай, энх тайвныг эрмэлздэг гэсэн таамаглал дээр суурилдаг. Иймээс идеалистууд дэлхийн хамтын нийгэмлэг энх тайван байх боломжтой гэж үздэг. Тэд соён гэгээрэл, мэдээлэл, хүмүүжил, боловсрол, ардчиллын үйл явцад найдаж, анхаарал хандуулдаг.

Дэлхийн нэгдүгээр
дайны дараагаар
нөлөө ихтэй
болсон.

Энэ онол дэлхийн нэгдүгээр дайны дараа онцгой нөлөөтэй байлаа. Энх тайван дэлхийн дэглэмийг урт хугацаанд бий болгох хүслээс энэ онол үүссэн. Иймээс 1918 онд америкийн ерөнхийлөгч Вудроу Уилсон энх тайван ба дэлхийн нэгдүгээр дайныг дуусгавар болгох

Үндэстнүүдийн холбоо нь Женев хотноо төвтэй олон улсын байгууллага байлаа. Энэ байгууллага 1920-1946 онд үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд дэлхийн нэгдүгээр дайны дараахан үүсгэн байгуулагдсан ба энх тайвны хүрсэн түвшнийг урт хугацаанд хадгалах үүрэгтэй байлаа. Үндэстнүүдийн холбоо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) түүчээлэгчдийн нэг хэлбэр нь байлаа. Америкийн ерөнхийлөгч Вудроу Уилсон

1 Сурах бичгийн 1-р дэвтэр, Нийгмийн ардчиллын үндсүүд, 2.1 бүлэг, Эрх чөлөө

1918 онд 14 зүйлт төлөвлөгөөндөө энэ санаагаа тусгасан. Үндэстнүүдийн холбоо байгуулагдсан нь юуны өмнө түүний олон улсын тавцанд гаргасан нэг амжилт байсан юм. Гэсэн ч Уилсон АНУ-ын Сенатын танхимыг Үндэстнүүдийн холбоонд Америк элсэх нь чухал гэдэгт итгүүлж чадаагүй юм. АНУ Үндэстнүүдийн холбооны гишүүн болоогүй тул энэ холбооны улс төрийн ач холбогдол ч дээшлээгүй юм.

урьдчилсан үндсэн нөхцөл гэж үзсэн учраас дайнд оролцогч улсуудыг ардчилах, тэдгээрийн газар нутгийн бие даасан байдлыг хангахыг шаардаж байлаа. Тэр 14 зүйлт төлөвлөгөөндөө Үндэстнүүдийн холбоог үүсгэн байгуулах санаагаа дэвшүүлсэн юм.

Реализм

Дэлхийн нэгдүгээр дайны дараах жилүүд тогтворгүй байдал, хэт туйлшрал, хүч хэрэглэсэн сөргөлдөөн зэрэг нэр томьёогоор илэрхийлэгдэж байлаа. Урт хугацаанд энх тайвныг хадгалах тухай идеалистуудын найдвар талаар болж, сүүлчийн найдвар нь 1939 оны 9-р сарын 1-нд нэг мөр тасарсан. Герман Польш руу гэнэт довтолсноор Дэлхийн хоёрдугаар дайн эхэлсэн билээ.

Реалист онол хүнийг айдас ба тодорхойгүй байдал тодорхойлдог гэж үздэг. Энэ гэнэтийн довтолгоо сэтгэлгээний өөр нэгэн чухал сургууль болох реалист үзэл онолын айдас, таамаглалыг баталлаа хэмээн реалистууд үзэж байлаа. Хүн харилцан итгэлцлийн үндсэн дээр харилцахын оронд орчин тойрноо хяналтдаа байлгахыг эрмэлздэг. Реалистуудын өнцгөөс харахад улс орнуудын гадаад бодлогын үйл ажиллагаа юуны өмнө энх тайван байх гэсэн хүслээр тодорхойлогддоггүй. Харин улс орнууд юуны өмнө бусдаас эрх илүү мэдэлтэй байж манлайлалд хүрэхийг эрмэлздэг.

Ханс Ёоахим Моргантау нь (1904-1980) америкийн улс төр судлаач эрдэмтэн, хуульч байлаа. Тэрээр Германд төрсөн бөгөөд Франкфурт, Мюнхен, Берлин хотноо суралцаж, ажиллаж байжээ. 1923 оноос эхлэн Женев хотноо дээд сургуульд багшилж эхэлсэн. Тэр еврей гаралтай хүн байсан тул 1933 оноос хойш Германд үндэсний социалист нам засгийн эрхэнд гарсан тул

Ертөнцийг үзэх үзлийн энэ онолын нэгэн чухал суурийг улс төр судлаач, эрдэмтэн Ханс Моргантау томьёолжээ. Тэр “Үндэстнүүд хоорондын улс төр” сэдэвт бүтээлдээ

*Дэлхийн
хоёрдугаар дайны
дараа*

*Реалистууд:
Хүнийг айдас
тодорхойлдог.*

Дэлгэрүүлэн унших:

Hans J. Morgenthau
(1948), *Politics
among Nations.
The Struggle for
Power and Peace*,
New York.

идеализмын эсрэг өөр нэг системчлэгдсэн төслийг боловсруулсан юм. 1970-аад он гэхэд уламжлалт реализмаар олон улсын харилцааг тайлбарлах боломжгүй болсон байв. Реализм нь Өрнө, Дорнын зөрчлийн дараах ойртох үе шатыг хангалттай

тайлбарлаж чадаагүй юм. Зөвхөн дайныг бус, харин улс орнууд хоорондын энх тайвны үе шатыг ч тайлбарлаж чаддаг байх ёстой гэдэг шаардлагаас үүдэн “Неолиберализм”-ын онол хөгжсөн юм. Америкийн улс төр судлаач, эрдэмтэн, “Олон улсын бодлогын онол” бүтээлээрээ нэрд гарсан Кеннет Уолцыг неолиберализмыг үндэслэгч гэж үздэг.

эргэн очихгүй байхаар шийдсэн. Учир нь Германд түүнийг мэргэжлээрээ ажиллахыг хориглосон байлаа. Германд буцаж ирээгүй тэрээр Испани, Италиар дамжаад эцэст нь 1937 онд АНУ руу дүрвэн гарсан юм. Түүний бүтээлүүдээс “Үндэстэн хоорондын бодлого. Эрх мэдэл ба энх тайван хоорондын тэмцэл” нь хамгийн нэрд гарсан бүтээл бөгөөд олон улсын харилцаанд реализмын сэтгэлгээний сургуулийн нэг үндэс гэж үздэг.

Неолиберализмын
шинэ шийдлүүд

Хүний төрөлх шинж чанаруудын тухай өмнө тодорхойлсон таамаглалууд нь сонгодог реализмын бүх эргэцүүллийн гарааны цэг юм. Харин неолиберализм нь эсрэгээрээ олон улсын харилцааны бүтцүүдийг ажиглан тайлбарлахаас гараагаа эхэлсэн. Иймээс неолиберализмыг бүтцийн реализм ч гэж нэрлэдэг.

Неолиберализмын ажиглалтад олон улсын харилцаанд дэг журам сахиулдаг бусдаас дээгүүр орших эрх мэдэл, эсвэл хяналтын шат гэж байдаггүй гэдэг ажиглалт чухал байр суурь эзэлдэг. Иймээс улс орнууд байнгын баталгаагүй байдал дунд өөртөө (цэргийн хүчиндээ) найдах хэрэгтэй болдог. Тэд тэсэж үлдэхийн тулд эрх мэдэл ба хүчний тэнцвэрийг хангах бодлого хэрэгжүүлдэг.

Тэсэж үлдэх зорилгын эсрэг эрх мэдэл ба давамгайл байдалд хүрэхийг эрмэлзэх бодлогыг сэргүүлэн тавих нь неолиберализм ба сонгодог реализмыг хооронд нь зааглах бас нэгэн онолын шугам юм. Ингэснээр неореализм нь сонгодог реализмаас ялгаатай нь улс орнуудын хоорондын энх тайвны үе шатыг болон, жишээ нь улс орнууд харилцан аюулгүй байдлаа хангах зорилгоор эвсэл байгуулахыг тайлбарлаж чаддаг.

Институционализм

Дэлхийн хоёрдугаар дайны дараа зөвхөн реализм л цаашаа хөгжөөд байгаагүй юм. Хөгжлийн зарим нэг шинэ хандлагад идеалистууд болон реалистууд сэтгэлд хүрэх тайлбар өгч чадахгүй байсан учраас онолын бас нэгэн шинэ салбар үүсэн хөгжсөн юм.

Үүний нэг жишээ бол европын нүүрс, гангийн нэгдэл (EGKS)-ийн амжилт бөгөөд энэ нэгдлийн суурин дээр Европын Холбоо үүсгэн байгуулагдсан түүхтэй. Уг нэгдлийн үүсгэн байгуулагдсан түүхийг гагцхүү реалист шийдэлтэй холбон тайлбарлах, мөн зөвхөн идеалист сэтгэлгээний сургуулийн өнцгөөс харж ойлгох боломжгүй юм. Харин үүний оронд идеализм ба реализмын эрс байр сууриудын дунд байршуулах боломжтой, онолын шийдлээр тайлбарлах нь зорилгод илүү нийцэх юм.

Институционализм нь хүмүүс эхний ээлжид өөртөө давуу талыг хайдаг гэдэг санаанаас эхтэй. Институционалистууд нь реалистууд учраас улс орнууд зорилтдоо хүрэхийн тулд хамтын ажиллагаанд бэлэн, хамтран ажиллах чадамжтай гэдэгт бат итгэдэг. Улс орнууд хангалуун амьдралын түвшингээ дээшлүүлэх, аюулгүй байдал, тогтвортой байдлаа улам бэхжүүлэхийн тулд хамтран ажилладаг.

Реализмын таамаглалууд дунд ч улс орнууд хамтын давуу тал бий болгохын төлөө нэгддэг гэдэг таамаглал бий. Хамтын ажиллагаагаар бүрдүүлэх давуу тал нь хэр их байх ёстой вэ? гэдэг асуултаар институционалистууд ба реалистуудыг хооронд нь зааглах онолын шугамыг татаж болно.

Реалистууд улс орнууд хоорондын анархизмаар илэрхийлэгдсэн дэлхий дээр тэд зөвхөн харьцангуй ашиг авчрах нөхцөлд л хамтран ажилладаг, эсвэл хэлэлцээр байгуулдаг гэж нотолдог бол институционалистууд улс орнууд алдагдал хүлээгээгүй л бол хамтран ажилласаар байдаг гэж нотолдог.

Реализм, идеализмаас ялгаатай нь институционализмд зөвхөн улс орнууд биш, харин олон улсын байгууллагууд хамтын ажиллагааны төвд байдаг. Иймээс идеализмаас ялгаатай нь улс орнуудын

Дэлгэрүүлэн унших:

Сурах бичгийн 4-р

дэвтэр, Европ ба

нийгмийн ардчилал,

3-р бүлэг Европ

өнөөдөр: яагаад ийм

болов, энэ юу вэ?

Хамтран ажиллах

чадамжтай

гэдэгт итгэдэг.

дотоодын нөхцөл байдал энд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэггүй.

*Институцуудыг
эерэгээр харах*

Үүний оронд энэ онолын хэтийн төлөвт байгууллагууд олон улсын харилцааг илэрхийлж байдаг. Энд байгууллагуудыг дундыг баримталсан буюу нейтрал гэж үздэг бөгөөд эндээс тэдний хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал, хэв журам сахиулах болон зохицуулах шинж чанар эхтэй. Иймэрхүү байгууллагуудын жишээ бол НҮБ ба Европын Холбоо (ЕХ) юм. Институционализм нь “Дэлхийн нийгэм”-ийн үзэл санаа тусгаар тогтнол, олон улсын эрх зүй, дипломат бодлого, эрх мэдлийн тэнцвэрт байдлыг хангах баталгаа болдог байгууллагуудын суурийг бүрдүүлж байдаг.

Неоинституционализм

Институционализмын өргөтгөсөн хэлбэр нь неоинституционализм бөгөөд улс орнуудын зэрэгцээ албан бус дүрэм журам, хэм хэмжээ эсвэл соёлыг өөрийн ажиглалтад багтаадаг. Институцууд өөрийн утга учир, ертөнцийг үзэх чиг хандлагыг нийлүүлдэг оролцогч талуудаа илэрхийлж байдаг.

Конструктивизм

Гэвч институционалистууд ч олон улсын харилцаан дах тодорхой үйл явцыг өргөн хүрээнд тайлбарлаж чаддаггүй байлаа.

Хүйтэн дайн олон улсын харилцааны дөрөвдөгч том онол конструктивизмын хөгжлийг дэмжсэн юм. Илүү тодорхой хэлэхэд шинжлэх ухааны төрөл бүрийн зарчимд тодорхой үүрэг гүйцэтгэдэг конструктивизмын сэтгэлгээний шийдлийн ач холбогдол олон улсын харилцааны онолуудад дээшилсэн юм.

*Таамаглал: Бодит
байдлыг хамтдаа
бүтээдэг.*

Конструктивизмын үндсэн санаа нь нийгмийн бодит байдал бол өөрчлөгдөшгүй нөхцөл биш, харин үйл ажиллагаа явуулж буй хүмүүс хамтдаа нийгмийн бодит байдлыг бүтээдэг (зохион бүтээдэг) гэж үздэг. Энэ санааг олон улсын харилцаа дээр буулгахад олон улсын системийн бүтэц нь мөн өөрчлөгдөшгүй бүтэц биш, харин уг бүтцийг оролцогч талууд хамтдаа бүрдүүлдэг гэж үздэг. Хамтран бүрдүүлсэн бүтэц нь эргээд оролцогч талуудад нөлөөлдөг.

Бусад шийдлүүд улс орнуудыг хатуу тогтоц гэж үздэг бол конструктивизм нь тодорхой хэмжээнд улс орнуудын дотоод руу өнгийж хардаг. Иймээс конструктив шийдлүүдийн хүрээн дэх энх тайвны стратегиуд нь оролцогч талуудын сэтгэлгээ ба үйл ажиллагааг өөрчлөхөд чиглэдэг. Өрсөлдөгч орнуудын хооронд залуусын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлснээр тухайн орнууд дах хэвшмэл сөрөг ойлголтыг өөрчлөх боломжтой.

Өнөөгийн бид нар герман-францын найрамдлын тухай ярьдаг бол дээр үед Францыг Германы цусан өшөөт дайсан гэж үздэг байлаа. Энэ бол олон улсын харилцааны сэтгэлгээ ба бүтцийг хамтдаа өөрчлөх боломжтой гэдгийг батлах тод жишээ юм.

Конструктивчууд олон улсын харилцааны дүн шинжилгээндээ төрийн бус байгууллагууд болон улс төрийн хөдөлгөөнүүд дээр онцгой анхаарал хандуулдаг. Тэд жишээлбэл энх тайван эсвэл хүний эрхийн хөдөлгөөнүүдийн үндэсний болон олон улсын хүсэл зоригийг бүрдүүлэхэд үзүүлэх нөлөөг онцгойлон авч үздэг. Үүний жишээ бол үйл ажиллагаа, кампанит ажлуудаараа олон улсын харилцааны бусад оролцогч талууд, улс орнуудад нөлөөлдөг, дээр үеийн Ардчилсан Герман Улсын эсэргүүцлийн хөдөлгөөнүүд, хүний эрхийн байгууллагууд, ашиг сонирхлын бүлгүүд шиг улс төрийн хөдөлгөөнүүд юм.

Либерализм

Бидний танилцуулах сүүлчийн, нэгэн чухал сэтгэлгээний сургууль бол либерализм юм. Либерализм нь соён гэгээрлийн үе, 17, 18-р зууны үед абсолютизмын эсрэг хөдөлгөөн болон үүссэн бөгөөд эхлээд Англид дараа нь Нидерландад хөгжсөн.

Либерализм нь хүний эрх чөлөөг нэн тэргүүнд тавьж нийгэм, улс төр, төрийн албадлагын бүх хэлбэрээс татгалздаг. Иймээс сэтгэлгээний энэ сургуулийн төлөөлөгчид (Жишээ нь: Жон Локе, Жон Стюарт Милл нар) улс төрийн ноёрхол ба нөлөөллийг хязгаарлахын төлөө тэмцэж байлаа. Гэхдээ энэ нь улс төрийн ноёрхлоос татгалзана гэсэн үг биш. Харин улс төр юуны өмнө эрх чөлөөг, хүн бүрийн эрх чөлөөг хамгаалах ёстой гэж үзэж байв. Англид Эрхийн тухай

*Дайсагналыг
найрамдал болгон
хувиргах*

*Хүний эрх чөлөө
нэн тэргүүнд*

хуулийн төсөл (1689 он), АНУ-д үндсэн хуулийг тунхаглан зарласан (1787 он) нь либерализмын хөгжлийн чухал үе шатууд юм.

Одоогоос 25 жилийн өмнө хүртэл либерализмыг реализмын онолын нэгэн хувилбар гэж үздэг байлаа. Энэ нь либерализм реализмаас ялгаатай нь олон улсын системд (Top down Ansatz-дээрээс доош чиглэсэн шийдэл) нэгдмэл үйл ажиллагаа явуулдаг төр дээр бус, харин улс орнуудын дотоодын оролцогч талууд дээр (Воттом up Perspektive - дороос дээш чиглэсэн хэтийн төлөв) гол анхаарлаа хандуулдагтай холбоотой.

*Идеализмын
хувилбарууд*

Тодорхой хэмжээнд либерализм нь идеализмын нэг хувилбар юм. Либерализмын төлөөлөгчид гадаад бодлогын үйл ажиллагаа нь өөр өөр ашиг сонирхол, хэрэгжүүлэх чадамж бүхий олон тооны, олон талт улс орнуудын дотоодын, нийгмийн дотоодын оролцогч талуудаар илэрхийлэгддэг гэж үздэг.

Ингэснээр нэг улсын гадаад бодлогын үйл ажиллагаанд зөвхөн олон улсын системийн бүтцүүд шийдвэрлэх ач холбогдолтой байдаггүй, харин тухайн улсын нийгмийн оролцогч талууд ба элитүүдийн өөрийн улсын гадаад бодлогод нөлөөлөх нөлөөллийн зэрэг онцгой чухал ач холбогдолтой байдаг. Энд аль нэг улсын дотоодын байгуулал гадаад бодлогын хандлагын илэрхийлэлд шийдвэрлэх үүрэгтэй байдаг.

Энэ нь энх тайвны асуудалд тусгайлан: ноёрхлын системд оролцооны зэрэг өндөр байхын хэрээр хуваарилалтын шударга ёс төдий чинээ сайн хангагдсан байдаг. Шударга ёс сайн хангагдахын хэрээр нийгмийн зөвшилцөл нь илүү бат бэх байдаг. Нийгмийн зөвшилцөл бат бэх байхын тулд ноёрхлын хүчирхийллийн зэрэг бага байхыг шаарддаг. Ардчилсан засаглалтай орнууд нь ардчилсан бус засаглалтай орнуудтай харьцуулахад гадагшаа илүү энх тайванч, хамтын ажиллагааг эрхэмлэсэн байдаг.

*“Ардчилсан энх
тайван”*

Ардчилсан орнууд хоорондоо бараг дайн байлдаан хийдэггүй бодит үнэн нь энэ таамаглалын нэгэн нотолгоо юм. Хүмүүс “ардчилсан энх тайван” гэж ярьдаг. Энх тайван судлаач, либерал сэтгэгч

Эрнст Отто Цемпиел эндээс гадаад бодлогын хоёр зааварчилгааг боловсруулсан. Нэг талаас олон улсын байгууллагуудыг бэхжүүлж, дахин идэвхжүүлэх хэрэгтэй. Нөгөө талаас дэлхий дахинд ардчиллын үйл явцыг урагшлуулах хэрэгтэй. Энд дарангуйллыг дайн

Эрнест-Отто Цемпиел нь (1927-2017) Герман улс төр, энх тайван судлаач эрдэмтэн байсан. Тэр олон улсын харилцааны либерализмын онолын гол төлөөлөгч юм

байлдаанаар зайлуулахыг хууль ёсных гэж үзэх үү? гэдэг нь мэдээж маргаантай хэрэг.

Ямар онол?

Эргэн сануулахад: Дээр танилцуулсан бүх онол түүхийн, улс төрийн, тодорхой ерөнхий нөхцөлүүдээр илэрхийлэгдсэн бөгөөд шинэ хөгжилд нийцүүлэх шаардлагатай болсон нь нийтлэг шинж чанар юм. Гэхдээ эдгээр онолын тодорхой элементүүд нь олон улсын харилцааг харах өнцөг ба харилцах байдалд нөлөөлж байдаг. Олон улсын харилцааны онолууд нь цогц нөхцөл байдлыг хялбар болгодог. Онолуудын томоохон ашиг тус нь эдгээрийн туслалцаатайгаар олон улсын харилцааны тодорхой зүй тогтлыг тодорхойлж болдог.

*Дэлгэрүүлэн унших:
Эрнст Отто Цемпиел
(1986 он) Энх тайвны
стратегүүд: олон
улсын байгууллагууд,
ардчилал, эдийн
засгаар дамжуулан
системийн хувьсалд
хүрэх нь Падерборн*

	Идеализм	(Нео-Реализм)	(Нео)-Институционализм	Конструктивизм	Либерализм (Идеализмын хувилбарууд)
Санаа	Дотоод бодлогын өгөгдлүүд (нөхцөл байдал) олон улсын бодлогыг тодорхойлдог.	Улс орнууд эрх мэдэл ба хяналтад хүрэхийг эрмэлздэг.	Хамтарсан бүтцүүд энх тайвныг цогцлоодог.	Бодит байдал гэж байдаггүй, харин хамтдаа бүтээдэг.	Дотоод бодлогын нөхцөл байдал олон улсын бодлогыг тодорхойлдог.
Өмнөх үеийн сэтгэгчид	Кант “Мөнхийн энх тайвны санаа”	Эдуард Халлетт Карр, Ханс Ж. Моргентау, Кеннет Уэлтц	Жозеф Най, Роберт О. Кеохане	Александр Вендт, Томас Риссе	Жон Лок, Жон Стюарт Милл, Адам Смит, Эрнст-Отто Цемпел
Цаад учир шалтгаан	Дэлхийн 1-р дайны дараах итгэл найдвар	Дэлхийн 2-р дайны туршлага, хожим нь Зүүн-Барууны ойртолт	Европын Холбоо зэрэг байгууллагуудын амжилт	Хүйтэн дайны үеийн сөргөлдөөн	1718-р зууны үед үүсэж хөгжсөн
Хүний тухай ойлголт	Хүн бол оюуниаг байхаар заяадсан, хэм хэмжээнүүд ба байгууллагуудаас чиг баримжаагаа авдаг.	Хүн аюулгүй байдлаа хангахын тулд эрх мэдэлд хүрэхийг эрмэлздэг.	Хүн аюулгүй байдлаа хангахыг эрхэмлэдэг.	Хүн нийгмийн амьтан бөгөөд нийэмшихийг эрмэлзэж байдаг.	Хүн бол ухаалаг байхаар заяадсан. Хүн амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчтэй байх заяагдмал эрхтэй.
Чухал оролцогчид	Хувь хүмүүс болон нийгмийн оролцогч талууд	Хувь хүмүүс, улс орнууд	Улс орнууд болон олон улсын байгууллагууд	Улс орнууд болон нийгмийн оролцогч талууд	Төр бол хэв журмыг хангах ерөнхий хүрээг тогтоогчийн хувиар нийгмийн оролцогч талууд мөн.
Олон улсын системийг харах өнцөг	Анархи буюу дүр зоргоороо байдал	Анархист үзэл, эрх мэдлийн хуваарилалт, эрх мэдлээ хадгалах	Харилцан хараат байдал, дэглэм	Соёл, ижил төстэй баялгамж чанар, анархи байдал	Анархи үзэл, төрийн болон нийгмийн бүтцүүд, нийгмийн гэрээ
Энх тайван, аюулгүй байдлын стратегиуд	Ардчилалдах үйл явц, соёлн гэгээрэл	Эрх мэдлийн төвлөрөл, эрх мэдлийн тэнцвэрт байдал, (balance of power)	Зохихцуулалтад оруулах, сүлжээ үүсгэх, ардчиллах үйл явц	Сэтгэлгээний өөрчлөлт	Ардчиллын үйл явц, соёлн гэгээрэл

2.2. Энх тайвны ойлголтууд

Дайн сүйтгэгч, аймшигт үр дагавартай учраас энх тайван бүх нийгэмд, бүх шашин шүтлэгт, бүх ертөнцийг үзэх үзэлд чухал байр суурь эзэлдэг нь ойлгомжтой.

Мөн бидний ярианд олон хэлц үгээр илэрхийлэгдэж байдаг. Жишээлбэл: Бид “амар амгалан амьдрахыг хүсэж байна.” эсвэл бид “амар амгалан байдлаа олохыг хүсэж байна” гэх мэтээр.

Хэрвээ аль нэг **тодорхойлолтод** ямар нэг зүйлийг **эерэг** эсвэл **сөрөг** хэмээн тодорхойлж байгаа бол энэ нь анхнаасаа “сайн” эсвэл “муу” байсан гэсэн үг биш юм. Харин сайн, муу гэхээсээ илүү ямар арга хэлбэрээр тодорхойлогдсоныг хэлээд байгаа юм. Сөрөг тодорхойлолт гэдэг бол ямар нэгэн юмнаас заагласан, өөрөөр хэлбэл аливаа юм ийм байж болохгүй гэсэн санаа юм. Эерэг тодорхойлолтод хүссэн зүйлээ ямарваа нэгэн зааглалгүйгээр тодорхойлдог. “Бороо орохгүй байна.” гэдэг нь цаг агаарын сөрөг тодорхойлолт, харин “хуурай байна.” гэдэг нь эерэг тодорхойлолт юм.

Энх тайван нь иргэдийн сайн сайхан, хангалуун чинээлэг байдлыг хамгийн эрхэм зорилгоо болгосон өргөн хүрээтэй, урт хугацаанд үргэлжлэх эрх зүйн дэглэм ба амьдралын хэлбэр юм. Энх тайван, зөрчилдөөн судлалд энх тайвны ойлголтыг а) сөрөг энх тайван (энэ нь хувь хүмүүсийн, шууд хүчирхийлэл байхгүй гэсэн үг), б) эерэг энх тайван (бүтцийн, шууд бус хүчирхийлэл байхгүй гэсэн үг) гэж хоёр хуваадаг. (Улс төрийн нэвтэрхий толь 2011 он, 115)

Энх тайван эдгээр жишээнүүдэд хэн ч саад болдоггүй амар амгалан байдал, эв зохицол, санаа зовох зүйлгүй амьдралыг тодорхойлдог. Эндээс энх тайван гэдэг бол дайн байлдаангүй байхаас илүү өргөн утгатай гэдэг нь харагдаж байна. Германы “хэл ам, хэрүүл шуугиан” гэдэг нэг үгэнд илүү тодорхой илэрхийлсэн байдаг. Герман хэлний тайлбар тольд хэл ам, хэрүүл маргаантай гэдэг үгийг хурцадмал, учир зүйгээ ололцохгүй, задрал, хэрүүл шуугиантай нөхцөл гэж тайлбарласан байдаг. Харин дайны нөхцөл гэсэн үг биш.

Тэгвэл энх тайван гэж чухам юу гэсэн үг вэ? Энх тайван судлалд чухам дээрх хоёр асуултын дагуу

энх тайвны хоёр өөр ойлголт төлөвшсөн байдаг. Эдгээр нь: сөрөг ба эерэг энх тайвны ойлголтууд юм.

Энх тайван: дайн байлдаангүй байхаас илүү өргөн утгатай.

Сөрөг энх тайван

Дайн байлдаангүй байхыг энх тайван гэнэ. Энэхүү энх тайвны “сөрөг” тодорхойлолт нь дэлхийн хоёрдугаар дайны дараагаар олон жилийн туршид олон улсын харилцааг ажиглах суурь нь болж байлаа. Сөрөг энх тайвны тухай ойлголтод дөрвөн үндсэн ойлголтыг онцгойлон тэмдэглэдэг. (харьцуулах Сайделманн 2004 он, 34-р тал)²

1. **Ажиглалтын түвшин: сөрөг энх тайвны тухай ойлголт нь** гагцхүү улс орнууд хоорондын үйл ажиллагаа дээр төвлөрдөг. Төрийн бус байгууллагууд, концернууд, олон улсын байгууллагууд ажиглалтын гадна үлддэг.
2. **Ажиглалтын судлагдахуун:** Сөрөг энх тайвны тодорхойлолтоос цэргийн хүч хэрэглэсэн үү? гэдэг асуулт урган гардаг. Цэргийн хүч зөвхөн төрийн мэдэлд байдаг гэхэд буруудахгүй.
3. **Энх тайвны стратегиудын хамрах хүрээ:** Сөрөг энх тайвны ойлголт нь улс хоорондын харилцаанд байхгүй байгаа харилцааны тодорхой хэлбэрүүд дээр суурилдаг. Энэ тодорхойлолтын дагуу цэргийн хүч хэрэглэхгүй байгаа газар бүрд энх тайван ноёрхож байна гэж үздэг гэсэн үг. Ийм ч учраас энх тайвны стратегиуд нь цэргийн хүч хэрэглэсэн зөрчил маргааныг хязгаарлах, гаргуулахгүй байхаар хязгаарлагддаг.
4. **Сөрөг энх тайвны ойлголтын ялгааг гаргаж ирэх:** Сөрөг энх тайвны тухай ойлголтод цэргийн хүчийг хэрэглэсэн байдлыг арга хэлбэр, хэмжээ, эрчмээр нь ялгаатай авч үздэг. Хүйтэн дайн цөмийн хүчийг бодитойгоор хэрэглэсэн үү? гэдэг талаас нь авч үзвэл энх тайвнаар төгссөн. Гэхдээ энд цөмийн зэвсгээр хөнөөнө хэмээн харилцан сүрдүүлснийг дайны байдалд байсан хэмээн үнэлж болно. Цөмийн бус зөрчилдөөнүүдийг цөмийн зөрчилдөөнөөс зааглаж олон жилийнхийг олон өдрийнхөөс зааглаж болно. Сөрөг энх тайвны тухай ойлголтод хүчирхийллийг эрчим, арга хэлбэр, хэмжээгээр хооронд нь ялгаж зааглах боломжтой.

2 Бид Бонн хот дах J.H.W.Dietz Nachf., хэвлэлийн газарт улс төрийн нэвтэрхий толиос (Шүберт/Клайн 2011 он) төрөл бүрийн ойлголтуудыг авч хэрэглэх боломж олгосонд талархал илэрхийлж байна.

Эерэг энх тайван

Энх тайван бол дайн байлдаангүй байхаас илүү өргөн утгатай. Иймээс эерэг энх тайвны тухай ойлголтыг нэг өгүүлбэрт нэгтгэх боломжтой.

Эерэг энх тайвны тухай ойлголтод хэл ам, хэрүүл шуугианы шалтгааныг арилгасан бол энх тайванд хүрсэн гэж үздэг. Норвегийн энх тайван судлаач Ёохан Галтунг нь эерэг энх тайвны ойлголтын гол төлөөлөгч юм. Сөрөг амар амгалан тухайн үед хүч хэрэглэж байна уу? үгүй юу? гэдгээр тодорхойлогддог бол Галтунгийн санаагаар

Ёохан Галтунг (1930 он) нь Норвегийн эрдэмтэн юм. Тэрээр 1959 онд Осло хотноо энх тайван судлалын хүрээлэнг, 1964 онд Энх тайван судлалын сэтгүүлийг үүсгэн байгуулсан. Түүнийг энх тайван, зөрчилдөөн судлалыг үүсгэн байгуулагчдын нэг гэж үздэг.

бүтцийн хүчирхийлэл байхгүй бол эерэг амар амгалан ноёрхож байна гэж үздэг. Эерэг энх тайвны тухай ойлголтод дараах гурван ойлголт шийдвэрлэх үүрэгтэй.

1. Бүтцийн ба цаг үеийн хүчирхийлэл хоорондын ялгаа:

Эерэг энх тайвны тухай ойлголтод хүчирхийллийг хооронд нь цаг үеийн болон бүтцийн хүчирхийлэл гэж ялгадаг. Цаг үеийн хүчирхийлэл нь шууд хувь хүн дээр, эсвэл үйл хэрэг дээр нөлөөлдөг. Товчоор хэлэхэд биеийн хүчирхийлэл юм. Бүтцийн хүчирхийлэл нь хүмүүсийг өөрсдийн чадамжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүйд хүргэдэг нийгэм, улс төр, эдийн засгийн эмх замбараагүй байдал юм.

Хүчирхийлэл нь нийгмийн тэгш бус болон шударга бус байдал, гадуурхалт, дарлал, баталгаагүй байдлын хэлбэрээр илэрдэг. Түүнчлэн худалдааны харилцаанд бол үнийг дангаараа тогтоох, гадаад хэлэнд албадан шилжүүлэх, эсвэл колонийн ба империалист бүтцэд нэгтгэх зэрэг хэлбэртэй байж болно. Энэ ойлголтоор бол энх тайвны эсрэг ойлголт нь дайн биш, харин зовлон зүдүүр болж байна. Зовлон зүдүүр нь шударга ёсны сэдэвтэй нягт холбоотой.

*Хэл ам, хэрүүл
шуугианы
шалтгааныг
арилгах*

*Цаг үеийн
хүчирхийлэл*

*Бүтцийн
хүчирхийлэл*

Дэлгэрүүлэн унших:
Ёохан Даам (2015
он), Эрхард Эпплер-
Хэлний хүч, Кристиан

Креллийн эрхлэн
гаргасан, Нийгмийн
ардчиллын өмнөх
үеийн сэтгэгчид, 49
хөрөг зураг, Бонн
хотын J.H.W. Dietz
хэвлэлийн газар 112-
188-р хуудас

Ардчилал энх
тайвны тулгын
чулуу болох нь

Энх тайванд
хүрэхийн тулд хүч
хэрэглэх нь зөв үү?

Германы Социалдемократ намын (ГСДН) 1989 онд Берлин хотноо батлагдсан мөрийн хөтөлбөрийг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэсэн Эрхард Эпплер үүнийг дараах байдлаар илэрхийлсэн.

“Өлсгөлөн, зовлон ноёлсон газарт урт хугацаанд энх тайван байх боломжгүй.” (1989 оны Берлиний хөтөлбөр, Доубе\Клотцбахаас ишлэл авав. 2004 он, 365-р хуудас)

2. Нийгмийн загварууд:

Эерэг энх тайвны тухай ойлголтын хоёрдох чухал тал нь эерэг энх тайвны нөхцөлийг бүрдүүлж байдаг нийгмийн загваруудын судалгаа юм. Эпплер, Брандт нар энх тайвны өргөн хүрээтэй бодлого нь хоорондоо эрс ялгаатай түвшнүүд дээр илүү сайн нөхцөл бүрдүүлэхийг шаарддаг гэдэг зааварчилгааг өгсөн байдаг. Хувь хүмүүсийн түвшинд бол хүчирхийллээс ангид үйл ажиллагаа, нийгмийн түвшинд бол ардчилах үйл явц олон улсын түвшинд бол эрхийн хэрэгжилт, ардчилах үйл явцаар дамжуулан илүү сайн нөхцөлийг бүрдүүлэх боломжтой. Энэ утгаараа ардчилал нь урт хугацааны энх тайвны тулгын чулууны нэг юм.

Эрхард Эпплер (1929 он) нь германы социалдемократ үзэл баримтлалын өмнөх үеийн сэтгэгч бөгөөд 1968-1974 он хүртэл германы хөгжлийн сайдаар ажиллаж байсан юм. Тэрээр ГСДН-ын 1989 онд Берлин хотноо батлагдсан, энх тайван, хөгжлийн бодлого, экологийн салбарт түлхүү ач холбогдол өгсөн мөрийн хөтөлбөрийг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэсэн юм.

3. Хэрэгжүүлэх стратегиуд:

Эерэг энх тайвны ойлголттой холбоотойгоор эерэг энх тайванд яаж хүрэх вэ? гэдэг асуулт гарч ирдэг. Ямар стратегиудыг зохистой, хууль ёсны гэж үзэх вэ? Бүтцийн хүчирхийллийг арилгахад, жишээлбэл цаг үеийн хүчирхийлэл хэрэглэхийг зөвтгөж болох уу?

Энэ асуултад түүхэнд нэрээ тодоор үлдээсэн зүтгэлтнүүд өөр өөр хариулт өгсөн байдаг. Энэтхэгийн тусгаар тогтнолын хөдөлгөөний удирдагч Махатма Ганди хүчирхийллээс ангид байх эрх чөлөөний төлөө тэмцэгч байсан. Харин Нелсон Мандела эсрэгээрээ түр хугацаанд өмнөд африкийн арьс өнгөөр ялгаварлан гадуурхагч

дэглэмийн эсрэг Африкийн Үндэсний Конгрессын хүч хэрэглэсэн эсэргүүцлийг дэмжиж байсан юм. АНУ-ын иргэний эрхийн хөдөлгөөнд Малком Х ба Мартин Лютер Кинг нар дээрх хоёр байр суурийг хатуу баримталдгаараа нэрд гарсан хувь хүмүүс байлаа. Галтунг өөрөө эерэг энх тайванд хүрэхийн тулд шууд хүч хэрэглэх нь зөв үү? гэдэг асуултад “буруу” гэдэг хариултыг өгч байжээ. Тэрээр хүчирхийллээс ангид байх эрх чөлөө нь өөрөө стратеги юм, жишээлбэл энх тайванч эсэргүүцлийн хэлбэрээр гэж хэлсэн байдаг.

Пакс эсвэл шалом?

“Энх тайван” гэдэг үгийг германд хэлэнд нарийн тодорхойлоогүй. Энх тайван эерэг ч байж болно, сөрөг ч байж болно. Иймээс бусад хэлтэй харьцуулж үзэх нь сонирхолтой юм. “**Пакс-Пакс**” гэдэг латин үг нь анхнаасаа сөрөг энх тайвны үзэл баримтлалыг илүү хүчтэй агуулдаг. Ромын эзэнт гүрний үед жишээлбэл ромчууд эзлэгдсэн газар нутгийн оршин суугчид хоорондын дайныг гэрээгээр тохиролцсоны үндсэн дээр зогсоохыг пакс гэж нэрлэдэг байв. Ихэнхдээ ромчууд амжилттай дайн хийсний дараагаар пакс тогтоодог боловч төдийлөн удаан хугацаанд тогтож байгаагүй аж. Эсрэгээрээ хэбрэй хэлний “**шалом**” гэдэг үг нь зөвхөн энх тайван, халдашгүй дархан байдал биш харин эрүүл мэнд, чин үнэн сэтгэлийн хандлага, сайн сайхан байдал, амар амгалан гэсэн утгыг агуулдаг. Иймээс шалом гэдэг үг нь эерэг энх тайвны тухай ойлголттой холбоотой, эрх тэгш түншүүд хэлэлцээрийн үр дүнд тогтоосон, урт хугацаанд тогтох энх тайван гэсэн утгатай.

Социал-демократ хэтийн чиг хандлага

Энх тайван нь бидний хувьд дайн байлдаангүй байхаас илүү өргөн утгатай. Энх тайван нь манай дэлхий дахины нийгмийн иргэншсэн хөгжлийн анхдагч суурь нь юм. Хямралаас урьдчилан сэргийлэх нь хамгийн үр өгөөж өндөртэй, аюулгүй байдлын бодлого юм. Бид өлсгөлөн, ядуурал, нөөцийн хомсдол зэрэг зөрчилдөөний бүтцийн шалтгааныг арилгасан нөхцөлд л урт хугацаанд энх тайвныг хангаж чадна гэдэгт итгэдэг.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 23)

Социал-демократ хэтийн чиг хандлагаас харахад энх тайван нь дайн байлдаангүй байхаас илүү өргөн утгатай байх ёстой гэдэг нь тодорхой харагддаг. Энэ өргөн агуулга нь социал-демократ

*Социал-демократ
үзэл: Энх тайван
бол дайнгүй
байхаас илүү
өргөн утгатай!*

үзлийн хэтийн зорилгод тусгалаа олсон байдаг. Социал-демократ үзэл нь бүх хүмүүсийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын үндсэн эрхүүдийг хангахыг эрмэлздэг.³

Үндсэн эрхүүдийг тэртээ 1976 онд НҮБ-ын “иргэний пакт”, “нийгмийн пакт” хэмээх хоёр пактад тодорхойлсон байдаг.

Эерэг энх тайвны ойлголтын агуулгаар бүтцийн хүчирхийллийг даван туулахын тулд энх тайвныг цогцлоох нь “байнгын үүрэг” хэмээн ойлгох ёстой гэдгийг Билли Брандт 1971 онд нобелийн энх тайвны шагналыг авахдаа хэлсэн үгэндээ тодорхой хэлсэн.

*Билли Брандт:
Гурван шалтгаан*

Брандт Осло хотноо өөрийг нь улс төрчийн хувьд хөтөлж, хөглөж ирсэн энх тайвны бодлогын гурван шалтгааныг танилцуулсан юм. Эдгээр нь:

1. Дайн улс төрийн хэрэгсэл байж таарахгүй. Гэхдээ энх тайванч хандлагыг зөвхөн тунхаглах нь хангалтгүй. Иймээс зөвхөн тунхаглаад зогсохгүй энх тайвныг идэвхтэйгээр зохион байгуулахыг эрмэлзэх ёстой. Энх тайвныг сорилт болон байнгын үүрэг хэмээн ойлговол зохилтой.
2. Тэрээр өөрийн орны нийгэмд, цаашлаад бусад орнуудад нийгмийн шударга ёсыг тогтоохыг эрмэлздэг социализмыг өөрийн энх тайвны бодлогын бас нэгэн эх ундарга хэмээн нэрлэсэн.
3. Хүмүүнлэг энэрэнгүй ёс. Энд Брандт германы идеализмын хамгийн чухал төлөөлөгчдийн нэг Кантын санаан дээр суурилан өөрийн санааг хэлсэн.

Брандтын нэрлэсэн энх тайвны бодлогын шаардлагын гурван суурь нь өнөөгийн социал-демократ бодлогод ач холбогдлоо огтхон ч гээгээгүй. Идеализмын үзэл санаанууд социал-демократ гадаад, хөгжлийн, аюулгүй байдлын бодлогын өнөөгийн үзэл баримтлалд тусгалаа олсоор байна.

Гэсэн хэдий ч социал-демократ хэтийн төлөвт сөрөг энх тайвны ойлголт ч нэгэн адил чухал. Цаг үеийн хүчирхийлэлгүй байх нь түүн дээр суурилан хөгжих нийгмийн хөгжлийн урьдач нөхцөл юм.

3 3.2 Үндсэн эрхүүд бүлгээс харна уу.

2.3. Аюулгүй байдлын ойлголтууд

Аюулгүй байдал нь амьдралын нэгэн үндэс юм. Амь насаа шууд хамгаалуулах эрх ба бие махбодийн халдашгүй дархан байдал нь анхдагч үндсэн эрхүүдийн нэг юм. Нийгмийн аюулгүй байдал нь бидний зовлон зүдүүргүй амьдрах нөхцөл юм. Харин аюулгүй байдлыг яаж маш тодорхой, оновчтой тодорхойлох вэ?

Аюулгүй байдал нь явцуу утгаараа бие махбодийн шууд хүчирхийлэл, заналхийлэлгүй байхыг хэлнэ гэдэг дээр зөвшилцөлд хүрсэн. Олон хүмүүс аюулгүй байдал гэдэг ойлголтод харин ажлын байрны аюулгүй байдал, санхүүгийн баталгаат байдал хангагдсан байх хамгийн доод хэмжээ багтдаг гэж боддог байх. Эндээс аюулгүй байдал нь ерөнхийдөө улс төрийн ойлголт нь гэдэг нь тодорхой харагдаж байна. Аюулгүй байдлын тухай ойлголт нь их маргаантай байсан, хойшид ч маргаантай хэвээр байх учраас байнгын хувьсаж байдаг ойлголт юм.

Юуг хэрхэн хамгаалах ёстой вэ? Ямар хэрэгслүүдээр хамгаалах вэ? Терроризм, алан хядах ажиллагаанаас үүдэлтэй шинэ хэлбэрийн заналхийллүүд бий болсон нь иргэдийн эрх чөлөөний эрхэд халдаж байгааг зөвтгөх шалтгаан мөн үү? Аюулгүй байдлыг улам бэхжүүлэхийн төлөө авч байгаа арга хэмжээнүүд шинэ аюултай байдлыг үүсгээд байгаа юм биш үү? Нийгэм ямар салбаруудад аюултай байдлыг зөвшөөрч, ямарт нь зөвшөөрөхгүй байх ёстой вэ? Эдгээр нь төр, нийгмийн өмнө байнга шинээр тавигддаг асуултууд.

Аюулгүй байдлыг хангах эрмэлзэл нь ханашгүй эрх мэдэл, энд төгсгөл гэж үгүйг бид мэднэ. Аюулгүй байдал нь эгнэгт хангагдсан амь нас гэж хаана ч үгүй. Хэрвээ байдаг бол энэ нь ер бусын байдлаар өөрийгөө үгүй хийхтэй адил мэт. (Майер 2010 он, 5)

Аюулгүй байдлын бодлого: Иргэд хооронд болон улс хооронд зөрчилд хүргэхгүй байх, хувь хүмүүс ба үйл хэргийн халдашгүй дархан байдлыг хамгаалах эсвэл төрийн халдашгүй байдлыг хангах бүх арга хэмжээний нийлбэрийг аюулгүй байдлын бодлого гэнэ. (Улс төрийн нэвтэрхий толь 2011 он: 267)

Олон улсын харилцаанд аюулгүй байдлын таван өөр ойлголт хоорондын ялгааг тайлбарлах нь сонирхолтой.

*Аюулгүй байдал:
их маргаантай
ойлголт*

Эдгээр нь: “дотоод” ба “гадаад аюулгүй байдал”, “сүлжээгээр холбогдсон аюулгүй байдал”, “өргөтгөсөн аюулгүй байдал ба сүлжээгээр холбогдсон үйл ажиллагаа”, “хүний аюулгүй байдал”. Хүмүүс аюулгүй байдлыг яаж ойлгож байгаа нь, аюулгүй байдлын ямар ойлголтыг хэрэглэж байгаа нь маш чухал. Учир нь аюулгүй байдлын ойлголт бүрийн цаана харилцан адилгүй харах өнцөг, зорилтууд, эрэмбэ дараалал, эдгээртэй холбоотойгоор аюулгүй байдалд хүрэхэд ашиглах хэрэгслүүдийн талаарх урьдчилсан шийдэл нуугдаж байдаг.

Сонгодог: дотоод ба гадаад аюулгүй байдал

Сонгодог утгаараа дотоод ба гадаад аюулгүй байдал нь хоорондоо ялгаатай. Энэ ялгаатай байдал нь германы засгийн газрын яамдын хуваарилалтад харагддаг. Нэг талд Холбооны дотоод хэргийн яам, нөгөө талд гадаад хэргийн яам, холбооны батлан хамгаалах яам байдаг.

*Дотоод аюулгүй
байдал*

Дотоод аюулгүй байдлыг заримдаа олон нийтийн аюулгүй байдал гэж нэрлэдэг. Энэ ойлголт нь гэмт хэрэгтэй тэмцэх, заналхийллээс хамгаалах хамгаалалтыг тодорхойлдог. Үндсэн хуулийн дагуу төр нь иргэдээ хүний ёсоор нэр төртэй, эрх чөлөөтэй амьдруулах үүрэг хүлээдэг. Төр иргэдээ цагдаа болон аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий бусад байгууллагуудаараа дамжуулан хамгаалах ёстой. Дотоод аюулгүй байдал нь мөн иргэдийнхээ хувийн орон зай, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах ёстой бөгөөд хүн амаа өвчлөл, тахлаас хамгаалах үүрэг мөн энд багтдаг.

Гадаад аюулгүй байдлын ойлголт нь цэргийн заналхийлэл буюу төртулсын хил дээрх аюул, эсвэл дайсагнагч гүрнээс хүн амд учруулж буй аюул зэргээс хамгаалах арга хэмжээнүүдийг тодорхойлдоогоороо дотоод аюулгүй байдлаас ялгаатай.

Хоёр өөр ойлголтод хуваалт хязгаартаа тулж байна.

Ийнхүү хоёр өөр ойлголтод хуваадаг байдал нь цагийн явцад хязгаартаа тулаад байна. Улс орнууд ба нийгэмд учирч буй заналхийллүүдийг дотоод ба гадаад бодлогод учирч буй заналхийлэл гэж тодорхой хуваахад бэрхшээлтэй болсоор байна.

Дэлгэрүүлэн унших:

Эдэлгард Булмаан,

Бодо Шүлце болон

бусад зохиогчид

(2017 он), Энх

тайвныг дэмжих,

даяаршлыг дотоодод

болон гадаадад

шударгаар жолоодох,

хэлэлцүүлэгт оруулах

хувь нэмэр Фридрих-

Эбертийн Сан (эрхлэн

гаргагч), Берлин

Олон улсын алан хядлага, байгаль орчны гамшигт үзэгдлүүд, эсвэл халдварт өвчнүүд улс орнуудын хилийн шугамд тулаад зогсолт хийхгүй нь мэдээж. “Тэгш хэмт дайн” хэмээн нэрлэж болох улс орнууд хоорондын сонгодог дайн байлдаан, зөрчилдөөний зэрэгцээ “тэгш хэмт бус” зөрчилдөөний тоо нэмэгдсээр байна. Улс орнууд ба төрийн бус оролцогч талууд хоорондын, жишээлбэл төр ба алан хядагч бүлгүүд хоорондын зөрчлүүдийг “тэгш хэмт бус” зөрчлүүд гэж нэрлэдэг.

1992 онд НҮБ-аас баталсан энх тайвны зорилтууд аюулгүй байдлын шинэ ойлголтын тухай хэлэлцүүлэгт чухал хувь нэмэр оруулсан. Энэ баримт бичигт хүйтэн дайны дараагаар дэлхий илүү энх тайван болоогүй гэдгийг тодорхойлсон. Харин оронд нь олон улс орнууд үндэсний цөөнх, шашин шүтлэг, нийгэм, соёлын зөрчилдөөн, ялгаварлан гадуурхалт, хаалттай байдал, алан хядлагын улмаас нурж болзошгүй байна. Энэ баримт бичигт мөн экологийн хохирол, зохицуулалт хийхэд бэрхшээлтэй хүн ам зүйн хөгжил, өрийн дарамт, худалдааны саад тотгор, хар тамхины наймаа, ядуурал, дарлал, бөөнөөрөө дүрвэн зайлах зэрэг шинэ сорилтуудыг нэрлэсэн байна.

Улс төрд аюулгүй байдал гэж юуг хэлээд байгаа тухай, аюулгүй байдалд хүрэх, хамгаалах ямар шийдлүүд байдаг вэ? гэдгийг шинээр тодорхойлох шаардлага тулгарч байна.

Аюулгүй байдлын шинэ ойлголтууд

20-р зууны дунд үеэс эхлэн энэхүү шинээр бүрдээд буй ерөнхий нөхцөлд хариулт өгч чадах аюулгүй байдлын шинэ ойлголтуудын тухай хэлэлцэж байна. Эдгээр хариултууд нь дотоод ба гадаад аюулгүй байдлыг хооронд нь зааглах шаардлагагүй гэж үздэг. Тэд харин үүний оронд дотогшоо ч гадагшаа ч нөлөөлж чадах аюулгүй байдлын бодлогын өргөн хүрээтэй стратегиуд, үзэл баримтлалууд боловсруулахыг шаардаж байна.

Аюулгүй байдлын эдгээр шинэ ойлголтуудын нэг нь **сүлжээгээр холбогдсон аюулгүй байдлын** тухай ойлголт юм. Энэ ойлголт нь иргэний болон цэргийн хүчнүүдийн харилцан үйлчлэл, төрөл бүрийн түвшинд байгууллагууд хоорондын зохицуулалт хийх, ба салбар

*Фридрих-Эбертийн
сан (эрхлэн гаргагч)
2016 он, Найдваргүй
цаг үед баталгаат
байдлыг хангах,
мозайк-аюулгүй
байдлын системийг
сонгох шийдвэр
2.0 Хүч хэрэглэхэд
монопол байдал
тогтоогоод байна
уу?. Дэлхий нийтийн
тусгал бүлгийн
тайлан*

дундын нягт зөвшилцөлд чиглэдэг. Энэ ойлголтыг 2006 онд германы хэлэлцүүлгийн хүрээнд Холбооны батлан хамгаалах яамны цагаан номд албан ёсоор оруулсан юм. Харин ширүүхэн хэлэлцүүлгийн дараагаар 2016 оны шинэчилсэн цагаан номоос энэ ойлголтыг хассан. Харин оронд нь өргөтгөсөн аюулгүй байдал, сүлжээгээр холбогдсон үйл ажиллагааны тухай ярих болсон юм.

“Цагаан ном” нь юуны өмнө аюулгүй байдлын бодлогын салбарт хэрэглэгддэг ойлголт юм. Цагаан номд тодорхой бодлогын салбарт гарсан саналуудыг нэгтгэдэг.

Дэлгэрүүлэн унших:

Мариус Мюллер
Хэнниг, Бодо Шүлце,
Наташа Зуфан (2011
он), *Найдваргүй
талбаруудын хөгжил,
ФриЭнт Зөвлөмж
№10, Бонн хот*
Кристиан Эндресс ба
Нилс Петерсен (2012
он) *Аюулгүй байдлын
ойлголтуудын цар
хүрээ, Холбооны улс
төрийн боловсролын
төв, Бонн хот*
Ульрих Фрай ба бусад
зохиогчид (2014 он)
*Аюулгүй байдлын
логикийн оронд
энх тайвны логик.*
*Шинжлэх ухаан ба
энх тайван сэтгүүлд*
*Онолын үндэснүүд ба
энх тайвны бодлогын
хэрэгжилт тун №75*
*Шинжлэх ухаан ба энх
тайван мэдээллийн
төв (эрхлэн гаргасан
Клеве)*

Ямар учраас “Сүлжээгээр холбогдсон аюулгүй байдал” гэдэг ойлголт эрс шүүмжлэлд өртдөг вэ?

Шүүмжлэл эхлээд уг ойлголтын үүссэн цэргийн нөхцөл байдалтай холбоотойгоор өрнөсөн. Эхлээд сүлжээнд орсон аюулгүй байдлын тухай ойлголтын дагуу энгийн иргэд нь цэргийнхний захиргаанд орох юм байна гэдэг шүүмжлэл өрнөсөн. Цэргийн ажиллагаа нь командын тодорхой бүтэц ба нууцыг хадгалах үүрэгт захирагддаг. Харин энгийн иргэд зарчмын хувьд алинд нь ч захирагддаггүй. Үүнээс болоод тэнцвэржүүлэх боломжгүй тэнцвэргүй байдал үүснэ гэж үзсэн юм. Хоёрдугаарт, уг ойлголтын дагуу иргэний ба цэргийн хамтын ажиллагаа нь иргэний ажиллагааг цэрэгжүүлнэ гэсэн үг. Гуравдугаарт, сүлжээгээр холбогдсон аюулгүй байдлын үзэл баримтлал нь хэлэлцүүлгийг нийтэд нь аюулгүй байдлын асуудал болгоод байна гэж үзсэн. Энэ ойлголтыг дэмжигсэд сүлжээгээр холбогдсон аюулгүй байдлын ойлголт нь нэгэн цогц, өргөн хүрээтэй шийдэл хэмээн хамгаалж байлаа.

Бүгдийг аюулгүй байдалд хамруулах гэдэг ойлголт нь бодлогын төрөл бүрийн салбарууд асуудлаа аюулгүй байдалтай холбон хэлэлцэх нь нэмэгдэж байгааг шүүмжилдэг. Цаашлаад цаг уурын өөрчлөлт, эсвэл дэлхий дахинд нэмэгдсээр байгаа цагаачдын урсгалыг ч аюулгүй байдлын асуудал гэж тодорхойлдог боллоо. Асуудлыг ингэж тодорхойлсноор ерөнхийдөө европын гадаад хилийн дээсийг тойруулан хашаа босгох, даланг өндөрсгөх зэрэг шийдэлд хүргэж байна хэмээн шүүмжилж байна. Эдгээр шийдлүүд нь цагаачдын амьдралын үндсэн суурийг хамгаалах, эрүүл энх, сайн сайхан байдалд тус болохгүй.

“Өргөтгөсөн аюулгүй байдал ба сүлжээгээр холбогдсон үйл ажиллагаа” гэдэг шинэ томъёоллоор бүхнийг аюулгүй байдалтай холболоо гэдэг шүүмжлэлд хариулт өгч, төрөл бүрийн оролцогч талуудыг зохицуулах сонирхлоо илэрхийлэх гэсэн оролдлого юм.

Хүний аюулгүй байдал нь аюулгүй байдлын өөр нэгэн чухал өргөтгөсөн ойлголт юм. Уламжлалт аюулгүй байдлын үзэл баримтлалаас ялгаатай нь энэ үзэл баримтлал зөвхөн улсыг хамгаалах бус, харин хувь хүмүүс ба хүмүүний нэр алдрыг хамгаалах хамгаалалтад онцгой ач холбогдол өгдөг үзэл баримтлал юм.

Хүний аюулгүй байдал: долоон өөр цар хүрээ

Энэ үзэл баримтлалыг НҮБ-ын 1994 оны хүний хөгжлийн илтгэл дээр суурилан боловсруулсан. Уг илтгэлд хүний аюулгүй байдалд чухал хоёр үндсэн элементийг онцлон тэмдэглэсэн. Эдгээр нь: зовлон зүдүүрээс ангид байх эрх чөлөө ба айдсаас ангид байх эрх чөлөө юм. (freedom from want and freedom from fear) Эндээс энэ үзэл баримтлал өмнө хэлэлцсэн “ээрэг энх тайван” ба “сөрөг энх тайван”-ны ойлголттой холбогдож байгааг харж болно.⁴

Хүний аюулгүй байдал нь долоон өөр цар хүрээгээр илэрхийлэгддэг. Эдгээр нь: эдийн засгийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал, байгаль орчны аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, улс төрийн аюулгүй байдал юм.

Эцэст нь социал-демократууд гол санааг нь өгсөн, энх тайвны маш чухал нэгэн ойлголт бол хамтын аюулгүй байдлын ойлголт юм. Уг ойлголт анх Палмегийн “Хамтын аюулгүй байдал нь амьд үлдэх алтан боломж”⁵ сэдэвт илтгэлийн нэрээс үүссэн юм. Олаф Палме тухайн үед шведийн ерөнхий сайд байхдаа зэвсэг хураах ба аюулгүй байдлын комиссын гишүүнээр ажиллаж байсан. Тус комиссын хаалтын илтгэлийг мөн Олаф Палме хэмээн нэрлэсэн юм. Тус илтгэлийг 1982 онд НҮБ-ын ерөнхий ассамблейн зэвсэг хураах онц хуралдаанд танилцуулсан.

Хамтын аюулгүй байдал

Уг илтгэлд аюулгүй байдал бол хамтын төсөл, хоорондоо дайсанагч эвслүүдийн хамтын хариуцлага гэдгийг ойлгуулсан билээ. Аюулгүй

4 Энэ номын энх тайвны ойлголтууд 2.2-р бүлгээс харна уу.

5 Орчуулга ЖД: “Хамтын аюулгүй байдал: Амьд үлдэх алтан боломж”

байдалд эсрэг талынхаа “эсрэг” бус харин эсрэг талтай “хамтран” хүрэх боломжтой. Зэвсэглэлээр хөөцөлдөх, айлган сүрдүүлэх бодлого нь хамтарсан аюулгүй байдлын ойлголттой нийцэхгүй.

Хамтын аюулгүй байдлын ойлголт нь, ялангуяа аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд хожим нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага болон бэхжихэд нь чухал ач холбогдолтой байлаа.⁶

Хамтын аюулгүй байдлын тухай ойлголттой нягт холбоотой ойлголт бол коллектив аюулгүй байдлын ойлголт юм. Хамтын аюулгүй байдлыг коллектив аюулгүй байдлын европ хувилбар хэмээн тодорхойлж болох юм.

“Хүн төрөлхтөн зөвхөн хамтдаа тэсэж үлдэж чадна, чадахгүй бол хамтдаа мөхнө. Түүхэнд адилтгах жишээ байхгүй, энэ хувилбарууд олон улсын үйл хэрэгт, ялангуяа энх тайвныг хангахад шинэ хандлага шаардаж байна.”

(ГСДН-ын Берлиний хөтөлбөр 1989 он, Друбе\ Клотцбахын ишлэл 2004 он, 361-р хуудас)

Аюулгүй байдлын ойлголтуудыг төрөлжүүлэх дөрвөн өөр цар хүрээ

Аюулгүй байдлын хуучин ойлголтуудаас шинэ ойлголтод шилжих шилжилтээс гарсан өөрчлөлтийг хэрхэн нэгтгэн тодорхойлох вэ? Үүний тулд хуучин ба шинэ ойлголтуудыг дөрвөн өөр цар хүрээнд авч үзэх шаардлагатай. (Дассе 2010 онтой харьцуулаарай.)

- Тодорхойлолтын цар хүрээнд гарсан өөрчлөлтүүд буюу хэний аюулгүй байдлыг хангах шаардлагатай вэ? гэдэг асуултын хүрээнд
- Ажил хэргийн цар хүрээнд гарсан өөрчлөлтүүд буюу бодлогын ямар талбарууд дээр заналхийлэл тулгарч байна вэ? гэдэг асуултын хүрээнд
- Орон зайн цар хүрээнд гарсан өөрчлөлтүүд буюу ямар газар нутаг дээр аюулгүй байдлыг тогтоохыг эрмэлзэж байна вэ? гэдэг асуултын хүрээнд

6 Энэ номын 1960-аад оноос эхэлсэн Зүүний шинэ бодлого 3.4.4. бүлэг ба ЕАБХАБ 5.4 бүлэг

- Аюулын цар хүрээнд гарсан өөрчлөлтүүд буюу улс төр хариулт өгөх ёстой асуудлыг яаж тодорхойлох вэ? гэдэг асуултын хүрээнд

“Үндэсний” аюулгүй байдлаас “хүмүүнлэгийн” аюулгүй байдал руу, “цэргийн” аюулгүй байдлаас “экологийн” аюулгүй байдал руу, “газар нутгийн” аюулгүй байдлаас “дэлхий дахины” аюулгүй байдал руу, “заналхийллээс хамгаалахаас” “эрсдэлээс сэргийлэх”- рүү шилжих чиг хандлага ажиглагдаж байна.
(Эндресс\ Петерсен 2012 он)

Социал-демократ үзэлд аюулгүй байдлыг хэрхэн ойлгодог вэ?

Эдгээр цар хүрээнд тулгуурлан ямар ойлголт нь социал-демократ үйл ажиллагааны чиглэл болж чадах вэ? гэдгийг тодорхойлох боломжтой болно.

Хэний аюулгүй байдал хангагдах ёстой вэ?

Иргэдээ хамгаалах нь төрийн үндсэн үүргийн нэг юм. Төрийн хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдлын үндэс нь иргэдийн хамгаалал юм. Энэ утгаараа хүн амын хамгаалал социал-демократ үзэлд чухал байр суурийг эзэлдэг. Социал-демократ үзэл нь ямагт олон улсын хөдөлгөөн байсан, байсаар ч байх болно. Социал-демократ үзэл нь олон улсын эв санааны нэгдэлд өндөр ач холбогдол өгдөг улс төрийн хүч. Иймээс зөрчилдөөнтэй газар нутаг дээр байгаа хүмүүсийг хамгаалахад улс төрийн бусад урсгалуудаас илүү хүчин чармайлт гарган ажилладаг.

Улс төрийн ямар салбарууд дээр заналхийлэл тулгарч байна?

Энэ цар хүрээнд социал-демократууд нь заналхийллийн талаар илүү гүнзгий ойлголттой байдаг. Социал-демократууд бүхнийг аюулгүй байдалд хамруулах оролдлогыг эсэргүүцдэг. Дүрвэгсдэд туслах хэрэгтэй, цаг уурын өөрчлөлтийг зогсоох хэрэгтэй. Гэхдээ үүнийг аюулгүй байдлын үүднээс бус, харин хүн ёсны үүднээс хийх ёстой. Хүн бүр хүний ёсоор амьдрах, амьдралын үндсэн сууриа хамгаалуулах эрхтэй. Иймээс социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужин нь өргөн хүрээтэй буюу бодлогын салбар дамнасан шийдлийг баримталдаг.⁷

⁷ Энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужингийн элементүүд 3.5 бүлгээс уншина уу.

Ямар газар нутгийн аюулгүй байдлыг хангахыг эрмэлзэж байна вэ?

Олон улсын эрхэд суурилсан шаардлагын улмаас социал-демократууд тодорхой салбарын аюулгүй байдлыг хангах нь хангалтгүй гэж үздэг. Европын энх тайван, аюулгүй байдал нь түүхэн амжилт юм. Европыг тойруулан энх тайвны цайз босгочхоод эргэн тойронд нь дайны гал дүрэлзэж байх юм бол энэ ирээдүйтэй үзэл баримтлал биш. Иймээс социал-демократууд хамтын аюулгүй байдлыг цогцлоодог дэлхий дахины аюулгүй байдлын тогтолцооны төлөө байдаг.

Энэ асуудлыг яаж тодорхойлдог вэ?

Социал-демократууд хэзээ ч цэвэр дайныг эсэргүүцэгч хөдөлгөөн байгаагүй. Гэхдээ дайныг эсэргүүцэх үзэл нь ямагт социал-демократуудын дунд нэгэн чухал урсгал байсаар ирсэн. Социал-демократуудын төлөөлөгчид зөрчилдөөний үед дан ганц заналхийллээс хамгаалах хамгаалалтад найдаж байгаагүй, харин эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөн авсаар ирсэн. Бүхнийг аюулгүй байдалд хамаатуулах шийдлийн дагуу бус, харин шударга дэлхийн төлөө, шударга хөгжил нь энх тайван, аюулгүй байдлын хамгийн шилдэг бодлого учраас дээрх хоёр арга хэмжээг авсаар ирсэн. Нэн тэргүүнд дипломат бодлого, хямралаас урьдчилан сэргийлэх иргэний арга хэмжээ, олон улсын байгууллагуудыг дэмжих, зэвсэглэлийг хураах, зэвсэглэлд хяналт тавих ба олон улсын эрх зүйг бэхжүүлэх, хүний эрхийн хамгаалах арга хэмжээнүүд тавигддаг.

2.4. Төрөл бүрийн загварууд: Дайны эсрэг үзэл, иргэний ба цэргийн хүч

Олон улсын харилцааны төрөл бүрийн онолууд, энх тайвны тухай ойлголтуудтай танилцахын зэрэгцээ энх тайван ба аюулгүй байдлын бодлогын чиг хандлагыг тогтооход чухал ач холбогдолтой бас нэгэн чухал хэмжигдэхүүн бий. Энэ бол аливаа улс орон өөрийн гадаад бодлогоо тодорхойлохдоо баримталдаг үзэл баримтлал юм.

Сурах бичгийн энэ дэвтэрт гурван үндсэн үзэл баримтлалыг танилцуулах болно. Эдгээрийг юуны өмнө бусад үзэл баримтлалаас тодорхой ялгах боломжтой, иймээс чиг баримжаа авахад илүү ойлгомжтой гэдэг талаас нь харж сонгосон. Эдгээр нь дайныг эсэргүүцэх үзэл баримтлал, иргэний буюу энх тайвны гүрэн, цэргийн гүрний үзэл баримтлал юм.

Фаципизм буюу дайныг эсэргүүцэх үзэл баримтлал

Орчин үеийн европын энх тайвны хөдөлгөөн нь 200 орчим жилийн түүхтэй. Энх тайвны хөдөлгөөн нь 19-р зууны эхний хагаст үүсгэн байгуулагдсан “Энх тайвны нийгэмлэгүүд”-ээс эхтэй. Эдгээр нийгэмлэгүүдийн гишүүдийн дийлэнх нь эрчимтэй хөгжиж байсан либерал хөрөнгөтнүүдээс гаралтай.

Фаципизм гэдэг үг хэллэг 20-р зууны эхэн үеэс энх тайвны төлөөх улс төрийн тэмцлийн ойлголт болон төлөвшсөн. Энэ үг нь латин хэлний “пакс-рах энх тайван” гэдэг нэр үг ба “facere- хийх, үйлдвэрлэх” гэдэг үйл үгнээс гаралтай.

“Фаципизм гэдэг ойлголтод нэгдсэн тодорхойлолт өгөхөд хэцүү. Энэ нь дайныг эсэргүүцэгч хөдөлгөөний дотор аажимдаа олон урсгал бий болсонтой холбоотой юм. Фаципизмын хамгийн нэрд гарсан урсгал нь соён гэгээрлийн сэтгэлгээ дээр суурилсан хөрөнгөтний эсвэл барууны фаципизм юм.

Энэ урсгалын үндсэн санаа нь “Эрхээр дамжуулж энх тайванд хүрэх” юм. Энэ урсгалын төлөөлөгчдийн хувьд ямар ч тохиолдолд

Дэлгэрүүлэн унших:
Гертруд Брюхер (2008 он), Дайныг эсэргүүцэх үзэл хэлэлцүүлэг, Виесбаден

Юрген Хабермас (1999 он) Балмад үйлдэл ба хүмүүнлэг чанар. Эрх ба зан суртахуун хоорондын зааг дээрх дайн, Цаг сэтгүүлийн 1999 оны дугаар 18.

Карл Холл (1988 он), Дайныг эсэргүүцэх үзэл Германд Франкфурт ам Майн

Төрөл бүрийн урсгалууд

Барууны фаципизм

шууд энх тайвныг хангах бус харин олон улсын харилцааг бүхэлд нь өөрчлөх нь илүү чухал. “Хүчтэнүүдийн эрх”-ийн оронд “Эрхийн ноёрхол” тавигдах ёстой.

Зарчмын хувьд цэргийн хүчнээс татгалзана гэсэн санаа энд байгаагүй. Гаднаас халдан ирсэн тохиолдолд цэргийн хүчээр улс орноо хамгаалах төрийн эрх, гадаадын эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг чөлөөлөх дайн хийх эрхийн адил цэргийн хүч хэрэглэх эрх бол эргэлзэх шаардлагагүй эрх хэмээн үздэг.

Шинжлэх ухааны фаципизм

Хөрөнгөтний фаципизмын цаашдын хөгжилд Альфред Х. Фриедийн 1900-аад онд боловсруулсан “шинжлэх ухааны” буюу “зохион байгуулалтын” фаципизмын санаа чухал үүрэг гүйцэтгэсэн. Тэрээр улс төр, хүмүүнлэг, эрх зүйн арга хэрэгслүүд ба байгууллагуудыг хөгжүүлэх, өргөжүүлэх замаар зөрчилдөөнийг дайнгүйгээр шийдэх зорилго тавьж байлаа.

“Зохион байгуулалтын фаципизм” гэдэг ойлголт нь дэлхийг хэрсэн сүлжээ, харилцаа, ба худалдаа, -гэрээ хэлэлцээрийн харилцаа улам бүр эрчимжиж байгаатай холбоотой үүссэн. Зохион байгуулалтын фаципизмын төлөөлөгчид нь өөрсдийн үзэл баримтлалаар түгээмэл энх тайвныг хангах үл гүйцэлдэх санааг баримтлаагүй, харин барууны фаципистуудын нэгэн адил олон улсын эрх зүйн тогтолцоог сайжруулах замаар улс орнууд хоорондын хүчирхийллийг хязгаарлах зорилго тавьж байлаа.

Дэлхий дахины буюу дэлхийн засаглал

Олон улсын хамтын ажиллагааны бүтцийг тодорхойлох орчин үеийн нэгэн үзэл баримтлал нь өнөөдөр “Дэлхий дахины засаглал”-ийн тухай ойлголттой холбоотой. Энэ нь төрийн болон төрийн бус оролцогч талуудын дэлхий дахины асуудлыг шийдвэрлэхийн төлөө явуулж буй бүх үйл ажиллагааг нэгтгэнэ гэсэн санаа юм. Энэ үзэл баримтлалыг дэмжигчид нь фаципизмаас амтагдаад байдаг үл гүйцэлдэх үзлийн амтыг арилгах, бодит бодлогын шинж чанартай болгох боломж дэлхий дахины засаглалд агуулагдаж байна гэж үздэг.

Шашны фаципизм

Дайныг эсэргүүцэгч өөр нэгэн урсгал бол шашны фаципизм юм.

Уг урсгал юуны өмнө англо америкийн орон зайд тодорхой үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд жишээлбэл: Христийн шашны уулын номлол буюу “Та нарт муу зүйл хийгээд байгаа нэгэнд эсэргүүцэл бүү үзүүл” гэдэг номлол дээр суурилдаг.

Дэлхийн нэгдүгээр дайны туршлагаас суралцан цэргийн хүчийг эсэргүүцдэг хүчирхэг бүрэлдэхүүн хэсэг бүхий эрс буюу **туйлширсан фаципизм** үүссэн юм. (Дайнд дайнаар хариу өгөхгүй байх). Олон нийтийн хэлэлцүүлэгт уг урсгалыг фаципизмтай адилтгах нь олонтаа. Туйлширсан фаципизмын төвд дайны албанаас татгалзах, зэвсэг хураах, цэргийн алба хаах үүргийг үгүй болгох, бүх армийг тараах санаа байдаг. Туйлширсан фаципизмын хөрөнгөтний, барууны фаципизмаас ялгаатай нь олон улсын харилцааны улс төрийн ба хуулийн бүтцэд дайныг эсэргүүцэх үзлийг тусгах, хэрэгжүүлэхийг хүсдэг бол радикал фаципистууд дайныг идэвхтэй эсэргүүцсэнээр ирээдүйд дайн гарах бүх нөхцөлийг эгнэгт үгүй болгохыг хүсдэг. 19-р зууны энх тайвны хөдөлгөөнөөс ялгаатай нь радикал фаципизм нь нийтийн хөдөлгөөн болон хөгжсөн. Уг урсгалыг зөвхөн хөрөнгөтний энх тайвны жижиг нийгэмлэгүүд бус, харин ажилчны хөдөлгөөн дэмжиж байлаа. Дээрээс нь Каете Коллвитц, Отто Дикс эсвэл Эрих Каэстнер зэрэг зохиолч нар, урлаг соёлынхон тэдний санааг дэмжиж байв.

Туйлширсан фаципизм нь идэвхтэй, хүчирхийллээс ангид эсэргүүцлийн үзэл баримтлалын хэлбэрээр хөгжиж уг санааг Ганди, Мартин Люүтер нар практик дээр хэрэгжүүлж байлаа. Хүчирхийллээс ангид эсэргүүцлийн зорилт нь хүчирхийллийг хүчирхийллээс ангид хэрэгслүүдээр даван туулах улмаар улс төр, нийгмийн өөрчлөлтөд хүргэхэд чиглэгдэж байв.

Фаципизмын ямар ойлголт вэ?

Фаципизмын тухай ойлголтод нэгдсэн тодорхойлолт өгөх нь ямар хэцүү болохыг та нар харлаа. Хүчирхийллээс туйлын ангид байх зарчим нь фаципизмын зөвхөн нэг л урсгал боловч олон нийт

Ихэвчлэн ажилчны хөдөлгөөнд хамаардаг түүхэн үзэгдэл болох **антимилитаризм** буюу милитаризмыг эсэргүүцэгч хөдөлгөөнөөс дайныг эсэргүүцэгч хөдөлгөөнийг ялгаж салгаж ойлгох нь зүйтэй. Антимилитаризмын зорилт нь уг урсгалыг дэмжигчдийн зүгээс харахад дайн ба амар амгалан бусын

*Туйлширсан
фаципизм*

*Туйлширсан
фаципизм
мэдрэхүйд
давамгайлдаг*

фаципизмыг уг ойлголттой адилтган үздэг. Төрөл бүрийн идеал хэв шинжийг хооронд нь ялгахын тулд туйлширсан фаципизмыг нэгэн туйл гэж нэрлэх нь зүйтэй байх. Энд санааныхаа мухарт хийгээд авах ёстой нэг зүйл бол өөрийгөө фаципист хэмээн нэрлэгч хүн бүр, аливаа хэлбэрийн хүч хэрэглэхээс татгалзах санал гаргагч бүр бодит байдал дээр жинхэнэ фаципист байдаггүй.

шалтгаан болсон нийгмийн бүтцүүдийг даван туулахад оршдог. Зарчмын хувьд уг шийдэл нь капитализмыг эсэргүүцэгч үндсэн хандлагуудтай холбоотой байлаа. 19-р зууны төгсгөл, 20-р зууны эхэн үеийн дайныг эсэргүүцэгч үзлийг сөрөг энх тайвны ойлголтод багтаах боломжтой бол милитаризмыг эсэргүүцэгч үзэл эсрэгээрээ эерэг энх тайвны ойлголтод багтдаг.

**ФАЦИПИЗМ БУЮУ
ДАЙНЫГ ЭСЭРГҮҮЦЭГЧ ҮЗЭЛ**

1. Жолоодох хүсэл зориг	Улс хоорондын хүч хэрэглэсэн тэмцэл маргааныг олон улсын харилцааны эрх зүйг хуульчлах замаар даван туулах (Улс орнуудын нийгмийн гэрээ, Фриед 1918 он)
2. Үндэсний зорилтууд	- Улс төр, нийгмийн ухамсрыг өөрчлөх - Нийгмийн энх тайвны соёлыг бий болгох - Зэвсэг хураах
3. Олон улсын зорилтууд	- Олон улсын харилцааны эрх зүйн зохицуулалтуудыг сайжруулах; улс үндэстнүүд хоорондын зөрчилдөөнийг иргэний хэрэгслүүдээр боловсруулах, энх тайвны замаар шийдвэрлэх - Олон улсын харилцааны эрх зүйн зохицуулалтуудыг дэмждэг байгууллагууд, дэглэмүүдийг бий болгох, - Дэлхий дахины худалдаа-гэрээ хэлэлцээрийн харилцааг эрчимжүүлэх - Зэвсэг хураах
4. Хоорондоо сүлжилдсэн ашиг сонирхлууд ба түгээмэл үнэлэмжүүд	- Цэргийн хүч хэрэглэхээс зайлсхийх - Дэлхий дахины засаглалыг дэмжих (Дэлхийн дотоод бодлого)

5. Гадаад бодлогын үйл ажиллагааны онцлог загварууд	Олон улсын төвшинд иргэний арга хэрэгслүүдийг бэхжүүлэх ба зэвсэг хураах дэглэмүүдийг хэрэгжүүлэх
6. Дайныг эсэргүүцэх үзлийн гадаад бодлогын хэрэгслүүд	- Дайн ба хүчирхийлэл нь хэзээ ч ашиг сонирхлоо хэрэгжүүлэх эсвэл эрх мэдлээ хадгалах хууль ёсны хэрэгсэл байж таарахгүй. - Иргэний хэрэгслүүд маш чухал үүрэгтэй. - Хувь хүмүүсийн хамгааллыг дэмжих

Иргэний гүрэн

1990-ээд оны эхэн үед “Иргэний гүрэн” гэдэг ойлголт Триерийн улс төр судлаач Ханнс Уа.Мауллын номоор дамжин улс төр, шинжлэх ухааны өргөн олон нийтэд танил болсон юм. Энэ үг бүтээд 20 жил болсныхоо дараагаар ийнхүү дахин шинээр танигдсан юм. Энэ ойлголтыг 1970-аад оны эхэн үед эхлээд Жеан Моннетийн хэвлэлийн референт, хожмоо Лондонгийн стратеги судлалын олон улсын хүрээлэнгийн захирал болсон фон Франциос Дучене нэвтрүүлснээс хойш хэрэглэж эхэлсэн. “Иргэний гүрэн Европ” гэдэг ойлголт нь энд европын нэгдлийн гишүүн орнуудын европт болон дэлхий дахинд энх тайвнаар зэрэгцэн орших санааг илэрхийлж байлаа.

Германд Ханнс Уа.Маулл Кнут Кистетэй хамтран энэ ойлголтыг хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэ хоёр иргэний гүрний үүргийн идеал хэв шинжтэй үзэл баримтлалыг боловсруулсан. Тэд мөн шалгуур үзүүлэлтүүдийн каталог боловсруулж каталогид иргэний хүчний шинж чанарыг ойлгомжтой тодорхойлсон.

Иргэний гүрний үзэл баримтлалыг социологич Норберт Элиасын иргэншлийн онол дээр суурилан боловсруулсан. Элиас “Иргэншлийн үйл явц” номдоо дундад зууны үеэс хойших нийгмийн дотоодын иргэншлийн хөгжлийг харуулсан. Тэрээр хүмүүсийн түүх хүмүүс хоорондын хүчирхийллийг номхотгосон түүхээс бүтдэг үү? гэдэгт дүн шинжилгээ хийсэн юм.

Үүсгэн байгуулагч:
Норберт Элиас

Нийгмийг хэрсэн холбоо, сүлжээ улам бүр нэмэгдэж байгаагийн улмаас “Зөрчилдөөнийг шийдвэрлэхэд хүч хэрэглэхээс эвгүйцэх” зэрэг мэдрэмж төрдөг болсон. Нийгмийн зүгээс хувь хүмүүс дээр ирэх биеэ зохистой авч явах дарамт маш их болсон тул хүн бүр нийгмийн дунд биеэ авч явах хэм хэмжээг зөрчихгүйн тулд өөрийн автомат хяналтын механизмтай болоход хүрсэн.

Эндээс эцэст нь хувь хүмүүс биеийн хүчирхийлэл үйлдэхээс татгалзаж, өөрсдөө хүч хэрэглэхийн оронд нийгмийн буюу төрийн байгууллагуудаар дамжуулан хүч хэрэглэхийг монополчлохыг дэмждэг болсон гэдэг дүгнэлтэд хүрсэн.

Норберт Элиас иргэншил улс үндэстнүүдийн хилийн шугамаар таслагдах ёсгүй гэж үзсэн учраас иргэншлийн үйл явцыг олон улсын харилцаан дээр ижил харьцаагаар буулгасан. Тэр “дэлхийн хүчирхийллийн монопол, дэлхийн улс төрийн төв хүрээлэн” байгуулагдах цаг ирж магадгүй”, уг хүрээлэн нь олон улсын харилцааг амар амгалан болгоход үйлчлэх боломжтой гэж үзэж байв.

*Цаашдын хөгжил:
Маулл ба Кирсте*

Маулл, Кирсте нар судалгаандаа Элиасын хөгжүүлсэн санааг оруулан судлаад үндэсний иргэншлийн үйл явцыг олон улсын түвшин дэх иргэншлийн үйл явцтай холбоход дэмжлэг үзүүлэх нь иргэний гүрний үүрэг гэж үзсэн.

*Зорилт:
Хүчирхийллийг
татан
оролцуулах*

Энд иргэншлийн үйл явцын зорилго нь хүмүүс хоорондын буюу улс хоорондын үзэгдэл болох эрх мэдэл эсвэл хүчийг үгүй болгохоос илүүтэйгээр эдгээр үзэгдлийг нийгмийн буюу улс орнуудын дээр орших (жишээ нь: Европын Холбоо, НҮБ гэх мэт) бүтцүүдтэй холбох зорилготой. Гэсэн хэдий ч иргэний гүрэн коллектив аюулгүй байдлыг дэмжих, нэг талт үйл ажиллагааг сөрөн зогсохын тулд өөрийн орны тусгаар тогтнолыг улс орнуудын дээр орших байгууллагуудад даатгах, эсвэл богино хугацааны үндэсний ашиг сонирхлыг олон улсын хэм хэмжээний тусын тулд хойш тавихад бэлэн байдаг.

Энэ зорилтдоо хүрэхийн тулд иргэний гүрэн (энх тайвны гүрэн) өөртөө олон улсын харилцааг хамтран хэрэгжүүлэх эрх олгохыг

шаарддаг. (жолоодох хүсэл зориг) Үүгээрээ иргэний гүрний зорилтууд ба стратеги нь сонгодог их гүрнүүдийнхээс ялгаатай. (Иргэний гүрэн эрх мэдлийн хувьд)

Иргэний гүрэн бол гадаад бодлогын үйл ажиллагаа нь олон улсын харилцааны иргэншлийн тусын тулд үйлчлэх зорилттой холбогддог улс юм. (жишээлбэл хангалуун чинээлэг амьдрал, түгээмэл үнэлэмжүүд ба олон улсын эрх зүйн хэрэгжилт). Иргэний гүрэнд чиглэгдсэн үүргийн үзэл баримтлал нь ХБНГУ-д дэлхийн хоёрдугаар дайны туршлагаас үүсэлтэй тогтсон бөгөөд гурван үндсэн санааны дагуу уг үзэл баримтлалыг тодорхойлох боломжтой.

Эхнийх нь “Дахиад хэзээ ч үгүй”: Дахин хэзээ ч хорих лагер барихгүй! Дахин хэзээ ч хүний эрх зөрчихгүй! Дахин хэзээ ч дарангуйлагч дэглэмтэй болохгүй! Хүний эрхийг хангах, ардчиллын төлөөх тэмцэл нь тэр цагаас хойш ХБНГУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалын үнэт зүйлст хамаарах болсон юм.

Хоёрдох сургамж “Дахин хэзээ ч ганцаараа хийхгүй”. Энэ нь

Сүүлийн жилүүдэд ХБНГУ-ын гадаад, аюулгүй байдлын бодлогын үйл ажиллагааг тодорхойлоход “Иргэний гүрэн” гэдэг ойлголтын оронд “энх тайвны гүрэн” гэдэг ойлголтыг мөн хэрэглэх болсон.

Эдгээр хоёр ойлголтыг хоорондоо ялгаатай гэж үздэг зарим улс төр судлаач эрдэмтэд байдаг. Энх тайвны гүрэн нь шаардлагатай үед цэргийн хэрэгсэл ашиглах боломжтой, ашиглах чадамжтай байдгаараа иргэний гүрнээс ялгаатай. Гэхдээ энэ үзэл иргэний гүрний үзэл баримтлалд зөвхөн өөр аргагүй болсон нөхцөлд сүүлчийн боломж болгон цэргийн хэрэгсэл ашиглана гэж заасан байдгийг буруугаар ойлгодог. Эдгээр хоёр ойлголтыг улс төрийн шинжлэх ухаан ба улс төрд ижил утгатай үг болгон хэрэглэдэг.

олон талт харилцаа буюу мултилатерализм ба барууны холбоотнуудтайгаа хамт гэсэн санааг илэрхийлдэг.

Баруун германы гадаад бодлогын гуравдах үндсэн санаа “Хүчнээс түрүүлж бодлого” нь цэргийн хүч хэрэглэхэд эргэлзээтэй хандах хандлагыг илэрхийлж байгаа юм. Энэ санааг “дайныг эсэргүүцэх үзэлтэй”-тэй адилтгаж болохгүй.

ХБНГУ-д
тод илэрдэг.

“Дахиад хэзээ ч
үгүй-Never again”

“Дахин хэзээ
ч ганцаараа
хийхгүй-Never
alone”

“Хүчнээс түрүүлж
бодлого-Politics
before force”

ИРГЭНИЙ ГҮРЭН

1. Хамтран жолоодох хүсэл зориг	- Олон улсын харилцааг коллектив идэвх чармайлтаар хамтран хэрэгжүүлэх эрхэд суурилсан шаардлага - Олон улсын өмнө хариуцлага хүлээхэд бэлэн байдал - Үлгэр жишээ болохуйц үүрэг, түүчээ тогорууны үүрэг гүйцэтгэх
2. Үндэсний зорилтууд	- Нийгмийн тэнцвэрт байдал ба ардчилсан тогтвортой байдал - Хангалуун чинээлэг амьдрал - Ардчилсан, нийгмийн баримжаат төрийн дотоод бодлогыг олон улсын харилцаан дээр буулгах
3. Олон улсын зорилт	- Түгээмэл үнэлэмжийг хэрэгжүүлэх - Тусгаар тогтнолоо олон улсын байгууллагуудад хэсэгчлэн шилжүүлэх - Байгууллагуудыг дэмжих, бэхжүүлэх, эрх зүйн зохицуулалтуудыг сайжруулах - Олон улсын эрхийг хэрэгжүүлэх
4. Хоорондоо сүлжилдсэн ашиг сонирхлууд ба түгээмэл үнэлэмжүүд	- Үнэлэмж дээр суурилсан гадаад бодлого - Ардчилагдах үйл явцыг дэмжих - Дэлхий дахины асуудлуудыг хамтарсан шийдлээр шийдвэрлэх (Дэлхийн дотоод бодлого) - Сайн засаглалыг дэмжих (эрх зүйт төр, ардчилал, олон ургалч үзэл, зах зээлийн эдийн засаг) - Тогтвортой хөгжлийг дэмжих
5. Гадаад бодлогын үйл ажиллагааны онцлог загварууд	- Нэг талт эсвэл бие даасан үйл ажиллагаа явуулахгүй байх - Коллектив болон хувь хүний өөрийгөө хамгаалах хамгаалалтаас бусад тохиолдолд хүч хэрэглэхээс татгалзах - Олон улсын хэм хэмжээг зөрчсөн нөхцөлд хамтарсан хориг арга хэмжээ авах - Харилцан буулт, хэлэлцээр, маргаан шийдвэрлэхийг гадаад бодлогын зөрчилдөөний соёл болгон хөгжүүлэх - Хүчний монопол бүрдүүлэх

**6. Иргэний хүчний
гадаад бодлогын
хэрэгслүүд**

- Коллектив аюулгүй байдлыг идеал зорилт болгох
- Сүрдүүлсэн, цэргийн хүч хэрэглэсэн тохиолдолд олон улсад хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал ба коллектив хэрэгжилттэй холбох.
- Цэргийн хүч хэрэглэхэд зарчмын хувьд эргэлзээтэй хандах; Улс төрийн хэрэгслүүдийг илүүд үзэх (жишээ нь: хориг тавих)
- Цэргийн хэрэгслүүдийг зөвхөн хямрал, зөрчилдөөний үед өөр арга зам байхгүй үед хэрэглэх

Цэргийн гүрэн

Нэг талаас иргэний гүрэн ба дайныг эсэргүүцэх үзэл нөгөө талаас 1980-аад оны эхээр Хедлей Буллын төслийг нь боловсруулсан цэргийн гүрний загварын үзэл баримтлалууд хоорондоо тодорхой ялгаатай. Францоис Дученегийн агуулгаар “Европ иргэний гүрэн”-ний үзэл баримтлалын эсрэг төсөл байсан.

Буллын өнцгөөс харахад баруун европын орнууд тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсын заналхийлэх чадамж бодитойгоор оршсоор байсан тул өөрсдийн батлан хамгаалахын бодлогын хэрэгслүүдийг сөргүүлэх тавих ёстой байлаа. Тэрээр цөмийн айлган сүрдүүлэх чадамж бүрдүүлэх, ердийн зэвсэгтэй зэвсэгт хүчнийг өргөтгөх болон Баруун Герман илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх шаардлагатай хэмээн үзэж байлаа.

Цэргийн гүрний загварыг реализмын онолын сургуульд хамааруулж болох юм. Энэ загварын төлөөлөгчдийн хувьд цэргийн хүч (hard power) нь ямагт хамгийн өндөр ач холбогдолтой байдаг. Ийм ч учраас цэргийн гүрний хувьд дайн нь өөрийн зорилтод хүрэх, эсвэл эрх мэдлээ хадгалах хууль ёсны нэгэн хэрэгсэл юм. Эсрэгээрээ иргэний хэрэгслүүдийг эргэлзээтэй үед ашиглана, төдийлөн чухал бус, эсвэл огт үүрэггүй гэж үздэг.

*Булл. Х-гийн үзэл
баримтлал*

Энэ нь дайн болж байгаа газар нутаг дээр цэргийн гүрэн дангаараа шийдвэр гаргах хандлагатай байдгийн нэг шалтгаан юм. Энх тайвны, эсвэл иргэний гүрнээс ялгаатай нь цэргийн гүрэн цэргийн хүч оруулахад НҮБ-ын хууль ёсны зөвшөөрөл заавал авах шаардлагагүй гэж үздэг, харин ингэснээр олон улсын байгууллагууд суларна гэдгийг тооцдоггүй.

Цэргийн гүрний энд танилцуулсан загварууд эцэстээ идеал хэв шинжийн шинж чанарыг агуулсан байдаг. Хамгийн сүүлчийн супер гүрэн, зарим зохиогч нарын цэргийн гүрэн гэж тодорхойлдог АНУ-д дээр танилцуулсан бүх хэв шинж тохирдоггүй. АНУ хамтын ажиллагаанаас хамааралтай буюу хэдийгээр цэрэг, батлан хамгаалахын хүчээр бусад орнуудаас давуу ч гэсэн хамтын ажиллагааг эрхэмлэдэг гэдгийг гольфийн булангийн хоёрдогч ба гуравдагч дайн тодорхой харууллаа.

ЦЭРГИЙН ГҮРЭН	
1. Хамтран жолоодох хүсэл зориг	Оролцогч талууд болон нөөцөөр дамжуулан хяналт тавих замаар олон улсын харилцааг хамтран жолоодох шаардлага
2. Үндэсний зорилтууд	Эрх мэдлийг боломжит дээд хэмжээнд хүртэл бэхжүүлэх
3. Олон улсын зорилтууд	Олон улсын орчинд боломжит дээд хэмжээнд хүртэл хяналт тавих
4. Хоорондоо сүлжилдсэн эрх ашиг ба түгээмэл үнэлэмжүүд	- Ашиг сонирхлыг өөртөө давуу байдал үүсгэх гэдэг утгаар ойлгодог. - Үндэсний сонирхол зөрчигдөөгүй үед хөндлөнгөөс оролцох боломж хаалттай.
5. Гадаад бодлогын үйл ажиллагааны онцлог загварууд	- Нэг талт үйл ажиллагаанд бэлэн байдал - Дангаараа хүч хэрэглэхэд бэлэн байдал - Түншлэлийн оронд тодорхой зорилтын дор нэгдэх, холбоотон болох - Олон улсын бодлогыг тэг нийлбэрийн тоглоом хэмээн ойлгодог.

Цэвэр цэргийн хүч гэж дэлхий дахинд байдаггүй.

**6. Цэргийн гүрний
гадаад бодлогын
хэрэгслүүд**

- Дайн нь өөрийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх эсвэл эрх мэдлээ хадгалах хууль ёсны нэгэн хэрэгсэл
- Иргэний хэрэгслүүд хоёрдугаар зэргийн үүрэг гүйцэтгэдэг.
- Хувь хүмүүсийн хамгаалалтыг дэмждэг.

3. СОЦИАЛ-ДЕМОКРАТ ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ЛУУЖИН

Энэхүү бүлэгт:

- Социал-демократ үнэт зүйлсийг тайлбарлана.
- Социал-демократ үндсэн эрхийн тухай ойлголтыг жишээн дээр тайлбарлана.
- Социал-демократ энх тайван-аюулгүй байдлын бодлогын зарчмуудыг боловсруулна.
- Социал-демократ энх тайван-аюулгүй байдлын бодлогын түүхэн замналын тэмдэглэгээнүүдийг танилцуулна.
- Социал-демократ энх тайван-аюулгүй байдлын бодлогын луужингийн саналыг боловсруулна.

Хоёрдугаар бүлэгт танилцуулсан энх тайван, аюулгүй байдлын бодлогын онолууд ба ойлголтууд дээр суурилсан социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужинг хэрхэн тодорхойлох вэ?

Энэ бүлэгт уншигчид өөрсдийн байр суурийг тодорхойлоход тус болох нэг саналыг боловсруулна.

Социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужин социал-демократ үнэт зүйлсээс эх авч үндсэн эрхүүд дээр суурилах нь тодорхой. 3.1 ба 3.2 бүлэгт дайн ба энх тайвны бодлогод үнэт зүйлс ба үндсэн эрхүүдийн ач холбогдлыг нарийвчлан тодорхойлно. 3.3-р бүлэгт социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын зарчмуудыг тодорхойлно. 3.4-р бүлэгт социал-демократ оролцогч талуудын бодлогын энэ талбар дээр гаргасан шийдвэрлэх шийдвэрүүд болон эдгээр шийдвэрүүдийг хэрхэн хэлэлцсэн талаар ярилцана. Эндээс гарсан эргэцүүллийг 3.5-р бүлэгт нэгтгэн дүгнэнэ.

Луужин: нэг санал

Дараа нь 3.6-р бүлэгт дэлхий дахины өнөөгийн энх тайван, аюулгүй байдлын бодлогыг тоймлон харуулна.

3.1. Үнэт зүйлс

Социал-демократ
үнэт зүйлсийн
гурвал

Эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдэл нь социал-демократ үзлийн үнэт зүйлс юм. Эдгээр үнэт зүйлс нь улс төрийн бодит байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд, нийгмийг илүү сайн сайхан болгох төсөөллийн масштаб, үйл ажиллагааны чиг баримжааг тогтоогч юм. Энд эдгээр гурван үнэт зүйлс нь нэгдмэл байдлыг бүрдүүлдэг. Үнэт зүйлс нь ижил үнэлэмжтэй, хэрэгжих нөхцөлөө харилцан бүрдүүлж, харилцан хамгаалж, харилцан нөхөж байдаг. Үнэт зүйлсийн энэ гурвал нь олон улсын бодлогод социал-демократ бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үндсэн хүрээг тогтоож байдаг.

Эрх чөлөө

Эрх чөлөө: Өөрийн
хүссэнээр амьдрах

Эрх чөлөө нь өөрийн хүссэнээр амьдрах боломжтой байх гэсэн утгатай. Эдгээр үнэт зүйлсийг дэлхий дахинд хүний улс төрийн эрхүүд, иргэний эрхүүдийн хэлбэрээр олон улсын хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрч хэрэгжилтийг нь хангасаар байна.

1948 оны 12-р сарын 10-нд НҮБ-ын ерөнхий ассамблейн хуралдаанаас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүний эрхийн хэрэгжүүлэх чиглэлд хийсэн нэгэн чухал алхам юм. Уг тунхаглалын 1-р зүйлийн 1-д:

“Бүх хүмүүс эрх чөлөөтэй, ижил алдар хүнд, эрхтэй төрдөг. Бүх хүмүүс оюун ухаан, зүрх сэтгэлийг өвлөн төрдөг, тэд хоорондоо ахан дүүсийн санаагаар учрах ёстой.”

(ГСДН-ын Берлиний хөтөлбөр 1989 он, Доубе\ Клотцбахын ишлэл 2004 он, 361-р хуудас)

Дэлхий дахинд хүний эрх хэрэгжихгүй байх нөхцөлд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх онцгой ач холбогдолтой. Өнөөдрийг хүртэл хүний эрхийн түгээмэл тунхаглал нь НҮБ-ын хамгийн хүчтэй, нөлөөтэй баримт бичигт тооцогддог. Олон улс орнууд үндсэн хуулиа боловсруулахдаа хүний эрхийн түгээмэл тунхаглалаас санаа

авсан байдаг. Дээрээс нь хүний эрхийг хамгаалах тухай олон тооны, олон талт гэрээ хэлэлцээрүүд хүний эрхийн түгээмэл тунхаглалаас эхтэй байдаг.

Германы социал-демократууд ямагт, ахин дахин ХЭТТ дээр тулгуурлан бодлогын бичиг баримтаа боловсруулдаг. Үүний нэг жишээ бол ГСДН-ын Хамбургийн хөтөлбөр юм.

“Хүний эрхийн түгээмэл тунхаглалд чөлөөтэй, ижил алдар хүнд, эрхтэй хэмээн тунхагласан ёсоор хүн бүр хүмүүний хамтын нийгэмлэгийн дунд өөрийн хүссэнээр амьдрах нөхцөлөөр хангагдсан байх ёстой.”

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 14)

Шударга ёс

Эрх чөлөөтэй харьцуулахад шударга ёс нь харьцангуй ойлголт. Хувь хүний халдашгүй байдал гэх мэт эрх чөлөөний тодорхой эрхүүдийг тодорхой нөхцөл байдлаас төдийлөн хамааралгүйгээр тодорхойлж болно. Шударга ёс нь ямагт материаллаг болон материаллаг бус үйлчилгээ, нөөц, оролцооны боломжийн асуудалтай холбогддог. Шударга хуваарилалтын тухай асуудал нь иймээс юуг хуваарилах юм? Хэнд хуваарилах юм бэ? гэдгээс байнга, шууд хамаардаг.

Улс үндэстний дотоодод хүйсийн тэгш эрх, нийгмийн, эрх зүйн шударга ёс зэрэг шударга ёсны төрөл бүрийн хэлбэрийг улс төрийн зорилтууд хэмээн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг, гэхдээ эдгээр нь улс хоорондын үйлчилгээнд хариуцлага хүлээлгэх үндэслэл болдоггүй. Шударга ёс нь улс хоорондын харилцаанд тодорхойлогч үүрэг гүйцэтгэдэггүй. Иймээс жишээ нь: аль нэг улсын хөгжлийн хамтын ажиллагааны салбарт оруулах хувь нэмэр эцэстээ сайн дурын зарчим дээр суурилдаг.

Хэдийгээр НҮБ-аас хүний хамгийн чухал эрхүүдийг хамгаалах ёстой олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийн олон улсын пакт (ICESCR), иргэний болон улс төрийн эрхүүдийн хүний эрхийн пакт (ICCPR)-ыг соёрхон баталсан ч бүх улс үндэстнүүд эдгээр пактуудыг бүрэн хэрэгжүүлдэггүй. Сурах бичгийн Даяаршил ба

Дэлгэрүүлэн унших:
Нийгмийн ардчиллын
сурах бичгийн 1-р
дэвтэр, Нийгмийн
ардчиллын үндсүүд,
2-р бүлэг Үнэт зүйлс
Кристиан Крелл ба
Майк Войке (2015 он),
Социал-демократ
үзэл баримтлалын
үнэт зүйлс, Түүхэн
үүсэл хөгжил ба улс
төрийн ач холбогдол

Нэн тэргүүнд:
Хуваарилалтын
асуудлууд

Дэлгэрүүлэн унших:

Социал-демократ
үзэл баримтлалын
сурах бичгийн 7-р
дэвтэр Даяаршил ба
социал-демократ үзэл
баримтлал, 4-р бүлэг
Нийгмийн шударга ёс
ба даяаршил

социал-демократ үзэл баримтлал сэдэвт 7-р дэвтэрт дэлхий дахины шударга ёсны талаар гүнзгий хэлэлцсэн.

Хэдэн арван жилийн өмнөөс социал-демократ үзэлд шударга ёсны асуудлууд олон улсын бодлогод чухал ач холбогдолтой болсон. Билли Брандтын удирдаж байсан Хойд-Өмнөдийн комисс болон 1989 онд батлагдсан Берлиний хөтөлбөр үүнийг батална.

“Аж үйлдвэржсэн ба хөгжиж буй орнууд хооронд тэнцвэрт байдлыг тогтоохгүй бол нийт хүн төрөлхтний ирээдүйд аюул учрах болно. Өлсгөлөн, зовлон ноёлсон газарт энх тайван тогтвортой байх боломжгүй.”

(Берлиний хөтөлбөр, 1989 он, Дуал Клотцбах нарын ишлэл: 365-р хуудас)

“2000 онд дэлхийн хүн амын томоохон хэсэг нь ядуу хэвээрээ байгаа нь бодит аюул юм. Дэлхийн хүн ам дэлхийн даац хэтрэх хэмжээнд хүртэл өсөж магадгүй, хотжилтын хэмжээ хэвийн хэмжээнээс давна гэдэгт эргэлзэх хэрэггүй. Бидний дэлхийн иргэншил гэж нэрлэдэг иргэншлийн үндэс суурийг шинэ, том дайн сүйрүүлчихдэггүй юм гэхэд өлсгөлөнгийн гамшиг, сүйтгэлийн аюул тохиолдох магадлал улам нэмэгдсээр байна.”

(Хойд-Өмнөд илтгэл, 1979 он)

Эв санааны нэгдэл

Бусдын төлөө сайн дураараа хариуцлага хүлээх болон бусадтай ижил зорилгын төлөө хамтран ажиллахад бэлэн байдлыг эв санааны нэгдэл гэнэ. Эв санааны нэгдэл нь нэгэн үнэлэмж бөгөөд энэ үнэлэмжийн санаагаар хүмүүс хуулиар зохицуулсан зохицуулалтаас давуулан нэг нь нийтийнхээ төлөө, нийт нь нэгнийхээ төлөө байдаг.

Олон улсын харилцаанд олон асуудлыг зохицуулдаг, бодитойгоор хэрэгждэг эрх зүйн зохицуулалт байдаггүй. Эдийн засаг, худалдаа, санхүү, технологи, хөгжлийн хамтын ажиллагааны асуудалд олон улсын эв санааны нэгдлийг хангахад бэлэн байдал нь дэлхийн

Эв санааны
нэгдэл: нэг нь
нийтийнхээ
төлөө, нийт нь
нэгнийхээ төлөө

өнцөг булан бүрд зовлон зүдүүр, өлсгөлөн, ядуурлын улмаас зовж байгаа хүмүүсийн хувьд амин чухал юм.

Олон улсын эв санааны нэгдлийн хүрээнд дорд үзэгдэн амьдарч буй хүмүүсийг хамгаалах нь зөвхөн социал-демократ үзлийн хүний тухай ойлголт төдийгүй гадаад, аюулгүй байдлын бодлогын маш тодорхой шалтгаанууд бий. Зөвхөн сүүлийн жилүүдийн туршлага: нийгмийн нөөцүүдээс хувь хүртэх боломж тэгш бус байх нь зөрчилдөөн, хүчирхийллийн шалтгаан болдог гэдгийг ахин дахин харуулж байна.

“Бүх ард түмний дэлхийн хангалуун чинээлэг амьдралаас тэгш хувь хүртэх эрх хангагдсан байх ёстой. Хөгжиж буй орнууд бусад ард түмнээс эв санааны нэгдэлтэй байхыг шаардах эрхтэй.”
(Годесбергийн хөтөлбөр 1959 он, Доуабел/Клотцбах нарын ишлэлд 2004 он, 327-р хуудас)

Дэлгэрүүлэн унших:
Социал-демократ
үзэл баримтлал сурах
бичгийн 1-р дэвтэр,
3-р бүлэг, Үндсэн
эрхүүд

3.2. Үндсэн эрхүүд

Үнэт зүйлс нь хийсвэрлэлийн маш өндөр түвшний ойлголт юм. Үндсэн эрхүүдээс эх авч тодорхой бодлого боловсруулахад хүндрэлтэй. Дээрээс нь эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдлийн үнэт зүйлсийг төрөл бүрийн урсгалууд өөр өөрөөр тайлбарладаг.

Иймээс улс төрийн үйл ажиллагааг үнэт зүйлсээс илүү өргөн, заавал хэрэгжих суурин дээр боловсруулан хэрэгжүүлэх нь илүү утга учиртай. Дэлхий дахины түвшинд энэхүү суурийг юуны өмнө хүний эрхийн түгээмэл тунхаглал, олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийн пакт болон иргэний, улс төрийн эрхүүдийн пакт бүрдүүлж байдаг. НҮБ-ын эдгээр баримт бичгүүдэд тусгасан үндсэн эрхүүд нь социал-демократ гадаад, аюулгүй байдлын бодлогын зарчмуудыг тодорхойлох чухал баганууд юм.

Эдгээр нь түгээмэл буюу соёл ба улс орнуудын хил хязгаар дамнасан, олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичгүүд юм. Юуны өмнө НҮБ-ын хүний эрхийн пактууд нь хүн бүрийн хүний

Үндсэн эрхүүд:
үнэт зүйлсээс
илүү, заавал
хэрэгжүүлэх
шаардлага
өндөртэй.

Хүний эрхийн
түгээмэл
тунхаглал-ХЭТТ

НҮБ-ын пактууд

эрхийг маш тодорхой, нарийн тодорхойлсон ч одоогийн байдлаар хувь хүмүүс болон хамт олон эрхүүд хэрэгжээгүй нөхцөлд шүүхээр заргалдахад маш хүндрэлтэй байгаа юм.

Гэхдээ энд ч гэсэн дэвшилд хүрсэн. Аймаглан устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг өдүүлэх, дайны гэмт хэргүүдийг шүүдэг олон улсын эрүүгийн шүүх байгуулагдсан. Энэ шүүх нь одоогоор асуудалтай байгаа бөгөөд жишээ нь, зөвхөн африкийн иргэдийг мөрдөөд байна гэдэг гомдолтойгоор африкийн олон орон гишүүнчлэлээс нь гарсан. (Тулл\Вебертэй харьцуулаарай. 2016 он)

Европын төвшинд Европын Холбооны хүний эрхийн харта ба Европын хүний эрхийн конвенц, товчилсон нэр нь: ЕХЭК, эдгээр хоёр баримт бичигт хүний үндсэн эрхүүдийг тусгасан байдаг.

ЕХЭК-нд 1950 оны 11-р сарын 4-нд үүсгэн байгуулагч 10 орон, эдгээрийн дотор ХБНГУ ба Турк улс гарын үсэг зурсан.

1953 оны 9-р сард уг конвенц хүчин төгөлдөр болсон бөгөөд тэр цагаас хойш 14 нэмэлт протокол батлагдаад байна. Ингэснээр үндсэн ба эрх чөлөөний эрхүүдийг анх удаа олон улсын эрх зүйд хувь хүний эрхүүд хэрэгжээгүй нөхцөлд шүүхээр заргалдах боломжтой хуулийн хэлбэрт оруулан баталсан. Энэхүү конвенц нь юуны өмнө хувь хүн бүрийн амьдралыг төрийн хөндлөнгийн оролцооноос хамгаалах, хамгаалагдах эрхийн цуглуулга юм. Хамгаалагдах эрхэд шашин шүтэх эрх чөлөө (9-р зүйл), үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө (10-р зүйл), эрүүдэн шүүлтийг хориглох (3-р зүйл) багтдаг. Европын хүний эрхийн конвенцын хэрэгжилтэд Штрассбург хотноо төвтэй европын дээд шүүх хяналт тавьж байдаг.

Европын зөвлөл нь 1949 онд байгуулагдсан, Европын Холбооноос хараат бус олон улсын байгууллага юм. Иймээс Европын зөвлөлийг Европын Холбооны нэг байгууллага болох Европын зөвлөлөөс ялгаж өгөх хэрэгтэй. Европын зөвлөлийг европчууд европын асуудлаа хамтдаа хэлэлцдэг нэгэн чуулган гэж ойлгох нь зүйтэй. Тус зөвлөл нь өнөөгийн байдлаар 47 гишүүнтэй, өөрөөр хэлбэл Европын Холбооноос өөрөөс нь илүү өргөн гишүүнчлэлтэй байгууллага юм.

Германы канцлер Герхард Шройдерийн удирдлага дор 1999 оны 6-р сард Кёльн хотноо болсон төр засгийн тэргүүн нарын уулзалтаас Европын Холбооны хартыг боловсруулах тухай тогтоол батлагдсан. 2000 онд Низза хотно Европын холбооны хүний үндсэн эрхийн харта батлагдсан. Европын хүний эрхийн конвенцын үндсэн эрхийн хартаас ялгаатай нь зөвхөн төрийн хөндлөнгийн оролцооноос хамгаалагдах эрхүүд бус, харин сурч боловсрох эрх (14-р зүйл), эсвэл хөдөлмөрлөх эрх (15-р зүйл) зэрэг боломж олгох буюу төрөөс дэмжлэг хүртэх эрхүүдийг багтаадаг. Үндсэн эрхүүдийн хартууд батлагдсанаар Европын холбооны түвшинд анх удаа заавал хэрэгжүүлэх үндсэн эрхүүдийг өргөн хүрээтэй бичмэл хэлбэрээр баталсан юм.

ХЭТТ ба НҮБ-ын пактуудын нэгэн адил Европын хүний эрхийн конвенц ба үндсэн эрхүүдийн хартуудын эрх зүйн нөлөөлөл хязгаарлагдмал бөгөөд германы үндсэн хуульд тусгасан үндсэн эрхүүдийн германы эрх зүйн систем дэх ач холбогдолтой харьцуулах боломжгүй юм.

Гэсэн хэдий ч хууль ёсны хүчин төгөлдөр байдал болон бодит нөлөө хоёрын хоорондох ангальг даван туулах, НҮБ-ын пактууд ба европын бичиг баримтуудад тодорхойлсон үндсэн эрхүүдийн ач холбогдлыг дээшлүүлэх нь социал-демократ эрхийн шаардлагад нийцнэ.

3.3. Энх тайван, аюулгүй байдлын бодлогын зарчмууд

Зарчим гэдгийг германы хэлний тайлбар толь Дүүденд хүмүүс өөрийн сэтгэлгээ ба үйл ажиллагааны удирдамж болгодог хатуу тогтсон журам хэмээн тайлбарласан байдаг. Социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын зарчмууд нь эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдлийн үнэт зүйлсээс эхтэй. Эдгээр зарчмууд нь зөвхөн социал-демократ намын хөтөлбөрийн текстэд төдийгүй улс төрийн тодорхой үйл ажиллагаанд тусгалаа олсон байдаг.

Дэлгэрүүлэн унших:
Хүний эрхийн дээд
комиссарын газар
/2016 он/, Эрт
сануулах ба эдийн
засаг, нийгэм, соёлын
эрхүүд, Хүний эрхийн
дээд комиссарын
газар, (Эрхлэн
гаргасан) Нью Йорк.

НҮБ ба ФЭС-гийн
хамтран эрхлэн
гаргасан (2016
он), Хүний эрх, энх
тайван, аюулгүй
байдалд суурилсан
илтгэл, Олон улсын
энх тайван, аюулгүй
байдлын өндөр
түвшний сэдэвчилсэн
хэлэлцүүлгийн
бэлтгэл ажил 2016
оны 5-р сар, Женев
хот

Тодорхой нөхцөл байдлаас үл хамааран нэрлэх боломжтой социал-демократ гадаад- аюулгүй байдлын бодлогын зарчмууд байдаг уу?

Таван зарчим

Бид энэ асуултад хариулт өгөх, хэлэлцүүлгийг тодорхой бүтцийн дагуу явуулах, эдгээр зарчмуудын хүрээнээс хальсан хэлэлцүүлэг хийхэд сэдэл өгөх зорилгоор доорх таван зарчмыг тодорхойллоо.

1. **Хууль ёсны байдал**, өөрөөр хэлбэл гадаад-аюулгүй байдлын үйл ажиллагааг өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын эрх зүй буюу олон улсын эрх зүйн гэрээний хүрээнд явуулах. (Жишээлбэл: НҮБ-ын хүний эрхийн харта)
2. **Хамтын ажиллагаа**: Дэглэмүүдэд тодорхой бодлогын талбар дээр тодорхой эрх ба үүрэг ногдуулах заавал баримтлах бүтцүүдийг бий болгох (Жишээ нь: НАТО- Цөмийн зэвсгийн хаалтын гэрээ, НҮБ-хүний эрхийн пактууд)
3. **Олон улсын эв санааны нэгдэл**: Бусдын төлөө сайн дураараа хариуцлага хүлээх, ижил зорилгын төлөө бусадтай хамтран ажиллахад бэлэн байдал. Дэлхий дахины өнөөгийн нөхцөлд нэн ялангуяа улс хоорондын эдийн засаг, худалдаа, санхүү, технологийн хамтын ажиллагааны хэлбэрээр болон хөгжлийн хамтын ажиллагаанд эв санааны нэгдлийн үнэт зүйл чухал үүрэг гүйцэтгэдэг.
4. **Урьдчилан сэргийлэх**: Энх тайван ба тогтвортой байдлыг хангахын тулд цаг хожимдсон хойно хөндлөнгөөс оролцохын оронд цагийг нь олсон, зорилтот хөрөнгө оруулалт хийх. Энэ санаа 2004 онд Холбооны улаан, ногооны эвслийн засгийн газраас баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Иргэний арга хэрэгслүүдээр дайнаас урьдчилан сэргийлэх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг тогтворжуулах” бүлэгт тусгасан. 2017 онд холбооны засгийн газраас “Хямралд хүргэхгүй байх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг дэмжих” удирдамжийг үйл ажиллагааны төлөвлөгөөний залгамжлагч болгон баталсан.
5. **Зэвсэг хураах ба намжмал байдал**: Дипломат бодлогыг ямагт хүчирхийллээс илүүд үзэх, ямагт зэвсгийн экспортын хязгаарлагдмал бодлогын төлөө байх, энэ нь хямралтай газар нутгууд руу зэвсэг экспортлохгүй байх гэсэн санаа.

Дэлгэрүүлэн унших:

Герд Вайскиршен

(2009 он), Нийгмийн

ардчилал ба Гадаад-

болон аюулгүй

байдлын бодлого,

Фридрих-Эбертийн

Сангийн онлайн

академи

Ролф Мютцинх

(2017 он), Нийгмийн

ардчиллын

Гадаад-ба аюулгүй

байдлын бодлогын

параметерууд, Шинэ

нийгэм\Франкфуртын

дэвтрүүд сэтгүүлийн

2017 оны №9, 30-34-р

хуудас

Хэлэлцүүлэгт:

Өдгөө эдгээр зарчмууд дээр үндэслэн ямар тодорхой зорилтуудыг тодорхойлох боломжтой вэ? 2017 оны 7-р сард ГСДН-ын дарга Мартин Шүлц, Гадаад хэргийн сайд Сигмар Гавриел нар Хамбург хотноо хуралдсан Их 20-ийн дээд хэмжээний уулзалтыг тохиолдуулан “Энх тайван, шударга ёсгүй бол бүх юм үнэ цэнэгүй. Олон улсын хамтын ажиллагааны шинэ үеийн таван зорилт” гарчигтайгаар доорх зорилтуудыг тодорхойлсон юм.(Шүлц\Гавриел 2017 он харьцуулаад үзээрэй)

1. Европын Холбоо ба НҮБ-ыг бэхжүүлэх: Зөвхөн Их 20-ын тогтолцоонд найдахын оронд жинхэнэ европын хамтын аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогыг эрхэмлэх, НҮБ-ыг бэхжүүлэх ёстой гэсэн үг.
2. Илүү хүчтэний давуу эрхийн оронд олон улсын эрхийг бэхжүүлэх: Хамгаалалтын илүү өндөр стандартуудтай орчин үеийн худалдааны хэлэлцээрүүд, хөгжлийн хамтын ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон улсын эрхийн бүрэн хэрэгжилтийг сайжруулах ёстой гэсэн үг.
3. Дэлхий дахинд зэвсэглэлээр хөөцөлдөхийн оронд зэвсэг хураах идэвх санаачилгыг өрнүүлэх: Зэвсэглэлээр хөөцөлдөх автоматизмаас татгалзах, зэвсэглэлд тавих хяналтыг чангатгах, мөн Европын холбоо ба НАТО-аас гадуурх орнууд ба бусад ижил төстэй орнуудад жижиг зэвсгийн экспортыг хориглох, автомат зэвсгийн системүүдийг жигших.
4. Орчин үеийн энх тайвны дипломат бодлого ба дайнаас урьдчилан сэргийлэх бодлогыг эрчимжүүлэх: Жишээлбэл энх тайвны албаны санхүүжилтийг нэмэгдүүлэх, энх тайвны иргэний корпус байгуулах, ойрх дорнодод энх тайвны процессыг дахин сэргээх, 2030 мянганы хөгжлийн зорилтууд ба НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх (SDG) гэсэн үг.
5. Дэлхий дахины цаг уурын бодлогын шинэ боломжуудыг дэмжих ба ашиглах: Аж үйлдвэржсэн орнуудаас ядуу орнуудын цаг уурын хамгаалал, дасан зохицох бодлогын хэрэгжилтэд туслах санхүүжилтийг 2020 он хүртэл 100 тэрбум ам.доллар хүртэл жил бүр нэмэгдүүлэх амлалтаа биелүүлэхийг шаардана гэсэн үг.

Энэ бичиг баримтад бусад олон тодорхой саналуудыг тусгасан. Та ямар асуудлуудыг илүү чухал гэж үзэж байна?

Дэлгэрүүлэн унших:

Холбооны засгийн газар (2017 он),
Хямралд хүргэхгүй байх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг дэмжих.
Холбооны засгийн газрын удирдамжууд, Берлин хот

Дэлхий дахины төрийн бодлогын хүрээлэл (2017 он),
Холбооны засгийн газрын удирдамжийн процессыг дагалдах блог, 2016 оны 7-р сараас 2017 оны 6-р сар, www.peace-ab2016.de.

Мариус Мюллер Хенниг (2015 он),
Хяналтын ном-дипломат арга хэрэгсэл мөн үү?
Зэвсэг нийлүүлэлтийн цаад талд германы хүлээх хариуцлага:
Гурван санал: IPG-сэтгүүл 2014 оны 8-р сарын 25-нд Берлин хотноо нийтлэгдсэн.

3.4. Түүхэн замнал

Социал-демократ гадаад, аюулгүй байдлын бодлогын ойлголт нь эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдлийн үнэт зүйлс дээр суурилдаг. Эдгээр үнэт зүйлс дээр суурилсан, салбар дундын үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг өмнөх бүлэгт тодорхойлсон. Энэхүү бүлэгт тодорхой шийдвэр гаргалтын үйл явцыг авч үзэх болно.

Энд үнэлэмжүүд дээр суурилсан энх тайван, аюулгүй байдлын маш тодорхой шийдвэрүүдийг гаргаж байсан, түүхэн эргэлтийн цэгүүдийг танилцуулах болно. Эдгээр нь зарим талаар ширүүхэн маргаан, хэлэлцүүлэг хийж байсан, заримынх нь талаар өнөөг хүртэл түүхчид маргасаар байгаа түүхэн үйл явдлууд юм.

Шийдвэрүүдийг тодорхой хөтөлбөрүүдэд хамруулахын тулд дараагийн хоёр хуудсан дээр ГСДН-ын мөрийн хөтөлбөрүүдийн энх тайван, аюулгүй байдлын бодлогын хөгжлийн хураангуйлсан тоймыг танилцуулах болно.

Эндээс өнгөцхөн харахад нүдэнд шууд тусах зүйл нь он цагийн эргэлтэд шинээр асуудал урган гарч эдгээрт хариулт өгөх шаардлагатай болдог нь тодорхой харагдана. Эдгээр шийдвэрт мөн тухайн үеийн түүхэн нөхцөл байдал тод мөр үлдээсэн байдаг.

НҮБ эсвэл НАТО зэрэг байгууллагуудад гишүүнээр элсэхийг дэмжих, эсвэл татгалзах шаардлага жишээлбэл эхлээд эдгээр байгууллагуудын үүсгэн байгуулагдсаны дараа тавигддаг. Харин 1921 онд батлагдсан Гоерлитцийн хөтөлбөрт Үндэстнүүдийн ардчилсан холбоо байгуулах саналыг дэвшүүлсэн байдаг.

Холбооны армийг гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулах эсэх тухай асуудал нь 1989 оны Берлиний хөтөлбөрт буюу хоёр Герман улс дахин нэгдэхээс өмнө чухал сэдэв биш байсан бол 2007 онд батлагдсан Хамбургийн хөтөлбөр энэ асуудалд хариулт өгсөн.

Дэлгэрүүлэн унших:

Мартин Херкенделл

(2012 он), Герман:

Иргэний, эсвэл энх

тайвны гүрэн байх

уу? ГСДН-ын гадаад,

аюулгүй байдлын

бодлогын чиг

баримжаа хувьсан

өөрчлөгдөж байна.

(1982-2007 он), Ж.Х.

Диетц хэвлэлийн

газар, Бонн хот

Үүний зэрэгцээ тухай үеийн маргаантай асуудлуудад өмнөх хөтөлбөрүүдээр өгсөн хариулт өнөөдрийг хүртэл хангалттай хэвээрээ байна. Жишээ нь: 1959 оны Годесбергийн хөтөлбөрөөр эх орноо батлан хамгаалахад “тийм” гэдэг хариулт өгсөн.

Түүхэн үйл явдлуудын тухай ярилцлагаар тухайн үеийн нөхцөл байдал ямар байсныг, мөн энх тайван, гадаад бодлогын шийдвэр гаргалтад найдаж болох бодлогын луужин ямар чухал вэ? гэдгийг харуулах болно. 3.5-р бүлэгт бодлогын луужингийн зураглалыг хэрхэн гаргах талаар нэгэн санал дэвшүүлэх болно.

3.4.1. Дайны зээлүүд: 1870 он

АСУУЛТ

Социалдемократ намаас нэр дэвшин сонгогдсон Хойд германы рейхстагийн гишүүд дайны зээлийг дэмжсэн санал өгөх ёстой юу?

НӨХЦӨЛ БАЙДАЛ

1870\71 оны герман-францын дайн: Хойд германы рейхстагт цөөн тооны социалдемократ гишүүд сонгогдсон байлаа.

ДЭМЖИХ ШАЛТГААНУУД

“Лассаллианер буюу Лассаллиан болон Маркс, Энгельсийг дэмжигчид: Наполеон 3-р хааны удирдлага дор довтлон ирсэн Францын довтолгооноос хамгаалах дайн

ТАТГАЛЗАХ ШАЛТГААНУУД

Август Вебел, Вильгелм Лиевкнэхт болон бусад: Язгууртнуудын хоорондын дайн болохоос олон улсын ажилчдын эрх ашгийг хамгаалахын төлөөх дайн биш

ШИЙДВЭР\ ҮР ДАГАВАР

Социалдемократ гишүүдийн дийлэнх нь татгалзсан санал өгсөн ч дайны зээлүүдийг зөвшөөрсөн, Социалдемократуудыг “эх оронгүй хөвгүүд” хэмээн зэмлэн буруушаасан.

Германы Социалдемократ намын мөрийн хөтөлбөрийн
энх тайван-аюулгүй байдлын бодлогын санаануудын тойм

	Эйзенахын хөтөлбөр (1869 он)	Готаурын хөтөлбөр (1875 он)	Эрфуртын хөтөлбөр (1891 он)	Гоерлитцерийн хөтөлбөр (1921)
Олон улсын эв санааны нэгдэл	Олон улсын ажилчны хөдөлгөөний нэгэн хэсэг Хүн төрөлхтний ахан дүүсэг байдал	Олон улсын ажилчны хөдөлгөөний нэгэн хэсэг Хүн төрөлхтний ахан дүүсэг байдал	Олон улсын ажилчны хөдөлгөөний нэгэн хэсэг	Ажилчин ангийн олон улсын холбоо
Эх орноо батлан хамгаалах	Байнгын армийн оронд цэргийн алба хаах үүрэг	Байнгын армийн оронд цэргийн алба хаах үүрэг	Цэргийн алба хаах үүрэг	-
Цэргийн тухай шийдвэрийг парламент гаргах	-	-	Дайн ба энхийн тухай шийдвэрийг парламент гаргана.	-
Олон улсын эрх зүй	-	-	Маргааныг маргаан таслах шүүхээр тасална.	Олон улсын маргааныг шүүхээр шийдвэрлэнэ.
Зэвсэг хураах ба зэвсэглэлд хяналт тавих	-	-	-	Олон улсад зэвсэг хураах
Коллектив аюулгүй байдал	-	-	-	Үндэстнүүдийн холбоогоор дамжуулан олон улсын өмнө хүлээсэн үүргийг албадан биелүүлэх
Колониализм\ хөгжлийн хамтын ажиллагаа	-	-	-	Ард түмнүүдийн өөрсдөө шийдвэр гаргах эрх
Олон улсын байгууллагууд	-	-	-	Үндэстнүүдийн ардчилсан холбоо
Гадаадад цэргийн ажиллагаанд оролцох	-	-	-	-
Хөгжлөөр буурай орнууд	-	-	-	-

Хайделбергийн хөтөлбөр (1925)	Годесбергийн хөтөлбөр (1959)	Берлиний хөтөлбөр (1989)	Хамбургийн хөтөлбөр (2007)
Ажилчин ангийн олон улсын холбоо	Ардчилсан социализм нь олон улсын хамтын ажиллагаа, эв санааны нэгдлийн сэтгэлгээгээр илэрхийлэгддэг.	Гуравдагч орнуудын иргэд хүний ёсоор амьдрах боломжоор хангагдах ёстой.	Дэлхийн эдийн засгийн дэглэмийг илүү шударга болгож, түншлэлд суурилсан хөгжлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх
Эзэнт улсын армийг Бүгд найрамдах улсын нэгэн найдвартай байгууллага болгон өөрчлөн зохион байгуулах	Улс орноо хамгаалахад за гэж хэлнэ.	Холбооны арми улс орноо хамгаалах, дайнаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй.	Улс орноо хамгаална, гэхдээ дотоодод цэрэг оруулахгүй, цэргийн алба хаах үүрэгт илүү сайн дурын байдлыг дэмжинэ.
–	Зэвсэгт хүчин парламентын хяналтын дор байна, Цэрэг бол цэргийн формтой иргэн	Холбооны арми Бундестагийн хяналтын дор байна, Цэрэг бол цэргийн формтой иргэн	Цэргийн ажиллагаанаас өмнө Бундестагаас мандат авах хэрэгтэй.
Олон улсын маргааныг шүүхээр шийдвэрлэнэ.	Олон улсын эрх зүй нь энх тайвны баталгаа болох ёстой.	НҮБ-ыг хүчирхийллээс ангид дэлхийн дотоод бодлогын хэрэгсэл болгон өргөтгөнө.	Дэлхий дахины эрх зүйг бий болгон хэрэгжүүлнэ, олон улсын шүүхүүдийг бэхжүүлнэ.
Олон улсад зэвсэглэл хураах	Олон улсад зэвсэг хураана, ХБНГУ бөөнөөр нь устгах зэвсэггүй байна.	Бөөнөөр нь устгах зэвсгийг устгана, зэвсэглэлийг хураана, бүтцийн довтолгооны чадамжгүй байдал, Сансрын уудмыг зэвсгээс ангид байлгана, герман бөөнөөр нь устгах зэвсэг үйлдвэрлэхгүй, герман бөөнөөр нь устгах зэвсэггүй байна.	Зэвсэг хураана, зэвсэглэлд хяналт тавина, сансрын уудмыг зэвсгээс ангид байлгана, дэлхий нийтээрээ цөмийн зэвсэггүй байна, герман бөөнөөр нь устгах зэвсэг үйлдвэрлэхгүй, зэвсгийн экспортод хяналт тавина.
Үндэстнүүдийн холбоог энх тайвны бодлогын нөлөө бүхий хэрэгсэл болгон өргөжүүлэх	Эрх мэдлийн хэрэгсэл бүхий эрх зүйн систем байгуулах замаар улс орноо хамгаалах шаардлага байхгүй болгоно.	Европын ямар ч орон болзошгүй сөргөлдөгчөөс илүү аюулгүй байх боломжгүй.	Оршихуйн чухал асуудлуудыг хүн төрөлхтөн зөвхөн хамтдаа шийдвэрлэж чадна.
Колоничлогч ард түмнүүдийн дарлалын эсрэг тэмцэх шийдвэрийг ард түмэн өөрсдөө гаргана.	Хөгжиж буй орнуудтай эв санааны нэгдэлтэй байна.	Дэлхийн эдийн засгийн шинэ бөгөөд шударга дэглэм, урт хугацааны хөгжлийг бүх улс оронд боломжтой болгох	Дэлхийн эдийн засгийн дэглэмийг илүү шударга болгож түншлэлд суурилсан хөгжлийн хамтын ажиллагааг явуулах
Европын нэгдсэн улс, ардчилдаг үйл явц, үндэстнүүдийн холбоо	НҮБ өөрт тавигдаж буй эрхэд суурилсан шаардлагыг хангадаг байх ёстой. Нийт европын энх тайвны дэглэм	НҮБ-ын үйл ажиллагааны чадамжийг дээшлүүлэх, Европын нэгдсэн улс, НАТО-д гишүүнчлэлтэй байх (хамгаалах, намжмал байдалд шилжихэд бэлэн байх), Социалист Интернационал	НҮБ-ыг өргөтгөх, НАТО-г шинэчлэх, Европын зөвлөл ба Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны байгууллага үлгэр жишээ болох нь, Европын нэгдсэн улс, Социалист Интернационал, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
–	–	–	НҮБ-ын мандат ба Бундестагийн зөвшөөрөлтэйгээр, Нэгдсэн үзэл баримтлалын хүрээлэл дунд
–	–	–	Доройтож мөхөж буй орнуудыг дахин сэргээх

*Нөхцөл байдал:
Герман-францын
дайн 1870\1871 он*

1870\71 оны Герман-Францын дайн нь испанийн хааны угсаа залгамжлагчийн талаар Прусс ба Франц хооронд гарсан хэрүүлийн нэгэн үр дагавар байлаа. Хойд германы рейхстагийн социалдемократ гишүүд дайны зээлийг зөвшөөрсөн, дайн ба энхийн асуудлаар маргаан үүсгэсэн юм.

*Бодлого,
хөтөлбөрт
тавигдаж байсан
шаардлагууд*

Гадаад, батлан хамгаалахын бодлого 1860-аад онд үүсэн хөгжиж байсан эхэн үед социалдемократ үзэл баримтлалд чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Бодлого-хөтөлбөрийн шаардлагуудыг дотоод бодлогын туршлага дээрээ суурилан боловсруулсан юм. Цэрэг, зэвсэгт хүчин ажилчны хөдөлгөөнийг нухчин дарахад чухал үүрэг гүйцэтгэж байлаа. Социалдемократууд байнгын зэвсэгт хүчний оронд ард түмний хамгааллыг нэвтрүүлэхийг номлож байв. Ард түмний хамгааллыг “бүх нийтийн сонгуулийн эрхтэй дүйцнэ” хэмээн үзэж байлаа.

1875 оны Готауерийн хөтөлбөрт зөвхөн ард түмэн буюу ард түмний төлөөлөл дайн ба энхийн тухай шийдвэр гаргадаг байхыг шаардаж байв. Ардчилсан орнуудын нийгэм дайн хийх сонирхолгүй гэдэгт найдвар тавьж байсан юм.

Социалдемократууд цаагуураа улс гүрнүүд хоорондын хэрүүл маргааныг таслах үүрэг бүхий “Олон улсын маргаан таслах шүүх”-ийг байгуулах зорилго тавьж “Эрх мэдлийн бодлогын оронд олон улсын эрх зүй” гэдэг уриа дор үйл ажиллагаа явуулж байлаа.

Хэдийгээр алсын зорилго нь “Бүх хүмүүсийг ахан дүүсэг болгох”-од чиглэгдэж байсан ч ГСДН нь дайныг эсэргүүцэгч нам байгаагүй. Тэд эх орноо хамгаалах дайныг нээлттэй дэмжиж байлаа. Герман-францын дайн хамгаалах дайн байсан уу? гэдэгт өгөх үнэлгээ дээр асуултад социал-демократууд хоорондоо санал зөрөлдөж байжээ.

*ГСДАХН ба ГАНХ
хоорондын санал
зөрөлдөөн*

Германы Социалдемократ ажилчны хөдөлгөөний намын (ГСДАХН) Вильгелм Лиевкнэхт, Август Вэбель нар дайны зээлийн эсрэг санал өгсөн. Тэд язгууртнууд хоорондын дайн ажилчдын эрх ашигтай ямар ч хамаагүй гэж үзэж байлаа.

Германы ажилчдын нэгдсэн холбооны (ГАНХ) төлөөлөгчид ба ГСДАХН-ын Рэйхстагийн гишүүн Фриче дайны зээлийн төлөө саналаа өгсөн. Франц, Прусс дайн зарласан учраас Германы ажилчдын нэгдсэн холбоо намын гишүүд “лассилланчууд” (Лассиллан нь ГСДАХН-ын анхны даргын нэр бөгөөд гишүүд нь түүний нэрээр нэрлэсэн) энэ дайныг хамгаалах дайн хэмжээн үзэж байлаа. Тэдний энэ байр суурийг Маркс, Энгельс болон бусад хүмүүс дэмжиж байлаа. Тэд францын эсрэг дайн нь тухайн үед үзэн ядагдаж байсан гуравдугаар Наполеоныг түлхэн унагах боломж хэмээн үзэж байлаа.

1870 оны 9-р сард Седанд францууд ялагдал хүлээсний дараагаар хоёр тал ойртож эхэлсэн юм. Тэд дайн германы талын хувьд хамгаалах шинж чанараа гэсэн гэдэг итгэл үнэмшлийг олж Эрласс-Лотерингенийг хүчээр нэгтгэхийг эсэргүүцэж байв.

Дэлгэрүүлэн унших:
Сурах бичиг,
Нийгмийн ардчиллын
түүх, 3-р бүлэг

3.4.2. Дайны зээлүүд 1914 он

АСУУЛТ

Германы Бундестагийн социал демократ гишүүд дайны зээлийг зөвшөөрсөн санал өгөх ёстой юу?

НӨХЦӨЛ БАЙДАЛ

1914 онд дэлхийн нэгдүгээр дайн дэгдсэн. Тэр үед ГСДН-ын бүлэг Рейхстагт хамгийн хүчирхэг бүлэг байлаа.

ДЭМЖИХ ШАЛТГААН

Хьюго Хаазе болон бусад гишүүд: Улам бүр дайсагнаж буй хаант Оросоос улс орноо хамгаалах дайн, дахиад эх оронгүй хөвгүүд хэмээн доромжлуулах бий “Социалистуудын хууль”-ийн дор амьдарч байсан үеийнх шиг үйл ажиллагааг нь хориглож дарлах бий гэдэгт санаа зовох (1878-1890)

ТАТГАЛЗАХ ШАЛТГААН

Карл Лиевкнхт болон бусад гишүүд: Интернационализм, зарчмын хувьд энх тайвны чиг баримжаа, ажилчин анги дайны эсрэг

ШИЙДВЭР ҮР ДАГАВАР

Рейхстагийн социал-демократ гишүүдийн дийлэнх нь зөвшөөрсөн санал өгсөн, эцэст нь дайны зээлийг зөвшөөрсөн, Нам ГДСДН ба ГХБСДН хоёр намд хуваагдсан.

Асуудал
дахин шинээр
тавигдсан: Дайны
зээлийг дэмжсэн
санал өгөх үү?

Эцэст нь:
Ажилчны
хөдөлгөөн
хуваагдсан.

1914 оны 7/8-р сард дайны зээлийн асуудал социал-демократуудын маргааны гол сэдэв болон дахин босож ирсэн. Эдгээр маргаан намын түүхэн замналд хар мөр үлдээсэн.

Дайны зээлийн маргаан маргаан эцэстээ 1917 онд ГСДН-ыг Германы дийлэнх социалдемократуудын нам ГДСДН болон Германы Хараат Бус Социалдемократ Нам ГХБСДН гэдэг хоёр намд хуваагдахад хүргэсэн.

ГСДН нь удаан жилийн туршид энх тайвны төлөө нам гэдгээ тодорхой илэрхийлж байсан. ГСДН дайныг эсэргүүцсэн том жагсаалыг хамтран зохион байгуулж байжээ. Гэтэл тус нам Герман улс дэлхийн нэгдүгээр дайнд оролцох зардлыг санхүүжүүлэх зээлийг зөвшөөрөх үү? үгүй юу? гэдэг асуулттай тулгарсан юм.

Хөрөнгөтнүүд дайнд хөөрсөн сэтгэлээ барьж дийлэхгүй байгаа мэт харагдаж байлаа. Дайнд германы цусан өшөөт дайсан Франц, Их Британийг ялна гэдэг нь олон хүний хувьд үндэсний бахархлын асуудал байлаа.

Харин ГСДН-ын сонгогчдын дийлэнх нь 1914 оны 7-р сар хүртэл дайнд оролцоно гэдэгт тэтгэлээ сэтгэлийн хөөрөлд автагдсангүй. Ажилчид дайн үр дагаварт айж тэдний эдийн засгийн оршихуйд аюул учируулах вий гэдгээс айж байлаа. Дайнд оролцсоны төлөө тэдний төлөх төлөөс элитүүдийнхээс өндөр байна гэдгийг таамаглаж байлаа.

Тухайн үед ГСДН сая гаруй гишүүнтэй хамгийн том нам төдийгүй Рейхстагт 110 гишүүнтэй хамгийн том намын бүлэг байв. Рейхтагийн гишүүдийн дунд дайныг эрс эсэргүүцэгчээс дайныг дэмжигч хүртэл өөр өөр байр суурийг баримтлагчид байлаа.

ГСДН-ын байр
суурь маргаантай
байлаа.

ГСДН-ын зарим дэмжигчид тэдний дунд Роза Люксенбург улам бүр дайсагнагч байр суурийг баримтлагч хаант засаглалт оросын эсрэг хамгаалах дайн зарласныг дэмжиж байлаа. Эцэст нь хамгаалах дайн зарлахыг дэмжигчид дийлсэн. Үүний зэрэгцээ социал-демократууд

дайны зээлийг дэмжсэн санал өгснөөрөө “Тэд эх орончид биш, харин “эх оронгүй хөвгүүд” гэдэг зэмлэлийг няцааж чадсан.

ГСДН-ын тухай үеийн дарга Хюүго Хаазе нэгдүгээр дайныг германыг хүчээр татан оролцуулсан түрэмгийлэх дайн гэж үнэлээд олон улсын тогтоолын дагуу аливаа ард түмэн үндэсний бие даасан байдал, өөрийгөө хамгаалах эрхтэй гэдгийг онцолж байлаа. Тэр энэ дайнаар эрх чөлөөг мөн хамгаална гэдэгт итгэлтэй байлаа. Харин бусад нь ГСДН дайны зээлийг зөвшөөрснөөрөө эх орноосоо урвасан хэмээн үнэлж байлаа.

Рейхстаг дах бүх намын бүлгүүд дайны зээлийг дэмжсэн санал өгснийг “цайзын энх тайван” хэмээн тодорхойлсон байдаг. 1914 оны зун тун удахгүй ялалт байгуулна гэдэгт итгэсэн олон зуун мянган хүн сайн дураараа фронтод бүртгүүлсэн.

Дайн удаан үргэлжлэхийн хэрээр сэтгэл санааны байдал ч өөрчлөгдсөн. 12-р сарын 2-нд ГСДН-аас Карл Лиевкнэхт дайны шинэ зээл олгох шийдвэрийн эсрэг санал өгсөн анхны социал-демократ гишүүн болсон юм. Нэгдүгээр дайны цаашдын явцад ГСДН-ын олон нийтийн өмнө нээлттэйгээр дайныг эсэргүүцсэн үг хэлсэн рейхстагийн гишүүдийн тоо нэмэгдсээр байлаа.

Дайны зээлийг дэмжих эсэх тухай маргаан даамжирсаар эцэст нь Карл Лиевкнэхтийг намын гишүүнээс хөөсөн юм. 1917 онд ГСДН нь Германы Социал-Демократ Дийлэнхийн Нам-ГСДН, Хараат Бус Социал-Демократуудын Нам-ГХБСДН гэдэг хоёр намд хуваагдсан. 1918 онд ГХБСДН-аас дахиад Спартакийн холбоо өрх тусгаарласан. 1922 онд ГХБСДН-ын хэсэг ГСДН-д дахин нэгдсэн бол гишүүдийн олонх нь Спартакийн холбоондоо үлдэж улмаар 1919 онд бусад бүлэглэлүүдтэй хамтран 1919 онд коммунист намыг үүсгэн байгуулсан.

Үүгээр ажилчны хөдөлгөөн эргэж буцалтгүйгээр хувьсгалч (коммунист), ба шинэчлэлд чиглэсэн (социал-демократ) намд хуваагдсан юм. Дэлхийн нэгдүгээр дайны дараа ГСДН Фридрих-Эбертийн удирдлага дор анх удаа засгийн эрх баригч нам болж Ваймарын Бүгд Найрамдах Улсын суурийг тавьж эхэлсэн.

*Олонхын
саналаар;
Зөвшөөрсөн*

1917 он: Хуваагдал

*Дэлгэрүүлэн унших:
Нийгмийн ардчиллын
түүх сурах бичиг, 4-р
бүлэг*

ГСДН-ын намын хуваагдалтай холбоотой, хожим нь засгийн эрхийг барих хариуцлагатай холбоотой гаргасан шийдвэрүүд нь намын түүхэн замналд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн үйл явдлууд байлаа. Эдгээр шийдвэрүүд нь тус нам дайныг эсэргүүцэх болон бодит бодлогын байр суурийг баримтлах болно гэдгийг эртнээс харуулсан.

3.4.3. Дахин зэвсэглэлийн тухай хэлэлцүүлгүүд 1949-1955

АСУУЛТ

Германы Бундестагийн гишүүд ХБНГУ-ын дахин зэвсэглэхийг дэмжих санал өгөх үү?

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дайны дараах үе ба хүйтэн дайны эхлэл тавигдаж байх үед ГСДН сөрөг хүчин байлаа.

ДЭМЖИХ ШАЛТГААН

Христосын Ардчилсан Холбоо Нам ХАХН: Аюулгүй байдалд зүүнээс ирж буй заналхийлэлд дахин зэвсэглэл ба барууны холбоосоор хариулт өгөх, дахин зэвсэглэлийг улс төрийн тэгш байдлыг хангах нэгэн алхам хэмээн үзэж байлаа.

ТАТГАЛЗАХ ШАЛТГААН

ГСДН: Дахин зэвсэглэснээр Герман дэлхийн гуравдугаар дайны цохилтын талбар болно, дахин зэвсэглэл германы хуваагдлыг цементлэн гагнах болно, нийгэмд байгаа дайныг эсэргүүцэгч хүчирхэг урсгалд анхаарал хандуулахгүй байна.

ШИЙДВЭР\ҮР ДАГАВАР

ГСДН эхний ээлжид дахин зэвсэглэлийг эсэргүүцээд амжилт олохгүй байлаа. Олон дахин сонгуульд ялагдал хүлээсний дараагаар гадаад, аюулгүй байдлын бодлогын үзэл баримтлалаа шинэчилсэн нь 1959 онд батлагдсан шинэ чиг баримжаанд тусгалаа олсон байдаг.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа социал-демократ намын ирээдүйд

баримтлах бодлогын чиг хандлагыг барууны гурван бүсэд бэхэлж өгсөн улс төрч бол Күрт Шүмахер байлаа. Дайны дараах эхний жилүүдэд аюулгүй байдлын эргэцүүллүүд цэвэр дайныг эсэргүүцсэн үзлээр илэрхийлэгдэж байлаа. “Дахин хэзээ ч дайн эхлүүлэхгүй!”

“Дахин хэзээ ч дайн эхлүүлэхгүй” гэдэг лозунг 1918 онтой харьцуулахад 1945 оны үед ГСДН-ын ухамсарт илүү гүн бат шингэсэн байлаа. Дэлхийн хоёрдугаар дайны аймшигт туршлагаас үүдэлтэйгээр Германы аюулгүй байдал зөвхөн бүх улсуудын олон улсын эв нэгдлээр коллектив аюулгүй байдлын системийн хүрээнд хангагдах боломжтой гэдэг таамаглал дээр суурилж байсан цаг. (Бусзилоувски 1973 он, 52-р хуудас)

Үүний цаана улс хоорондын асуудлыг дахин дайнаар шийдвэрлэхгүй байх гэдэг найдвар агуулагдаж байлаа. ГСДН-ын зорилго нь “Зэвсэглэлийг нийтээрээ бүрэн хураах” -ад чиглэгдэж байлаа.

ГСДН ийм ч учраас 1949 оны 12-р сард Холбооны канцлер Конрад Аденаурын эхлүүлсэн дахин зэвсэглэх тухай хэлэлцүүлэгт маш тодорхой эсрэг байр суурь баримталж байлаа. ГСДН-ын Бундестаг дах бүлгийн дэд дарга Эрих Олленхауер ГСДН дахин зэвсэглэх талаар бодож үзэхээс ч татгалзаж байна гэж тайлбарласан байдаг. ГСДН-ын зүгээс харахад европын батлан хамгаалахын нийгэмлэгийн хүрээнд эрмэлзэж буй дахин зэвсэглэл үүнээс үүдэлтэй Барууны холбоос нь германы дахин нэгдэлд саад болох аюулыг дагуулах эрсдэлтэй байлаа.

Христосын-либерал засгийн эрхийг баригч намууд эсрэгээрээ европын армийг байгуулах нь баруун германы улс төрийн эрх тэгш байдлыг дахин сэргээх, транс-атлантын холбоонд ойртох боломж хэмээн үзэж байлаа.

ГСДН дахин зэвсэглэлийн эсрэг коллектив аюулгүй байдлын систем байгуулах санаа бүхий гадаад бодлогын эсрэг төслөө боловсруулсан. Сонгодог цэргийн холбооноос ялгаатай нь юуны өмнө цэргийн хоёр эвсэл хоёулаа уг холбоонд нэгдэх ёстой байлаа.

„Nie wieder Krieg!“

*ГСДН дахин
зэвсэглэлээс
татгалзаж
байлаа.*

*ГСДН: коллектив
аюулгүй байдал*

Холбооны засгийн газар эцэст нь өөрийн төсөөллийг хэрэгжүүлж чадсан юм. 1952 оны 5-р сарын 26, 27-нд Европын батлан хамгаалах нийгэмлэгийн гэрээнд герман гарын үсэг зурсан. Германы гэрээ ёсоор ХБНГУ-ын эзэмшлийн бүсүүдийн статусыг хүчингүй болгож Германд дотоод ба гадаад тусгаар тогтнолыг нь дахин олгох ёстой байлаа.

Гэвч 1952 оны тавдугаар сард Германы гэрээг соёрхон баталж байх үед францын үндэсний хурал европын батлан хамгаалах нийгэмлэгийн гэрээнээс татгалзсан юм. Ингэснээр зөвхөн европын батлан хамгаалах нийгэмлэгийн гэрээ төдийгүй германы гэрээ ч хүчин төгөлдөр болж чадаагүй юм. 1955 он гэхэд германы гэрээний өөрчлөгдсөн хувилбар батлагдаж, ХБНГУ тусгаар тогтнолоо дахин олж авсан. Мөн тэр жилд Герман НАТО-д гишүүнээр элссэн.

ГСДН Германы гэрээг зарчмын хувьд эсэргүүцээгүй юм. Тус нам мөн ирээдүйн батлан хамгаалах бодлогын талаар ярилцахад ч бэлэн байлаа. Социал-демократуудын хувьд германы дахин нэгдэл хамгийн чухал зорилт байсан учраас дахин зэвсэглэл ба барууны холбоос уг зорилтод саад учруулна хэмээн үзэж байлаа.

ГСДН дахин нэгдэх байр суурин дээр хатуу зогсож байсан нь тус намын гадаад бодлогын тоглолтын оройн зайг хумьж байлаа. ХАХН\ХНАХН ГСДН-ыг засгийн эрх барих чадамжгүй хэмээн шоолж байлаа. 1957 оны сонгуульд дахин ялагдал хүлээсэн нь тус намыг бодлогын чиг баримжаагаа өөрчлөхөд хүргэсэн юм. Холбооны германы батлан хамгаалахад оруулах хувь нэмрийг хүлээн зөвшөөрснөөр бодлого хөтөлбөртөө анхны шанг татаж олон нийтийн анхаарлыг татсан юм.

Годесбергийн хөтөлбөр батлахдаа тус намын гадаад, аюулгүй байдлын бодлогын зорилтуудын эрэмбэ дараалал бүрмөсөн өөрчлөгдсөнийг тунхагласан юм. ГСДН Аденаурын засаглалын үед тогтсон барууны холбооны бодит байдлыг хүлээн зөвшөөрсөн. 1960 онд “Дахин нэгдлээр аюулгүй байдлаа хангана” гэдэг томъёоллоосоо бүрмөсөн татгалзсан. Ингэснээр ГСДН христосын ардчилагчидтай ойртоход тулгарч байсан саадыг нэг мөр үгүй хийж Чөлөөт Ардчилсан Намтай холбогдох гүүрээ тавьж чадсан.

*Годесбергийн
хөтөлбөрөөр
бодлогын шинэ
чиг баримжаагаа
тунхагласан.*

3.4.4. 1960-аад оноос зүүний шинэ бодлогыг баримталж эхэлсэн.

АСУУЛТ

Германы ХБНГУ ба БНАГУ-д хуваагдсан хуваагдмал байдалд намжмал байдлын бодлогоор хариулт өгөх нь зүйтэй юу?

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Герман улс дэлхийн хоёрдугаар дайны дараа ХБНГУ ба БНАГУ-д хуваагдаж уг хуваагдлыг 1961 оны 8-р сарын 13-нд Берлиний хана барьснаар цементлэн бэхэлсэн юм. Зүүн ба Барууны хооронд хүйтэн дайны байдал ноёлсон.

ДЭМЖИХ ШАЛТГААН

ГСДН: Билли Брандт “Эгон Баар нар: “Ойртлоор хувьсалд”

ТАТГАЛЗАХ ШАЛТГААН

ХАХН: Намжмал байдал нь Зүүн германы газар нутгийн үүрэг гэсэн утгатай. Намжмал байдлын оронд хязгаарлах бодлого

ШИЙДВЭРҮҮР ДАГАВАР

ГСДН үзэл баримтлалаа социал-либерал эвслийн засгийн газрын үед хэрэгжүүлсэн. Билли Брандт энх тайвны нобелийн шагнал хүртсэн. ГСДН 1972 оны сонгуульд ялалт байгуулж анх удаа хамгийн хүчирхэг нам болсон. Шинэ гишүүд олноороо ГСДН-д элссэн.

Эгон Баар (1922-2015 он) аж үйлдвэрийн худалдаачны мэргэжил эзэмшиж хожим нь сэтгүүлч болон бусад мэргэжлээр ажиллаж байсан. Тэрээр Билли Брандтын “Зүүний шинэ бодлого”-ын шийдвэрлэх сэтгэгч болон хамтран боловсруулагчдын нэг байлаа. Баар 1960-1966 онд Брандтыг Берлин хотын дарга байхад хэвлэлийн төлөөлөгчөөр нь ажиллаж байв. Тэдний хамтын ажиллагаа олон хэлбэрээр цаашид үргэлжилсэн юм. Брандтын тэргүүлсэн засгийн газрын кабинетэд Баар 1972-1974

Баар 1963 оны 7-р сарын 15-нд Евангелийн академи дээр болсон хэлэлцүүлэгт тавьсан илтгэлдээ “Хувьслаар дамжуулан ойртох” гарчиг өгсөн юм. Түүний энэ илтгэл зүүний шинэ бодлогын төрсний гэрчилгээ нь болох ёстой байлаа. Баарын хувьд “Ойртлоор дамжуулан

*Эгон Баар
“Ойртлоор
хувьсалд”*

хувьсалд хүрэх” бодлого нь Зүүн ба Барууны хоорондын статус квог даван туулахын тулд эхний ээлжид энэ статусыг өөрчлөхгүй байх ёстой хэмээн үзэж байлаа. Социал-демократ гадаад бодлогын зорилго нь зүүн ба барууны нийгмийн системүүдийг урт хугацаанд ойртуулах, европт энх тайвны дэглэмийг удаан хугацаанд тогтооход чиглэгдэж байлаа. ГСДН “Аюулгүй байдал” ба “Намжмал байдал”-ын зарчмуудаар эдгээр зорилтод хүрэхийг эрмэлзэж байлаа.

онд холбооны тусгай үүрэгт сайдаар, хожим нь Шмидтийн кабинетад (1974-1981) онд эдийн засгийн хамтын ажиллагааны сайдаар тус тус ажиллаж байсан. Баар 1976-1981 онд ГСДН-ын холбооны үйл ажиллагаа эрхэлсэн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан.

Эгон Баар ба Билли Брандт нар “Ойртлоор хувьсалд” үзэл баримтлалаараа ХАХН-ын хязгаарлах бодлогын эсрэг хаалттай, логикийн хувьд нотлогдсон, шинжлэх ухааны үндэслэлтэй төслийг боловсруулсан юм.

“Хэлэлцээр”,
“Эвлэрэх”,
“Ойртох”

Брандт, Баар нар “Ойртлоор хувьсалд” үзэл баримтлалаа урт хугацаанд хэрэгжүүлнэ, хэрэгжилт нь “хэлэлцээрт орох”, “эвлэрэх”, “ойртох” гэдэг түлхүүр үгсээр тодорхойлогдоно хэмээн үзэж байлаа. Ингэснээр социалдемократ гадаад, аюулгүй байдлын бодлогын чиг хандлага олон талаар НАТО-гийн улс төрийн шинэ чиг хандлагатай нийцэж байлаа. Нэн ялангуяа АНУ-ын ерөнхийлөгч Жон, Ф, Кеннеди 1962 оны Кубын хямралын дараа намжмал байдлыг тогтоохын төлөө ихээхэн хүчин чармайлт гаргаж байсан үе.

НАТО-гийн шинэ чиг баримжааны өмнөх замыг

Хязгаарлах бодлого нь Зөвлөлт Холбоот Улс ба коммунист үзэл санааны нөлөөг дэлхий дахинд бууруулах, шаардлагатай бол цэргийн хүч хэрэглэх /жишээ нь Вьетнамд/ зорилготой холбоотой байлаа. Хязгаарлах бодлого нь холбооны герман улсын гадаад бодлогод **Халлштайны номлолын** агуулгаар тод тусгагдсан байлаа. ХБНГУ Халлштайны номлолоор гадаад бодлогын хүрээгээ тогтоож 1955-1969 онд гадаад бодлогоо тодорхойлж байжээ. Уг номлол ёсоор тухайн үеийн БНАГУ-тай дипломат харилцаа тогтоогч орнуудад ХБНГУ хориг арга хэмжээ авна гэдэг санааг агуулж байсан. Тэгэхлээр уг номлол БНАГУ-ыг гадаад бодлогын талбар дээр тусгаарлах, германыг гадагшаа төлөөлөх цор ганц орон бол ХБНГУ юм гэдэг шаардлагыг хэрэгжүүлэх зорилготой байлаа.

заасан Хармелийн илтгэл гэж нэрлэгддэг баримт бичигт дараах хоёр зорилтыг тодорхойлсон. Нэгдүгээрт цэргийн хүч ба улс төрийн эв нэгдлийг хангалттай хэмжээнд байлгах, хоёрдугаарт: энэ нь төмөр хөшигний ард байгаа улсуудад намжмал байдлыг эрхэмлэ гэдэг нэгэн шинэ, тодорхой сигнал өгсөн.

ГСДН зүүний бодлогын эхний давлагааг 1966 оноос их эвслийн үед үүсгэж чадсан. Гэхдээ зүүний бодлого их эвслийн хүрээнд ямагт дотоод зөрчилдөөнд хүргэдэг байлаа.

1969 онд Германы социал-демократ нам ба Германы чөлөөт ардчилсан намын (либерал) - социал-либерал эвсэл байгуулагдсанаас цагаас хойш гарааны нөхцөл сайжирсан. Засгийн эрхийг авснаас хойш цөөн хэдэн сар өнгөрч байхад социал-либерал эвсэл “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх” гэрээнд гарын үсэг зурж шинэ саналууд дэвшүүлсэн юм.

Үүний зэрэгцээ ХБНГУ-д сэрэмжтэй ханддаг зүүн европын орнуудын эргэлзээг арилгаж чадсан. Мөн сонгуулийн дараа зүүний бодлого хурдан хугацаанд хүчээ авсан. Дээрээс нь дэлхийн бодлогын бүтэц тааламжтай байдлыг бий болгосон нь мөн нөлөөлсөн. 1969 оны 3-р сард хилийн ойролцоох Уссури гол дээр болсон зөвлөлт-хятадын удаа дараагийн тэмцэл, Чехословакид болсон үйл явдлуудаас үүдэлтэй Москвад сэтгэлгээний өөрчлөлт гарсан юм. 1969 оны 12-р сард ХБНГУ ба тухайн үеийн ЗХУ хооронд эхний ярилцлагууд болж өнгөрсөн.

Хоёр тал хоёулаа Москвагийн гэрээгээр сүрдүүлэх, хүч хэрэглэхээс татгалзах тухай болон “Өнөөгийн хилийн зурвасуудаар хязгаарлагдаж буй европын бүх улсуудын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг аливаа хязгаарлалтгүйгээр хүндэтгэнэ” гэдэг ойлголцолд хүрсэн.

Улмаар ХБНГУ нь дээрхтэй төстэй агуулга бүхий гэрээг Польш, Чехословак, БНАГУ-тай байгуулахад бэлэн, эдгээр гэрээ нь Москвагийн гэрээтэй нийлээд нэгдсэн гэрээ байх боломжтой хэмээн үзэж байгаагаа илэрхийлсэн юм.

*1966 оноос Эхний
давлагаа*

*1969 оноос
социал-либерал
эвсэл*

1970 он:
ХБНГУ-ЗХУ-ын
гэрээ

Сөрөг хүчин, консерватив намыг дэмждэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, эх орноосоо хөөгдөгсдийн холбооны зүгээс зарим талаар хатуу шүүмжлэлд өртөж байсан ч 1970 оны 8-р сарын 12-нд Москва хотноо ХБНГУ ба Зөвлөлт Холбоот Улс хоорондын гэрээнд Билли Брандт, Леонид Брежнев нар гарын үсэг зурсан. Москвад болсон ярилцлагуудын зэрэгцээ төрийн нарийн бичгийн дарга Георг Фердинанд Дуквитц 1970 оны 2-р сараас Варшавтай хэлэлцээр хийж эхэлсэн.

1970: ХБНГУ-
БНАГУ хоорондын
дээд хэмжээний
уулзалт

Мөн герман, германы харилцаанд холбооны канцлер Брандт, БНАГУ-ын ерөнхий сайд Билли Стоп нар Эрфурт, Кассел хотноо дээд хэмжээний уулзалт хийж 1970 оны 3 ба 5-р сард түүхэнд шинэ хуудас нээсэн юм.

1970 он:
Варшавын гэрээ

1970 оны 12-р сарын 7-нд Варшавын гэрээ нэрээр түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн гэрээнд гарын үсэг зурсан. Гэрээний үндсэн хэсэг болох 1-р зүйлд хоёр улс “өнөөгийн хилийн шугам” нь Польшийн ард улсын баруун хилийн шугам байна гэдэг дээр тохиролцсон. Үүнээс гадна гэрээний түншүүд “Өнөөгийн хилийн шугамын халдашгүй дархан байдлыг одоо ба ирээдүйд хамгаална.” хэмээн хүлээн зөвшөөрсөн.

1970 он:
Брандтын өвдөг
сөгдөлт

Мөн тэр өдөр Билли Брандт Варшавын Геттогийн амь эрсэдсэн босогчдын дурсгалын хөшөөний өмнө өвдөг сөгдсөн юм. Брандтын энэ өвдөг сөгдөлт түүний зүүний бодлогын бэлэг тэмдэг болох ёстой байлаа. Олон социалдемократууд, гаднын хүмүүст түүний өвдөг сөгдөлт 20-р зууны түүхтэй холбон авч үзэхэд социалдемократ ижил төстэй ба ялгамж чанар ба социалдемократ байр суурийн бэлэг тэмдэг байлаа.

Брандтын өвдөг сөгдөлтийн талаар өнөөдөр хэн ч маргахгүй боловч 1970 гэхэд германчууд ийм хуваагдмал байдалд байсан юм. Мэдээллийн “Толь” сэтгүүлээс явуулсан санал асуулгаар санал асуулгад оролцсон хүмүүсийн 48% нь Брандтын биеийн хэлэмжийг хэтрүүлсэн гэж үзсэн бол 41% нь зохистой гэж үзсэн байна. Хэдийгээр хилийн дээсийг эцэслэн тогтоохыг хожим болсон энх тайвны бага хурал хүртэл хойшлуулсан боловч үүгээр зүүн германы

нутаг дэвсгэрээс эргэлт буцалтгүйгээр татгалзсан гэдэг үзэл ноёлж байлаа.

Брандт энд нууц задруулсан зүйл байхгүй шүү гэдгийг сануулж “Аль хэдийн алдагдсан боломж байгаагүй. Бид боломжийг хажуугаараа өнгөрүүлээгүй. ХБНГУ-д улс төрийн хариуцлага хүлээж байгаа бид болон, өмнө нь хүлээж байсан улс төрчид ч боломжийг хажуугаараа өнгөрүүлээгүй. Харин гэмт хэрэгтэн дэглэм, үндэсний социалистуудын үгүй хийсэн боломж.” гэж хэлсэн.

1971 онд нобелийн энх тайвны шагналыг Билли Брандтад гардуулсан нь түүний эвлэрлийн бодлогыг олон улсад өндрөөр үнэлсний бодит илэрхийлэл юм. Нобелийн энх тайвны шагналтан зүүний бодлогоороо дэлхий дахины хүндэтгэлийг хүлээж ХБНГУ-ыг олон улсад дахин нэр нөлөөтэй болоход тус болсон. 1972 оны 11-р сарын 19-нд болсон Бундестагийн сонгуулиар ГСДН нь ХБНГУ-ын түүхэнд анх удаа 45.8%-ийн санал авч хамгийн хүчтэй нам болсныхоо дараагаар гадаад, Германы бодлогын асуудлаар бүх ард түмний санал асуулга явуулсан юм.

Зүүний гэрээнүүд болон “Суурийг тавьсан гэрээ” гэрээгээр ХБНГУ ба БНАГУ хоорондын харилцааны суурь тавигдаж хоёр орны харилцааг болгоомжтойгоор хэвийн байдалд оруулах чухал алхмууд хийгдсэнээс хойш холбооны социал-либерал эвслийн засгийн газар олон талт харилцааны түвшинд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлаас хаалтын гэрээ батлагдсан нь түүхэн чухал үйл явдал юм.⁸

*1971 он:
Нобелийн энх
тайвны шагналыг
Брандтад олгосон*

*Суурийг тавьсан
гэрээ ба Европын
аюулгүй байдал
ба хамтын
ажиллагааны бага
хурлаас баталсан
хаалтын гэрээ*

8 Энэ номын Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага 5-р бүлэг

3.4.5. Югославын задрал ба түүний үр дагавар: Босниен (1992-1995) ба Косовогийн Дайн (1998-1999 он)

АСУУЛТ

Улаан, ногооны эвслийн холбооны засгийн газар ба Бундестагийн олонх НАТО-гийн “Эвссэн хүч” ажиллагаанд герман оролцохыг дэмжсэн санал өгөх нь зүйтэй юу?

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Косовод иргэний дайн гарсан. Энх тайвныг хангахын төлөө гаргасан хичээл зүтгэл бүтэлгүйтсэн.

ДЭМЖИХ ШАЛТГААН

Герхард Шройдер\Эрхард Эппле болон бусад: Хүмүүнлэгийн гамшигт хүрэхээс сэрэмжлэн зайлуулах, Үнэнч холбоотон байх, германы тусгай замнал гэж байхгүй, маргаан дагуулсан “Тахны төмөр төлөвлөгөө”

ТАТГАЛЗАХ ШАЛТГААН

Олон улсын эрх зүйн дагуу хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал дутмаг агаарын довтолгоо нь зохистой хэрэгсэл биш. НҮБ-ыг байгууллагын хувьд сулруулна.

ШИЙДВЭРҮР ДАГАВАР

Дэлхийн хоёрдугаар дайны дараа анх удаа германы цэргүүдийг дайнд оролцуулахаар илгээсэн. Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх үзэл баримтлалууд анхаарлын төвд орж ирсэн.

*Дайн Европт
эгэн ирэв.*

Олон хүмүүс хоёр герман улс энх тайвнаар нэгдэж мөн Зүүн Барууны зөрчил төгсгөл болсны дараа урт хугацааны энх тайвны үе эхэлнэ гэдэгт найдаж байлаа. Энэ найдвар урам хугарлаар солигдов. Үүний хоёр жишээ: 1991 оны Гольфийн булангийн дайн ба Руандад аймаглан устгасан дайн. Харин Югослав улс задарсны нөлөөгөөр 1991 онд дайн дахиад европ руу эргэсэн юм.

ГСДН-д эдгээр болон бусад зөрчилдөөний үед холбооны арми оролцох уу? Оролцвол ямар хэлбэрээр оролцох вэ? гэдэг асуудал маргаантай байлаа. Намын гишүүдийн дийлэнх ба намын удирдлага холбооны армийг цэнхэр дуулгатнуудын ажиллагааны хүрээнд оролцохыг дэмжиж, харин НАТО, НҮБ, Баруун европын холбооны хүрээнд байлдааны ажиллагаанд оролцуулахаас татгалзаж байлаа. Бодит бодлогын жигүүр засгийн газрын үйл ажиллагааны чадамжтай холбогдуулан холбооны армийг байлдааны ажиллагаанд оролцуулах зөвшөөрөл олгохын тулд үндсэн хуулийн өөрчлөлт хийх нь зүйтэй хэмээн үзэж байлаа.

Гадаад, аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх зөв замыг тодорхойлохын төлөөх агуулгын тухай додоодын маргаанаас болоод социал-демократ нам бодлогын энэ талбар дээр 1990-ээд оны дунд үеийг хүртэл гацаанд ороод байлаа. Харин 1994 оны 7-р сарын 12-нд холбооны үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гарснаас хойш хатуу байр суурин дээрээ хөшиж орхисон фронтууд хөдөлгөөнд орж эхэлсэн. Холбооны армийг гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулахын эсрэг зарчмын эсэргүүцэл эхлээд Бундестаг дах намын бүлгийн төвшинд арилав. Карлсрүү-гийн буюу үндсэн хуулийн шүүхийн шүүгч нар холбооны армийн цэргүүдийг НАТО, НҮБ-ын хүрээнд гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулах нь германы үндсэн хуулийн 24-р зүйлийн дагуу үндсэн хуульд нийцэж байна гэдэг шийдвэрийг гаргасан. Дээрээс нь цэцийн энэ шийдвэр холбооны армийн зэвсэглэсэн зэвсэгт хүчнийг гадаадад цэргийн ажиллагаанд оруулахаас “Парламентын цааргалах эрх”-ийг баталгаажуулсан юм. Холбооны армийн цэргүүдийг гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулахад парламентын зөвшөөрөл авах ёстой учраас холбооны армийг “парламентын арми” ч гэж нэрлэдэг.

1998 онд ГСДН Холбоотон 90\ Ногоон намтай эвслийн засгийн газар байгуулсны дараагаар энх тайван, аюулгүй байдлын бодлогын өргөн хүрээтэй, алсыг харсан шийдвэр гаргах ёстой болсон юм. Дээр үеийн Югославт Сербийн Бүгд Найрамдах Улсын бүрэлдэхүүнд байсан Косовогийн эргэн тойронд зөрчилдөөн ноцтой хурцадсан юм. НҮБ-ын аюулгүй байдлын зөвлөл Косовод явуулах цаашдын ажиллагааны талаар нэгдсэн шийдэлд хүргэх гээд чадаагүй. Орос НҮБ-ын аюулгүй байдлын зөвлөлд хориг тавьснаар Сербийн эсрэг

*1994 он:-Холбооны
үндсэн хуулийн
шүүхийн шийдвэр*

*1998 он: Холбооны
улаан, ногооны
эвслийн засгийн
газар*

цэргийн ажиллагаа явуулах НҮБ-ын боломжийг хааж орхисон юм.

1999 он: НАТО-
гийн ажиллагаа

1999 оны 2-р сард Рамбоуиллит ба Парисын бага хурлууд бүтэлгүйтсэний дараагаар Косовогоос албаничуудыг хүч хэрэглэн хөөн гаргасантай холбогдуулан НАТО НҮБ-ын мандатгүйгээр ажиллагаа явуулах шийдвэрт хүрсэн. Ингэснээр 1999 оны 3-р сарын 24-нд Сербийн эсрэг НАТО-гийн цэргийн ангиудыг оруулсан “Эвссэн хүч” нэртэй НАТО-гийн ажиллагааг эхлүүлсэн.

Эцэстээ Косовогийн цэргийн ажиллагаа олон улсын хамтын нийгэмлэгийг бүхэлд нь ГСДН-ыг ч хүнд байдалд оруулсан. Нэг талаас олон улсын эрх зүйд аливаа орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглодог, нөгөө талаас үйл ажиллагаа явуулахгүй байна гэдэг нь хүний эрхийн ноцтой зөрчлийг хүлцэнэ гэсэн үг юм.

Эргэлтийн цэг

Социал-демократ намын түүхэнд энэ хөндлөнгийн оролцоо нэгэн чухал эргэлтийн цэг тавьсан. Холбоотнуудаа үнэнч байхын зэрэгцээ шинээр сонгогдсон засгийн газар олон улсад тусгаарлагдаж орхих бий гэдэг болгоомжлолоос үүдэн шийдвэр гаргагчид шийдвэр гаргалтад моралын буюу зан суртахууны хариуцлага гэдэг нэгэн шалтгааныг нэмсэн юм. Гэсэн ч балканы хойгийн бодлогын асуудлаар намын их хурлаас шинэхэн батлагдсан тогтоолууд болон эвслийн гэрээ хоорондоо зарим талаар зөрчилдөж байлаа. Зөвхөн НҮБ-ын мандатаар Герман цэргүүдийг цэргийн ажиллагаанд оролцуулна хэмээн заасан байлаа.

Дэлгэрүүлэн унших:

“Хөндлөнгөөс

оролцохгүй байх уу?

эсвэл хамгаалах уу?

Энэ номын 7.4-р бүлэг

Моралын үндэслэл нь энд сүүлийн жилүүдэд маш их хичээл зүтгэлийн хүчинд арайхийн босгосон гадаад бодлогын хүрээг тогтоон барьж байх холбогч материалын үүрэг гүйцэтгэж байлаа. Хэдийгээр НАТО-гийн Косовод явуулсан үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж байсан ч дийлэнх олонх нь Герхард Шройдер, Рудолф Шарпинг нарын бодлогын чиг баримжааг дэмжиж байлаа. Ингэж олонхын дэмжлэгийг авахад Эрхард Эпплерийн 1999 онд Бонн хотноо хуралдсан намын онц их хурал дээр хэлсэн үг их тус болсон. Эпплер ийнхүү намын хурлын төлөөлөгчдийн өмнө гарч ирснээрээ илүү дайныг эсэргүүцэгч зүүний үзэлтнүүдийг нэгтгэж чадсан юм.

“Тэсрэх бөмбөг шидсэн хүн буруудах нь дамжиггүй. Үүний дараагаар зөвхөн буруутныг яаж илүү буруутан болгох вэ? гэдэг асуулт л тавигддаг.”

(Эпплер 1999 он, 112-113)

Зүүн Тимор, Македон зэрэг бусад олон улсын зөрчилдөөний үед ч нэгэн адил ХБНГУ гадаад бодлогын хүчин чармайлт гаргаж эхэлсэн. Үүний үр дүнд Бундестаг 2001 оны 9-р сарын 27-нд дийлэнх олонхын саналаар Македоны байдлыг тогтворжуулах НАТО-гийн цэргийн ажиллагааг дэмжиж 600 гаруй герман цэргийг илгээсэн.

Үүний зэрэгцээ холбооны улаан, ногооны эвслийн засгийн газар хямрал, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх хэрэгслүүдээ өргөтгөж, мөн өргөн хүрээтэй аюулгүй байдлын ойлголтын суурин дээр тухайн үед социал-демократ сайдуудын тэргүүлж байсан Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам, Холбооны батлан хамгаалах яамны үүрэг хариуцлагыг өргөтгөсөн.

Ногоонтон Ёошка Фишерийн тэргүүлсэн Гадаад хэргийн Яам гадаад бодлогын “2000 үзэл баримтлалаа” “Хямрал, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, боловсруулах” зэрэг чухал сэдвүүдээр өргөжүүлсэн нь олон улсын цэргийн ажиллагаанд оролцох хүмүүсийг сургах, мэргэжил дээшлүүлэх үүрэг бүхий олон улсын энхийг сахиулах ажиллагааны төв зэрэг байгууллагуудыг байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн. Мөн 2004 онд холбооны улаан, ногооны эвслийн засгийн газар “Иргэний хямралаас урьдчилан сэргийлэх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг бэхжүүлэх” үйл ажиллагааны төлөвлөгөөг уг үзэл баримтлалтай уялдуулан баталсан.⁹

Шинэ хэрэгслүүд

*“2000 үзэл
баримтлал*

9 Энэ номын 5.1-р бүлэг: Германы гадаад бодлогын оролцогч талууд

3.4.6. Алан хядлагын эсрэг дайн

АСУУЛТ

Герман алан хядлагын эсрэг, болон Афганистаны дайнд оролцох шаардлагатай юу?

НӨХЦӨЛ БАЙДАЛ

2001 оны 9-р сарын 11-нд алан хядагчид Нью Йорк хотноо Дэлхийн худалдааны төвийг бөмбөгдсөнийг НАТО-гийн түүхэнд эхний ба цор удаа бүх холбоотнуудын эсрэг дайн зарласанд тооцсон.

ДЭМЖИХ ШАЛТГААН

Олон улсын терроризм холбоотнуудын эв санааны нэгдэл болон Германы аюулгүй байдалд аюул учруулж байна.

ТАТГАЛЗАХ ШАЛТГААН

Дайн бол алан хядлагатай тэмцэх зохистой хэрэгсэл биш

ШИЙДВЭРҮР ДАГАВАР

Герман НҮБ-аас батламжилсан “Энхийг сахиулах-Үргэлжийн эрх чөлөө” ажиллагаа НАТО-гийн удирдлага дор явуулсан олон улсын аюулгүй байдлын туслах хүчин ажиллагаанд хязгаарлагдмал байдлаар оролцсон.

Дэлхийн худалдааны төвийн цамхгууд нуран унаснаас хойш нэг цагийн дараа Холбооны канцлер Герхард Шройдер хэвлэл мэдээллийнхний камерын өмнө “Энэ бөмбөгдөлт бол иргэншсэн дэлхий нийтэд зарлаж буй дайн” хэмээн тайлбарласан. Герман энэ хүнд үед АНУ-ын талд бат зогсоно.” Тэр ерөнхийлөгч Жорж Бушид “ХБНГУ-ын аливаа хязгаарлалтгүй эв санааны нэгдлийг” илэрхийлж байна гэв.

Бөмбөгдөлтөөс нэг өдрийн дараа НҮБ 1368-р шийдвэрээ баталж уг шийдвэрээр АНУ-д НҮБ-ын хартатай нийцүүлэн өөрийгөө хамгаалах эрхтэй гэдгийг баталсан. Мөн 2001 оны 9-р сарын 12-нд Хойд атлантикийн зөвлөл бөмбөгдөлт АНУ-ын эсрэг гаднаас халдсан

Шройдер 2001 оны 9-р сарын 11-нд: “аливаа хязгаарлалтгүй эв санааны нэгдэл”

2001 оны 9-р сарын 12: НАТО-гийн гэрээний дагуу холбоотны үүргээ биелүүлсэн

халдлага тул НАТО-гийн гэрээний холбоотнуудаа дэмжих үүргийн тухай 5-р зүйлийн агуулгаар бүх холбоотны эсрэг дайн зарласанд

НАТО-гийн гэрээний 5-р зүйлд **бүх холбоотнуудад дайн зарласанд** тооцох тухай заасан байдаг. Уг зүйлд НАТО-гийн гишүүн орнууд НАТО-гийн аль нэг орны эсрэг үйлдсэн зэвсэгт халдлагыг НАТО-гийн гишүүн бүх орнуудын эсрэг үйлдсэн халдлага хэмээн үзэж харилцан дэмжлэг үзүүлнэ хэмээн заасан байдаг.

тооцно гэдэг шийдвэр гаргасан. Энэ нь НАТО-гийн түүхэнд анх удаа, өнөөг хүртэл цор ганц удаа НАТО-гийн бүх Холбоотнуудад дайн зарласан тохиолдол болсон юм.

2001 оны 9-р сарын 11-нд Холбооны канцлер НҮБ-ын шийдвэр ба НАТО-гийн тогтоол дээр суурилан засгийн газрын тайлбараа хийсэн. Тэрээр Герман зөвхөн моралын болон улс төрийн эв санааны нэгдэлтэй байх үүрэг хүлээгээд зогсохгүй, цэргийн дэмжлэг үзүүлэхийг үгүйсгэхгүй гэдгээ илэрхийлсэн.

Шройдер эхнээсээ “Герман улс шийдвэр гаргахдаа германы үндсэн хууль, үндсэн хуулийн цэцийн шийдвэр нэн ялангуяа парламентын цааргалах эрхийг чандлан сахина, шаардлагатай тохиолдолд цэргийн туслалцааг ямар ч хэлбэрээр бай үзүүлэхэд хэзээд бэлэн” гэдгийг онцолсон.

“Зөвхөн цэргийн арга хэмжээн дээр төвлөрөх”-ийг социал-демократ засгийн газар хор уршиг ихтэй хэмээн үзэж “Алан хядлагатай тэмцэх өргөн хүрээтэй үзэл баримтлал” боловсруулахын чухлыг онцолж байв. ГСДН, Ногоон намын болон бүлгийн удирдлагууд энэ замаар засгийн эрхийг баригч эвслийг бүрдүүлэгч хоёр намын зүүний жигүүрүүдийг аль болох эрт нэгтгэх, гадаад бодлогыг цэрэгжүүллээ гэдэг шүүмжлэлд эхнээсээ өртөхгүй байхыг оролдож байлаа.

АНУ 2001 оны 10-р сарын 7-нд Таливаны дэглэм ба Осама Бин Ладений сүлжээний эсрэг цэргийн эхний арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлсний дараагаар Шройдер эдгээр арга хэмжээг “Нью Йоркт алан хядагчдын хийсэн бөмбөгдөлтөд хариуг нь өглөө” хэмээн дэмжиж Герман транс-атлантын нэгэн чухал түншийн хувьд ногдсон үүргийн дагуу хариуцлага хүлээх болно гэдэг тайлбар хийсэн.

*Шройдерийн
засгийн газрын
тайлбар*

Бундестаг дах социалдемократ намын бүлгийн удирдлага, холбооны засгийн газар америкийн нэгдсэн улсын америкууд ба британичуудыг дэмжих цэргийн арга хэмжээг дэмжсэн байр суурийг баримталж байхад Ногоон Нам ба ГСДН-ын эгнээнд тэсрэх бодисын хэрэглээг шүүмжилсэн, зохист харьцааг хангахыг уриалсан дуу хоолой чангарч байлаа.

2001 оны 11-р сарын эхээр ГСДН-ын Бундестаг дах бүлгийн гишүүдийн дунд довтолгоог зогсоохыг уриалсан дуу хоолой даравч дардайна гэгчээр чангарч эхэлсэн. Бундестагийн ерөнхийлөгч Вольфганг Тиерзе зэрэг тэргүүлэх социалдемократууд хүртэл олон нийтийн дунд ил тод шүүмжилж, үйлдвэрчний эвлэлүүд засгийн газарт шаардлага хүргүүлж, бөмбөгдөлтийг зогсооход нөлөөлөхийг эрмэлзэж байлаа.

*Үргэлжийн
энх тайван
ажиллагаанд
/ҮЭТА/ оролцох
эсэх тухай санал
хураалт нь итгэл
үзүүлэх эсэх тухай
асуудал болж
хувирсан*

“Үргэлжийн эрх чөлөө”-ажиллагаанд оролцох эсэхэд засгийн эрхийг баригч хоёр нам болон тус хоёр намын Бундестаг дах бүлгийн гишүүд эргэлзэж эхэлсэн юм. Холбооны канцлер Герхард Шройдер “Үргэлжийн эрх чөлөө”ажиллагаанд оролцосноор герман эвсэх чадамжтай гэдгийг харуулах болно хэмээн үзэж байлаа. Засгийн газрын тэргүүн “Үргэлжийн эрх чөлөө” ажиллагаанд үгүй гэж хэлэх нь НАТО-гийн гишүүн орнуудын дунд Германыг тусгаарлах аюултай хэмээн болгоомжилж байлаа. Тэрээр эцэст нь уг ажиллагаанд оролцох эсэх асуудлыг канцлерт итгэл үзүүлэх эсэх асуудалтай холбон Бундестагт санал хураалт явуулах шийдвэр гаргасан.

2001 оны 11-р сарын 16-нд нөлөө бүхий эсэргүүцэгчид бараг бүгдээрээ Холбооны армийг уг ажиллагаанд оролцуулахыг дэмжсэн санал өгсөн. Эцэст нь ногоон намын ердөө дөрвөн гишүүн болон холбооны армийг Афганистанд цэргийн ажиллагаанд оролцуулахыг эсэргүүцэн бүлгээсээ гарсан Бундестагийн гишүүн Криста Лоерхер нар эсрэг санал өгсөн. Тэгсэн ч Афганистаны асуудлаар ГСДН-ын бүлэг дотор саналын зөрүү ямар их байсан бэ? гэдгийг социал-демократ 80 гишүүний өгсөн санал дээрээ нэмж өгсөн шүүмжлэлтэй тайлбараас тодорхой харагддаг.

2001 оны 11-р сарын 16-нд Германы Бундестаг өргөдлийн талаар санал хураасны дараа Герман “Үргэлжийн эрх чөлөө” ажиллагааны

хүрээнд терроризмийн эсрэг тэмцэлд дөрвөн өөр бүс нутагт оролцсон: Афганистан, Африкийн эвэр, Филиппин, Африк болон Сахарын өмнө талд.

Афганистаны дайнд германы хуурай замын 100 цэрэг анх удаа тусгай хүчний командын дор оролцсон. “Үргэлжийн эрх чөлөө” ажиллагааны хүрээнд холбооны армид олгосон мандатад Бундестаг жил бүр хяналт тавьж хяналт тавих бүрдээ цэргийн ангийн бие бүрэлдэхүүний тоог тогтмол бууруулсаар байсан. 2008 оны 11-р сард мандатыг зөвхөн Африкийн эврийн аюулгүй байдлыг хангахаар хязгаарлаж, 2010 оны 6-р сард мандатыг дахин сунгаагүй.

ҮЭТА-ны хэлцэлтэй цаг хугацааны хувьд давхцуулан дайны ажиллагаа дуусаад нэлээд хугацаа өнгөрсний дараагаар дахин нэг ажиллагаа эхлүүлсэн юм. 2001 оны 12-р сарын 20-нд НҮБ-ын аюулгүйн зөвлөл олон улсын аюулгүй байдлыг хангах ангид мандат олгосон. Энэ ажиллагааг “Олон улсын аюулгүй байдлын туслах хүч-ISAF” хэмээн нэрлэсэн бөгөөд уг тусгай ангийг Хамид Карсайн шилжилтийн засгийн газрыг дэмжих, Кабул хот болон тус хотын эргэн тойронд аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр байгуулсан.

Герман цагийг нь олж цэргийн анги илгээж оролцоно гэдгээ мэдэгдэж, Бундестаг 2001 оны 12-р сарын 20-нд ширүүн хэлэлцүүлэг хийсний дараа олонхын саналаар 1200 герман цэрэг Хиндикуш рүү илгээсэн.

ОУАБТХ нь өнөөг хүртэл НАТО-гийн түүхэнд хамгийн удаан үргэлжилсэн, хамгийн их хохирол амссан ажиллагаа болсон бөгөөд 2014 оны 12-р сарын 31-нд дууссан. Энэ ажиллагаанд зарим үед 40 орны 140 000 хүртэл цэрэг оролцож байлаа. 13 жил үргэлжилсэн энэ ажиллагааны үеэр германы 55 цэрэг амиа алдсан.

Ямар учраас социал-демократ нам ба улаан, ногооны эвслийн засгийн газарт ҮЭТА-ны мандат ОУАБТХ-ээс бага маргаан дагуулсан бэ? Учир нь тухайн улсын нөхцөл байдлыг тогтворжуулах, үүргээ гүйцэтгэх чадамж бүхий төрийн бүтцүүдийг шинээр болон сэргээн байгуулах зорилгоор ОУАБТХ-д мандат олгосон. Үр дүнд нь тухайн улсад өөрийн замнал ба нөөцөөр хөгжих боломж

“Олон улсын аюулгүй байдлын туслах хүч-ОУАБТХ” -ISAF”

*Дэлгэрүүлэн унших:
Мирко Гюнтер /2017 он/, Цэргийн хүчээр энэ дайнд ялалт байгуулах боломжгүй юм байна. 2017 оны 8-р сарын 25-нд Олон улсын улс төр ба нийгэм сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэл*

*Нийлс Аннен,
Иркен Виезе /2008 он/, Хиндикуш дэх германы ашиг сонирхол Бүс нутгийн стратегид зориулсан гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн үг Шинэ нийгэм франкфуртын сэтгүүл 2008/12, 60-63-р хуудас*

бүрдүүлэх ёстой байлаа. Цэргийн бэлэн байдал нь юуны өмнө иргэний үйл ажиллагааны баталгааг хангах үүрэгтэй байсан бөгөөд ҮЭТА-аас ялгаатай нь алан хядлагатай дан ганц цэргийн хүчээр тэмцэх боломжгүй гэдэг мэдлэг дээр суурилж байлаа. Эдгээр хоёр ажиллагааг газар дээр нь, практик дээр хооронд нь ялгахад бэрхшээлтэй байлаа.

2017 онд аюулгүй байдал дахин хүндэрч АНУ цэргийн ангийнхаа тоог шинээр нэмэгдүүлэхээс өөр аргагүй гэдэг дүгнэлтэд хүрэв. ОУАБТХА-д олгосон мандат амжилтад хүрсэн үү? гэдэгт шүүмжлэлт дүгнэлт гаргах нэн шаардлагатай байлаа.

3.4.7. Иракийн дайнд үгүй гэж хэлэв.

АСУУЛТ

Герман Иракийн эсрэг дайнд оролцох нь зүйтэй юу?

НӨХЦӨЛ БАЙДАЛ

АНУ Ирак бөөнөөр нь устгах хөнөөлт зэвсэг эзэмшдэг хэмээн батлаад байдаг. Тэд дарангуйлагч Саддам Хусейнийг огцруулах зорилготой дайнд бэлтгэж эхэлсэн.

ДЭМЖИХ ШАЛТГААН

ХАХН: АНУ бол аюулгүй байдлын хамгийн чухал түнш. Европ гадаад, аюулгүй байдлын асуудлаар хуваагдсан. Германы “тусгай зам”

ТАТГАЛЗАХ ШАЛТГААН

ГСДН: Неоконсервативчуудын сурталчлаад байгаа “сайн” ба “муу” орнууд байдаг гэж үздэг ертөнцийг үзэх үзлийг няцаах. Бөөнөөр устгах хөнөөлт зэвсэгтэй гэдэг нотолгоо байхгүй, НҮБ хууль ёсны эрх олгоогүй.

ШИЙДВЭРҮР ДАГАВАР

2003 оны 3-р сарын 19-нд АНУ-ын удирдлага дор байгуулагдсан дайны эвсэл Иракт довтолсон. Герман уг довтолх дайнд оролцоогүй.

Нью Йоркод болсон бөмбөгдөлтөөс хэдхэн сарын дараагаар ерөнхийлөгч хүү Буш үндэстний нөхцөл байдлын талаар хэлсэн үгэндээ Иран, Ирак, Хойд Солонгосыг “муу санаатнуудын тэнхлэг” хэмээн нэрлэсэн. Тэрээр АНУ нь терроризмын эсрэг хийх тэмцлийн дараагийн шатанд аргагүйдсэн нөхцөлд “үл бүтэх орнууд”-ын эсрэг тэмцлийг дангаараа эхлүүлэх болно хэмээн мэдэгдсэн. Ингэснээр америкийн засгийн газар гадаад бодлогынхоо чиг баримжааг шинэчлэн тодорхойлсон юм.

Түүний хэлсэн үг дэлхий дахинд юуны өмнө дээр нэрлэсэн орнууд ба европт таагүй байдал үүсгэсэн. Бөмбөгдөлтийн дараагаар эхлээд АНУ-д элэгсэг, нөхцөл байдлыг ойлгон хандаж байгааг дэмжиж байсан ГСДН-ын Бундестаг дах бүлгийн дэд дарга Гернот Эрлер эдгээр гурван орны талаар түүний хэлсэн үгийг “христын шашны эртний гэрээслэлийн тамгатай” хэмээн ил тод шүүмжилж, Ираны эсрэг бодлогыг “европын бодлогыг гутаан доромжилж буй хэрэг” гэж тодорхойлсон. АНУ аюулгүй байдлын бодлогоо цэргийн үйл ажиллагаа дээр улам төвлөрүүлэн хумьж байхад улаан, ногооны эвслийн засгийн газар “Аюулгүй байдлын ойлголтын хүрээг улам тэлж өргөтгөсөөр” байлаа. Батлан хамгаалахын сайд Рудолф Шарфинг аюулгүй байдлын бодлогод “орчин үеийн аюулгүй байдлын бодлогын төвд урьдчилан сэргийлэх бодлого тавигдах ёстой. \Бид\ олон талт тохиролцоо, олон улсын хэм хэмжээ баримтлахгүй бол дэлхий дахины аюулгүй байдал, тогтвортой байдлыг улам дордуулах болно. Дээрх хоёр байр суурь хоорондын нэгдсэн хуваарь буюу дундын хувилбарыг олох нь бараг боломжгүй зүйл байлаа.

Герман зөвхөн цэргийн ажиллагаа дээр төвлөрч байна хэмээн америкийн бодлогыг шүүмжилж гомдоллож байлаа. Холбооны канцлер Шройдер НАТО-гийн түншүүдийн шүүмжлэлд эхлээд эмзэглэсэнгүй, хүү Буш түүнтэй ганцаарчлан ярилцахдаа цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцох төлөвлөгөө түүнд байхгүй гэдгийг батлан хэлсэн хэмээн тайлбарлаж байв. Гадаад хэргийн сайд Фишер терроризмын эсрэг эвсэл АНУ Ирак руу довтолсон нөхцөлд задрах эрсдэлтэй шүү хэмээн сануулж байв.

Хэдийгээр нэлээд эрт зөрчлийн шугам тодорч эхэлсэн ч Иракын

асуудал 2002 оны 8-р сарын эхээр сонгуулийн кампанит ажил эхлэх хүртэл төдийлөн чухал бус байв. Харин 2002 оны 8-р сарын 5-нд нөхцөл байдал эрс өөрчлөгдөв. Энэ өдөр холбооны канцлер Герхард Шройдер Ханнобер хотноо олны анхаарлыг татсан илтгэл тавьсан юм. Тэр хэлэхдээ Иракийн дайнаас болж олон хүн айдаст автаж байгааг ойлгож байна, гэхдээ Иракт цэрэг оруулахын эсрэг байна гэдгээ тодорхой илэрхийлсэн.

ГСДН-ын дарга ийнхүү Иракийн дайнд “үгүй” гэж хэлсэнтэй бүгд санал нэгдэж байлаа. “Шпиегэл- толь” сэтгүүлээс явуулсан санал асуулгад оролцогсдын 65% нь Иракт довтлох дайнд Герман оролцохын эсрэг санал өгч байв. НҮБ-ын мандаттай байсан ч үгүй гэж хариулсан. Сөрөг хүчин ХАХН транс-атлантын түншлэлд аюул учрах бий гэдгээс болгоомжилж байлаа.

ГСДН-ын өнцгөөс харахад АНУ-д дайны заналхийллээр дамжуулан америкийн нео-консервативчуудын дэмжээд байгаа ертөнцийг үзэх үзэл бэхжиж байлаа. Тэдний ертөнцийг үзэх үзэл ёсоор дэлхий дээр сайн ба муу орнууд гэж бий.

2002 оны 8-р сарын 28-нд АНУ-ын дэд ерөнхийлөгч Дик Ченей иракийн эсрэг “урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” явуулах “зайлшгүй шаардлагатай” хэмээн мэдэгдсэнээс хойш уг зөрчлийг шийдвэрлэх америкийн шийдэлд дипломат бодлого огт үүрэг гүйцэтгэхгүй юм байна гэдэг таамаглал улам бэхжив. Шройдер америкийн ерөнхийлөгчид ганцаараа хөдлөх хэрэггүй гэдгийг сануулж “НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн хууль ёсны зөвшөөрөлгүйгээр аливаа ажиллагаа явуулах эрх хэнд ч байхгүй” хэмээн тайлбарлаж байлаа.

*Транс-Атлантын
харилцаанд
эргэлт гарав.*

Энэ хугацаанд ХБНГУ терроризмтой тэмцэх үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэсээр америкийн аюулгүй байдлын асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудтай нягт хамтран ажилласаар байлаа. Гэсэн хэдий ч холбооны канцлерын иракын дайнд “Үгүй” гэдэг байр суурь транс-атлантын харилцаанд зөвхөн эргэлтийн цэг хатгаад зогссонгүй, Европ гадаад, аюулгүй байдлын бодлогын чухал асуудалд нэг хоолойгоор ярьдаггүй буюу санал нэгтэй байдаггүй гэдгийг харуулсан юм. Герман, Франц, Бельги болон Австри, АНУ-

ыг шүүмжилж байлаа. Их Британи, Итали, Испани, Португал, Дани, Унгар, Польш, Чех дэмжинэ гэдгээ илэрхийлж байлаа.

2003 оны 2-р сарын 5-нд америкийн гадаад хэргийн сайд Колин Паулл НҮБ-ын аюулгүйн зөвлөлд иракийн бөөнөөр нь устгах зэвсгийн үйлдвэртэй гэдгийг нотлох нотолгоо гэгчийг танилцуулсан байна. 2003 оны 3-р сарын 17-нд америкийн ерөнхийлөгч иракийн дарангуйлагч Хуссейнд 48 цагийн дотор Иракийг орхин гар гэдэг утгатай сүүлчийн тулган шаардах бичиг хүргүүлсэн. Энэ нь тухайн үеийг хүртэл НҮБ-аас Ирактай холбоотой гаргасан НҮБ-ын 18 шийдвэрийн алинтай нь ч авцалдаагүй тулган шаардалт байлаа. Буш үг хэлснээс хойш гурван өдрийн дараагаар “Шоконд оруул, айлга” гэдэг ажиллагаагаар гольфийн гуравдугаар дайн эхэлсэн.

Хэлэлцүүлэгт:

2014 онд германы Бундестаг Иракийн автономит бүс нутаг курдийн Пешмерга буюу Иракийн автономит бүс нутаг Курдистаны зэвсэгт хүчинд зэвсэг нийлүүлэх эсэх асуудлаар хэлэлцэв. Дэмжигчид “Исламын улсууд” гэдэг террорист байгууллагын эсрэг Курдийн явуулж буй тэмцэлд дэмжлэг үзүүлэхэд зохистой арга хэмжээ гэж үзэж байлаа. Харин шүүмжлэгчид хямралтай бүс нутгуудад зэвсэг нийлүүлэхгүй байх нь германы аюулгүй байдлын бодлогын үндсэн зарчмуудын нэг гэдгийг сануулж байлаа. Зэвсгээр богино хугацаанд хүссэн зорилгодоо хүрч болох ч урт хугацаанд тухайн бүс нутгийн зөрчилдөөний чадамжийг дээшлүүлдэг, энэ тохиолдолд жишээлбэл курдүүд ба НАТО-гийн гишүүн орон Турк улс хоорондын болзошгүй зөрчилдөөний аюулыг дээшлүүлнэ. Германы засгийн газар эцэст нь зэвсэг нийлүүлэх нь зүйтэй гэж шийдсэн.

Та байсан бол ямар шийдвэр гаргах байсан бэ?

3.5. Энх тайван, аюулгүй байдлын бодлогын чиглүүлэгч луужингийн элémentүүд

*“Үйл явдлууд, залуу
минь үйл явдлууд”*

Он жилүүдийн тэртээд тухайн үеийн английн ерөнхий сайд Харолд Максимилланаас (1894-1986 он) засгийн газруудын бодлогын чиг хандлага юунаас болоод өөрчлөгддөг вэ? гэдэг сэтгүүлчийн асуултад “Үйл явдлууд, залуу минь үйл явдлууд” гэж хариулсан гэдэг¹⁰.

Ялангуяа гадаад, аюулгүй байдлын бодлогын талбарт энэ ишлэл онцгой хэлбэрээр тохирох ишлэл мөн үү? гэж асуувал бүх хүн эргэлзэхгүйгээр “тийм шүү” гэж хариулна. Социал-демократ бодлогын оролцогч талууд ч нэгэн адил өнгөрсөн 154 жилийн шийдвэрлэх үйл явдлуудын дараагаар өөрсдийн аюулгүй байдлын бодлогын чиг хандлагаа ахин дахин шинэчлэн тодорхойлсоор ирсэн.

*Луужингийн
элементүүд*

Дэлгэрүүлэн унших:

ГСДН-ын Бундестаг

дах бүлгээс эрхлэн

гаргав. (2017

он), Олон улсын

сорилтуудын эрин

үеийн энх тайван,

намжмал байдлын

социалдемократ

бодлого, Берлин

ГСДН-ын үнэт

зүйлсийн комисс

(эрхлэн гаргагч) (2015

он) Энх тайван,

ардчилал, хөгжил,

европ, Дэлхийн

Бодлогын чиг хандлагыг шинэчлэн тодорхойлох бүрд социал-демократ үзлийн эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдлийн гурван үнэт зүйлс дээр үндэслэн тогтоосон үнэт зүйлсийн луужин л харин өөрчлөгдөшгүй суурийг нь бүрдүүлж байдаг. Энэ луужингийн заасан чиг яваад эхэлмэгц олон улсын бодлогод эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдлийн үнэт зүйлсийг гагцхүү гадаад (жишээлбэл дипломат бодлого) ба аюулгүй байдлын (цэргийн) бодлогын хэрэгслүүдээр биш, харин хөгжлийн бодлогын хэрэгслүүдээр хэрэгжүүлэх боломжтой гэдэг нь тун удалгүй тодорхой болоод ирнэ. Хүсээгүй үр дагавраас аль болохоор зайлсхийх, бүтцийн эерэг нөлөөг боломжит дээд хэмжээнд хүртэл дээшлүүлэхийн тулд худалдаа, байгаль орчин, дэлхий дахины аюулгүй байдал зэрэг бодлогын бусад талбаруудыг сүлжээгээр хоорондоо холбогдсон шийдлийн хүрээнд хамтад нь сэтгэж, хамтад нь авч үзэх шаардлагатай. Үүний тулд зорилтууд хоорондын зөрчлийн талаар нээлттэй хэлэлцүүлэг хийх шаардлагатай.

Улс төрийн үйл ажиллагааны тодорхой бодлогын үндэслэлийг гаргаж ирэхийн тулд хөлөг онгоцонд зангуу хадах бусад тэмдэглэгээ хийх хэрэгтэй. Эдгээр зангууны тэмдэглэгээний нэг нь энэ номын

10 Ж.Д-ийн орчуулга “Events, my boy, events”

2.1-р бүлэгт тодорхойлсон социал-демократ энх тайвны ойлголт юм. Социал-демократ хэтийн төлөвөөс харахад энх тайван дайн байлдаангүй байхаас илүү өргөн утгатай тухай 2.1-р бүлэгт хэлэлцсэн.

2.2-р бүлэгт тодорхойлсон аюулгүй байдлын өргөн хүрээтэй ойлголт нь социал-демократ олон улсын бодлогын суурийн бас нэгэн зангуу тогтоох цэг бөгөөд энэ ойлголтод гадаад, аюулгүй бодлогын элементүүдийн зэрэгцээ эдийн засаг, хөгжлийн бодлогын болон экологийн элементүүдийг багтдаг.

бодлогод дэлхийн
өнөөгийн хямралын
замын зураглал,
Хэлэлцүүлгийн
баримт бичиг,
Берлин

ЗАРЧМУУД


- Хууль ёсны байх
- Хамтын ажиллагаа
- Олон улсын эв санааны нэгдэл
- Зэвсэг хураах ба намжмал байдал

Үндсэн санаа:

Иргэний-
буюу энх тайвны гүрэн

Иргэний давуу байдал
Урьдчилан сэргийлэх,
намжмал байдал, дипломат бодлого

Холбооны армийг гадаадад цэргийн
ажиллагаанд оролцуулах
Зөвхөн бодлогын нэгдсэн стратегийн хүрээнд
-германы үндсэн хууль, НҮБ-ын хүний эрхийн харта болон
бусад шалгуур үзүүлэлтүүдийн дагуу



ҮНДСЭН ЭРХҮҮД

СОЦИАЛ-ДЕМОКРАТ
ҮЗЛИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

Хүний эрхийн
түгээмэл тунхаглал

Иргэний ба нийгмийн
эрхийн пакт

Үндсэн эрхүүдийн харта
(Европын холбоо)

Хүний эрхийн
конвенц

ЭРХ ЧӨЛӨӨ

ШУДАРГА ЁС

ЭВ САНААНЫ НЭГДЭЛ

Зураг1: Энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужин

“Бид олон улсын бодлогоо аюулгүй байдлын өргөн хүрээтэй ойлголт дээр тулгуурлан боловсруулна: Энх тайван, шударга ёс, эрх чөлөө, ардчилал, нийгэм, эдийн засаг, соёл, тогтвортой хөгжил хангагдсан нөхцөлд бүх хүмүүсийн аюулгүй байдал хангагдана.”
(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 20)

Дэлгэрүүлэн унших:

Нийлс Аннен (2016 он)

урьдчилан сэргийлэх,

стратегийн, үнэт

зүйлсийн хямралаас

урьдчилан сэргийлэх

бодлогыг боловсронгуй

болгох, Пеаселае 2016 он,

2016 оны 7-р сарын 21-ний

нийтлэл

Дэлгэрүүлэн унших:

Ёхен Хиплер (2007он),

Цэргийн хүчээр

хөндлөнгөөс оролцоход

тавигдах болзол, үзүүлэлт,

хязгаар Бруно Шох болон

бусад зохиогчид (эрхлэн

гаргасан) Энх тайвны

үнэлгээ 2007 он

Жайр фон дер Лижин

(2017 он), Хүч хэрэглэхийг

хууль ёсны дагуу хүлээн

зөвшөөрөх монополын

ирээдүй: Дэлхий нийтийн

ирээдүйн дөрвөн хувилбар

ФЭС (эрхлэн гаргасан)

Германы энх тайван

судлалын таван

хүрээлэнгээс жил

тутамд нийтлэлдэг энх

тайвны үнэлгээ www.friedens-gutachten.de

Стокхольмын олон улсын

энх тайван судлалын

хүрээлэнгийн оны ном

(SIPRI)

Эцэст нь социал-демократ үзэл үндсэн санааныхаа дагуу хөдөлж байх коридорыг тогтоох боломжтой. Хэдийгээр социал-демократ үзэл нь дайныг эсэргүүцэгч урсгал биш ч гэсэн дээр тодорхойлсон үнэлэмжийн катологиос харахад Германыг цэрэгжсэн гүрэн болгох тухай төсөөлөх ч боломжгүй юм. Үүнээс илүүтэйгээр үндсэн санааны “Иргэний буюу энх тайванч гүрэн” гэдэг орон зайд **бодлогоо боловсруулах боломжтой.**

“Хэдийгээр дайныг тууштай эсэргүүцэгчид социал-демократ хөдөлгөөнийг улс төрийн эх орноо гэж үздэг ч тус нам хэзээ ч дайныг эсэргүүцэгч нам байгаагүй юм. Гэхдээ тус нам засгийн эрхийг барьж байхдаа ямагт үндэсний дээрэнгүй үзэл ба милитаризмын эсрэг дархлаатай, энхийг эрхэмлэгч нам байсаар ирсэн. Бид хэзээ ч дайн, дарлал эсвэл хүчирхийллээр ноёлох дэглэмийг ард түмнийхээ дээр тавьж байгаагүй гэдгээрээ бахархдаг.”

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 13-14-р хуудас)


Социал-демократ хэтийн төлөвөөс харахад зөвхөн НҮБ-ын мандаттай бол парламентын зөвшөөрөлтэйгөөр, улс төрийн нэгдсэн шийдлийн хүрээнд бодит зорилтыг хэрэгжүүлэхийн тулд холбооны армийг гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулж болно. Үүний цаана /цэргийн/ үйл ажиллагааны нөлөөг хараат бус үнэлгээчдээр үнэлүүлж хяналт тавьдаг байх ёстой гэдэг санаа агуулагдаж буй.

Цаашилбал Холбооны армийг гадаадад цэргийн ажиллагаанд илгээхээс өмнө шийдвэр гаргалтын шалгуур үзүүлэлтүүд, улс төрийн зорилтууд, амжилтад хүрэх нөхцөлүүд, арга хэрэгслүүдийн нөлөөллийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах нь зүйтэй.

3.6. Газрын зургийг өнгөцхөн харахад: Энх тайвнаар зэрэгцэн орших нь үл гүйцэлдэх санаа юу?


Луужин чиг баримжааг тогтоож зүг чигийг заадаг. Эргэн тойрноо ажиглаж сайн газрын зураг ашиглаж байж тодорхой алхмуудыг тодорхойлдог. 2017 онд энх тайван, аюулгүй байдлын газрын зургийг өнгөцхөн харахад сэтгэл сэр хийм дүр зураг харагдаж байлаа.

Хайделбергийн олон улсын зөрчил судлалын хүрээлэнгээс гаргасан зөрчилдөөний барометерт 2016 онд дэлхий дахинд нийт 402 зөрчил бүртгэгдсэнээс 226 нь хүч хэрэглэсэн зөрчил байжээ.



Projection: World Wagner IV; Übersetzung: JD

Зураг 2: Зөрчилдөөнүүд 2016 оны байдлаар (үндэсний болон олон улсын төвшинд)
(2016 он, 10) Хайделбергийн олон улсын зөрчилдөөн судлалын хүрээлэн



Projection: World Wagner IV; Übersetzung: JD

Зураг 3: Хүч хэрэглэсэн зөрчилдөөний цар хүрээ (улс орнуудын доод түвшинд)
(2016 он, 11) Хайделбергийн олон улсын зөрчилдөөн судлалын хүрээлэн

2016 онд Стокхолмын энх тайван судлалын хүрээлэнгийн (SI-PRI) тооцооллоор дэлхий дахинд 1.686 тэрбум доллар зэвсэглэлд зарцуулсан байна. Энэ нь дэлхий дахины Дотоодын Нийт Бүтээгдэхүүний (ДНБ) 2.2% -тай тэнцэж байв. Хүн бүрд 227 ам.доллар ногдох хэмжээний хөрөнгийг зарцуулсан гэсэн үг. Баруун европын зэвсэглэлд зарцуулсан хөрөнгө 2015 оныхоос 2.6%-аар өссөн байна. Харин дэлхий дахинд зэвсэглэлд зарцуулсан хөрөнгийн хэмжээ тогтмол хэмжээнд байна. (SIPRI- Стокхолмын Хүрээлэн 2017 он, 12-р тал)

НАТО ба ОХУ-ын хооронд байсан зөрчилдөөний хуучин шугамууд Крымийг эзэлснээс хойш дахин шинээр тодрон гарч ирсэн. Үүний зэрэгцээ Сири зэрэг орнуудад их гүрнүүд хоорондын төлөөллийн дайн дэгдэж цэргийн хүчээр маргаан шийдвэрлэх Исламын улс, Бoko Харам зэрэг төрийн бус, алан хядагч оролцогч талууд гэдэг цар хүрээ шинээр нэмэгдлээ.

Эдгээр зөрчилдөөнийг олон талын оролцоотой шийдлээр шийдвэрлэнэ гэдэг найдварыг европт болон АНУ-д үндсэрхэг үзэлтэй хөдөлгөөнүүдийн хүчирхэгжилт сулруулж байна. Олон талын бүтэцтэй бодлогын хүрээлэнгүүдийн ач холбогдол буурахад тэд өөрсдөө ч хувь нэмэр оруулсан нь мэдээж. НҮБ ба Европын Холбоо зэрэгт багтдаг технократ аппаратууд ил тод байдал, үр өгөөжийг дээшлүүлэх, тайлагнах үүргээс үүдэлтэй нэн даруй шинэчлэгдэх шаардлагыг хэрэгжүүлэхээс маш урт хугацаагаар цааргалж чадсан юм. Гэвч дэлхий дахинд дүрэм журам тогтоогч, хэрэгжүүлэгч хамгийн чухал чуулган болох НҮБ болон бүс нутгийн хамтын ажиллагааны эвсэл холбоод зөвхөн гишүүд нь эрх олгосон нөхцөлд л нөлөөлж чаддаг. Үүнээс болоод бодлого эргээд үндэсний түвшинд шилжиж буй өнөө үед европын энх тайвны архитектурын бүтцүүд ба хэрэгслүүдийн нэгэн адил НҮБ гүнзгий хямралд орсонд гайхаад байх хэрэггүй юм.

Гэхдээ найдвар тасарчхаагүй байна. “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030” ба Парисын цаг уурын хэлэлцээр батлагдсан нь урт хугацааны туршид хэрэгжих боломжгүй гэж үздэг байсан зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлд гарсан амжилтууд юм. Цөмийн зэвсгийн эсрэг кампанит ажилд (ICAN) нобелийн энх тайвны

шагналыг олгосноор нобелийн шагналын хороо дэлхий дахинд зэвсэг хураах чиглэлд тод тэмдгийг тавьж чадсан. Социал-демократ үзэл луужингаар тодорхойлсон идеал зорилтууддаа ойртохын тулд энх тайвны ямар стратеги баримтлах вэ? Энэ асуултад 4.0 бүлэгт хариулах болно.

4. ЭНХ ТАЙВНЫГ ЦОГЦЛООХ НЬ: СТРАТЕГИУД БОЛОН ШИЙДЛҮҮД

Энэхүү бүлэгт:

- Социал-демократ энх тайвны бодлогын шийдлийн тулах цэгүүдийг тоймлон хүргэнэ.
- Ямар учраас энх тайвныг хангахын тулд дэлхий дахинд шударга ёсыг бэхжүүлэх шаардлагатай вэ? гэдгийг тайлбарлана.
- Хөгжлийн хамтын ажиллагаа энх тайванд яаж хувь нэмрээ оруулдаг вэ? гэдгийг тодорхойлно.
- Зэвсэгт мөргөлдөөний үед болон энх тайвныг тогтооход жендер ямар үүрэгтэй вэ? гэдэг талаар хэлэлцэнэ.
- Зэвсэг хураах ба цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх бодлогыг яаж хэрэгжүүлэх вэ? гэдгийг тойм зураг дээр тайлбарлана.

Энх тайвныг дэлгэрүүлэх боломжтой. Энх тайвныг боловсруулах, сахин хамгаалах ёстой боломжтой. Энэ бол социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужингаас олж авсан мэдлэг. Энэ мэдлэг дээрээ суурилан социал-демократ энх тайвны стратегид ямар элементүүд агуулагдсан байх ёстой вэ? гэдгийг тойм зургаар гаргаж ирнэ. Дээрээс нь социал-демократ хэтийн төлөвөөс харахад онцгой чухал бодлогын дөрвөн тодорхой шийдлийг танилцуулах болно.

4.1. Социал-демократ олон улсын энх тайвны стратегийн тулгын чулуунууд

Зохиогчид Константин Баервалд, Бодо Шүлце нар

Луужин олон улсын бодлогын үйл ажиллагаанд ямар чигийг зааж байна? Социал-демократ энх тайвны бодлогод стратегийн ямар тулгын чулуунуудыг эндээс тодорхойлох боломжтой вэ?

Хүмүүс энх тайвныг дэлгэрүүлж чадна.

Дэлгэрүүлэн унших:

Олон улсын энх тайван, аюулгүй байдлын бодлогын салбарт ФЭС-ийн явуулж буй олон улсын ажилд зориулсан шинэлэг мэдээлэл: www.fes.de/index.php?id=2677

Үнэлэмжүүд ба зарчмуудаар чиг баримжаа авсны ачаар луужин нэн түрүүнд дэлхий даяараа тайван бус аж төрж байгаа өнөө үед чиг баримжааг заадаг.

*Олон улсын
бодлого бол
тэг нийлбэрийн
тоглоом биш*

Европ болон бусад газруудын түүхэн туршлага болон социал-демократ үзлийн түүхэн замын тэмдэглэгээнүүд (3.4-р бүлэгтэй харьцуулах)-ээс харахад дэлхий даяар дахин сэргэж буй үндсэрхэг үзэл, национализм ба ганцаарчлан ноёрхох дэглэм, олон улсын бодлого бол тэг нийлбэрийн тоглоом гэдэг ойлголтын аль аль нь өдгөө дэлхий дахинд тулгараад байгаа цаг уурын өөрчлөлт, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэх, терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, дүрвэлт, эх орноос нь албадан хөөх зэрэг глобал асуудлуудаас нэгийг ч болов шийдэхэд тус болохгүй нь ойлгомжтой.

*“Энэ чигээрээ
яваад бай” гэх нь
хангалтгүй.*

Харин ч эсрэгээрээ: Эдгээр сорилтуудыг өөрийн улсаас зайлууллаа, бусад улсууд руу түлхлээ гээд шийдэгдэхгүй, эдгээрийн нөлөөнд энэ дэлхийн хамгийн ядуу нь, хамгийн сул дорой нь хамгийн хүндээр өртөж, их сайндаа өөр бүс нутаг руу зайлуулж чаддаг юм гэхэд дунд хугацаанд дэлхийн бүх иргэдийн нөхцөл байдал хүндэрнэ. Үр дагаврыг нь харин тооцоолох боломжгүй юм. Иймээс социал-демократ энх тайвны стратегийг олон талын оролцоотойгоор боловсруулах ёстой.

“Тойрог замаасаа гарчих гээд байгаа мэт санагдах” (Франк Вальтер Штайнмайер) эх дэлхийгээ харахад үндэсний болон олон улсын бодлогод зүгээр л “Энэ чигээрээ цаашаа яваад бай” гэх нь яав ч хангалттай бус. НҮБ зэрэг байгууллагуудын ардчилал-нөлөөлөл суларч байгааг дунд хугацаанд засах ёстой. Германчууд бид, европчууд, барууны холбоотнууд, эсвэл дэлхийн хамтын нийгэмлэг ер нь дэлхий дахиныг ямар үнэлэмжүүд хооронд нь холбож байдаг вэ? гэдэг асуултын дор хэлэлцүүлэг өрнүүлэх ёстой.

Эцэст нь хүмүүс ирээдүйд эрчимтэй хөгжиж буй даяаршлын (Даяаршил ба нийгмийн ардчилал цуврал сурах бичгийн 7-р дэвтэр) улмаас олон улсын хамтын нийгэмлэгийн амжилт ба бүтэлгүйтэл, үйл ажиллагаа явуулах, үйл ажиллагаа эс явуулахын нөлөөг өөрсдийн хувийн амьдралын орчинд улам илүү мэдрэх болно.

Ирээдүйд өөрийн орны хүн амд гадаад бодлогын үйл ажиллагааг тайлбарлах, өөрийн орны иргэдээр хэлэлцүүлэх асуудал илүү чухал болно. Энд нэгэн адил бодлогын чигийг заагч луужин байр суурь, нотолгоогоо боловсруулж улам бэхжүүлэх, боловсронгуй болгоход маань туслах болно. Эцэст нь хэлэхэд хямралын бүх нөхцөлийг даван туулах, хүчирхийлэл хэрэглэсэн зөрчлийг шийдэх нэгдсэн стратеги байх боломжгүй гэдэг дээр санал нэгдсэн. Нэгдсэн стратегиас илүүтэй тухайн онцлог нөхцөл байдалд нийцсэн улс төрийн шийдэл ба хэрэгслүүдийн зөв холимгийг тодорхойлох хэрэгтэй. Иймээс германы үйл ажиллагааг тодорхойлох үнэлэмж, ашиг сонирхол, зорилтуудыг тодорхойлдог, хэрэгжүүлэлтийн алхмуудыг тодорхой заасан нэгдсэн үзэл баримтлал шаардлагатай. Учир нь энх тайвныг дэлгэрүүлэх боломжтой. Гаднын оролцогч талууд мөн энх тайвныг дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж ерөнхий нөхцөлүүдэд эергээр нөлөөлөх боломжтой. Энх тайвныг орон нутагтаа боловсруулах, тогтвортой тогтоох зорилтын хэрэгжилт эцсийн эцэст орон нутгийн болон бүс нутгийн оролцогч талуудын улс төрийн хүсэл зоригоос хамаардаг. Энэ нь мөн социал-демократ энх тайван, аюулгүй байдлын бодлогын луужингаас олж авсан мэдлэг юм.

Иймээс бид социал-демократ үзлийн өнцгөөс харахад дэлхий дахинд энх тайван-коллектив аюулгүй байдлыг дэмжихэд онцгой чухал үйл ажиллагааны гурван өөр талбар буюу тулах цэг\тулганы чулууг бид энд нэрлэж байна.

- а). Иргэний арга хэрэгслүүдээр хямралаас сэргийлэх, энх тайвныг дэмжих
- б). Намжмал байдлыг тогтоох бодлого, зэвсэг хураах, зэвсэглэл үл дэлгэрүүлэх
- в). Дэлхий дахины шударга ёс, олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа

Дараагийн хэсэгт эдгээр шийдлүүдийн тулгуур цэгүүдийн тойм зургийг гаргана. Сонгон авсан хэсгүүдийн талаар гүнзгийрүүлсэн мэдлэгийг хүмүүсийн саналаар дамжуулан олгох болно.

а) Иргэний арга хэрэгслүүдээр хямралаас сэргийлэх ба энх тайвныг дэмжих

Энх тайван, аюулгүй байдлыг хангах олон улсын хичээл зүтгэлийг бараг л хямрал бүрийг цэргийн шийдлээр шийдвэрлэх гэсэн, эсвэл тухайн газар нутгийн бодит байдлын цогц байдлыг бүрэн харж чадаагүй шийдлийг сонгон авч хэрэгжүүлдэг хямралт байдлаас гаргах хэрэгтэй. Ихэвчлэн “дээрээс доош” чиглэсэн өмнөх хямралуудыг шийдсэн хямралын менежментийн туршлагыг үл хэрэгссэн шийдвэрүүд гардаг.

*Өмнөх
хөндлөнгийн
оролцооны
туршлагаас
суралцах*

Афганистан ба Ливи улсад тогтвортой байдлыг тогтоох, төрийг сэргээн байгуулах зорилгын дор явуулсан цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцсон оролцоо тун хуумгай болжээ гэдгийг түүх харуулсан. Улс орнуудын дотоодын болон улс хоорондын зөрчлийг цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцох замаар шийдэх боломжгүй. Ливид дайныг хүчээр зогсоож чадсан ч дайны шалтгаан болсон зөрчлийг хэлэлцээр ба тохиролцооны үр дүнд шийдвэрлэж чадсан. Иймээс хүчирхийлэл дэгдэхээс өмнө хямралаас урьдчилан сэргийлэх, дэлхий дахинд энх тайван ба аюулгүй байдлыг дэмжихийн тулд хүч хэрэглэж байх үед болон хүчирхийлэл дууссаны дараа зөрчилдөөнийг судлан боловсруулах нь онцгой чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг германы улс төрд бодлогын талбаруудын огтлолцол буюу салбар дундын бодлогын стратегийн үүрэг гэдэг утгаар нь тусгах шаардлагатай.

*Энх тайвныг
дэмжих*

Энх тайвныг дэмжих үйл ажиллагаа гадагшаа энх тайванч, хамтын ажиллагааг дэмжсэн олон улсын харилцааг тогтвортой бэхжүүлэхэд чиглэсэн, ингэснээр дэлхий дахины эрх чөлөө, аюулгүй байдал, хангалуун амьдралын ерөнхий нөхцөлийг баталгаажуулахад хувь нэмрээ ёстой. Иргэний нийгмийн оролцогч талууд ба түншлэгч орнуудтай хэрэгжүүлж буй түншлэлийн хамтын ажиллагаанд дэлхий дахины энх тайванд хувь нэмрээ оруулах тухай үндсэн хуулийн зорилтууд ба оршлын үзэл санаанд нийцэж байгаа юм. Үйл ажиллагааны дараах талбаруудыг сонгон авах боломжтой. Эдгээр нь:

- Хамтын ажиллагаа, дүрэм журам дээр суурилсан олон улсын дэглэмийн үйл ажиллагааны ерөнхий хүрээний бодлого ба

*Үйл ажиллагааны
боломжит
талбарууд:*

санхүүг бэхжүүлэх

- Олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны чадамжийг дээшлүүлэх, Жишээ нь: НҮБ-ын энх тайвны архитектурын бүтэц ба энхийг сахиулах үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлэх, шинэчлэх, тогтвортой хөгжлийн 2030 зорилтуудыг хэрэгжүүлэх, эсвэл европын гадаад, аюулгүй байдлын бодлогын үндсэн тулгуур багана болох урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөтгөх, зуучлах, энхийг дэмжих арга хэмжээ, зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор НҮБ-ын байгууллагуудын бүтцийг өөрчлөн шинэчлэх
- Зөрчил гарсан газар нутагт зөрчлийн учир шалтгаануудыг урт хугацаанд нөлөөтэй байхаар боловсруулах, боловсруулалтад зөрчилдөөний учир шалтгаан нь улс төр-нийгмийн ерөнхий орчин, муу засаглал, хүний эрхийн зөрчил, нийгмийн хаалттай байдал, нийгмийн нөөцүүдээс хувь хүртэх боломж тэгш бус, мөнгө угаалт, зэвсгийн худалдаа зэрэг олон улсын хүчин зүйлсээс эхлэлтэй байдаг.
- Тухайн орон нутгийн иргэний нийгмийн оролцогч талуудыг бэхжүүлэх, орон нутагт энх тайвны архитектурын бүтцийг бий болгох
- Яриа, хэлэлцээ ба энх тайвны үйл явцыг дагалдах, дэмжлэг үзүүлэх, жишээлбэл эмэгтэйчүүдийг түлхүү оруулах замаар¹¹
- Шилжилтийн үеийн шүүх, өнгөрсөн үеийн түүхийн боловсруулалт, зөрчилдөгч талуудын хооронд зуучлах зэрэг шийдлүүдийг бэхжүүлэх
- Дэлхий дахины “хамгаалах хариуцлага”-ыг (responsibility to protect- R2P) олон улсын эрх зүйн нэгэн зарчмын хувьд бэхжүүлэх¹²

Хүч хэрэглэсэн зөрчилдөөн шат ахин хурцдаж буй эсвэл хэдийн хурцадсан газарт богино хугацаанд нөлөөлөх тогтворжуулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Эдгээр арга хэмжээ нь улс төрийн динамикт нөлөөлөх замаар хүчирхийллийг бууруулах, зөрчилдөөнийг оролцоог хангасан, тогтвортой шийдлээр шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгод чиглэгдэх ёстой. Тогтворжуулах арга хэмжээний төвд дипломат бодлогоор дэмжигдсэн улс төрийн үйл явц тавигдах ёстой. Хүмүүнлэгийн, хөгжлийн эсвэл аюулгүй байдлын бодлогын арга хэмжээнүүдээр

Дэлгэрүүлэн унших:
Эделгард Булмаан,
Бодо Шүлце болон
бусад зохиогчид /2017
он/, Энх тайвныг
дэмжих, даяаршлыг
гадагшаа болон
дотогшоо шударгаар
хэрэгжүүлэх, Эрхлэн
гаргагч ФЭС, Берлин
хот

Энх тайвныг
дэмжих, зөрчилдөөнд
хандах нийгмийн
хандлагыг өөрчлөх,
өргөн хүрээтэй, эв
санааны нэгдэлтэй,
тогтвортой, эрхлэн
гаргагч ФЭС, Берлин

11 Энэ номын Жендэр, зэвсэгт мөргөлдөөн, энх тайвныг хангах сэдэвт 4.4-р бүлгээс уншаарай.

12 Хөндлөнгөөс оролцохгүй гээд хараад суух уу? эсвэл хамгаалах уу? сэдэвт 7.4-р бүлгээс уншаарай.

тогтворжуулах арга хэмжээг дэмжиж өгөх хэрэгтэй. Ингэхдээ тухайн орон нутгийн онцлог нөхцөл байдалд яв цав нийцсэн төслүүдийг боловсруулах шаардлагатай.

*Харилцан үйлчлэл:
дотоод ба гадаад
энх тайван*

Энд дотоод ба гадаад энх тайван хоорондын харилцан үйлчлэлийн ач холбогдол дээшилнэ. Германд нийгмийн дотоодын зөрчил нэмэгдсээр байгаа нь бидний чухал нөөцүүдийг хооронд нь холбох замаар энх тайвныг гадагшаа дэмжих чадамжийг бууруулж байгаа юм. Харин бидний европын ойрын болон холын хөршүүдээ хоорондын зөрчилд хүргэхгүй байх, урьдчилан сэргийлэх, эсвэл бидний олон улсад явуулж буй үйл ажиллагааны үр дагавар нь шууд мэдрэгдэж байдаг дотоодын энх тайвнаа бэхжүүлэх чадамжийг дээшлүүлж байдаг. Бид нийгмийн дотоод энх тайвныг бэхжүүлэх явцдаа гадагшаа энх тайвныг амжилттай дэмжих чадамжаа нэгэн зэрэг дээшлүүлж байдаг. Эсрэгээрээ бид энх тайвныг гадагшаа дэмжих явцдаа дотоодын энх тайвнаа бэхжүүлж байдаг.

*Дотоодын энх
тайван*

Иймээс бид дотоодын энх тайвныг дэмжих үйл явцыг эрх чөлөөт нийгмийн байгуулал, ардчилал, нийгмийн шударга ёс, эв санааны нэгдэл, эрх зүйт төр зэрэг нийгмийнхээ үндсэн үнэлэмжүүдийг хамгаалах, тэдгээрийн нийгмийн суурийг бэхжүүлэх зорилготой уялдуулж байх ёстой. Иймээс улс төр манай нийгмийг хагалан бутаргах оролдлогыг няцааж, дотоодын улс төр, нийгэм, эдийн засгийн сорилтуудыг хүчирхийллээс ангид шийдвэрлэх замыг дэмжих ёстой.

б) Намжмал байдлын бодлого, зэвсэг хураах, зэвсэглэлийг үл дэлгэрүүлэх

Зэвсгийн (Жижиг) олдоц дэлхий дахинд нэмэгдсээр байна. Энэ нь нийтийн аюулгүй байдалд аюул учруулж, аюулгүй байдлыг худалдан авах чадалтай нь л хүртдэг тансаг баялаг болгож байна. Дээрээс нь хурцадмал байдалтай байгаа газар нутгууд руу зэвсэг экспортлох нь зөрчилдөөний гал улам дүрэлзэх аюулыг улам нэмэгдүүлж байна. Зэвсгийн экспорт хүмүүнлэгийн болон улс төрийн ямар гамшигт үр дагаварт хүргэдэг гэдгийг удаан хугацаанд үргэлжилж буй Йемений дайны жишээн дээр бид харж байна.

*Зэвсэглэлийг
(экспорт)
бууруулах*

Европын зэвсгийн үйлдвэрүүдийн хүчин чадал хэтийдсэн тул зэвсэг экспортлохыг шаарддаг. Зэвсгийн экспортын оронд урт хугацаанд ажлын байрны баталгааг хангах, салбарын инновацын чадамжийг иргэний зориулалтаар ашиглахын тулд тэд үйлдвэрчний эвлэлүүд ба улс төрчидтэй хамтраад зэвсгийн зориулалтыг хувирган өөрчлөх стратегиудыг боловсруулах хэрэгтэй.

Сүүлийн хэдэн арван жилд олон орны зэвсэгт хүчний зардал эрс нэмэгдлээ. Дээрээс нь нэмж хэлэхэд батлан хамгаалахын зардал нэмэгдэхийн хэрээр боловсрол, дэд бүтэц, нийгмийн хамгааллын системүүдэд зарцуулах мөнгө хомсдож, ингэснээр тухайн оронд улс төрийн зөрчил хурцдах эрсдэл үүсдэг. Аюулгүй байдлын аппаратууд гэдэг нэр зүүсэн байгууллагууд нь ихэвчлэн өөрийн орны сөрөг хүчний эсрэг ажиллаж, ноёлогч элитүүдийн эрх мэдлээ хадгалах хэрэгсэл болон ашиглагддаг.

Зэвсэглэлээр эрчимтэй хөөцөлдөх шинэ давлагаа Зүүн ба Баруун хоорондын зэвсэглэлээр хоорондоо өрсөлдөж байсан үеийн гамшигт өрсөлдөөн ба хүйтэн дайны үеийн айлган сүрдүүлэх бодлогыг санагдуулах боллоо. Заналхийлэлд өртөгч гэж өөрийгөө үзэж буй нэгэн аюулгүй байдлаа батлан хамгаалах, цэргийн хичээл зүтгэлээ нэмэгдүүлэх замаар хангаж чадна гэж боддог. Энэ механизм бидэнд танил юм. (Өөрийн гэртээ эсвэл холбоотнуудаа айлгах замаар)

Үүний оронд хүйтэн дайныг төгсгөл болгоход хувь нэмрээ оруулсан, хамтын аюулгүй байдал, итгэлцэл бэхжүүлэх арга хэмжээ, зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих, бөөнөөр нь устгах зэвсгийг үл дэлгэрүүлэх зэрэг үзэл баримтлалуудыг эргэн санах нь ашигтай.¹³

Хамтын аюулгүй байдал нь европын (энд Европын холбоо эсвэл барууны гэсэн агуулга байхгүй) аюулгүй байдлыг хангах архитекторын бүтцэд зориулан боловсруулсан үзэл баримтлал юм. Хүйтэн дайны үед хуримтлуулсан туршлага эвслүүд хоорондын зөрчилдөөний аюултай нөхцөл байдалд хүртэл Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны бага хурлыг (Эхлээд европын аюулгүй байдал хамтын ажиллагааны бага хурал-KSZE нэртэй

*Батлан
хамгаалахын
зардалд зарцуулж
байгаа мөнгө
өөр хаа нэгтээ
дутагдаж л
байгаа*

13 Цөмийн зэвсгийг хураах ба үл дэлгэрүүлэх сэдэвт 4.5-р бүлэг

Дэлгэрүүлэн унших:

Сараа Брокмайер (2017 он) Дипломатууд үгүй дипломат шийдэл гэж байхгүй. Пеаслав 2016 он, 2017 оны 4-р сарын 27-ны дугаарт нийтлэгдсэн нийтлэл

Уте Финч-Краемер (2016 он), Удирдамжид зориулсан нэгэн сэдэв: Зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих, Пеас Лав 2016, 2016 оны 11-р сарын 01-нд нийтлэгдсэн нийтлэл

Макс М. Мүчлер, Мариус Балес нар (2017 он), Лайсзес файре-ийн оронд Нотлох үүрэг Холбооны шинэ засгийн газрын германы зэвсэг экспортлох бодлогын шинэчлэлд зориулсан зөвлөмж, Олон улсын зэвсгийн зориулалт өөрчлөх төв, Бонн хот(BICC), Бодлогын захидал 7, Бонн хот

Маттеу Болтон (2017 он) Цөмийн зэвсгийг хориглох ба бүх хүмүүсийн аюулгүй байдал, Эрхлэн гаргагч Фридрих-Эбертийн Сан, Нью Йорк

байсныг хожим Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага-OSZE болгон өөрчилсөн) байгуулснаар намжмал байдал, улмаар хамтын аюулгүй байдалд хүргэх улс төрийн ерөнхий хүрээг бүрдүүлж чадсан гэдгийг эргэн санах хэрэгтэй.¹⁴

Харилцан итгэлцлийг бүрдүүлэх гэдэг нь эсрэг талынхаа бодит болон бодит юм шиг санагдаж буй аюулгүй байдлын санаа зовоосон асуудалд нухацтай ханд гэсэн санаа юм. Энэ утгаар Герман, Европын Холбоо нь урьдчилан сэргийлэх дипломат бодлогын салбарт илүү идэвх санаачилгатай ажиллаж НАТО-Орос-Зөвлөл, эсвэл Ойрх Дорнодын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурал зэрэг хамтын ажиллагааны форматыг санаачлах, өргөжүүлэх, эсвэл хоёр солонгосын асуудал зэрэг зөрчилдөөнтэй нөхцөлд зуучлагчийн үүрэг гүйцэтгэх санал тавина гэсэн үг юм.

Зэвсэглэл хураах, зэвсэглэлд хяналт тавих, зэвсэглэлийг үл дэлгэрүүлэх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь олон улсын өнөөгийн тогтворгүй орчинд урьд өмнөхөөс илүү чухал болоод байна.

Герман, Европын Холбооны Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд 2016 оны дундуур эхлүүлсэн ердийн зэвсэглэлд хяналт тавих тухай тохиролцоог шинэчлэх хичээл зүтгэл ба глобал төвшинд (Arms Trade Treaty, АТТ-зэвсгийн худалдааны гэрээ)-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, НҮБ-ын хүрээнд дэлхийн 130 гаруй орон гарын үсэг зурж нэгдээд байгаа “цөмийн зэвсгийг хориглох” тухай идэвх санаачилгад нэгдэх шаардлагатай байна. Үхэлд хүргэх автомат буюу өөрийн удирдлагатай зэвсэг хэрэглэхийг НҮБ-ын зэвсгийн тухай конвенцоор буруушаах хэрэгтэй.

Герман улс зэвсэглэх боломжтой дрон худалдан авахаас татгалзаж чадвал Герман бол иргэний-ба энх тайвны төлөөх гүрэн гэдэгт итгэх итгэл эрс дээшлэхсэн. Герман зэвсэг экспортлох хязгаарлагдмал бодлогыг хэрэгжүүлэх, зэвсгийн экспортын европын нэгдсэн бодлогыг үндэсний парламентууд болон европын парламентын

14 Энэ номын 3.4.4 1960-аад оны Зүүний шинэ бодлого бүлэг болон 5.4.Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага бүлгээс уншаарай.

идэвхтэй оролцоотойгоор батлуулах санаачилгад түүчээ тогорууны үүрэг гүйцэтгэх боломжтой. Ингэж чадвал ЕХ ба НАТО-ын гишүүн бус гуравдагч орнуудад зэвсэг экспортлохыг хориглох, зэвсгийн эд ангиудыг үйлдвэрлэх лиценз олгохыг хориглох, нэгэнт олгогдсон экспортын зөвшөөрлийг бага зэрэг цөөрүүлэх зэрэг арга хэмжээг энэ бодлогын хүрээнд хэрэгжүүлж болох юм.

Их 20-ийн гишүүн орнуудад дэлхий дахины цэргийн зардлын 80% нь ногдож байгаа бол дэлхий дахины зэвсгийн экспортыг бараг бүгдийг нь үйлдвэрлэж байна. Мөн геополитикийн хамгийн нөлөө бүхий ашиг сонирхлууд эдгээр орнууд дээр зангидагдаж байна. Иймээс Их 20 өнөөгийн зэвсэглэлээр хөөцөлдөх өрсөлдөөн ба хямралтай байгаа газар нутгуудад зэвсэг нэмж нийлүүлж байгаагийн гол хариуцлагыг хүлээх ёстой. Гол хариуцлага хүлээгчдийн хувьд энэ хандлагыг эргүүлэх гол хариуцлагыг мөн хүлээх ёстой.

в). Дэлхий дахины шударга ёс ба олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа

“Бид айдас, хүчирхийллээс ангид, энх тайвныг эрхэмлэгч, шударга, оролцоотой нийгмийг дэмжих шийдвэр дээрээ бат зогсох болно. Энх тайвангүй тогтвортой хөгжил гэж үгүй. Тогтвортой хөгжилгүй бол энх тайван гэж үгүй.”

(2030 зорилтуудын оршил)

Дэлхий дахины шударга ёс нь энх тайвны нэгэн чухал нөхцөл юм. Энэ утгаараа “2030 тогтвортой хөгжлийн зорилтууд” нь 2015 онд НҮБ-ын бүх гишүүн орнуудын соёрхон баталсан мянганы хөгжлийн зорилтууд (Millennium Development Goals)-ыг залгамжлагч нь юм. Тогтвортой хөгжлийн 17 (Sustainable Development Goals SDG) зорилтуудаас бүрддэг 2030 зорилтууд нь шударга, тогтвортой дэлхийг тодорхойлох гловал ерөнхий хүрээг тогтоох юм. Эдгээр зорилтуудыг өргөн хүрээтэй энх тайвны цар хүрээтэй нэгтгэснээр тогтвортой хөгжил ба хүмүүний аюулгүй байдал нь зөвхөн энх тайван цагт боломжтой, хүчирхийлэл, эргэлзээтэй байдал, муу засаглал үндсэн саад тотгор юм гэдгийг тодорхой харуулж байна.

Дроноос
татгалзах
Герман

Их 20-д: Дэлхий
дахины цэргийн
зардлын 80%
ногдож байна.

2030 тогтвортой
хөгжлийн
зорилтууд

Энх тайван:
гол тулгуур
багануудын нэг

Дэлгэрүүлэн унших:

Марк Ваксманн (2017 он), Зарчмууд дээр тулгуурлах нь тусгай, 2030 зорилтуудаар яаж зөрчилдөөний нөхцөл байдлыг энх тайванд хувиргах вэ? Энх тайван Хөгжил-зөвлөмж №12, Бонн хот

Баербэл Кофлер (2017 он), Хямралаас сэргийлэх ба хүний эрхийн хамгаалалд компаниудын гүйцэтгэх үүрэг ПеесЛав 2016, 2017 оны 5-р сарын 17

НҮБ (2017 он), энх тайвныг сахин хамгаалах гэж юу гэсэн үг вэ? Нью Йорк

Дэлхийн банкны бүлэг ба НҮБ (2017 он) Энх тайванд хүрэх замууд: хүч хэрэглэсэн зөрчилдөөнөөс сэргийлэх оролцоонд тулгуурласан шийдлүүд. Нью Йорк

Иймээс энх тайван нь эдгээр зорилтуудын таван үндсэн тулгуур баганын нэг (ардтүмэн, цэнхэр гараг, хангалуунамыдрал, энхтайван, түншлэл) ба бие даасан 16-дах зорилт юм. (Энх тайван, шударга ёс, хүчирхэг байгууллагууд). Эдгээр нэгдмэл хэтийн чиглэлийн ачаар бусад зорилтуудад мөн энх тайван ба аюулгүй байдалд чухал цар хүрээ ба хувь нэмэр тусгагдсан байдаг. Жишээлбэл: Ядууралтай тэмцэх, (Зорилт 1.4 нийгмийн үйлчилгээ ба газар ашиглалтаас тэгш эрхтэйгээр хувь хүртэх), боловсролын салбарт (Зорилт 4.7 Хүч үл хэрэглэх, энх тайвны соёлыг сургалтын агуулгад нэгтгэх), хүйсийн тэгш байдлыг хангах (Зорилт 5.2 Эмэгтэйчүүд ба охидын эсрэг хүч хэрэглэх аливаа хэлбэрийг устгах), Тэгш бус байдлын салбарт (Зорилго 10.2 Хүн амын бүлгүүд хоорондын улс төр, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулах), эсвэл хот ба бүс нутгийн хөгжилд (Зорилт 11 Тогтвортой, аюулгүй хотууд ба дүүргүүд).

Зорилтууд түгээмэл шинж чанартай байх ёстой. Тус зорилтууд “Хойд” ба “Өмнөд” буюу “Донор” ба “Тусламж хүлээн авагч” хоорондын ялгааг арилгаж бүх орнууд, улс төр, иргэний нийгэм, эдийн засгийн оролцогч талуудын хамтын хариуцлагыг тодорхойлж дэлхий дахинд эдийн засаг, нийгмийн нийгэм-экологийн шилжилтийг урагшлуулах ёстой. Учир нь нэн ялангуяа германд, европт, барууны ертөнцөд энэ шилжилтийг хийхгүй бол дэлхий дахины тэгш бус байдал, эрх мэдлийн тэгш хэмт бус харьцаа, эрх мэдлээс хараат байдал, байгаль орчны сүйтгэл, газар нутгийг тонон дээрэмдэх явдал газар авч эдгээрээс үүдэлтэй (хүчирхийлэл) зөрчилдөөн шийдвэрлэгдэхгүй мухардмал байдалд орох болно. (Бүтцийн) Хүчирхийллийн шалтгаан ба өөрийн хариуцлагад нухацтай дүн шинжилгээ хийхгүйгээр энх тайвныг дэмжих ба энгийн зөрчилдөөнийг боловсруулах үзэл баримтлалд дорвитой ахиц гарахгүй.

Германы хувьд манай улсын үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл (жишээ нь: Олон улсын санхүү, худалдаа, зэвсэглэл, байгаль орчны бодлогын салбарт) өөр нэгэн газарт, урьд өмнөхөөс илүү өргөн хүрээтэй зөрчилдөөний динамикийг үүсгэх боломжтой гэдгийг санаж байх ёстой. Үүний тулд зорилтууд хоорондын зөрчлийг илрүүлж хэлэлцэх хэрэгтэй. Жишээ нь: Холбооны засгийн газар ба Бундестаг “Энх тайванд нийлэмжтэй байдал”, эсвэл

тогтвортой байдлын өргөтгөсөн шалгалтын хүрээнд улс төрийн эерэг санаачилгууд ба хуулийн төслүүд дээр нэмэлт хяналт тавих боломжтой.

Мөн НҮБ-ын ерөнхий ассамблейн хуралдаан ба НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн “энх тайвныг тогтворжуулах” шийдвэрийн санаан дээр суурилан бүтцийн хүчирхийллийн шалтгаануудын боловсруулалтыг НҮБ ба НҮБ-ын гишүүн орнуудаас явуулж буй ажиллагааны төвд оруулах замаар энх тайвныг дэмжих ажиллагааг хүчирхийлэл хүрээгээ тэлэхээс өмнө явуулах ёстой гэдгийг онцлон тэмдэглэсэн.¹⁵

Цаашилбал Герман улс сул дорой, хямралд өртсөн орнуудад тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь онцгойлон дэмжлэг үзүүлэх санаачилга гаргах ёстой. Үүний тулд дэлхий дахины бүтцийн асуудлыг (жишээ нь: олон улсын худалдаа, санхүү, татвар, байгаль орчин, эрүүл мэндийн бодлогод) энх тайвны бодлогын хэтийн хандлагын үүднээс хамтран шийдэх ёстой.

4.2 Шударга ёсны үнэт зүйлээр дамжуулан энх тайвныг тогтоох нь

Зохиогч Фон Хайдемариэ Виесзорек-Цойл

Бид нийгмийн дотоодын зөрчил ба шинэ задралын цаг үед амьдарч байна. Бараг гурван аравны туршид үргэлжилсэн зах зээлийн радикализм бүх орны нийт хүн амын амьжиргааны доод төвшинд амьдарч байгаа 40%-ийг үл тоомсорлосноос болоод бүх орны нийгэмд баян, ядуугийн болон болон баян ба ядуу орнууд хоорондын ялгаа эрс нэмэгдсэн.

Өдгөө нэгэнт тогтоод байгаа хөгжиж буй орнуудын дийлэнхийг уламжлалт түүхий эдийн экспортлогчид, аж үйлдвэржсэн орнуудыг инновацтай үйлдвэрлэл эсвэл үйлчилгээний үйлдвэрлэгчид болгоод байгаа олон улсын хөдөлмөрийн хуваарилалт асуудлыг улам хурцатгаж байна. Энэ хөдөлмөрийн хуваарилалтын нөлөөгөөр аж үйлдвэржсэн орнууд ба хөгжиж буй орнуудын хооронд үйлдвэрлэл, өртөг шингээсэн үйлдвэрлэлийн шинэ сүлжээнүүд хөгжиж,

*Гурван арваны
туршид
зах зээлийн
радикализм*

*Гамшигт хөтлөх
нөлөөллүүд*

¹⁵ Энэ номын шударга ёсыг хангах замаар энх тайванд хүрэх сэдэвт 4.2-р бүлэг ба Хөгжлөөр энх тайванд хүрэх сэдэвт 4.3-р бүлгээс уншаарай.

эдгээрийн гамшигт нөлөө, жишээлбэл хувцас үйлдвэрлэлийн аж үйлдвэрт тодорхой харагдаж байна. Бангладеш болон бусад хөгжиж буй орнуудад хөдөлмөрлөх нөхцөл маш муу, цалингийн мөлжлөг явагдаж байна. Эрчимтэй хөгжлийн гараан дээрээ байгаа орнууд мөн адил хамгийн ядуу иргэдийн тоогоороо дэлхий дахинд тэргүүлж байна.

Хурцадмал

байдал:

Санхүүгийн зах

зээлийн хямрал

Дэлхий дахины шударга бус байдалд жишээлбэл “газар түрээслүүлэх” аргыг нэрлэж болно. Олон аж үйлдвэржсэн болон эрчимтэй хөгжлийн гараан дээрээ байгаа орнууд африкийн орнуудаас олон сая гектар газрыг эрчим хүчний ургамал тариалах зориулалтаар худалдан авч, эсвэл түрээсэлж байна. Гэтэл энэ газар нутаг нь африкчуудын хүнсний аюулгүй байдлыг хангахад эдгээр орнуудад нэн чухал хэрэгтэй байгаа юм. Эцэст нь 2008\2009 оны санхүүгийн зах зээлийн хямрал дэлхийн улс орнуудын нийгмийг доргиож, энэ доржилт хөгжиж буй орнуудад хамгийн хүндээр тусч, өлсгөлөнд нэрвэгдэгсдийн тоо нэмэгдсэн учраас улсын төсвийн мөнгөөр санхүүгийн зах зээлүүдийг тогтворжуулах арга хэмжээнүүдийг санхүүжүүлж, иргэдээ доголдсон, зохицуулалтгүй санхүүгийн эдийн засгийн алдагдлыг үүрэх золиос болгохоос хамгаалахыг оролдож байна. Энэ бүхэн тэртэй, тэргүй хүн амынх нь төрөл бүрийн бүлгүүд хоорондоо зөрчилтэй байсан орнуудад зөрчилдөөн ба хүчирхийллийн хэлбэртэй маргааныг улам хурцатгаж байна.

Зөвхөн санхүүгийн

секторыг аврах

нь хангалтгүй.

Санхүүгийн секторыг аврахын тулд тэрбум тэрбумаар нь мөнгө зарцуулдаг хэр нь дэлхийг өлсгөлөн, ядуурал, ажилгүйдэл эсвэл цаг уурын өөрчлөлтөөс хамгаалах хүчгүй, зориггүй үеийнхэн гэдэг нэрээр түүхэнд үлдэхийг манай үеийнхэн бид зөвшөөрч болохгүй.

Учир нь зах зээлд бүхнийг даатгасан даяаршлын нөлөө дээр дэлхий дахины цаг уурын өөрчлөлтийн нөлөө нэмэгдсээр байна. Эдгээр өөрчлөлтүүд дэлхийн агаар мандлын дулааралд хамгийн бага хувь нэмэр оруулсан, дэлхийн хамгийн ядуу орнууд, хүн амын хамгийн ядуу бүлгүүдэд хамгийн хүндээр тусаж байна гэдгийг НҮБ ахин дахин сануулсаар байна. Эдгээр орнууд болон хүн амын бүлгүүд амьдралын боломжуудаа алдах, өлсгөлөнд нэрвэгдэх, өсөн нэмэгдэж буй байгалийн гамшигт нэрвэгдэх, дүрвэх зэргээр энэ хохирлыг төлж байна.

Эдгээр гарааны тэгш бус нөхцөлүүдээс үүдэлтэй газар нутаг, ус, ашиглаж болох газрын төлөөх хэр хэмжээний хохирол, сүйтгэл дагуулахыг тооцох боломжгүй хүчирхийллийн хэлбэртэй маргаан, зөрчлөөс урьдчилан сэргийлэхийг хүсэж байгаа бол олон улсын хамтын ажиллагаа ба шударга ёс зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл 2000 онд мянганы хөгжлийн зорилтуудаар дэвшүүлсэн дэлхий дахинд ядууралтай тэмцэх хамтын зорилтоо 2015 он хүртэл хэрэгжүүлсэн байх ёстой бөгөөд эдгээр 8 журмыг даяаршлыг шударгаар хөгжүүлэхэд дагаж мөрдөх ёстой.

Мянганы хөгжлийн зорилтуудын дараагаар 2015 оны 9-р сард тогтвортой хөгжлийн зорилтуудыг баталсан. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг 2030 он хүртэл хэрэгжүүлэх ёстой. Эдгээр зорилтуудыг бүх орон түгээмэл хэрэгжүүлж, ядууралтай хийх тэмцлийг цаг уурын өөрчлөлтийн эсрэг хийх тэмцэлтэйгээ холбох ёстой юм. Үүний тулд юуны өмнө бүх орны амьжиргааны доогуур төвшинд амьдарч буй 40%-ийн амьдралын нөхцөлийг сайжруулж, нийгмийн дотоодод шударга ёсыг илүү бэхжүүлэх шаардлагатай. Нийгмийн шударга ёсыг хангахын тулд германд цалингийн идэвхтэй бодлого хэрэгжүүлж хуулиар цалингийн доод хэмжээг тогтоож байгаа бол хөгжиж буй орнууд олон улсын хөдөлмөрийн байгууллагаас тогтоосон зохист хөдөлмөрийн суурь хэм хэмжээнүүдийг баримталж нийгмийн хамгааллын суурь түвшнийг тогтоох ёстой.

Өнөөдөр тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа хүн бүр дараагийн хэдэн арван жилд тохиох нийгмийн хүнд “цунами”-гийн хариуцлагыг хүлээх болно. Иймээс шаардлагатай байгаа нийгэм-экологийн шилжилтийг хийхэд аж үйлдвэржсэн орнууд үлгэр жишээ үзүүлж, дэвшилтэт засгийн газрууд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран дэвшилтэт эвслүүдийг байгуулж, санхүүгийн амлалтаа биелүүлж, зарцуулалтын төрлийн эзэлж буй хувь хэмжээг өөрчлөх хэрэгтэй байна. 1.7 их наяд доллар зэвсэглэлд зарцуулсан хэр нь хөгжлийн хамтын ажиллагаанд зөвхөн 130 тэрбум евро зарцуулж байгаа өнөөгийн харьцааг өөрчлөх шаардлагатай.

Дэлхийд зэвсгийн экспорт хэрэггүй, мөн байлдааны дрон зэрэг шинэ зэвсэглэлээр хөөцөлдөх шинэ өрсөлдөөн ч хэрэггүй. Дэлхийд

Мянганы
хөгжлийн
зорилтууд

Тогтвортой
хөгжлийн
зорилтууд (SDG)

Зэвсэглэлд:
Хөгжлийн хамтын
ажиллагаанд
жил тутамд 130
тэрбум доллар
зарцуулж байгаа
бол, зэвсэглэлд
жил бүр 1.7 их
наяд доллар
зарцуулж байна.

илүү шударга ёс хэрэгтэй байна!. Тэртээ дээр үед Билли Брандтын Хойд-Өмнөдийн илтгэлдээ дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шударга ёс ба энх тайван нь ихэр төрсөн эгч дүүс юм.

Дэлгэрүүлэн унших:

Фон Хайдемариэ Виесзорек -Цойл (2017 он), Шударга ёс ба энх тайван нь ихэр төрсөн эгч дүүс юм. Марбург

Томас Погге (2015 он), Ядуурал дэлхий дахинд ба хүний эрхүүд-зохион бичлэг, Холбооны улс төрийн боловсролын төв (Эрхлэн гаргагч) Улс төр ба он цагийн түүхүүд сэтгүүл 2007 оны дугаар 24, Бонн хот

Тилман Сантариус (2007 он) Цаг уурын өөрчлөлт ба гловал шударга ёс, Холбооны улс төрийн боловсролын төв (Эрхлэн гаргагч) Улс төр ба он цагийн түүхүүд 24/2007, Бонн хот

Тиймээ. Заримдаа “хамгаалах хариуцлага”-аа хэрэгжүүлэхийн тулд цэргийн ажиллагаа явуулах шаардлага гардаг нь үнэн. Гэхдээ: Энэ дэлхийн хамгийн хүнд зөрчилдөөнийг заавал зэвсгийн хүчээр шийдвэрлэдэггүй. Шударга ёс, энх тайван хоёр бол ихэр эгч дүүс юм. Энэ нь Европын Холбооны энх тайвны шагналыг шалгаруулахад тавигддаг нэгэн шаардлага юм. Хүн бүр энх тайван, шударга ёсны агуулгаар аливаа үйл хэрэгт хандах ёстой.

Билли Брандт Хойд, Өмнөдийн бодлогын оршилд алсын хараатай тодорхойлсон байдаг:

“Бидний тайлан.... зөвхөн дайн ба энхийн сонгодог асуудлуудыг тусгаад зогсоогүй харин дэлхий дахинд өлсгөлөнг яаж ялах вэ? нийтийг хамарсан зовлон зүдүүр, баян ядуугийн амьдралын нөхцөлийн тэгш бус байдлаас үүдэлтэй сорилтуудыг яаж даван туулах вэ? гэдэг асуудлыг ч багтаасан. Нэгтгээд хэлэх юм бол: Энэ тайлан бол энх тайвны тайлан юм гэж хэлсэн байдаг.”
(Билли Брандт 2013 он, 39-р тал)

4.3 Хөгжлөөр дамжуулан энх тайвныг ТОГТООХ НЬ

Зохиогч Инке Виесе

“Амьжиргааны суурь нь өдөр тутмын энгийн хэрэгцээнээс болоод ганхахдаа тулж байдаг газарт аюулгүй байдлын тухай ярихын ч хэрэггүй. \...\ Дайныг жигшигч хүн бүр, өлсгөлөнг мөн жигших хэрэгтэй.”

(1973 он, 35-37-р хуудас. ХБНГУ улс НҮБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан Билли Брандтын НҮБ-ын ерөнхий ассамблейн хуралдаан дээр хэлсэн үг. 1973 оны 9-р сарын 26)

Хөгжлийн бодлого боловсруулагчдад ядуурал ба дайн хоорондоо

нягт холбоотой гэдэг нь ойлгомжтой байгаа. Аюулгүй байдлын бодлогод энэ холбоосыг урт хугацаанд харгалзалгүй явсаар ирлээ.

Хэдийгээр 1980-аад онд Билли Брандтын удирдлага дор ажилласан НҮБ-ын Хойд-Өмнөдийн комисс хаалтын илтгэлдээ зааварчилгаа өгсөн боловч хөгжлийн бодлогын хямралаас урьдчилан сэргийлэх чадамжийг удаан хугацааны туршид үл тоомсорлосоор иржээ. Үүний оронд эвслүүд хоорондын мөргөлдөөний үед буюу 1980-аад оны сүүлч хүртэл хөгжлийн хамтын ажиллагааг ихэнхдээ ядууралтай хийх тэмцэл гэхээс илүү улс төр ба аюулгүй байдлын эвслийг баталгаажуулах хэрэгсэл болгон ашиглаж иржээ. (Хаттори 2001 он)

Харин 1990-ээд оны эхэн үеэс ядуурч хоосорсон орнуудын нийгэм ба төрөөс дэлхий дахины аюулгүй байдалд эрсдэл учруулах аюултай талаар дахин эрчимтэй хэлэлцэж эхэлсэн. Өргөн хүрээтэй аюулгүй байдлын ойлголтын тухай улс төрийн хэлэлцүүлгийн цаана улс төрийн практик дээр хөгжлийн хамтын ажиллагааны ач холбогдлыг аюулгүй байдлын бодлогын хэрэгсэл болгох хэмжээнд бууруулах аюул нуугдаж байдаг.

Иймээс энэхүү бүлгээр зөвхөн хөгжлийн хамтын ажиллагааны бодлогын чадамжийн тухай ойлголтыг гүнзгийрүүлээд зогсохгүй хөгжлийн бодлогод өөрийн гэсэн тодорхой зорилтууд бий шүү гэдгийг сануулах болно. Хөгжлийн бодлогын эдгээр зорилтууд гадаад-аюулгүй байдлын бодлогын болон эдийн засаг, санхүүгийн бодлогын ашиг сонирхлуудтай зөрчилдөхийг үгүй гэх газаргүй юм. (Фон Виесзорек-Цойл 2007 он, 247-р тал)

“Хөгжил” хувьсалд загвар

Олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл үеэс буюу дэлхийн бөмбөрцгийн өмнөдийн олон орнууд колоничлолын задралын хүрээнд үндэсний тусгаар тогтнолоо олж авсан тэр үеэс эхэлсэн гэж үздэг. Тухайн үеийн дэлхийн бөмбөрцгийн хойд зүгийн аж үйлдвэржсэн орнуудын хөгжлийн бодлогын идэвх санаачилга эхлээд “хөгжлөөр гүйцэх” буюу “үлгэр жишээ авч хөгжих” загвараар илэрхийлэгдэж байлаа.

*Чадамжийг олж
харалгүй олон
жил өнгөрч
-1990 оноос хойш
хэлэлцүүлгийн
агуулга
өөрчлөгдсөн.*

*1945 оноос хойш:
төрөл бүрийн
загвар*

Дэлхийн бөмбөрцгийн өмнөдийн орнуудын ард түмнийг хөгжлөөр хол түрүүлсэн хойд зүгийн орнуудын жишээгээр баримжаа аван хөгжих гэж байгаа “хоцрогдсон” ард түмэн хэмээн тодорхойлж байлаа. Харин ямар стратегиар хөгжвөл зохистой вэ? гэдэг дээр саналын асар том зөрүүтэй байлаа.

Шинэчлэлийн онол

Шинэчлэлийн онол нь юуны өмнө нийгмийн дотоодын хаалт буюу тухайн үеийнхээ байгаа байдалтайгаа зууралдах, хөдлөхгүй байх чиг хандлагад гол асуудал нь байна хэмээн үзэж байлаа. Шинэчлэлийн онол хөгжлийн бодлого аж үйлдвэржилтийг гаднаас нь дэмжиж ингэснээр нийгмийн соёл өөрчлөгдөх үйл явцыг эхлүүлэх ёстой хэмээн үзэж байлаа. Үүний үр дүнд “уламжлалт” байгууллагуудыг “орчин үеийн” байгууллагуудаар солих замаар хөгжиж буй орнууд албадлагаар, автоматаар ардчилагдах ёстой байлаа.

Хараат байдлын онолчид

Марксаас санаа авсан хараат байдлын онолчдын зүгээс харахад хөгжиж буй орнууд хөгжлөөр буурай байгаа нь тэдний буруу биш, харин дэлхийн бөмбөрцгийн хойд зүгийн аж үйлдвэржсэн капиталист орнуудаас болоод тэд ийм нөхцөл байдалд орсон. Иймээс хараат байдлын онолчид дэлхийд эдийн засгийн шинэ дэглэм тогтоохыг шаардаж байлаа. Тэдний энэ нотолгоо бурууг үндэсний төрөөс бус харин гловал бодлогоос хайснаараа шинэчлэлийн онолоос ялгаатай.

Хараат байдлын онол: хараат байдал буюу захирагдах гэсэн утгатай ‘dependencia’ гэдэг испани үгнээс гаралтай. Энэ онолын төлөөлөгчид хөгжиж буй орнууд аж үйлдвэржсэн орнуудаас хараат байдалд оршиж байгаа учраас ядуу байгаа юм, иймээс аж үйлдвэржсэн орнууд тэдний ядуу зүдүү байдлын бурууг хамтдаа хүлээх ёстой хэмээн үзэж байлаа.

Неосонгодог ба неолиберализм

Хүйтэн дайны үеийн системийн зөрчлийн нэгэн илрэл хэмээн үзэж болох дээрх хоёр онолд 1970-аад оноос эхлэн олон талаас нь өрсөлдөгчид гарч ирсэн. 1970-аад оноос хойш хөгжлийг санхүүжүүлэгч байгууллагууд олноороо байгуулагдаж байх үед үүссэн нео-сонгодог ба неолиберал шийдлүүдийн дээрх хоёр шийдлээс ялгаатай нь төр дээр бус харин хувийн секторт түшиглэдэг.

Ядууралтай тэмцэх бодлогыг зах зээлийн өөрийн зохицуулалтын чадамжтай зөрчилдөж байна, “нийгмийн зардлыг суга өсгөлөө” гэдэг шалтгаанаар үл хэрэгсдэг. Үр дагаварт нь хөгжлийн бодлогын стратегийн хүрээнд 1990-ээд оны сүүлч хүртэл засгийн газрын чадамжийг бэхжүүлэх асуудлыг орхигдуулсан. 2001 онд Афганистаны асуудалд хөндлөнгөөс оролцсоноос хойш энэ хандлагад эргэлт ажиглагдаж эхэлсэн. (Майр 2005 он)

Мөн 1970-аад оны үеэс гловал хөгжлийн амлалтад экологийн асуудлууд хязгаарлалт тавих юм байна гэдэг мэдлэг гүнзгийрч эхэлсэн. Тухайн үед үүссэн “тогтвортой хөгжил-sustainable development”-ийн үзэл баримтлалын дагуу хөгжил нийгэмд ээлтэй, нийт нийгмийн хангалуун амьдралын төвшинг дээшлүүлэхийн тулд байгалийн нөөцийг ариг гамтай зарцуулах ёстой гэдэг үзэл бэхэжсэн байдаг.

Эдийн засагт чиглэсэн эдгээр шийдлүүдийн эсрэг, цаг хугацааны хувьд ойролцоо хувь хүн дээр төвлөрсөн “human development-хүний хөгжил” гэдэг шинэ үзэл баримтлал үүсэн хөгжсөн. Уг үзэл баримтлал нь хүмүүс өөрсдийн үйлдвэрлэгч чадамж ба capabilities-ур чадвараа цогцоор нь хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, өөрсдийн хэрэгцээ ба ашиг сонирхолд нийцсэн бүтээмжтэй, бүтээлч амьдралаар амьдрахын чухлыг сурталчилдаг.

Хүний хөгжлийн үзэл баримтлал нь хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх ёстой долоон эрх чөлөөнд багтаасан. Эдгээр нь:

- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх чөлөө
- Зовлон зүдүүрээс ангид байх эрх чөлөө
- Хүн бүрийн хөгжих ба авьяас чадвараа хэрэгжүүлэх эрх чөлөө
- Айдсаас ангид байх эрх чөлөө
- Шударга бус байдлаас ангид байх эрх чөлөө
- Шийдвэр гаргалтад оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, эвсэл, холбоо байгуулах эрх чөлөө
- Дарлал мөлжлөгөөс ангид зохист хөдөлмөр эрхлэх эрх чөлөө

Эдгээр эрх чөлөөг нобелийн шагналт Амартияа Сен “чадамжийн шийдэл” хэмээн нэрлэсэн бөгөөд хөгжлийн зорилт бөгөөд хэрэгсэл

*Тогтвортой
хөгжил*

Хүний хөгжил

*Амартияа Сен:
“Чадамжийн
шийдэл”*

болох чадамжийн шийдэл нь хүний хөгжлийн үзэл баримтлалын үндсэн тулгуур баганын нэг юм. Тэрээр эдийн засгийн өсөлтийн стратегиуд нь зөвхөн эдийн засгийн эрх чөлөөг дэмжихийг гол зорилтоо болгох нь хангалтгүй, харин нийгмийн хүчин зүйлсийг адилхан харгалзан үзэх ёстой гэдэг шаардлагыг тавьсан. (Сен 1999 он, 43-р хуудас)

Сений үзэл баримтлал нь юуны өмнө хүний хөгжлийн индекс зэрэг хүний хөгжилд гарсан дэвшлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах удирдамж болсон юм. Хүний хөгжлийн индекс нь юуны өмнө хөгжлийн тухайн хүрсэн түвшнийг боловсролын түвшин, дундаж наслалт, худалдан авах чадвараар хэмжигдэх амьдралын стандарт зэрэг үзүүлэлтүүдээр хэмждэг.

*Шинэ фокус:
“чадавхижуулах”*

Хувь хүмүүсийг чадавхижуулах, тэдэнд эрх олгоход гол анхаарлаа хандуулах ёстой гэдэг шаардлагыг зөвхөн “хүний хөгжил”-ийг хөхиүлэн дэмжигчид төдийгүй хөгжлийн хамтын ажиллагааг практик дээр хэрэгжүүлэгчид тавьдаг. Иймээс “participatory development-оролцоог хангасан хөгжил”-ийн шийдэл, жишээ нь орон нутгийн хүн амын оролцоог хөгжлийн төслүүдийн төлөвлөлт ба хэрэгжилтэд нэмэгдүүлэхийг шаарддаг.

Энэ нөхцөлд “дороос дээш чиглэсэн хөгжил буюу өвсний үндэс шийдэл” гэж ярьцгаадаг. Олон тооны орон нутгийн хөдөлгөөнүүд ба ТББ-уудын даяаршлыг шүүмжлэх шүүмжлэл хүчээ авч байгаа өнөө үед “оролцоог хангасан хөгжил”-д ихээхэн анхаарал хандуулах боллоо. Гэхдээ энэ шийдлийг нэгэнт тогтсон эрх мэдлийн бүтцүүдийг цементлэн бэхжүүлж, захад шахагдсан, хохирсон бүлгүүдийг анхаарлын гадна орхигдуулдаг хэмээн шүүмжилдэг.

*Феминист
шийдлүүд*

Эдгээр хохирогч бүлгүүдийн нэг нь бол эмэгтэйчүүд. Ялангуяа феминист судлаачид хөгжлийн бодлогын үйл ажиллагааны эмэгтэйчүүдэд нөлөөлөх үр дагаврыг мэдрэх чадвараа дээшлүүлэхийг шаарддаг. Мөн энх тайвны бодлогод улс төр, нийгэм, мөн хувь хүмүүсийн хувьд нөлөө бүхий оролцогч тал учраас эмэгтэйчүүдэд илүү анхаарал хандуулах ёстой.¹⁶

Хөгжлийн бодлогын стратегиуд ба тодорхой зорилтууд

¹⁶ Энэ номын жендер, зэвсэгт мөргөлдөөнүүд ба энхийг тогтоох сэдэвт 4.4 бүлгээс уншаарай.

НҮБ олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны стратегийн зорилтуудыг тодорхойлсон. Эдгээр зорилтуудаас хамгийн чухал нь (Millennium Development Goals MDGs)-мянганы хөгжлийн найман зорилт юм. Эдгээр найман зорилт нь өмнөх үеийн өсөлтөд суурилсан хөгжлийн шийдлүүдийг үндсэн хэрэгцээг хангахад чиглэсэн стратегиудтай холбосон нэгэн шинэ стратегийн суурийг бүрдүүлдэг. Ядууралд чиглэсэн өсөлтийг ("pro-poor growth") эхний ээлжид өргөн хүрээтэй эдийн засгийн өсөлтийн зорилтод чиглүүлэх ёстой. (Сангмаистер\Шоенштедт 2009 он, 179-р хуудас)

Энэхүү үндсэн хэрэгцээг хангахад чиглэсэн стратегиуд нь ядуусыг өөрсдөө "үндсэн хэрэгцээгээ шууд ба тогтвортой хангах, дээрээс нь илүү гарсныгаа эдийн засгийн эргэлтэд оруулах, урт хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулсан илүүдлээсээ үйлдвэрлэлийн хэрэгслээ санхүүжүүлэх" хэмжээнд хүртэл чадавхжуулах ёстой. (Нүшелер 2005 он, 232-р хуудас) Мянганы хөгжлийн зорилтууд хэтэрхий эдийн засгийн сонирхлыг өдөөх механизм дээр суурилсан, нийгмийн эрх мэдлийн тэгш бус харьцааг арилгах арга хэмжээнүүдийг анхаарлын гадна орхигдуулсан гэдэг шүүмжлэлд ихэвчлэн өртдөг. (Сангмаистер\Шоенштедт 2009 он, 184-р хуудас)

Энэ талаас нь харахад МХЗ-уудыг тогтвортой хөгжлийн зорилтууд гэж нэрлэгддэг (Sustainable Development Goals SDG -Тогтвортой хөгжлийн зорилтууд, цаашид ТХЗ хэмээн товчлох) ТХЗ-ууд болгон цаашид хөгжүүлэх тухай хэлэлцүүлэг улс төрийн хувьд илүү амбицтай өрнөсөн.

2015 онд эдгээр зорилтуудаас 17 зорилтыг олон улсын хамтын нийгэмлэгээс баталсан бөгөөд эдгээр зорилтууд 2030 он хүртэлх хөгжлийг хөтлөх ёстой юм. Эдгээрт нийгмийн хүчин зүйлсийн зэрэгцээ эдийн засаг ба экологийн хүчин зүйлсийг өмнөхөөс илүү харгалзан үзсэн бөгөөд уг зорилтууд даяаршлын үйл явцыг тогтвортой, шударгаар жолоодоход чиглүүлэх юм. 16-р зорилт (Энх тайван, шударга ёс, хүчирхэг байгууллагууд) нь улс орнуудын нийгмийг илүү амар амгалан, шударга болгох, хүчирхийллийн бүх хэлбэрийг бууруулахад чиглэгддэг. Гэсэн хэдий ч барууны аж үйлдвэржсэн олон орнууд энэ зорилтын хэрэгжилтэд эргэлзээтэй хандаж байна.¹⁷

17 Социал-демократ олон улсын энх тайвны стратегийн тулгын чулуунууд сэдэвт 4.1 бүлгээс уншаарай.

Хөгжлийг зөвхөн материаллаг дэвшилтэй адилтган үздэг үзэл баримтлалуудын талд нийгмийн болон оюун санааны амар амгалан байдлын ач холбогдлыг онцлон тэмдэглэдэг шийдлүүд гарч ирсэн. (Зондерманн 2013 он, 187-р хуудас) Дээрээс нь дэлхийн өмнөдийн орнууд БРИКС-ын удирдлага дор (БРИКС-Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк) хөгжлийн хэлэлцүүлгийн фокусыг хэрэгцээнээс илүү хүний эрхийг хангах шаардлага руу шилжүүлэхийг эрчимтэй шаардаж байна. Тэртээ 1959 онд батлагдсан ГСДН-ын Годесбергийн хөтөлбөрт энэ шаардлагыг тавьсан байдаг. (Эпплер 2007 он, 131-р хуудас) Хөгжих эрхийг хэрэгжүүлэх шаардлага, жишээлбэл хөгжлийн санхүүжилтийн загваруудад томоохон үр дүн авчрах болно.

*Стандарт
загвар биш*

Ядууралтай хийх тэмцлийг дэлхий дахинд улс төрийн бодлогын талбаруудын огтлол буюу салбар дамнасан бодлогоор хэрэгжүүлнэ.

Өнөөдөр хөгжлийн бодлогын стандарт загваруудаар ядууралтай тэмцэх боломж урьд өмнөхөөс илүү буурч байна. Доройтож буй орнуудын зүгээс хүн ам олонтой, эрчимтэй хөгжлийн гараан дээрээ байгаа Хятад, Энэтхэг, Пакистан зэрэг орнуудад улам бүр нэмэгдэж байгаа ядууралтай улс төрийн өөр хэрэгслүүдээр тэмцэхийг шаардаж байна. Дээрээс нь ирээдүйд эрчимтэй хөгжлийн гараан дээрээ байгаа, хүн ам олонтой орнуудад амьдарч буй ядуусын дийлэнх хэсэгт хөгжлийн бодлогын арга хэмжээнүүдийг хүргэх боломжгүй болно. Арга хэмжээнд хамрагдахгүй үлдэх ядуусын тоо улам нэмэгдсээр байх болно. Эдгээр орнуудын улс ардын аж ахуй өсөн тэлж байгаа тул хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй материаллаг, технологийн, боловсон хүчний дэмжлэгийн ашиг тусаас өчүүхэн хэсгийг л хүртэх болно.

Ингэснээр бөмбөрцгийн хойд зүгийн орнуудын баячууд дангаараа бус, харин өмнөд зүгийн орнуудын шинэ баячуудаас дэлхий дахины шударга ёсны цоорхойг нөхөхөд хувь нэмрээ оруулахыг шаардах болно. (Нүшелер 2005 он, 485-р хуудас)

Зах зээлүүдийн өөрийн зохицуулалт ба даяаршил бараг автоматаар бүх хүмүүсийг хангалуун амьдрүүлчихна гэдэг горьдлогыг хэтэрхий

Дэлгэрүүлэн унших:

*Германы хөгжлийн
хамтын ажиллагааны
ирээдүй Блог, [http://b.ogs.
die-gdi.de/zukunft-der-ezl](http://b.ogs.die-gdi.de/zukunft-der-ezl)*

*Холбооны эдийн
засгийн хамтын
ажиллагааны яам
(2013 он), Энх тайван,
аюулгүй байдлыг
хангахад хөгжлийн
үүрэг, Зөрчилдөөн,
доройтол ба
хүчирхийлэлтэй
талбар дээрх хөгжлийн
бодлогын хичээл
зүтгэл, Германы эдийн
засгийн хамтын
ажиллагааны яамны
стратегийн баримт
бичиг 412013, Берлин*

удаан тээлээ. Өнөөгийн хөгжлийн бодлогын болон даяаршилд шүүмжлэлтэй ханддаг хэлэлцүүлгүүдэд даяаршлын хохирогсдод идэвхтэй дахин хуваарилалтын бодлогоор дамжуулан санхүүгийн хохирлыг нь барагдуулах нөхөн олговор олгохыг шаардах боллоо. (Шнайдер 2006 он, 123-р хуудас) Энэ хохирлыг хөгжлийн бодлого дангаараа барагдуулах боломжгүй. Хувийн эдийн засгийн оролцогч талуудад нэгэн адил даяаршлыг шударгаар хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүрэг ногдуулах ёстой. Олон улсын бодлого, эдийн засгийн харилцан хамаарал ба эрчмийг илүү сайн мэдрэхийн тулд хэрэглэгчдийн дунд ухамсрын хувьсал явагдах ёстой.

Хэтийн төлөв

Сүүлийн хоёр арван жилд явагдсан хэлэлцүүлгүүд алсыг харсан, өргөн хүрээтэй энх тайвны бодлого нь аюулгүй байдлын бодлогын хамгийн нөлөө бүхий хэлбэр юм байна гэдэг ойлголтыг бэхжүүлээ. Хөгжлийн бодлого хамгийн өндөр ач холбогдолтой ч бусад салбарууд бодлогоор дэмжиж өгөх хэрэгтэй.

Брандтын илтгэлийн хувь заяа, түүнийг олон улсын бодлогын түлхүүр буюу хамгийн чухал баримт бичиг гэдгийг хэдэн арван жилийн дараа ойлгосон нь онолын мэдлэгийг идэвхтэй бодлогын практикт тусган хэрэгжүүлэх ямар хүнд байдаг вэ? гэдгийг харуулж байна. (Месснэр 2013 он) Салбар дамнасан хамтын ажиллагаагаар харилцан бие биеэ нөхөх, үр өгөөжийг нь дээшлүүлэх нөлөөг нэмэгдүүлэх боломжтой. Салбар дундын хамтын ажиллагаа нь мэргэжлийн улс төрчид өөрсдийн дүн шинжилгээ ба стратегиудаар сохор толбонуудыг ил болгоход тустай. Аюулгүй байдлын өргөн хүрээтэй ойлголтын үүсэн хөгжсөн түүх ба хөгжлийн бодлогыг аюулгүй байдлын бодлогод ашигтай байх ёстой гэдэг шалгуурт нийцүүлэн хумих аюул зэрэг нь эдгээрийн тодорхой жишээнүүд юм.

Гэвч аюулгүй байдлын бодлогын ярилцлагын хүрээлэлд цаашид ч хөгжлийн болон энх тайвны бодлого тодорхойлогчид байхгүй хэвээр байх нь, тэгэхлээр эдийн засаг, байгаль орчин, нийгмийн бодлого тодорхойлогчид байхгүй байх нь бүр ч ойлгомжтой. Дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа цогц асуудлуудыг үзэл баримтлалууд ба стратегиудыг тухайн асуудлын шийдэлд

*Хар буюу сохор
толбонуудыг
гэрэлт толбонууд
болгох*

хамрагдаж буй талбаруудын мэдлэг, туршлагаар баяжуулсан байж л шийдвэрлэж чадна. Германы стратегийн чадамжийн тухай шинээр өрнөж буй хэлэлцүүлгийн шийдлийн саналууд өмнөх үеийн хэлэлцүүлгийн эрхэд суурилсан шаардлагын хүрээнээс хальж чадалгүй үлдчих бий гэдэгт анхаарал хандуулах шаардлагатай.

4.4 Жендэр, зэвсэгт мөргөлдөөн ба энх тайвныг тогтоох

Зохиогч Константин Баервалд

Аюулгүй байдлын (олон улсын) бодлогын хэлэлцүүлэг юуны өмнө 1990-ээд оны эхэн үеийнхээс хувьсан өөрчлөгджээ гэдэг нь 2.3-р бүлгээс тодорхой харагдлаа. Хамгаалалтад байх ёстой бүлгүүд ба хувь хүмүүс аюулгүй байдлын бодлогын төвд орж ирсэн. “Хүний аюулгүй байдал”-ын үзэл баримтлал ба НҮБ-аас хүлээн зөвшөөрсөн “хамгаалах хариуцлага”-ын зарчим нь энэ хөгжлийн оргил цэгүүд юм.

Хэлэлцүүлэгт гарсан энэ шилжилтийн нөлөөгөөр аюулгүй байдлын бодлогын ажиглалтын төвд зөвхөн төр тодорхойлогч объект байхаа больсон. Мөн зэвсэгт мөргөлдөөн болсон газар нутаг дээр байгаа (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд) мөргөлдөөнд нэрвэгдсэн, хамгаалагдах хэрэгцээ бүхий хүмүүсийг аюулгүй байдлын бодлогод харгалзан үзэх байдал дээшилсэн.

*Шинэ:
жендерийн
онцлогтой
асуултууд*

Аюулгүй байдлын бодлогын хэлэлцүүлгийн хүрээг өргөтгөснөөр анх удаа жендерийн онцлогтой асуудлуудыг өмнө нь уламжлалт аргаар явагдаж ирсэн аюулгүй байдлын бодлогод онцлон тэмдэглэсэн. Зэвсэгт мөргөлдөөн хүйсийн харьцаанд ямар нөлөө үзүүлдэг вэ? Хүйсийн онцлогтой үүргийн талаар өмнө тогтсон ойлголт, хүчний харьцаа зэвсэгт мөргөлдөөний үед хүчирхэгждэг үү? эсвэл сулардаг уу? Энх тайвны үйл явцууд дайны дараах үеийн нийгэмд хүйсийн харьцаа шинээр тогтоход өөрчлөлтийн ямар чадамжийг агуулж байдаг вэ?

*НҮБ 2000:
1325-р шийдвэр:
“Эмэгтэйчүүд, энх
тайван, аюулгүй
байдал”*

Олон улсын эрх зүйд энэхүү хувьсан өөрчлөгдсөн үзэл бодол 2001 онд батлагдсан НҮБ-ын “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал”-ын тухай 1325-р шийдвэрт тусгалаа олж норматив

хэлбэрээр илэрхийлэгдсэн байдаг. Олон улсын хамтын нийгэмлэг энэ шийдвэрт анх удаа эмэгтэйчүүд дайн ба зэвсэгт мөргөлдөөний үр дагаварт онцгой нэрвэгддэг, энэ нь дэлхий дахины энх тайван ба аюулгүй байдалд тулгамдаж буй нэгэн заналхийлэл юм гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Өнөөдрийг хүртэл уг шийдвэр болон энэ хооронд уг шийдвэрийг дагалдан гарсан долоон шийдвэр нь олон улсын энх тайван, аюулгүй байдлын бодлогод хүйсийн тэгш эрхийг тусгах тухай олон улсын хамтын нийгэмлэгээс гаргасан хамгийн дэлгэрэнгүй тайлбар юм.

НҮБ-ын гишүүн орнууд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн амьдралын нөхцөл ба үүргийн зөрүүтэй байдлыг дайн ба дайны дараах үеийн нөхцөл байдалд, иргэний арга хэрэгслээр дайнаас урьдчилан сэргийлэх, тухайн улсын сэргээн босголтын үйл хэрэгт харгалзан үзэх ёстой. Эмэгтэйчүүдийг энх тайван, аюулгүй байдлын бодлогын бүх салбарт тэгш эрхтэйгээр оролцуулах ёстой. Дээрээс нь эмэгтэйчүүд зөрчилдөөнд хүргэхгүй байх, зөрчилдөөн, мөргөлдөөнд хандах нийгмийн хандлагыг өөрчлөхөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бол үүнийг олон улсын бодлогод онцгойлон үнэлэх ёстой. НҮБ-ын 1325-р шийдвэр ба уг шийдвэрийг дагалдан гарсан бусад шийдвэрүүд цаагуураа охид, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалахыг уриалсан.

НҮБ-ын 1325-р шийдвэр гарсны 15 жилийн ойг тохиолдуулан НҮБ-ын захиалгаар энх тайван, аюулгүй байдлын бодлогын шийдвэрт дэвшүүлсэн зорилтууд хэр хэрэгжиж байгааг судалсан. Судалгааны үр дүн зорилтуудын хэрэгжилт туйлын хангалтгүй байгааг харуулсан. 2000 оноос хойш дэвшил гарсан ч энхийн хэлэлцээрт эмэгтэйчүүдийн оролцоо урьдын адил туйлын хангалтгүй байна. Зөрчилдөөний дараах үед эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн ашиг сонирхлыг хангалттай хэмжээнд харгалзан үздэггүй. Эрэгтэйчүүд урьдын адил төрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагуудад давамгайлж, НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагааны боловсон хүчний 95 хүртэлх хувийг бүрдүүлж байна. Эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зөрчилдөөнтэй олон газарт системтэйгээр зэвсэг болгон ашиглаж байна.

*Зорилтууд
хэрэгжсэн үү?*

Хүйсийн онцлог үүрэг ба зэвсэгт мөргөлдөөний шалтгаан, үр дагавар

Адилхан...

Зарчмын хувьд эмэгтэйчүүд зэвсэгт мөргөлдөөний үр дагаварт охид, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ба хөвгүүдтэй адилхан арга хэлбэрээр нэрвэгддэг. Тэдний амь насыг бүрэлгэж, бэртээж гэмтээж, эрүүдэн шүүж, булаан авч, хүчирхийлдэг. Тэднийг зэвсгээр айлган сүрдүүлж нутаг орноос нь хөөн зайлуулж тэд ядуурал, өлсгөлөн, өвчин, айдсын зовлон амсдаг. Албадан хөдөлмөр, боолчлол, албадан нүүлгэлт нь зэвсэгт мөргөлдөөний хэвшмэл дагалдах үзэгдэл болж байдаг. Амьд гарахын төлөөх өдөр тутмын тэмцэл нь өөрөө дайн, мөргөлдөөний шалтгаан ба үр дагавар болж байдаг.

...эрэгтэйчүүд ба
эмэгтэйчүүд өөр
өөр заналхийлэлд
өртдөг

Олон тооны хяналтын үр дүн зэвсэгт мөргөлдөөн эрэгтэй ба эмэгтэйчүүдийн амьдралын ертөнцөд өөр өөр хэлбэрээр заналхийлдэг (заналхийлэх боломжтой) гэдгийг тогтоосон. 1945 оноос хойш зэвсэгт мөргөлдөөн ба дайны хөлд амь эрсэдсэн энгийн иргэдийн дунд эмэгтэйчүүд, хүүхдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илт давуу байна. Дайны дүрвэгсдийн 70-80% нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байна. Дүрвэн зайлах замдаа ба дүрвэгсдийн лагерьт эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэл болон хүчирхийллийн бусад хэлбэрт илүү өртөмхий байдаг. Өнгөрсөн болон өнөө үеийн зэвсэгт мөргөлдөөний үед бэлгийн хүчирхийллийг дайны стратегийн хэрэгсэл болгон ашигласаар ирсэн. Руанда, Сиерра Леона, Боснид бөөнөөр нь хүчиндсэн хэрэг хүн төрөлхтний түүхэнд болсон хамгийн хүнд гэмт хэрэгт тооцогддог. Сири, Иракийн дайны үед эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн бэлгийн доромжлол ба хүчирхийлэл нь өөрсдийгөө Исламын улс гэж нэрлэдэг дайчдын эзэрхэг үзэл суртлын цөмийг бүрдүүлж байжээ.

Шууд бус үр
дагаврууд

Эмэгтэйчүүд ихэнхдээ зэвсэгт мөргөлдөөний шууд бус үр дагаварт илүү өртдөг. Энх тайван цагт эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс өндөр байдаг бол зэвсэгт мөргөлдөөнтэй үед эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс богиносдог. Нийгэм, эдийн засгийн бүтцүүд зэвсэгт мөргөлдөөний улмаас шууд ба шууд бусаар сүйтгэгддэг. Энэ нь амьдралын суурь, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд гамшигт нөлөө үзүүлдэг. Дэлхий дахинд

зөрчилдөөнтэй бараг бүх газар, нутаг дээр зөрчилдөөний эдийн засгийн чухал хэсгийг бүрдүүлж байдаг эмэгтэйчүүдийн наймаа, насанд хүрээгүй хүүхдүүдийг буруугаар ашиглах (албадан), биеийг нь үнэлүүлэх явдлыг дэмждэг бүтцүүд бий болсон байдаг. Тэдний сэтгэлийн шарх дээр бэлгийн замын өвчин, ДОХ-оор өвчлөгсдийн тоо эрс нэмэгдэж байгаа нь бэлгийн хүчирхийллийн үр дагавар юм.

Зөвхөн эмэгтэйчүүд л зэвсэгт мөргөлдөөний золиос болдог мэтээр ярих нь буруу. Иймэрхүү тодорхойлолт эмпирик судалгаагаар батлагдаагүй. Иймээс эрчүүд бол “дайчид”, эмэгтэйчүүд бол “золиос” гэдэг буруу хэвшмэл ойлголт олны дунд амь бөхтэй хэвээр байна. Хүйсийн шударга бус байдлыг хэвшмэл загварууд улам бэхжүүлж байдаг.

Үнэн байдал илүү цогц байх нь ойлгомжтой. Эмэгтэйчүүд ч тэмцдэг (жишээ нь: Эритрея, Балба, Шри Ланка, Мьянмарт), зэвсгийн үйлдвэрт ажилладаг, армийг дэмждэг. (Жишээ нь: дэлхийн хоёрдугаар дайны үед Германд, АНУ-д), дайн зогсоох тухай хэлэлцээр хийж (Жишээ нь: Сири эсвэл Мьянмар) энх тайвныг түгээн дэлгэрүүлж, энх тайвныг хамгаалахын төлөө ажилладаг. (Жишээ нь: Либериа, Руанда)

Үүргийн энэхүү олон талт байдал нь эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн биологийн өгөгдлийн үр дүн биш, харин нийгмийн зүгээс тэдэнд оноож буй үүрэг болон хүйсүүд хоорондын эрх мэдлийн харьцааны үр дүн юм. Эмэгтэйчүүд эхээс төрөхөөсөө илүү энх тайвныг эрхэмлэдэг хүйс биш, харин тэдэнд ногдуулсан нийгмийн үүрэг нь тэднийг ихэвчлэн хүчирхийлэл, цэрэг, дайнаас илүү хол байлгадаг. Зөрчилдөөний болон дайны дараах үеийн орнуудын нийгэмд хүйсийн үүргийн хуваарилалт энх тайвныг хангах ба тогтоох үнэт нөөц гэдэг нь батлагдсан.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга агсан Кофи Аннан үүнийг дараах үгсээр тодорхойлсон. “Дайнд нэрвэгдсэн орнуудад эмэгтэйчүүд ихэнхдээ нийгмийг авч явдаг. Тэд нийгмийн байгууллын баталгаа болж байдаг. Тэд нийгмийн үйлчилгээг орлож, өвчтөнүүд, шархдагсдыг асарч байдаг. Үр дүнд нь эмэгтэйчүүд энх

*Хэвшмэл
ойлголтоос
болгоомжил*

тайвны хамгийн чухал тууштай хамгаалагчид юм.”¹⁸

*Судалгаанууд:
Хүйсийн шударга
ёсыг хангасан
орнууд илүү амар
амгалан байдаг.*

Жендер ба энх тайвныг тогтоох

Хүйсийн шударга ёсыг бэхжүүлэх болон тогтвортой энх тайвныг дэмжихийн тулд НҮБ-ын 1325-р шийдвэрийн шаардлагын дагуу эмэгтэйчүүдийг дайны дараах нийгмийн бүтээн байгуулалтад бүрэн оролцуулахыг шаарддаг. Олон судалгаа нийгэмд эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд хоорондын эрх мэдлийн зөрүү бага байхын хэрээр тухайн орны нийгэм ба гадаад харилцаа илүү энх тайванч байдаг гэдгийг баталсан. Дайнаас энх тайван байдалд шилжих шилжилтийн үеийг амжилттай туулахыг хүсэгч орнуудын зөрчилдөөний дараах нийгэмд маш өндөр шаардлагууд тавигддаг. Шилжилтийн үеийн нийгэм зарчмын хувьд эмзэг болон хэврэг байдлаар илэрхийлэгддэг. Нийгмийн төслүүдийн төлөөх улс төрийн өрсөлдөөн ба үндэсний, үндэсний цөөнхийн, соёлын, шашны, ижил төстэй ба ялгамж чанарыг /шинэчлэн/ тодорхойлох тухай хэлэлцүүлэг ихэвчлэн эрчимтэй өрнөж байдаг. Жендерийн мэдрэмжтэй хэтийн чиг хандлагаас харахад энэ үе шатанд хүйсүүд хоорондын харьцааны асуудлыг хөндөхөд ихээхэн таатай нөхцөл бүрдсэн байдаг. Дайны гашуун дурсамж, сэтгэлийн шаналал, бэлгийн хүчирхийлэлд зохистой үнэлэлт, дүгнэлт өгөх нь үүнтэй холбоотойгоор маш чухал. Учир нь эдгээр гэмт хэргүүд ихэнхдээ зөрчилдөөний явцад хүйсийн шударга ёс ноцтой зөрчигдсөний илэрхийлэл байдаг.

*Сэргээн
босголтын үед
эмэгтэйчүүдийг
хүчирхэгжүүлэх*

Хувьсал ба эрчимтэй хөгжлийн үед эмэгтэйчүүдийг тэгш эрхтэйгээр шийдвэр гаргах байр сууринд гаргаж, тэдэнд энх тайвны хэлэлцээр, төрийн албаны албан тушаал, албан бус байгууллагуудад удирдах үүрэгтэйгээр оролцуулах хэрэгтэй. Эмпирик судалгааны үр дүн эмэгтэйчүүд энх тайвны яриа хэлэлцээ, сэргээн босголтод оролцоотой байх нөхцөлд энх тайвны хэлэлцээр илүү удаан хугацаагаар мөрдөгддөг гэдгийг тогтоосон. Хууль зүй, цагдаа, цэрэгт эмэгтэйчүүдийн үнэлэмжийг дээшлүүлэх нь шийдвэрлэх үүрэгтэй. Ингэснээр хүйсийн онцлогтой заналхийлэл, аюулын мэдрэмж, нийтийн болон хувийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дайны дараах үеийн нийгэмд квот нэвтрүүлэх

18 Übersetzung JD: „In war-torn societies, women often keep societies going. They maintain the social fabric. They replace destroyed social services and tend to the sick and wounded. As a result, women are the prime advocates of peace.”

зэргээр “эрх олгох” арга хэмжээ маш чухал байдаг. Эмэгтэйчүүдийг дэмжих нь дангаараа хангалтгүй байдаг.

Эрэгтэйчүүд заавал жендерийн бодлогыг эсэргүүцэгч байх албагүйн нэгэн адил эмэгтэйчүүд заавал жендерийн шударга ёсыг хангах бодлогын өмгөөлөгч нар байх албагүй. Эмэгтэйчүүдийг дэмжих нь жендерийн бодлогыг орлож чадахгүй, хамгийн муугаар бодоход эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн дэвшил, хөгжилд дайсагнасан хандлага нь хүйсийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

Афганистанд жишээлбэл, эмэгтэйчүүдийг дэмжих төслүүдийг афганистаны хүн ам сөргөөр хүлээн авдаг. Учир нь эмэгтэйчүүдийг дэмжих төслүүдийн техникийн шийдэл тус улсын улс төр, нийгэм, соёлын онцлог нөхцөл байдлыг хангалттай хэмжээнд харгалзан үзэж чаддаггүй. Эмэгтэйчүүдийг дэмжих төсөлд эрэгтэйчүүдийг хамруулдаггүй учраас тэдэнд ялгаварлан гадуурхагдаад байгаа мэдрэмж төрж, эмэгтэйчүүдийн төслийн дэмжлэгээр дээшилсэн үүргийг хүйсийн уламжлалт үүргийг нь илүү хүчтэй эргэн сануулах замаар эрэгтэйчүүдэд ашигтай байдал үүсгэж, өөрсдийнхөөрөө нөхөх оролдлого хийдэг.

Иймээс олон улсын оролцогч талууд тухайн оронд ноёлдог жендерийн ижил төстэй ба ялгамж чанарыг ойлгохын тулд тухайн зөрчилдөөний нөхцөл байдлын нийгэм, соёл, түүхийн өргөн хүрээтэй ойлголттой байх ёстой. Мөн зөрчилдөөний эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд болон тэдгээрийн гэр бүлд нөлөөлөх нөлөөг тухайн орны онцлог, нөхцөл байдалд нийцүүлэн ойлгох хэрэгтэй. Зөвхөн ингэсэн нөхцөлд тухайн оронд жендерийн тогтсон уламжлалт бүтцийг энх тайвныг тогтоох үйл ажиллагаагаар улам бэхжүүлэх бус, харин урт хугацаанд эергээр өөрчилж чадна. Зөрчилдөөний дараах үеийн нийгэмд үндэсний болон олон улсын оролцогч талуудын явуулах үйл ажиллагаанд тавигдах наад захын шаардлага бол тодорхой бодлого, хөтөлбөрүүд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд хэрхэн өөр өөр арга хэлбэрээр нөлөөлөх вэ? гэдгийг ухамсарлах чадвартай байх ёстой.

Эмэгтэйчүүдийг дэмжих нь жендерийн бодлогыг орлож чадахгүй.

Тухайн онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэх

Дэлгэрүүлэн унших: Лина Абирафен (2008 он) Зөрчилдөөний дараах Афганистанд хэрэгжүүлсэн жендэрт суурилсан олон улсын тусламжаас авсан сургамж, ФЭС, Бонн хот

Санам Нараги Андерлини (2007 он), Эмэгтэйчүүдийн энхийг тогтоохын төлөө хийж байгаа ажил ямар учраас чухал вэ? Боулдер Эделгард Бүүлманн болон бусад

4.5 Цөмийн зэвсэглэл ба үл дэлгэрүүлэх бодлого

Зохиогч Оливер Траенерт

2009 оны 4-р сарын 5-нд америкийн тухайн үеийн ерөнхийлөгч асан Барак Обама Прагийн цайзын өмнө онцлон тэмдэглүүштэй нэгэн илтгэл тавьсан юм. Түүний илтгэлийн гол сэдэв нь цөмийн зэвсэглэл байсан юм. Обамагийн зорилго бол цөмийн зэвсгийг бүгдийг нь устгах гэдэг утгатай үг хэлсэн. Тэр өөрөө энэ алсын харааг биелэхийг үзэхгүй байж магадгүй, харин ирээдүй хойч үеийнхэн цөмийн зэвсэггүй дэлхийн төлөө тууштай тэмцэх ёстой. Тэгэхгүй бол эрт орой хэзээ нэгэн цагт бүх зэвсгийн хамгийн хүчтэй нь болох цөмийн зэвсгийг ашиглах аюултай бөгөөд тооцоолох боломжгүй үр дагаврыг нь шууд нэрвэгдэгсэд, цаашлаад нийт хүн төрөлхтөн амсах болно.

Анхны атомын бөмбөг

1945 оны 4-р сарын 5 -нд Невадагийн цөлд анхны атомын бөмбөгийг дэлбэлсэн цагаас хойш цөмийн эрин үе эхэлсэн. Түүнээс хойш удалгүй 1945 оны 8-р сарын 6 ба 8-нд АНУ-ын агаарын цэрэг японы Хирошима, Нагасаки хотууд дээр тус бүр нэг атомын бөмбөг хаясан. Япон дайнд бууж өгч, дэлхийн хоёрдугаар дайн дууссан. Атомын бөмбөгдөлтөөс хүний ой тойнд багтахын аргагүй их хохирол учирсан бөгөөд цөмийн мэргэжилтнүүд ба улс төрчид дараагаар нь тун удалгүй цөмийн зэвсгийг нээснээс хойш дэлхий бүр мөсөн өөрчлөгджээ гэдэг дүгнэлтийг хийсэн. Ирээдүйд цөмийн дайн гаргуулахгүй байх дээр санал нэгдсэн.

1949 онд ЗХУ анхны атомын бөмбөгөө дэлбэлсэн. Үүний дараагийн жилүүдэд Зүүн ба Баруун хоорондоо уралдан цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөж эхэлсэн. 1962 оны Кубын хямралын үед ЗХУ атомын зэвсгээ карибын арал дээр өөрөөр хэлбэл Америкийн хаалганы босгоны дор байршуулж, хоёр супер гүрэн цөмийн мөхлийн ирмэг дээр ирсэн юм. Зөвхөн том аз тохиосны ачаар энэ цөмийн мөргөлдөөнөөс сэргийлж чадсан. Эндээс хоёр тал хоёулаа суралцаж, дараахан нь цөмийн зэвсгийг бууруулах ба зэвсэглэлд

зохиогчид (2003 он), Энхийг дэмжих, зөрчилдөөнд хандах нийгмийн хандлагыг өөрчлөх стратегийн үндсэн асуудлууд: өргөн хүрээтэй, эв санааны нэгдэлтэй, тогтвортой. ФЭС (Эрхлэн гаргагч), Берлин хот

Николе Детраз (2012 он) Олон улсын аюулгүй байдал ба Жендэр, Мемпис

Юудит Анн Тикнер (2001 он), Дэлхийн бодлогод жендерийн нөлөө, Хүйтэн дайны дараах үеийн асуудал ба шийдэл, Нью Йорк

НҮБ Эмэгтэйчүүд (2015 он) Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, Шилжилтийн үеийн шударга ёс, энх тайвныг хангах. НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн 1325-р шийдвэрийн хэрэгжилт дэлхий дахинд судалгаа

хяналт тавих тухай хэлэлцээрийг эхлүүлсэн. Олон төрлийн гэрээний тусламжтайгаар цөмийн зэвсгээр зэвсэглэх өрсөлдөөнийг төрөлжүүлж чадсан юм.

1987 он: Орос ба Америк зэвсэглэлээ бууруулж эхэлсэн.

1980-аад онд АНУ НАТО-гийн давхар тогтоолын хүрээнд шинэ цөмийн зэвсгээ Европт байршуулахаар төлөвлөж байх үедээ өргөн хүрээг хамарсан эсэргүүцэлтэй тулгарсан юм. Социалдемократ нам тухайн үед шинэхэн үүсгэн байгуулагдаад байсан энх тайвны хөдөлгөөнд идэвхтэй оролцож эхэлсэн. Хэдийгээр цөмийн зэвсэг бодитойгоор байршуулж эхэлсэн боловч 1987 оны 12-р сард АНУ-ын ерөнхийлөгч Роналд Реаген, ЗХУ-ын ерөнхийлөгч Михаел Горбачёв нар дунд тусгалын цөмийн зэвсгээ бүгдийг нь устгах тухай гэрээнд гарын үсэг зурсан.

Эхний удаад цөмийн зэвсгийн нэг ангиллыг бүгдийг нь устгасан. Хүйтэн дайны төгсгөл үед Реаген, Горбачёв нар ЗХУ ба АНУ харилцан шууд хүрч чадах алсын тусгалын стратегийн цөмийн зэвсгийг бууруулах тухай СТАРТ хэлэлцээрийг эхлүүлж чадсан юм. 1991 онд ЗХУ задарсны дараагаар хараат бус Казахстан, Украин, Беларусын бүгд найрамдах улсууд өөрсдийн газар нутаг дээр байршуулсан атомын зэвсгээс татгалзаж Орос руу шилжүүлснээр СТАРТ-ын ач холбогдол нь эрс дээшилсэн. Энэ талаар СТАРТ-ын хэлэлцээрийн протоколд 1994 онд тэмдэглэсэн байдаг.

Хүйтэн дайн төгсгөл болсны дараагаар цөмийн зэвсэглэлийн олон асуудлын ач холбогдол буурч эхэлсэн. АНУ, Орос хэлэлцээрээ үргэлжлүүлсээр байсан ч дорвитой үр дүнд хүрээгүй. 2010 оны 4-р сард Обама, Медведев нар СТАРТ-ыг залгамжлах гэрээнд гарын үсэг зурсан. Стратегийн цөмийн зэвсгийн тоонд шинээр хязгаар тавьж, ингэснээр зэвсэг хураах зорилтод нэгэн шинэ алхам хийсэн.

Атомын зэвсэгтэй шинэ гүрнүүд

Энэ хооронд цөмийн зэвсгийг улам дэлгэрүүлэхэд тулгарсан асуудал тэргүүн эгнээнд гарч ирсэн. Тэртээ 1950-аад он, 1960-аад оны үед Франц, Их Британи, Хятад улсууд цөмийн туршилт явуулж атомын зэвсгийн чадамжтай гэдгээ баталсан. Израйл нэгэн адил

*СТАРТ-Эхлэл,
хэлэлцээр*

*2010 он: СТАРТ-ыг
залгамжлагч*

*Улам
дэлгэрүүлэхэд
тулгарсан
асуудал*

цөмийн зэвсгээ хөгжүүлсээр байсан ч туршилт хийж батлаагүй. Өнөөг хүртэл израйлийн бүх засгийн газрууд Израйл улс цөмийн зэвсэг эзэмшдэг гэдгийг батлахаас татгалзсаар ирсэн.

1998 онд Энэтхэг, Пакистан атомын зэвсгээ туршсан. Ингэснээр тэд цөмийн зэвсэгтэй орнуудын клубт элссэн. Эдгээр хоёр орон хоёулаа Камширын бүс нутгийг эзэмших эрхтэй гэж үздэгээс үүдэлтэй хоорондоо улс төрийн зөрчилтэй байдаг учраас энэ бүс нутаг дээр цөмийн мөргөлдөөнд хүрэх эрсдэлтэй. Эцэст нь Хойд Солонгос 2006 оны 10-р сард цөмийн дэлбэлэгч бодис дэлбэлсэн. Ядууралд гүнзгий өртсөн, улс төрийн хувьд тусгаарлагдсан энэ улс 2009 оны 5-р сард, мөн 2013 оны 2-р сард дараагийн оролдлогуудаа хийсэн. Үүнээс хойш Хойд Солонгос цөмийн зэвсэгтэй гүрэнд тооцогдох болсон.

Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээний асуудал (ЦЗҮДГ)

Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ ёсоор бол шинээр цөмийн зэвсэгтэй болох гүрнүүдийн тоо нэмэгдэхгүй байх ёстой байлаа. 1970 онд хүчин төгөлдөр болсон уг хэлэлцээрийн дагуу гэрээнд нэгдсэн орнууд (Энэ хооронд бараг бүх орон) цөмийн зэвсгээс татгалзах үүрэг хүлээсэн. Гэвч энэ гэрээнд зарим онцгой тохиолдлыг зааж өгсөн. Учир нь уг гэрээ батлагдахаас өмнө цөмийн зэвсэгтэй болчихсон байсан АНУ, Орос, Хятад, Их Британи, Франц улсуудыг цөмийн зэвсэг эзэмшихийг зөвшөөрсөн. Гэсэн ч тэд цөмийн зэвсгийг бүр мөсөн устгах зорилгоор цөмийн зэвсэг хураахын төлөө хүчин зүтгэх болно гэдэг амлалтыг өгсөн. Энэтхэг, Пакистан, мөн Израйл эхнээсээ цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээнд нэгдэхгүй гэдгээ илэрхийлж гэрээнд нэгдээгүй. Хойд Солонгос 1985 онд гишүүнээр элссэн ч 2003 онд гишүүнчлэлээ цуцалсан.

*Цөмийн зэвсэг үл
дэлгэрүүлэх тухай
гэрээ (NVT)*

Иран

Цөмийн зэвсэггүй дэлхий болох Обамагийн алсын хараа цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээг бэхжүүлэхтэй нягт холбоотой байлаа. Цөмийн зэвсэг хураах чиглэлд хийгдэх шийдэмгий алхмууд наанаа юу ч байхгүй гээд суугаад байдаг орнуудыг ЦЗҮДГ-г бэхжүүлэх нь зайлшгүй чухал гэдэгт итгүүлэх хэрэгтэй байлаа. Уг гэрээнд гэрээгээр хүлээсэн үүрэгтээ үнэнч бус гишүүн орнуудаас болоод ахин дахин заналхийлэл тулгарч байдаг. 1980-аад онд иракийн

дарангуйлагч Саддам Хуссейн ЦЗҮДГ-ээр хүлээсэн үүргийнхээ эсрэг нууцаар цөмийн зэвсэгтэй болохын төлөө ажиллаж байв. Иракийн цөмийн зэвсгийн хөтөлбөр 1990-ээд оны үед НҮБ-аас тогтоосон онцгой дэглэмийн (1991 онд булангийн дайныг зогсоох, дайн дуусгах тухай хэлэлцээрийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг нь болж байлаа) нөлөөгөөр учир нь тайлагдаж, дуусгавар болсон юм. Ираны цөмийн хөтөлбөрийн хувьд Европын холбоо-3+3 (Франц, Их Британи, Герман, АНУ, Орос, Хятад)+ Иран 2015 оны 7-р сарын 14-нд өргөн хүрээг хамарсан үйл ажиллагааны хөтөлбөрт гарын үсэг зурсан нь дипломат бодлогод гарсан чухал дэвшил байлаа.

Дүрэм зөрчсөн Ираны өмнө дахин цөмийн зэвсэггүй ЦЗҮДГ-ний гишүүн орон болох боломж нээлттэй байгаа. Тегеран ойрын 10-15 жилд цөмийн хөтөлбөрт нь томоохон хязгаарлалт тавихыг зөвшөөрсний үндсэн дээр зохих дэд бүтцүүдийг хэвээр нь үлдээх боломжтой болсон. Харин Иран урт хугацаанд цөмийн зэвсгийн өөр хувилбаруудаас татгалзсан хэвээрээ байх уу? гэдэг нь тодорхойгүй хэвээр байна.

Хойд Солонгос, Ирак, Иран ЦЗҮДГ-ний зарчмын сул талуудыг харуулж байна. Нэн ялангуяа энх тайвны зориулалтаар гэж зарлан тунхаглаад байгаа цөмийн хөтөлбөрүүд учир дутагдалтай. Иймээс 1990-ээд онд өргөн хүрээтэй мэдэгдэх үүрэг ногдуулсан, олон улсын цөмийн энергийн газрын байцаагч нарын цөмийн байгууламжид нэвтрэх эрхийг илүү баталгаажуулсан шинэ удирдамжуудыг боловсруулсан. ЦЗҮДГ-ний гишүүн олон орнууд, цөмийн зэвсэгтэй гүрнүүд цөмийн зэвсэг хураах зорилтын хүрээнд тодорхой дэвшилд хүрсний дараагаар эдгээр удирдамжийг дагаж мөрдөхөд бэлэн гэдгээ илэрхийлж байна.

Харин Америк-Орос хоорондын холбогдох хэлэлцээрүүд хүлээгдсээр байна. Америкийн пуужингаас хамгаалах чадамжаа нэмэгдүүлэх төлөвлөгөө Оросын аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй хэмээн Москва болгоомжилдог. Цаашилбал Орос үргэлжлүүлэн шинэчилсээр байгаа цөмийн зэвсгээ нэр төрийн чухал овъект хэмээн үздэг учраас тоог нь цаашид цөөрүүлэхийг хүсэхгүй байгаа юм. Доналд Трампын толгойлж буй АНУ-ын засгийн газар цөмийн

*ЦЗҮДГ-ний
сул талууд*

зэвсэг хураахад хэр зэрэг бэлэн байгааг одот тэнгэр л мэдэх хэрэг. Одоогоор Вашингтон эхний ээлжид цөмийн зэвсгээ шинэчлэхийн төлөө ажиллаж байна.

Мөн Франц, Их Британи, Хятад ирээдүйд явагдах зэвсэг хураах тухай хэлэлцээрт хэр хэмжээнд оролцох нь тодорхой бус байна. Өнөөг хүртэл эдгээр орнууд эхний ээлжид АНУ ба Орос тэдний түвшинд хүртэл зэвсэглэлээ хорогдуулаг, тэгснийх нь дараагаар хэлэлцээрт оролцоно гэдэг шалтгаанаар хаалт хийсээр байна. Мөн Энэтхэг, Пакистан, Израйлыг цөмийн зэвсэг хураах ажиллагаанд оролцуулах асуудал бүр ч тодорхой бус байна. Үүнтэй холбоотойгоор ЦЗҮДГ-г бэхжүүлэх идэвх санаачилгын хүрээнд Ойрх Дорнодод бөөнөөр нь устгах зэвсэггүй бүс байгуулах санаачилга нь 2015 онд ЦЗҮДГ-ийн хэрэгжилтэд хяналт тавих 9-р бага хурлын үеэр эхний байдлаар бүтэлгүйтсэн.

Социалдемократ хэтийн төлөв

Түүхэн он цагийн урсгалд ахин дахин цөмийн зэвсэг хураахын төлөө тэмцэж ирсэн социал-демократуудын өнцгөөс харахад өнөөгийн нөхцөл байдал сэтгэлд хүрэхгүй байна. Хэдийгээр дэлхий дахинд атомын зэвсгийн тоо хүйтэн дайны үеийнхтэй харьцуулахад буурсан ч хүн төрөлхтнийг хэд дахин хүйс тэмтрэхэд хүрэлцэхүйц хэмжээний ойролцоогоор 15 000 цөмийн зэвсэг үлдээд байна. Өнөөгийн цөмийн зэвсэгтэй гүрэн дээр шинэ гүрнүүд нэмэгдэх юм бол цөмийн дайн гарах эрсдэлтэй. Обамагийн алсын хараанд нухацтай хандах нь энэ цаг үеийн шаардлага юм.

Дэлгэрүүлэн унших:

Олибер Майер (2017 он),

НҮБ цөмийн зэвсгийг

хориглох шийдвэр

гаргалаа. 2017 оны А

54-рт, Шинжлэх ухаан,

улс төрийн сан (эрхлэн

гаргав), Берлин хот

Алсын хараанд

нухацтай ханд.

5. ОРОЛЦОГЧ ТАЛУУД БА БАЙГУУЛЛАГУУД

Энэхүү бүлэгт:

- Германы энх тайван, аюулгүй байдлын бодлогын байгууллагууд болон оролцогч талуудтай товч танилцана.
- Олон улсын харилцааны гурван чухал оролцогч талыг танилцуулна. НҮБ, НАТО, ЕАБХАБ
- Онолын ямар сургууль дээр үндэслэн эдгээр байгууллагууд үүсэн байгуулагдсан бэ? гэдгийг танилцуулна.
- Эдгээр байгууллагуудын хэтийн төлөв ба шинэчлэлийн саналуудын талаар хэлэлцэнэ.

Олон улсын байгууллагууд олон улсын системийн түүхэнд харьцангуй шинэ үзэгдэл юм. Эдгээр байгууллагуудыг ихэнхдээ улс орнууд хоорондын зөрчилдөөнтэй асуудлуудыг цэгцлэх, зохицуулахын тулд байгуулж байсан түүхтэй. Эдгээр нь ихэнхдээ нэг улсын бусад орнуудтай харилцах харилцаагаа зохицуулах, хэрэгжүүлэх орон зай хумигдсаны улмаас уг орон зайг бусад орнуудтай хамтран тэлэх гэсэн оролдлогын үр дүнд байгуулагдсан. Социал-демократ хэтийн төлөвөөс харахад олон улсын харилцааг зохицуулах тодорхой бүтцүүд байгуулах, эдгээр бүтцүүдэд эрх олгох нь нэгэн онцгой зорилт юм. Иймээс энэ бүлэгт 20-р зуунд үүсгэн байгуулагдсан гурван чухал оролцогч талуудыг танилцуулах болно. НҮБ, НАТО, ЕАБХАБ нь олон улсын харилцааны хоорондоо эрс ялгаатай гурван өөр алсын харааг илэрхийлдэг.

Бүс нутгийн аюулгүй байдлын байгууллагууд нь зөрчилдөөнийг шийдэж болох хамгийн доод төвшинд буюу үүссэн төвшинд нь асуудлыг шийдэх зарчмыг хэрэгжүүлэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэх боломжтой тул энэ бүлэгт ЕАБХАБ-ын зэрэгцээ африкийн холбоо ба европын холбооны энх тайван, аюулгүй байдлын бодлогын бүтцүүдийг танилцуулах болно.

Эхний ээлжид германы энх тайван, аюулгүй байдлын бодлогын оролцогчдын онцгой баялаг орчинтой танилцана.

НҮБ, НАТО, ЕАБХАБ

*Африкийн холбоо
ба Европын
холбоо*

*Германы оролцогч
талууд*

5.1. Германы гадаад бодлогын оролцогч талууд

Зохиогч Михаел Херолд

*Улаан, ногооны
эвслийн засгийн
газар олон
шинэчлэл хийсэн.*

Германы гадаад бодлого сүүлийн хэдэн арван жилд бодлогын багцаа шинэ хэрэгслүүдээр эрс баяжуулсан. Гэвч Вашингтон, Москва, Бээжинд НАТО ба сонгодог дипломат бодлого урьдын адил чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Гэвч 1998-2005 онд засгийн эрхийг барьсан улаан, ногооны эвслийн засгийн газраас гаргасан шийдвэрүүдээр, нэн ялангуяа хямралаас урьдчилан сэргийлэх иргэний салбарт сонгодог гадаад, аюулгүй байдлын бодлогын хэрэгслүүдийг баяжуулсан нэлээд олон байгууллагууд байгуулагдсан.

Мөн түүнчлэн засгийн газрын дотоодын бүтцэд байгаа өнөөгийн бүтцүүд хувьсан өөрчлөгдөж байна: Гадаад хэргийн яам нь өнөөдөр зөвхөн Германы дэлхий дахинд явуулж буй хүмүүнлэгийн туслалцааг хариуцдаггүй. Харин тухайн үед гадаад хэргийн сайд байсан Франк Вальтер Штайнмайерын санаачилсан “2014 оныг эргэн харахад: хэтийг харсан гадаад бодлого” шинэчлэлийн үйл явцын хүрээнд хямралаас урьдчилан сэргийлэх, тогтворжуулах, зөрчилдөөний дараах нөхөн сэргээх ажиллагааг хариуцсан шинэ хэлтсийг байгуулсан. Энэ “Т” тогтворжуулах хэлтэст энэ хооронд 100 гаруй ажилтан хямралын мөчлөгөөс хамааран ажиллаж байна.

Дараах бүлгүүдэд Германы гадаад бодлогын хамгийн чухал оролцогчдыг заавал бүрэн бүтэн байх шаардлага тавихгүйгээр, гүнзгий дүн шинжилгээ хийлгүйгээр товч танилцуулах болно.¹⁹

Холбооны засгийн газар

Үндсэн хуулийн дагуу гадаад орнуудтай харилцах асуудлыг Холбоо хариуцдаг. (32-р зүйл). Германы үндсэн хуулийн дагуу (72-р зүйл) Холбоо гадаад харилцааг зохицуулах үүргийг дангаараа хүлээдэг. Германы холбооны улсууд болон тэдгээрийн парламентуудын гадаад бодлогын чадамж энэ хэмжээгээр сул байдаг. (Харин

19 2007 онд Биесбаденд хэвлэгдэн гарсан зохиогч Сиегмар Шмидт болон бусад зохиогчдын “Германы гадаад бодлогын гарын авлага” нэртэй номыг олон салбарт нэмэлт эх сурвалж болгохыг зөвлөсөөр байна.

Европын бодлогын чадамж нь онцгой тохиолдол)

Холбооны төвшний оролцогчд талуудын дунд Холбооны засгийн газарт хамгийн чухал үүрэг ногддог. Холбооны үндсэн хуулийн цэцийн шийдвэр болон өнөөг хүртэл авсан хамгийн том сургамжийн дагуу Холбооны засгийн газар өөрийн хариуцлагаар гадаад хэргийн үүргийг маш уудам орон зайд хэрэгжүүлж байдаг.

Холбооны төвшин дээрх хамгийн хүчирхэг оролцогч тал

Холбооны засгийн газрын дотоодод Гадаад Хэргийн Яам бусад орнууд болон олон улсын байгууллагуудтай хэрэгжүүлэх дипломат бодлого боловсруулах, хэрэгжүүлэх болон гадаад оронд байгаа германы иргэдийг хамгаалах үүрэг хүлээдэг. Дээрээс нь Гадаад Хэргийн Яам нийт 227 төлөөлөгчийн газруудтай (эдгээрийн дотор 153 оронд германы элчин сайдын яамд ажилладаг). Эдгээр нь дэлхий дахинд германы дипломат сүлжээг бүрдүүлдэг. Герман шиг дипломат харилцааны ийм өргөн сүлжээтэй орон цөөхөн байдаг. Гадаад орнууд дах германы төлөөллийн газруудыг “германы нүд, чих, дуу хоолой” гэж нэрлэх дуртай байдаг. Берлинээс өгсөн зааврын дагуу эдгээр байгууллагууд оршин суугаа газар нутагтаа Герман орныг төлөөлж, тухайн орны засгийн газартай хэлэлцээр хийж, эдгээр орнуудтай явуулах улс төрийн харилцаа ба эдийн засаг, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааг дэмжиж байдаг.

Гадаад хэргийн яам

Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам ба сүүлийн үед улам чухал үүрэг гүйцэтгэх болсон Холбооны батлан хамгаалах яам нь гадаад бодлогын талбарт ажилладаг. Дээрээс нь олон улсын зөвшилцөл явагддаггүй салбар бараг байдаггүй учраас холбооны бүх яам гадаад бодлогын харилцагч нартай байдаг. Иймээс гадаад хэргийн яам зохицуулагчийн (холбогчийн) үүрэг гүйцэтгэдэг. Холбооны засгийн газрын үйл ажиллагааны журмын дагуу бодлогын салбар бүр олон улсын хэлэлцээрийг зөвхөн гадаад хэргийн яамны зөвшөөрлөөр явуулдаг.

Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам-ХЭЗХХАЯ, Холбооны батлан хамгаалах яам-ХБХЯ

Гадаад харилцаанд гадаад хэргийн яамтай ижил төстэй рефератууд буюу газар, хэлтсүүд бүхий холбооны канцлерын ажлын алба онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гадаад бодлогод зохицуулах, удирдах хэлбэрээр хөндлөнгөөс оролцох эрхтэй. Тодорхой

Холбооны канцлерын ажлын алба

сэдвүүдийг байсхийгээд “үндсэн асуудал” болгон зарладаг. Германд эвслийн засгийн газар байгуулагдах нь хэвийн үзэгдэл тул Гадаад Хэргийн яамыг эвслийн “жигжиг” түнш удирддаг уламжлалтай. Канцлерын ажлын албатай санал зөрөлдөх тохиолдол ховор бус. Ялангуяа европын бодлогод ихэвчлэн канцлерын ажлын алба ба \Холбооны сангийн яам дээр\ хэтэрхий их эрх мэдэл төвлөрч байгаа нь Гадаад Хэргийн Яаманд хүндрэл учруулж байна хэмээн гомдоллох нь олонтоо.

Хямралаас иргэний арга хэрэгслүүдээр урьдчилан сэргийлэх төрийн бодлого

2004 онд батлагдсан “Хямралаас иргэний арга хэрэгслээр урьдчилан сэргийлэх, Зөрчилдөөнийг шийдвэрлэх, Энх тайвныг тогтворжуулах” төлөвлөгөөнд тухайн үед холбооны засгийн газрыг бүрдүүлж байсан улаан, ногооны эвсэл анх удаа дэлхийн энх тайвныг дэмжих өргөн хүрээтэй байр сууриа тодорхойлсон. Уг шийдэл энх тайвны бодлого ба хямралаас сэргийлэх иргэний арга хэмжээ холбооны засгийн газрын салбар дундын бодлогын үүрэг байх ёстой учраас зөвхөн нэг яамны хүрээнд бус салбар дундын хэмжээнд сэтгэж хэрэгжүүлэх ёстой гэсэн үндсэн санаа дээр суурилдаг. Иргэний хэрэгслүүд цэргийн хэрэгслүүдээс тэргүүнд тавигдах ёстой.

Иргэний хэрэгслүүдээр энх тайвны урьдчилан сэргийлэх бодлогын тойрог буюу салбар дундын бодлогын уялдааг хангах сонгуульт байгууллагыг гадаад хэргийн яамны удирдлага дор байгуулсан. Тус байгууллага иргэний арга хэрэгслүүдээр хямралаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эхлүүлэх, яамд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, иргэний нийгэмтэй хэрэгжүүлэх хамтын ажиллагааг онцгойлон бэхжүүлэх үүрэгтэй. Түүнчлэн бодлогын тойргийн ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий иргэний нийгэм, эдийн засаг, бодлогын зөвлөгөө өгөх төлөөлөгчдөөс бүрдсэн иргэний хэрэгслүүдээр хямралаас урьдчилан сэргийлэх бодлогын зөвлөл байгуулсан.

Тэртээ 2002 онд улаан, ногооны засгийн газар олон улсын энхийг сахиулах үйл ажиллагааны төвийг байгуулсан. Энэ хооронд тус төвд жил тутамд олон улсын энхийн ажиллагаанд зориулан 150

*2004 он: Үйл
ажиллагааны
төлөвлөгөө*

*Энх тайвны
урьдчилан
сэргийлэх иргэний
бодлогын тойрог*

*Олон улсын
энхийг сахиулах
ажиллагааны
төв-ОУЭСАТ*

мэргэжилтэн, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын захиалгаар (ЕАБХАБ) сонгуулийн 300 ажиглагчид бэлтгэдэг. 2017 онд шинэчлэн баталсан дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу Олон улсын энхийг сахиулах ажиллагааны төвийн байр суурийг дээшлүүлж бүрэн эрхтэй илгээгч байгууллага болгон өөрчилсөн. Германаас иргэний хэрэгслүүдээр хямралаас урьдчилан сэргийлэх олон улсын ажиллагаанд илгээж буй мэргэжлийн боловсон хүчний эрх зүйн болон нийгмийн баталгааг сайжруулсан. Иргэний ажиллагааны мэргэжилтнээр ажиллах, эсвэл иргэний мэргэжилтнээр ажиллах сонирхлыг дээшлүүлэх, тоог нь нэмэгдүүлэх зорилготой. Ингэснээр германы олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оруулах хувь нэмэр дээшлэх ёстой юм.

2017 оны зун холбооны засгийн газраас “Хямралаас зайлсхийх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг дэмжих” шинэ удирдамжийг баталсан. Энэхүү удирдамж нь 2004 онд батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний оронд хэрэгжих юм. Энд засгийн газар хямралыг улс төрийн аргаар даван туулах багаж хэрэгслүүдийг улам боловсронгуй болгох үүрэг хүлээсэн. Дээрээс нь олон улсын энх тайвны зуучлалыг зорилттойгоор дэмжиж, зэвсэглэлд хяналт тавих, жишээлбэл мин, тэсрэх бөмбөг, байлдааны хэрэгслүүдийг зайлуулах, жижиг зэвсэгт тавих хяналтын арга хэмжээг чангатгах шаардлагатай. Иргэний хэрэгслүүдээр хямралаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн үнэлэмжийг дээшлүүлж хангамжийг сайжруулсан.

Хэдийгээр сайжруулаад байгаа ч шийдвэрлэхэд амаргүй үндсэн асуудлууд шийдэгдээгүй хэвээрээ байна. Иргэний хэрэгслүүдээр хямралаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилт урт хугацаа шаарддаг, олон нийтэд нөлөө багатай. Хүчирхийллээс амжилттай хамгаалж чадсан ч нүдэнд харагддаггүй, бодит байдал дээр хамгаалсан гэдгээ батлахад бэрхшээлтэй. Харин цэргийн арга хэмжээ ба хүчирхийллийн үйл явдлууд тэр даруйдаа олны анхаарлыг татдаг. Тэр хэрээр иргэний хэрэгслүүдээр хямралаас урьдчилан сэргийлэх гол баатруудыг элсүүлэхэд, олоход бэрхшээлтэй байдаг.

Салбар дундын хамтын ажиллагаа илүү үр дүнтэй гэдгийг оролцогч

2017 он: Шинэ удирдамжууд

Асуудал: Анхаарал хандуулах байдал харилцан адилгүй

Хайж байна: стратегийн бичиг баримт

бүх талууд мэддэг хэр нь тус тусын байшингууд, хариуцсан салбарын хуучин ойлголтын хүрээнд сэтгэсэн хэвээрээ байна. Гадаад хэргийн яам дипломат бодлогод, Холбооны эдийн засгийн хамтын ажиллагааны яам хөгжлийн хамтын ажиллагаанд, Холбооны батлан хамгаалах яам цэргийн ажиллагаанд санаа тавьсаар байна. Энэ логикийн дагуу шинэ удирдамжуудын зэрэгцээ Холбооны батлан хамгаалах яамны удирдлага дор “Холбооны армийн ирээдүйн тухай аюулгүй байдлын цагаан ном” нэртэй батлан хамгаалахын ерөнхий зарчмуудыг боловсруулж 2016 онд батлуулсан. Холбооны засгийн газар Холбооны эдийн засгийн хамтын ажиллагааны яамны удирдлага дор дөрвөн жил тутамд холбооны “Хөгжлийн бодлогын илтгэл”-ийг хэвлэн нийтэлдэг. Герман олон улсын системд ямар байр суурьтай байх вэ? гэдэг асуултад хариулт өгөх стратегийн баримт бичиг өнөөг хүртэл байхгүй байна.

Бундестаг

Бундестаг гадаад бодлогын салбарт юуны өмнө хамтран оролцох эрхтэй. Бундестаг болон Бундестагийн гишүүд гадаад бодлогын бүхий л асуудлаар тодруулга авах эрхтэй. Холбооны засгийн газар парламентад үйл ажиллагаагаа танилцуулж асуулгад хариулах үүрэгтэй.

*Чухал байнгын
хороод*

Чуулганы хуралдааны зэрэгцээ юуны өмнө үндсэн хуулийн дагуу байгуулагдсан гадаад бодлого, батлан хамгаалах, Европын холбооны хэрэг, эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжил, хүний эрх, хүмүүнлэгийн туслалцааны байнгын хороод гадаад бодлогын асуудлаар хэлэлцэж байдаг. Сүүлийн хэдэн жилд гадаад хэргийн байнгын хороо нь иргэний арга хэрэгслүүдээр хямралаас урьдчилан сэргийлэх, зөрчилдөөнийг судлан боловсруулах, сүлжээгээр холбогдсон үйл ажиллагаа зэрэг асуудал хариуцсан дэд хороодыг дэргэдээ байгуулсан. Тус хороод дээр тодорхойлсон удирдамжуудыг боловсруулах үйл явцад идэвхтэй ажилласан.

*Парламентын
болзол*

Бундестагийн зөвшөөрөлтэйгээр Холбоо олон улсын эрх зүйн гэрээ байгуулдаг. (Соёрхон баталдаг) Германы цэргүүдийг гадаадад байлдааны зэвсэглэсэн ажиллагаанд илгээх тухай шийдвэрт германы парламент оролцооны онцгой эрх эдэлдэг.

1994 онд Холбооны үндсэн хуулийн шүүхээс Холбооны арми нь парламентын арми юм гэдгийг тогтоосон. Учир нь тус армийг гадаадад цэргийн ажиллагаанд оролцуулах эсэхийг үндсэн хуулийн дагуу парламентын тогтоолоор шийддэг. (Бундестагийн болзол)

Бодлогын бусад салбарын нэгэн адил гадаад бодлого ч санхүүжилтээс хараат байдаг. Бундестаг өөрийн төсөв батлах бүрэн эрхийн дагуу зөвхөн гадаад хэргийн яам, холбооны армийн санхүүжилт төдийгүй германы дэлхий дахинд үзүүлэх хүмүүнлэгийн тусламж ба хөгжлийн хамтын ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг тогтоодог.

Улс төрийн намууд ба улс төрийн сангууд

Германы гадаад бодлогын өдөр тутмын үйл ажиллагаанд улс төрийн намууд шууд нөлөөлдөггүй. Тэглээ гээд тэдний ач холбогдлыг доогуур үнэлж болохгүй. Намууд жилээс жилд нэмэгдэж буй олон улсын сүлжээ, нэн ялангуяа бусад орнуудын эгч дүүс намуудтай байгуулсан олон улсын сүлжээтэй байдаг.

Гадаад бодлогын оролцогч талуудын нэгэн чухал бүлэг бол гадаадад үйл ажиллагаа явуулдаг улс төрийн намуудад ойр байдаг улс төрийн зургаан сан юм. Эдгээр сангууд төр гадаад бодлогоороо аливаа асуудалгүйгээр хамтран ажиллах боломжгүй үйлдвэрчний эвлэлүүд, сэтгүүлчид, сөрөг хүчний намууд зэрэг түншүүдтэйгээ хамтран ажиллаж, төрөөс доод бүх түвшинд хоёр талт хамтын ажиллагааны нягт холбоосыг бүрдүүлж байдаг.

Энх тайвны хөдөлгөөн, ТББ, сүм хийдүүд

Энх тайвны төлөө идэвх санаачилга гарган ажилладаг иргэд засгийн газрын гадаад бодлогын үйл ажиллагааг шүүмжилдэг нь шинэ зүйл биш. Харин 1990-ээд онд нийгмийн хөдөлгөөний нэгэн хэсэг болон бүтэц хэлбэрээ олсон, олон улсын болон гадаад бодлогын сэдвүүдээр ажилладаг, олноороо үүсгэн байгуулагдсаар байгаа ТББ-ууд шинэлэг хөгжил юм.

Үзэгдлүүд маш олон талтай учраас нэгдсэн тойм гаргах боломжгүй юм. Байгууллагуудын ихэнх нь бодлогын тодорхой талбар

*Төсөв батлах
бүрэн эрх*

*Олон талт
үзэгдлүүд*

дээр (хүний эрх, хөгжлийн бодлого, байгаль орчны бодлого, зэвсэглэлийг бууруулах гэх мэт) олон нийтийн ба лобби ажлын тусламжтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Зарим ТББ-ууд хүчээ нэмэгдүүлэхийн тулд холбоодод нэгддэг.

Ингэснээр 1995 онд хөгжлийн бодлого ба хүмүүнлэгийн тусламжийн германы төрийн бус байгууллагуудын холбоо (VEN-RO) үүсгэн байгуулагдсан. Энэ хооронд тус холбоонд 120 гаруй ТББ нэгдсэн байна. 1994 оноос хойш тодорхой сэдвийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг 50 ТББ хүний эрхийг өргөн хүрээнд хамгаалахын тулд хүний эрхийн чуулганд нэгдсэн.

*Иргэний
хэрэгслүүдээр
зөрчилдөөнийг
боловсруулах
платформ*

Иргэний хэрэгслүүдээр зөрчилдөөнийг судлан боловсруулах платформ 1998 онд байгуулагдсан бөгөөд энэ платформыг зөрчилдөөнийг боловсруулахад дэмжлэг үзүүлдэг нээлттэй сүлжээ гэж ойлгох нь зүйтэй. Тус платформ нь хүн бүрд, ТББ-аар дамжуулан идэвх санаачилгаа нэгтгэх орон зайг бүрдүүлж өгдөг бөгөөд тэд өөрсдийгөө олон улсын иргэний нийгмийн оролцогч талуудын нэгэн хэсэг гэж үздэг.

*Энх тайван,
хөгжлийн
дугуйлан (ЭТХД)*

2001 онд байгуулагдсан энх тайван ба хөгжлийн дугуйлан нь германы хөгжлийн бодлогын энх тайвны үйл ажиллагаа явуулдаг төрийн болон иргэний нийгмийн 9 байгууллагыг нэгтгэсэн дээвэр байгууллага юм. (Эдгээрт Холбооны эдийн засгийн хамтын ажиллагааны яам, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Фридрих-Эбертийн Сан багтаж буй)

*Иргэний энх
тайвны алба
(ИЭТА)*

Виесзорек-Цойлыг Эдийн засгийн хамтын ажиллагааны сайд байх үед тус яам энх тайвны хөдөлгөөний санаачилга гаргаж, иргэний энх тайвны албаны хөтөлбөрийн шугамыг байгуулсан юм. Холбооны эдийн засгийн хамтын ажиллагааны яамны санхүүжилтээр германы энх тайван, хөгжлийн 9 байгууллага Иргэний энх тайвны албыг орон нутгийн түнш байгууллагуудтайгаа хамтран удирдаж байна. Иргэний энх тайвны мэргэжлийн ажилтнуудыг хямралтай газар нутгууд руу орон нутгийн түнш байгууллагуудын тусламжтайгаар зөрчилдөөнийг хүчирхийллээс ангид, цэргийн бус хэрэгслүүдээр боловсруулах бүтэц байгуулахын тулд мэргэжилтнээр илгээж байна.

ИЭТА нь хөгжлийн хамтын ажиллагааны бусад хэрэгслүүдээр, жишээлбэл үйл ажиллагаагаа заавал засгийн газрын оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлэх зорилт тавихын оронд өвсний үндэс буюу орон нутгийн идэвхтнүүдтэй хамтран энх тайвны чадамжийг улс төр, нийгмийн өргөн салбарт дэмждэг.

Энх тайвны хөдөлгөөнөөс эхтэй хүчирхийллээс ангид үйл ажиллагааны төлөөх сургалт, боловсролын төв, цэрэгжилтийн мэдээллийн газар, Цөмийн дайнаас урьдчилан сэргийлэх олон улсын эмч нар зэрэг сонгодог байгууллагууд байдаг. (IPPNW)

Нийгмийн хөдөлгөөнүүд ерөнхийдөө бодлогын тодорхой чиг шугамыг эсэргүүцсэн эсэргүүцлийн хөдөлгөөний хэлбэрээр үүсгэн байгуулагддаг бол Гадаад, хөгжлийн бодлогын салбарт олон нийтийн үйл ажиллагаандаа засгийн газрын үйл ажиллагааг засварлагч гэж өөрсдийгөө ойлгодог ч зарим талаар Холбооны засгийн газартай хамтран ажилладаг олон тооны ТББ-ууд байдаг.

Өдгөө хүний эрхийн ТББ-уудтай явуулдаг яриа хэлэлцээ нь гадаад хэргийн яаманд ердийн үзэгдэл болсон. Ялангуяа гадаад орнуудад элчин сайдын яамд тухайн оронд сүлжээ болон мэдээлэл сайтай байдаг тул Эмнести интернационал, Хүний эрхийн хяналт болон бусад байгууллагуудтай хамтран ажиллахыг эрмэлздэг болсон. НҮБ-ын хүрээнд хүний эрхийн сэдвээр шийдвэр гаргуулах шаардлагатай нөхцөлд барууны орнууд ба ТББ-ууд нь иргэний болон энгийн иргэдийн эрхтэй холбоотой асуудлаар ази, африкийн орнуудын эсэргүүцлийг давахад дэвшилтэт бодлогыг бэхжүүлэхэд шаардагдах олонхыг бүрдүүлэх түншүүд гэж өөрсдийгөө ойлгодог. (Жишээ нь: Бэлгийн цөөнхийн эрх)

“Хөгжил ба хүмүүнлэгийн туслалцаа”-ны салбарт зарим ТББ-ууд холбооны засгийн газрын даалгавраар тухайн оронд ажиллаж тодорхой төслүүдийг хэрэгжүүлдэг. Иймээс ТББ-уудын үйл ажиллагааны талбар дээр засгийн газартай хэр ойр байх эсвэл төрийн байгууллагуудаас ямар зай баривал зохистой талаар хэлэлцүүлэг байнга явагдаж байдаг. Гадаадад цэргийн ажиллагааны хүрээнд холбооны армитай хамтран ажиллах тухай асуудал онцгой хүндрэл үүсгэдэг.

Германы хоёр том сүм юуны өмнө хөгжлийн бодлого ба ядууралтай хийх тэмцэлд гол анхаарлаа төвлөрүүлдэг. Католик шашны сүмүүдийн талд энэ үйл ажиллагаа Мисереор тусламжийн байгууллага ба үйл ажиллагааны сүлжээ Миссио-ын нэгдэл “Justitia et Pax” дамжуулан явуулдаг бол евангелийн шашны талд евангелийн хөгжлийн алба ба “Дэлхийд талх” байгууллагуудаар дамжуулан явуулдаг. Дээрээс нь эдгээр хоёр сүм уламжлалын дагуу энх тайвны хөдөлгөөний чухал түшиц газар ба түншүүд байсан бөгөөд байсаар ч байна. Пакс Христи холбоо жишээ нь, олон улсад католик шашны сүмүүд дундаас энх тайвны бодлогын хэрэгжилтийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, Герман даяар бүлгүүдтэй байгууллага юм.

Шинжлэх ухаан ба бодлогын зөвлөгөө

Олон улсын бодлогын цогц байдал ба гадаад, аюулгүй байдлын бодлогын сорилтууд нэмэгдэхийн хэрээр шинжлэх ухааны дүн шинжилгээ ба зөвлөгөөний хэрэгцээ шаардлага өсөж байна.

Засгийн газрын төлөвлөлтийн алба, эсвэл Германы Бундестагийн шинжлэх ухааны албаны зэрэг дотоодын зөвлөгөө, шинжилгээний байгууллагуудын зэрэгцээ гадаад, аюулгүй байдлын бодлогын салбарт төсвөөс санхүүжилтээ бүрэн эсвэл дийлэнх хэсгийг бүрдүүлдэг хөндлөнгийн судалгааны олон байгууллагууд байдаг. Эдгээр байгууллагуудын судалгааны үрдүнг ихэвчлэн олон нийтэд танилцуулдаг.

Шинжлэх ухаан ба улс төрийн сан нь практикт чиглэсэн гадаад-аюулгүй байдлын бодлогын судалгааны байгууллага бөгөөд судалгааны энэ салбартаа европын хамгийн том байгууллага юм. Тус сан 1962 оноос хойш өргөн сэдвээр судалгаа явуулж байгаа бөгөөд холбооны төсвөөс бараг бүрэн санхүүжилтээ авдаг.

Германы гадаад бодлогын нийгэмлэг нь 1950-аад онд британи ба америкаас үлгэр жишээ авч байгуулагдсан, тус нийгэмлэгт гүйцэтгэх засаглал ба хууль тогтоогчдын төлөөлөгчид санал бодлоо солилцдог сургалтын олон бүлгүүд суралцдаг. ГГБН нь 1970-аад оноос өөрийн судалгааны хүрээлэнг байгуулсан. 1987 оноос хойш (энэ хооронд) германы 5 тэргүүлэх хүрээлэн жил тутамд энх тайвны үнэлгээ хийж хэвлэн нийтэлдэг.

Энэхүү үнэлгээнд сүүлийн үеийн зөрчилдөөнүүдэд дүн шинжилгээ хийж, герман болон европын энх тайван, аюулгүй байдлын бодлогод зориулсан тодорхой зөвлөмжүүдийг боловсруулдаг. Өгч буй чиглэл нь “засгийн газарт ойр” байгууллагуудтай харьцуулахад эрс шүүмжлэлтэй ханддаг. Оролцогч хүрээлэнгүүдээс нэрлэвэл Лайвнитцийн хүрээлэн, Хессений энх тайван, зөрчилдөөн судалгааны сан, Бонны олон улсын хувьсал судлалын хүрээлэн, евангелийн шашны суралцагсдын нийгэмлэгийн судалгааны газар, хөгжил, энх тайвны хүрээлэн, Хамбургийн их сургуулийн дэргэдэх энх тайван судлал ба аюулгүй байдлын бодлогын хүрээлэн гэх мэт.

2000 онд Улаан, ногооны эвслийн засгийн газраас Германы энх тайван судлалын санг үүсгэн байгуулсан. Тус сан германд энх тайван судлалыг урт хугацаанд бэхжүүлж, энх тайван судлалын улс төрийн ба санхүүгийн хараат бус байдлыг хангахад хувь нэмрээ оруулах үүрэгтэй. Гэхдээ тус сан өөрөө шинжлэх ухааныг хөгжүүлдэггүй, харин шинжлэх ухааны зорилтуудын санаачилга, дэмжлэг, шинжлэх ухааны солилцоо, залуу үеийг дэмжихэд төвлөрч ажилладаг.

5.2. Нэгдсэн Үндэстний Байгууллага

Зохиогч Томас Хартманн

НҮБ нь өнөөгийн байдлаар эгнээндээ 193 орныг нэгтгэсэн, Нью Йоркт төвтэй, улс хоорондын нэгдэл юм. НҮБ-ыг дэлхийн хоёрдугаар дайны дараа НҮБ-ын хартын удиртгалд бичсэний дагуу “Ирээдүйн эмэгтэй, эрэгтэйчүүдийг дайны барьцааны хүмүүс болохоос хамгаалах”-ын тулд үүсгэн байгуулсан.

НҮБ-ын хартад 1945 оны 6-р сарын 26-нд Сан Франциско хотноо 50 орон гарын үсгээ зурж, 1945 оны 10-р сарын 24-өөс хүчин төгөлдөр болсон. АНУ гарын үсэг зурсан анхны орон болсон. Дэлхийн нэгдүгээр дайны дараагаар НҮБ-тай ижил төстэй зорилгоор байгуулсан Үндэстний холбоо АНУ тус холбоонд гишүүнээр элсээгүйн улмаас бүтэлгүйтсэн.

НҮБ-ын харта хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн нь дэлхийн хоёрдугаар дайны гашуун туршлагын дараагаар урт хугацаанд

Жил тутамд энх тайвны үнэлгээ хийдэг.

*Дэлгэрүүлэн унших:
www.friedens-gutacht-en.de хаягаар
орж дэлгэрүүлэн уншаарай.*

Германы энх тайван судлалын сан -ГЭТСС

*Дэлгэрүүлэн унших:
Олон улсын бодлого ба нийгэм (2015 он), НҮБ-ын 70 жил, Сарын онцлох сэдэв Дэлгэрүүлэн уншаарай.
Холбооны улс төрийн боловсролын төв (2011 он), НҮБ, улс төрийн боловсролын мэдээлэл 310-р дэвтэр Бонн хот*

энх тайван байх дэлхийн дэглэм байгуулах боломжтой гэдэг итгэл найдварыг сэргээсэн.

Үндсэн зорилтууд

НҮБ-ын хартын 1-р бүлэгт тус байгууллагын үндсэн зорилтуудыг нэрлэсэн байдаг. Эдгээр нь:

- Дэлхийн энх тайван ба олон улсын аюулгүй байдлыг хангах
- Бүх маргааныг энх тайвнаар таслах
- Хүч хэрэглэхээс татгалзах
- Бүх улс орнуудын тэгш байдал ба үндэсний тусгаар тогтнолыг хүндэтгэх
- Энх тайвныг хангахын төлөөх найрамдалт хамтын ажиллагааг дэмжих
- Эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг дэмжих
- Арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгээс үл хамааран хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх

Идеализмын хүүхэд

Эдгээр зорилтуудаас НҮБ бол оюун санааны түүхийн хувьд идеализмын хүүхэд гэдэг нь тодорхой харагдаж байна. Эдгээр зорилтууд эрүүл саруул ухааныг эрхэмлэгч хүмүүс хоорондоо энх тайвныг бүрдүүлж чадна гэдэг итгэл үнэмшил дээр суурилсан байдаг. Энх тайванд НҮБ өөрийн төрөл бүрийн байгууллагууд, хөтөлбөр, фондуудын системээрээ дамжуулан хувь нэмрээ оруулж байдаг. НҮБ-ын хүүхдийн сан (UNICEF), НҮБ-ын цагаачдын комиссарын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр зэрэг олноо танигдсан хөтөлбөрүүд байдаг. НҮБ-ын хүрээнд Парисын цаг уурын хэлэлцээр, үүнтэй нэгэн адил 2030 зорилтууд, Тогтвортой Хөгжлийн зорилтуудын тухай хэлэлцээр батлагдсан.

Бэрхшээлтэй зам

НҮБ байгуулагдсан цагаасаа хойш ямагт амар дардан замыг туулж ирээгүй юм. Зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих санаачилгууд зэрэг нь дэлхийн энх тайвны хөгжилд чухал хувь нэмэр оруулсан ч дэлхийн хэмжээний энэ байгууллага нөөц чадамжаа бүрэн ашигладаггүй, бүтцийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байна гэх зэргээр шүүмжлэлд өртөж байдаг. НҮБ дэлхийн энх тайвныг хамгаалах, дахин сэргээх, олон улсын аюулгүй байдлыг

хангах олон тооны хэрэгслүүдтэй. Урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр зөрчилдөөнд хүргэхгүй байх, нэгэнт гарсан хямралын үед идэвхтэй хөндлөнгийн оролцоогоор энгийн иргэдийг хамгаалах, хямралын дараагаар тогтвортой энх тайвныг тогтоох ёстой. Энд аюулгүйн зөвлөл ба НҮБ-ын чуулган шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Аюулгүйн зөвлөл

Аюулгүйн зөвлөл нь “Энх тайван ба аюулгүй байдал”-ын салбарт НҮБ-ын дотоод бүтцийн хамгийн чухал байгууллага юм. Аюулгүйн зөвлөлийн дарга сар тутамд солигддог, 15 гишүүнээс бүрддэг.

Эдгээрээс 5 нь байнгын гишүүн байдаг. (Их Британи, Хятад, Орос, АНУ, Франц) 10 нь байнгын бус гишүүд байдаг. Байнгын бус 10 гишүүн орон тус бүрийг хоёр жил тутамд НҮБ-ын чуулганаас сонгодог. Дэлхийн төрөл бүрийн бүс нутгийг харгалзан үзэхийн тулд энэ бүлгийн дотор газарзүйн тусгай түлхүүрийн дагуу сугалаа сугалах замаар суудлын хуваарилалтыг хийдэг. Аюулгүйн зөвлөлийн зэрэгцээ ажлын түвшинд олон тооны ажлын хэсэг, комиссууд ажилладаг.

Аюулгүйн зөвлөлийн онцгой байр суурийг НҮБ-ын хартын VII бүлгээр баталгаажуулсан байдаг. Хартын 39-р зүйлд аюулгүйн зөвлөлд “заналхийлэл, энх тайвныг эвдэх эсвэл халдлага болох аюул” байна гэдэг итгэл үнэмшил төрсөн бол эдийн засгийн хориг арга хэмжээ авах (41-р зүйл) эсвэл цэргийн ажиллагаа явуулах (42-р зүйл) тогтоол гаргаж болно хэмээн заасан байдаг.

Дээрээс нь аюулгүйн зөвлөл зөрчилдөөнд өөрийн хяналт тавьж, зөрчилдөгч талуудад зөвлөмж өгч, эсвэл дайн зогсоох тухай хэлэлцээр ба зэвсэглэлд зохицуулалт хийх тухай тогтоол баталж болно.

Эвслүүдийн зөрчил дуусгавар болсон цагаас хойш угсаатны, шашны, эсвэл улс төрийн сэдэлтэй дотоодын зөрчил нэмэгдсээр байна. Аюулгүйн зөвлөлөөс энэ хооронд цөөнхийг дарлах (1990 оны 688-р шийдвэр) болон хүний эрхийн ноцтой зөрчил (2004 оны 1546-р

Бүрэлдэхүүн

Онцгой байр суурь

шийдвэр)-ийг энх тайванд учирч буй заналхийлэл гэж үздэг болсон. 39-р зүйлийн тайлбар 2001 оны 9-р сарын 11-ээс хойш өөрчлөгдсөн. Олон улсын терроризм, алан хядлага эсвэл үй олноор нь хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зэрэг үзэгдлүүдийг энэ цагаас хойш дэлхийн энх тайванд учирч буй аюул гэдэг шатлалд оруулсан.

*Дэлхийн хууль
тогтоогч*

Аюулгүйн зөвлөл 2001 оны 1373-р шийдвэрээрээ бүх гишүүн орнууддаа терроризмыг санхүүжүүлэх аливаа хэлбэрийг эрүүгийн эрх зүйн дагуу шийдвэрлэх үүрэг ногдуулсан. 2004 оны 1540-р шийдвэрээр НҮБ бүх гишүүн орнуудаас ABC-зэвсгийн үйлдвэрлэлтэй холбоотой материал, технологийг бусдад дамжуулсан тохиолдол бүрд ял шийтгэл ногдуулах хууль батлахыг шаардсан. Хууль тогтоогчийн энэ үйл ажиллагааны улмаас аюулгүйн зөвлөлийг “дэлхийн хууль тогтоогч” гэж нэрлэдэг. Энэ нь улс төрийн болон хууль зүйн хувьд маргаангүй нэр биш юм.

*Өөрийн зэвсэгт
хүчин байхгүй.*

Аюулгүйн зөвлөл цэргийн арга хэмжээ авах тухай тогтоол баталсан нөхцөлд (тэнгист хаалт тавих, агаарын довтолгоо хийх, хуурай замын анги илгээх зэрэг) гишүүн орнуудын зэвсэгт хүчнийг дайчлах хэрэгтэй болдог. АНУ зэрэг чухал гишүүн орнууд НҮБ-н байнгын цэргийн анги байгуулахаас татгалзсаар ирсэн. Үүний оронд аюулгүйн зөвлөл НҮБ-ын хартын 53-р зүйлийн дагуу улс орнуудын төрөл бүрийн бүлгүүд, эсвэл бүс нутгийн байгууллагуудад энх тайвныг цогцлоох арга хэмжээ хэрэгжүүлэх “даалгавар” өгдөг. (жишээ нь: ISAF-Олон улсын аюулгүй байдлын туслах хүч 2003-2014 онд НАТО-гийн удирдлага дор Афганистанд явуулсан цэргийн ажиллагаа, эсвэл европын холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын сонгуулийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа, 2006 онд)

*Цэнхэр
дуулгатнууд*

Мөн аюулгүйн зөвлөл цэнхэр дуулгатнуудын ажиллагааны тухай шийдвэрийг гаргадаг. 1948 онд анх удаа шинээр байгуулагдсан Израйл улс болон тус улсын араб хөршүүдийн хооронд дайн зогсоох тухай шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар цэнхэр дуулгатнуудыг илгээсэн. Энэ ажиллагаа өнөөдрийг хүртэл үргэлж байна. Цэнхэр дуулгатнууд энэ цагаас хойш дэлхийн зөрчилдөөнтэй олон бүс нутгуудад ажиллагаанд оролцож, 1988 онд тэдний дэлхийн энх тайвныг хангахын төлөө гаргасан идэвх, санаачилгад нобелийн

энх тайвны шагналыг олгосон.

1990-ээд оны эхэн үеийг хүртэл цэнхэр дуулгатнууд энх тайвныг албадан тогтоох мандаттай байсан ч Босни, Сомалиа, Руандад энгийн иргэдэд тохиолдсон аймшигт үр дагавраас сэргийлж, мандатаа хэрэгжүүлж чадаагүй учраас НҮБ шинэ зуун солигдох үед энх тайвны шинэ үзэл баримтлал боловсруулсан. Өдгөө аюулгүйн зөвлөл аль болохоор зөрчилдөгч талуудын зөвшөөрөлтэйгөөр энх тайвныг хангах “илүү баталгаатай” мандат олгох тал руугаа хэлбийж байна.

Цэнхэр дуулгатнууд хяналттай завсрын бүс байгуулах, дайн зогсоох, энх тайвны хэлэлцээрт хяналт тавих, хүмүүнлэгийн туламжийг хамгаалах, хуваарилахаас авахуулаад засгийн газрын үүргийг хэрэгжүүлэх зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. 2015 оны 5-р сард Бангладеш, Пакистан, Энэтхэгт хамгийн том анги нэгтгэлийг бүрдүүлж байжээ.

Аюулгүйн зөвлөл есөн саналынхаа олонхын саналаар шийдвэр гаргадаг. “Маш чухал” улс төрийн шийдвэрүүдийг (жишээлбэл хориг арга хэмжээ) байнгын 5 гишүүний олонх буюу байнгын бус дөрвөөс доошгүй гишүүний саналаар гаргадаг. Байнгын гишүүд шийдвэрт хориг тавих замаар хаалт тавьдаг. Нэн ялангуяа Зүүн, Барууны зөрчлийн үед хориг тавих эрхээ ашиглаж, ингэснээр аюулгүйн зөвлөл бодит байдал дээр үйл ажиллагааны чадамжгүй болж байсан. Гишүүдийн нэг нь эзгүй байх, эсвэл түдгэлзэх замаар тогтоол батлахад саад хийх боломжгүй. Эвслүүд хоорондын зөрчил төгсгөл болсноос хойш аюулгүйн зөвлөлийн үйл ажиллагааны чадамж дээшилсэн. Гэсэн хэдий ч хориг тавина шүү гэдэг сануулга өгсөн тохиолдолд шийдвэрийг албан ёсны санал хураалгад оруулдаггүй.

Ерөнхий ассамблейн хуралдаан

Ерөнхий ассамблей нь НҮБ-ын гишүүн бүх орнууд “Нэг улс-нэг санал” зарчмын дагуу төлөөллөө илгээдэг хэлэлцээрийн ерөнхий чуулган юм. Жил бүр нэг ерөнхийлөгч, ерөнхийлөгчийн удирдлага дор ажиллах 21 дэд ерөнхийлөгчийг сонгодог. Дэд ерөнхийлөгч нараас тавыг нь аюулгүйн зөвлөлийн 5 гишүүдийн тойргоос сонгодог. Гишүүн орон тус бүр дээд тал нь таван төлөөлөгчөө ерөнхий

*Шийдвэр гаргах
зам*

Нэг улс-нэг санал

ассамблейн хуралдаанд илгээдэг. Өмнө нь ярилцан тохиролцсон нэг ерөнхий хэлэлцүүлгээр хуралдаан эхэлж гишүүн орнуудын төр засгийн тэргүүн нар төлөөлөгчдийн өмнө үг хэлдэг. Үүнээс гадна аюулгүйн зөвлөл эсвэл НҮБ-ын гишүүн орнуудын олонх ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болдог.

Ажлын арга барил

Ерөнхий ассамблейн хуралдааны бэлтгэлийг хангах зургаан үндсэн хороог байгуулдаг. Эдгээр хороонд бүх гишүүн орнуудын төлөөлөл багтсан байдаг. Эдгээрт: Зэвсэг хураах ба олон улсын аюулгүй байдал (1-р хороо), Эдийн засаг ба санхүүгийн асуудал (2-р хороо), нийгэм, хүмүүнлэг, соёлын асуудал (3-р хороо), улс төрийн онцгой асуудлууд (4-р хороо), захиргаа, төсвийн асуудал (5-р хороо), эрх зүйн асуудал (6-р хороо)

Ерөнхий ассамблейн хуралдаанаас гишүүн орнууд ба аюулгүйн зөвлөлд хандан олон улсын аюулгүй байдал, дэлхийн энх тайван, эсвэл зэвсэг хураах асуудлаар зөвлөмж гаргаж болно. Хэдийгээр гишүүн орнууд эдгээр зөвлөмжүүдийг заавал биелүүлэх үүрэг хүлээдэггүй ч өнгөрсөн хугацаанд олонтоо хэрэгжүүлж, ингэснээр олон улсын эрх зүйн болон улс төрийн стандартуудад нөлөөлж ирсэн.

Аюулгүйн зөвлөл өөрөө өөрийгөө саажуулахын эсрэг тэртээ 1950 онд болсон Солонгосын дайны сургамжаас “Uniting for Peace- Энх тайвны төлөө нэгдэгтүн” шийдвэрийг гаргасан байдаг. Энэ шийдвэрийн дагуу ерөнхий ассамблейн хуралдаанд иймэрхүү тохиолдолд аюулгүйн зөвлөлд хариуцсан асуудлыг өөртөө авч, ээлжит хуралдаанаас гадуур онцгой шаардлага гарсан үед арга хэмжээ санал болгохын тулд онц хурал зарлан хуралдуулах эрх олгосон. Аюулгүйн зөвлөлөөс гарсан тогтоолыг бүх гишүүн орнууд ёсчлон биелүүлэх үүрэг хүлээдэг цор ганц сонгуульт байгууллага нь аюулгүйн зөвлөл учраас ерөнхий ассамблей нь эрх мэдлийн хувьд аюулгүйн зөвлөлийн дор хэвээрээ байна.

Ерөнхий ассамблейн хуралдаан нь бүрэлдэхүүн ба ажлын арга барилаасаа болоод энх тайван ба аюулгүй байдлын асуудлаар ажиллахад НҮБ-ын удаан байгууллага юм. Ерөнхий ассамблейн хуралдааны шийдвэрүүд, тогтоолууд нь олон улсын эрх зүйн

үүднээс авч үзвэл зөвхөн зөвлөмжийн чанартай боловч эдгээр нь олон улсын шинэ эрхийн суурийг бүрдүүлэх боломжтой. Шийдвэрийг зарчмын хувьд энгийн олонхын саналаар гаргадаг. Дэлхийн энх тайвныг хангах болон олон улсын аюулгүй байдалтай холбоотой асуудлыг гуравны хоёрын саналаар шийддэг. Шийдвэр гаргалтын явцад нэг бүс нутгийн орнууд хоорондоо, эсвэл эдийн засаг, улс төрийн ашиг сонирхол ойролцоо орнууд эвсэл байгуулах нь олонтоо байдаг. Ялангуяа бүх орнуудад дипломат төлөөлөгчийн газаргүй жижиг орнуудын хувьд жил тутмын хуралдаан нь өөрсдийн асуудалд бусад орнуудын анхаарлыг хандуулах боломж юм.

Шинэчлэлийн тухай хэлэлцүүлгүүд

2017 онд НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерресийг шинэ аргачлалаар сонгосон. Шинэ аргачлал нь хуучинтай нь харьцуулахад илүү ил тод бөгөөд нэр дэвшигчид тус бүр нэг шинэчлэлийн зорилт танилцуулсан. Хэдийгээр сонгуулийн энэ шинэ аргачлалыг цаашид сайжруулах шаардлагатай, шүүмжлэлд өртдөг ч үүгээр НҮБ шинэчлэгдэх чадамжтай гэдгээ харуулж чадсан.

НҮБ-д хандсан гол шүүмжлэл бол цаашид ч олон улсын энх тайвныг хангах, зөрчилдөөнийг боловсруулахад ихэвчлэн хүндрэл учруулдаг, учруулсаар ч байх аюулгүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, байнгын таван гишүүний хориг тавих эрхийн асуудал юм. Шүүмжлэгчид аюулгүйн зөвлөлийг тус зөвлөл дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл үеийн хүчний харьцааны тусгал учраас 21-р зууны дэлхийн бодлогын бодит байдалд нийцдэггүй хэмээн шүүмжилдэг. Бүх тивийн төлөөллийг тэнцүү оруулах, байнгын гишүүдийн хориг тавих эрхээр дамжуулан аюулгүйн зөвлөлийн хаалт тавих эрхийг алхам алхмаар даван туулах шаардлагыг тавьдаг.

Аюулгүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх саналууд байнгын болон байнгын бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх зорилготой байдаг. Герман өнгөрсөн хугацаанд Бразил, Энэтхэг, Японтой хамтран байнгын гишүүдийн тоог зургаагаар, байнгын бус гишүүдийн тоог дөрвөөр нэмэгдүүлэх санал оруулж байсан.

Байнгын нэмэлт 6 гишүүнийг дараах түлхүүрийн дагуу сонгоно.

*Ерөнхий нарийн
бичгийн даргын
шинэ сонгууль*

*Дэлгэрүүлэн унших:
www.1for7billion.org*

*Аюулгүйн
зөвлөлийн
бүрэлдэхүүн*

*Санал: гишүүдийн
тоог нэмэх*

Дэлгэрүүлэн унших:

Софи Айзентраут (2016 он) НҮБ-ын аюулгүйн зөвлөл: Шинэчлэлийн шинэ эрчим, Амжилтад хүрэх найдвар ба тэдгээрийн Германд авчрах үр дагаврууд, Шинэчлэх ухаан ба улс төрийн сан-шинэ 79, Берлин

Хэрэгжилт нь маргаантай

Хориг тавих эрхийг хязгаарлах

Түлхүүр нь: африкийн орнуудаас нэгийг, азийн орнуудаас нэгийг, зүүн европын орнуудаас нэгийг, латин америк, карибын орнуудаас нэгийг.

Энэ санал ёсоор аюулгүйн зөвлөлийн нөлөө, итгэл даах байдал, хууль ёсны байдал буюу хүлээн зөвшөөрөгдөх байдал дээшлэх ёстой байлаа. Энэ саналыг хэзээ нэг цагт хүлээж авах эсэх нь эргэлзээтэй, гэхдээ нээлттэй байгаа. Учир нь энэ чиглэлээр шинэчлэл хийх оролдлого ерөнхий ассамблейн хуралдааны гуравны хоёрын санал шаардлагатай учраас өнөөг хүртэл юуны өмнө хориг тавих эрх бүхий гүрнүүдийн ашиг сонирхлоос болоод бүтэлгүйтсээр байна.

Энд мөн бүс нутгууд хоорондын ялгаатай байдал, хөрш орнууд хоорондын өрсөлдөөн шинэчлэл хийх эрмэлзэлд чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир нь Герман, Япон, Бразилын хөрш орнууд байнгын гишүүн орнуудыг улс төр, эдийн засгийн хувьд хүчирхэг орнуудаар өргөтгөхөд ихэвчлэн эргэлзээтэй ханддаг. Дээрээс нь хориг тавих эрх бүхий гишүүдийн тоог нэмсэн нөхцөлд сонгуульт байгууллага болох аюулгүйн зөвлөлийн ажлын чадамжийг сайжруулна гэж үздэг.

Үүний зэрэгцээ аюулгүйн зөвлөлийн төлөөлөх чадвар, хүлээн зөвшөөрөгдөх байдал ба үр өгөөжтэй шийдвэр гаргалтын тэнцвэр хангагдах бөгөөд ингэснээр АЗ-ийн дэлхийн энх тайван, олон улсын аюулгүй байдлын өмнө хариуцлага дээшлэх юм. Хэдийгээр зарим зүйлийг сайжруулсан ч ил тод байдлыг дээшлүүлэх, АЗ-ийн ажлын практикт иргэний нийгмийн илүү олон оролцогч талуудын оролцоог хангах шаардлага хэвээр байна.

АЗ-ийн ажлын арга барилтай холбоотойгоор байнгын гишүүд тодорхой нөхцөлд өөрсдийн хориг тавих эрхээс татгалздаг байх талаар хэлэлцүүлэг өрнөдөг. АЗ-ийн хориг тавих эрх бүхий байнгын гишүүн Франц улс нь хориг тавих эрх бүхий гүрнүүд аймаглан устгах, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг өдүүлсэн гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах үед өөрсдийн хориг тавих эрхээс татгалздаг байх саналыг дэвшүүлсэн.

Үндэсний суурь эрх ашиг хөндөгдөж буй нөхцөлд үүнийг онцгой

тохиолдол гэж үзэх ёстой. Мэдээж энд тухайн ойлголтуудыг хэрхэн тайлбарлах вэ? гэдэг асуудал гарч ирнэ. Францын саналын дагуу аймаглан устгасан уу?, дайны гэмт хэрэг өдүүлсэн үү?, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг өдүүлсэн үү? гэдгийг ерөнхий нарийн бичгийн дарга 50 гишүүн оронтой хамтран тогтооно. Үндэсний ашиг сонирхлыг хөндөгдөж байна уу? гэдэг асуултын хариултад хориг тавих эрх бүхий гүрнүүдийн хэмжүүр чухал үүрэгтэй, гэхдээ хориг тавих хэмжүүрийн орон зай магадгүй үүгээр хумигдаж болзошгүй юм.

Дэлхий дахины хямрал, аюулгүй байдлын бодлогын шинэ сорилтыг даван туулах нь олон улсын хамтын ажиллагаанд урьд өмнөхөөс илүү олон хэлбэрийг шаардаж байна. АЗ, ерөнхий ассамблейн хуралдаан нь зөрчилдөөнийг судлан боловсруулах, дэлхийн энх тайвныг хангахад өндөр чадамжтай НҮБ-ын сонгуульт байгууллагууд юм. Гэхдээ эдгээр нь эцэстээ гишүүн улсуудынхаа зөвшөөрсөн хэмжээнд л хэрэгжүүлэх чадамжтай байдаг.

АЗ шийдвэр гаргах эрх бүхий үндсэн сонгуульт байгууллагын хувьд албан ёсны хүчирхэг эрх мэдэлтэй ч, харин энэ эрх мэдлээ шууд хэрэгжүүлэх хэрэгсэл байхгүй. (Жишээлбэл: эхэндээ НҮБ-ын хартад НҮБ өөрийн цэрэгтэй байна гэдэг заалт байсан) Бодит байдал дээр НҮБ-ын эрх мэдэл ямагт улс орнуудын сайн дурын хамтын ажиллагаа, тэдгээрийн энх тайвны ажиллагаанд оролцох, эсвэл эдийн засгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хүслээс хамаардаг.

Социалдемократ хэтийн төлөв

Социалдемократ хэтийн төлөвөөс харахад НҮБ нь олон улсын энх тайвны дэглэм журмын татгалзаж үл болох нэгэн бүрэлдэхүүн хэсэг мөн. Эдгээр нь олон төрлийн ашиг сонирхлуудын талаар иргэншсэн хэлэлцээр явуулах өлгий нутаг юм. НҮБ-ыг илүү хүчирхэг болгосноор хүчтэнүүдийн эрхийг улам бэхжүүлэхийн оронд олон улсын эрхийг бэхжүүлнэ гэсэн үг юм. Сигмар Гавриел, Мартин Шульц нарын 2017 оны дундуур боловсруулсан бодлогын бичиг баримтад Их 20-ийг бэхжүүлэхийн оронд НҮБ-ыг бэхжүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглэсэн байдаг. \Өмнө нь ишлэл татсан\ НҮБ-ын хүрээнд гаргасан хичээл зүтгэл ихэвчлэн амаргүй, тууштай

Дэлгэрүүлэн унших:

Флориан Т.Фуртак

(2015 он). Олон

улсын байгууллагууд.

Дэлхийн бодлогод

төрийн болон

төрийн бус

байгууллагууд.

Виесбаден

Фридрих-Эбертийн

сангийн Нью Йорк

дох НҮБ-ын оффисын

шинэ мэдээлэл: www.fes-newyork.org

байхыг шаарддаг ч Парисын цаг уурын хэлэлцээр эсвэл тогтвортой хөгжлийн зорилтуудыг баталсан шинэ цагийн амжилтууд амаргүй ч хичээл зүтгэл үр дүнд хүрдэг гэдгийг харуулж байна.

Социал-демократуудын төлөөлөл АЗ-ийн хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд бүрэлдэхүүн, түүний ажлын арга барилыг өөрчлөхийн төлөө идэвхтэй ажилладаг.

*Шүүмжлэлтэй:
Энхийг сахиулах
ажиллагаанд
оролцох*

Социал-демократ хэтийн төлөвөөс харахад НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд герман болон барууны орнуудын оролцоо дутмаг байгаад шүүмжлэлтэй хандах ёстой. Барууны орнууд цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцох чухал ажиллагаануудад юуны өмнө НАТО-гийн бүтцийг ашигладаг. Барууны орнууд өөрсдөд нь төдийлөн чухал бус НҮБ-ын ажиллагаанууд оролцохоос хойш суудаг нь НҮБ-ын үйл ажиллагааг тодорхой хэмжээнд хүчгүйдүүлдэг.

5.3. НАТО

Зохиогч Томас Хартманн

*Реализмын
онолын сургууль:
“Хүчний тэнцвэр”*

НАТО реализмын онолын сургуульд хамаарах нь ойлгомжтой. Реализмын өнцгөөс харахад өөрийн эрх мэдлийг хориг арга хэмжээгээр хэрэгжүүлж чадах НАТО-аас дээгүүр эрэмбэлэгдэх дээд шатны байгууллага байхгүй. Улс орнууд эрх мэдэл ба аюулгүй байдлаа дээд зэргээр хангахыг эрмэлздэг. Бодит таамаглалуудын дагуу бол олон улсын систем дэх эрх мэдэл нь тэг нийлбэрийн тоглоомтой адил. Өөрөөр хэлбэл нэг улсын алдсаныг нөгөө улс нь хожно гэсэн үг. Энэ таамаглалаар бол улс орнуудын хамтран ажиллах сонирхлыг өдөөх хүчин зүйл байхгүй болж таарах нь. Улс орнууд олон улсын систем дэх өөрсдийн байр суурийг бусад оролцогч талуудын байр суурьтай харьцуулсан байдлаар хамгаалахыг эрмэлздэг. Эхний ээлжид тэнцвэрт байдлыг тогтоох, баталгаажуулахын төлөө байдаг. (balance of power-хүчний тэнцвэр).

29 орон

Энэ утгаар НАТО-д европ, хойд америкийн орнууд нэгдсэн байдаг. Гишүүн орнууд цэргийн халдлагад өртсөн тохиолдолд харилцан бие биедээ дэмжлэг үзүүлнэ гэдгээ баталгаажуулан хойд

атлантикийн гэрээнд гарын үсэг зурсан. Энд юуны өмнө НАТО-ийн гишүүн орнуудын аль нэг нь халдлагад өртсөн бол бүх гишүүн орнуудад халдсанд тооцож харилцан туслалцана гэж тохиролцсон. Тус цэргийн холбоо нь хойд атлантикийн гэрээний нэрээр НАТО-(North Atlantic Treaty Organisation) нэрлэгдсэн, Хойд Атлантикийн Гэрээнд нэгдсэн орнууд юм. НАТО батлан хамгаалахын холбооны зориулалтаар үүсгэн байгуулагдсан, хожим тус байгууллагын мандатад зарчмын хувьд өөрийн гишүүн орнуудын аюулгүй байдал болон дэлхий дахины тогтвортой байдлыг дэмжинэ хэмээн нэмэлт өөрчлөлт оруулсан. Хойд атлантикийн гэрээ нь 1949 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

НАТО нь засгийн газар хоорондын байгууллага юм. Гишүүн орнууд нь нягт хамтран ажилладаг ч үндэсний тусгаар тогтнолын эрхүүдээ хамтарсан байгууллагадаа шилжүүлдэггүй. Гишүүн орнууд нь улс төрийн ба цэргийн зохион байгуулалтын салбаруудад хуваагддаг. Гишүүн орнуудын аюулгүй байдлыг коллектив хамгаалалтын хүрээнд хамгаалахын зэрэгцээ энх тайван ба аюулгүй байдлыг тогтоох, хамгаалах нь НАТО-гийн үндсэн үүрэг. Зүүн, Барууны зөрчилдөөний үед аюулгүй байдлын хурцадмал байдал үүсээгүй бол тус байгууллага юуны төлөө байгуулагдсаныг тайлбарлах боломжгүй байх байлаа.

Хойд атлантикийн зөвлөл нь НАТО-ийн улс төрийн шийдвэр гаргах дээд байгууллага юм. Тус зөвлөлөөс НАТО-г хөгжүүлэх удирдамжийг баталдаг. Зөвлөл ерөнхийдөө долоо хоног тутамд гишүүн орнуудын байнгын төлөөлөгчийн түвшинд (НАТО-элчин сайдууд) НАТО-гийн төв байр байрладаг Брюссел хотноо, хагас жил тутамд үндэсний гадаад, батлан хамгаалах сайдуудын түвшинд, жил тутамд гишүүн орнуудын төр, засгийн тэргүүнүүдийн түвшинд уулздаг. Зөвлөлийн дор байдаг хамгийн чухал байгууллагууд нь батлан хамгаалахын сайд нарын төлөвлөлтийн хороо, цөмийн төлөвлөлтийн бүлэг юм. Зөвлөл шийдвэрээ зөвшилцлийн аргачлалаар гаргадаг. Зөвлөлийн гишүүн 28 орон том, жижгээсээ үл хамааран хориг тавих нэг эрхтэй байдаг.

Ерөнхий нарийн бичгийн дарга нь НАТО-ийн зөвлөлдөх, шийдвэр

*Бүтэц: Засгийн
газар хоорондын*

*Хойд
атлантикийн
зөвлөл*

гаргах явцыг удирддаг, дөрвөн жил тутамд гишүүдээс сонгогддог. Дээрээс нь ерөнхий нарийн бичгийн дарга холбоог гадагшаа ба дотогшоо төлөөлдөг.

Цэргийн хороо

Цэргийн хороо нь НАТО-ийн цэргийн шийдвэр гаргах сонгуульт, дээд байгууллага юм. Тус хороо НАТО-ийн улс төрийн шийдвэр гаргах сонгуульт дээд байгууллагад цэргийн стратегийн асуудлаар зөвлөгөө өгдөг бөгөөд НАТО-ийн цэргийн үүргийн нэгдсэн удирдлагыг хариуцдаг, улс төрийн шийдвэрүүдийг цэргийн зааварчилгаанд шилжүүлэн хэрэгжүүлдэг.

Үүний зэрэгцээ тус хорооны дор олон сонгуульт байгууллагууд (Хороод, ажлын хэсгүүд гэх мэт) болон олон улсын цэргийн штабууд байдаг. Эдгээр нь сонгуульт дээд байгууллагуудын ажлыг дэмжих үүрэгтэй.

1955 он: ХБНГУ элсэн орсон

1955 оны 5-р сарын 9-нд Герман улс барууны нэгдэлд элссэний нөлөөгөөр НАТО-д гишүүнээр элссэн. Үүнээс хойш таван өдрийн дараа Варшавын гэрээ үүсгэн байгуулагдсан. АНУ ба ЗХУ-ын оролцоотой Гитлерийн эсрэг эвслийн оронд дэлхийн батлан хамгаалахын салбар АНУ-ын удирддаг НАТО ба ЗХУ-ын удирддаг Варшавын гэрээ гэдэг хоёр хэсэгт хуваагдсан. Энэхүү эсрэг, тэсрэг байдал нь хүйтэн дайныг тодорхойлж байлаа. Харилцан айлган сүрдүүлэх бодлогын цаана цохилт амссан талд хоёрдох цохилт өгөх боломж олдох юм бол халдлага үйлдсэн талыг цөмийн зэвсгээр бараг бүр мөсөн устгах хүчтэй гэсэн санаа байсан.

1967 он: Хармелийн илтгэл

1960-аад онд намжмал байдлын үе шат эхэлсний дараагаар уг цэргийн холбоог улс төрийн цар хүрээгээр өргөтгөсөн. 1967 онд нийтлэгдсэн Хармелийн илтгэл хэмээн нэрлэгдсэн илтгэлд НАТО-гийн хоёр үндсэн үүргийг зохицуулсан: нэг талд тус холбооны цэргийн хүчээ айлган сүрдүүлэх хэмжээнд хадгалах, нөгөө талд Варшавын гэрээний орнуудтай урт хугацааны харилцааг хөгжүүлэх. ЗХУ дунд тусгалын пуужингаар зэвсэглэлээ нэмэгдүүлсэн, хариуд нь 1979 онд НАТО-гийн давхар тогтоол батлагдсаны улмаас хоёр фронт улам хатуурсан. Уг тогтоолоор баруун европт цөмийн Першинг-II дунд зайн пуужинг байрлуулах шийдвэр гарсан. Харин

баруун европын олон нийт тус пуужингуудыг байршуулахыг хүчтэй эсэргүүцсэн учраас НАТО-ийн холбоотнуудын дунд мөн хурцадмал байдал үүссэн.

Төмөр нуран хөшиг унаснаар гео-стратегийн нөхцөл байдал үндсээрээ өөрчлөгдсөн. ЗХУ ба Варшавын гэрээ задарсан. 1997 онд Парис хотноо харилцаа, хамтын ажиллагаа, аюулгүй байдлын Үндсэн актыг НАТО ба ОХУ-ын хооронд байгуулснаар анх удаа НАТО ба ОХУ -г дайсагнагч талууд хэмээн нэрлээгүй бичиг баримт батлагдсан юм.

Ингэснээр НАТО эхний ээлжид Варшавын гэрээний орнуудаас эхтэй, санаанаасаа зохиосон цэргийн шууд заналхийллийн эсрэг цэргийн эвсэл гэдэг түүхэн хөгжлийн үр дүнд бий болсон хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдлаа алдсан. НАТО-ийн өмнө өргөн хүрээтэй шинэчлэл, чиг хандлагаа шинэчлэн тогтоох үе шат хүлээж байлаа.

НАТО задралын эсрэг шийдвэр гаргаж, задралын оронд өөрийн ойлголтыг өөрчилсөн юм. НАТО олон улсын эрх зүйн үндэслэлтэй, үндэслэлгүй НҮБ-ын мандаттайгаар холбоотнуудын нутаг дэвсгэр дээр болон нутаг дэвсгэрээс гадуур (out of area) энх тайвныг хадгалах ажиллагаа, хүмүүнлэгийн хөндлөнгийн оролцоо, алан хядлагатай тэмцэхэд оролцох замаар үүргээ өргөтгөх болно хэмээн тайлбарласан. Энэ цагаас хойш НАТО аюулгүй байдлын салбарт түншлэлийн хөтөлбөрөөр дамжуулан олон улсын яриа хэлэлцээ хийх, эсвэл гуравдагч орнууд ба НҮБ, ЕХ зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах замаар энх тайвныг дэмжихийг үүргээ гэж үзэх болсон. Гишүүн болон гишүүн бус орнуудтай хамтран ажиллах замаар зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлж, тогтвортой байдлыг тогтоох нь мөн НАТО-ийн үүрэг гэж үзсэн.

НАТО 2010 онд стратегиа шинэчлэн баталж, тус эвслийн үндсэн үүрэг нь гишүүн орнуудын эрх чөлөө, аюулгүй байдлыг улс төрийн болон батлан хамгаалахын хэрэгслүүдээр коллектив батлан хамгаалах (collective defence), хямралын менежмент (crisis management), хамтын аюулгүй байдал (cooperative security) гэсэн гурван салбарт хамгаалах хэмээн тодорхойлсон.

*Төмөр хөшиг
нуран унасан нь*

НАТО дээрээс нь Дундад ба Зүүн европ болон Балтийн тэнгисийн орнуудыг гишүүнээр элсүүлэхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн. 2002 онд Прага хотноо болсон дээд хэмжээний уулзалтаас гишүүнчлэлээ өргөтгөх хамгийн том шийдвэрийг гаргасан. Эцэст нь НАТО 2004 оны 3-р сард Болгар, Румын, Словак, Словени, хуучин ЗХУ-н бүрэлдэхүүнд байсан балтийн гурван улсаар гишүүнчлэлээ өргөтгөсөн. Өнөөдрийн байдлаар НАТО 28 гишүүнтэй. 1990-ээд оноос зүүнийг өргөтгөх бодлого ОХУ-ын аюулгүй байдлын ашиг сонирхлыг хөндөж байгаа тул НАТО ба Оросын харилцаанд онцгой хүндрэл учруулж байна. Батлан хамгаалах, аюулгүй байдлын бодлогын салбарын хамтын ажиллагааг сайжруулахын тулд 2002 онд зохицуулалтын форум болох НАТО - ОХУ-ын зөвлөлийг байгуулсан. 2001 оны 9-р сарын 11-нд АНУ-д алан хядагчдын хийсэн бөмбөгдөлтийг НАТО-гийн түүхэнд анх удаа НАТО-гийн бүх гишүүдэд халдсан батлан хамгаалахын тохиолдол мөн гэдгийг баталгаажуулсан. 2003 онд НАТО Афганистанд олон улсын аюулгүй байдлын туслах хүчний удирдлагыг гартаа авсан.

Орос Крымийг түрэмгийлэн эзлэхээс ч өмнө геостратегийн зөрчилдөөний хуучин шугамууд дахин тодорч, холбооны анхдагч зорилтууд (коллектив өөрийн хамгаалал) дахин сэргэсэн.

Нэг талаас НАТО-гийн төлөвлөөд байгаа болон хэрэгжүүлээд байгаа зүүний өргөтгөлд хариуг нь өгөхийн тулд, нөгөө талд оросын пуужинг европт саатуулж болзошгүй пуужингаас хамгаалах шүхрээс болоод хүчний тэнцвэр өөрчлөгдөж болзошгүй хэмээн үзсэн учраас Орос НАТО-г өөрийн улсад учирч болзошгүй аюулын шатлалд дахин оруулсан. НАТО-гийн гишүүн орнуудын дунд Украйны хямралд хариулт өгч, зэвсэглэлийг нэмэгдүүл гэдэг шаардлага чангарах боллоо.

Социалдемократ хэтийн төлөв

Германы НАТО-гийн гишүүнчлэл нь дэлхийн хоёрдугаар дайны дараах үед ГСДН Шүмакер даргатай байх үеэс ГСДН-ын үеэс 1990-ээд оныг хүртэл маргаантай асуудал байлаа. Эцэст нь хүчирхэг, хэрэгжүүлэх чадамжтай НҮБ-тай дэлхийд НАТО-аас татгалзахад болохгүй гэх газаргүй гэдэг санаа төрж байлаа.

Дэлгэрүүлэн унших:

Флориан Т.Фуртак

(2015 он) Олон улсын

байгууллагууд.

Дэлхийн бодлогод

төрийн болон

төрийн бус

байгууллагууд,

Виесбаден

Социалдемократ

үзэл: бодлого

төлөвлөлтөд

оролцоотой байя

гэвэл хамтдаа

бай

Социалдемократуудын төлөөлөгчид европын армитай байх санааг ахин дахин дэмжин түрсээр байна.

Дэлхийн бодит нөхцөл байдлаас шалтгаалаад ГСДН өнөөдөр харин Германы НАТО-гийн гишүүнчлэлийг шийдэмгий дэмжиж байна. Зөвхөн ширээний ард хамтдаа сууж байгаа нэгэнд л НАТО-ийн бодлого төлөвлөлтөд оролцоотой байх боломж олдоно. НАТО-гийн шинэ өөрийн ойлголтыг эрс тэлэх, шаардлагагүй нөхцөлд байдлыг шат ахиулан хурцатгахгүй байх, зэвсэглэлээр өрсөлдөх зэрэг нуугдмал аюулыг германы холбооны засгийн газарт улс төрийн хүсэл зориг нь байгаа нөхцөлд НАТО-гийн гаднаас нь бус дотроос нь сөрөх боломж өндөр.

5.4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)

Томас Хартманн

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага нь институционализмын онолын сургуульд хамаарна гэдэг нь онцгой арга хэлбэрээр маш тодорхой харагддаг.²⁰

ЕАБХАБ нь тогтмолжсон энх тайвны бага хурлын нэгэн хэлбэр юм. Тус хуралд дэлхийн 57 орон оролцдог. Европын бүх улсууд дээр нэмэх нь: Турк, Монгол, ЗХУ-ыг залгамжлагч орнууд, АНУ, Канад зэрэг орнууд багтдаг. ЕАБХАБ-ын төв нь Вена хотод байрладаг.

ЕАБХАБ нь 1995 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны хурлаас эхтэй байгуулагдсан. Харин Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны хурал нь 1975 онд байгуулагдсан. Хурлыг байгууллага болгон өөрчлөн байгуулснаар тогтмолжсон энх тайвны хурал болсон гэдгийг нэр нь тодорхой хэлээд өгнө.

ЕАБХ 1975 онд Хельсинки хотноо анх удаа хуралдсан. Энэхүү эвсэл дамнасан аюулгүй байдлын бага хурал зохион байгуулах санаачилгыг Варшавын гэрээний орнууд гаргасан. ХБНГУ аюулгүй байдлын бага хурлын хүрээнд германы хуваагдлыг баталгаажуулах

*Онолын сургууль:
Институционализм*

*Үргэлжилсээр буй
Энх тайвны бага
хурал*

*1995 он:
Бага хурлаас
байгууллага
болсон*

1975 он: Хельсинки

²⁰ Олон улсын харилцааны онолууд сэдэвт 2.1 бүлгээс харна уу.

вий гэдэг айдсаасаа болоод тэдний энэ санаачилгыг удаан хугацаанд хүлээж аваагүй юм. Харин “ойртох замаар хувьсалд хүрэх” уриа дор Билли Брандтын удирдан хэрэгжүүлсэн социал-либерал намжмал байдлын бодлогын нөлөөгөөр тус бага хурал бодит ажил болсон юм.

Хаалтын гэрээ

Бага хурлын үндсэн баримт бичиг болох 1975 оны 7-р сарын 30-нд батлагдсан хаалтын гэрээ нь хүйтэн дайны ид үед намжмал байдлын бодлогод чухал ач холбогдолтой баримт бичиг болсон юм.

Уг хаалтын гэрээ нь сүүлчийн цэг, таслалыг нь хүртэл бодож боловсруулсан, харилцан буултын санааг агуулсан баримт бичиг байсан. Уг гэрээ нь хоёр талын хэрэгцээг санаанд нь хүртэл илэрхийлсэн. Хельсинкийн гэрээ гурван сагснаас бүрддэг.

“Гурван сагс”

Эхний сагсанд нь арван зарчим багтсан. Уг зарчмуудыг оролцогч орнууд өөрсдийн харилцаандаа удирдлага болгох ёстой. Эдгээрт: “Хилийн халдашгүй дархан байдал”, “Хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хүндэтгэх”, болон “Дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох”, “Холбооны гэрээний тал байх, эсвэл гэрээний тал болохгүй байх” зэрэг багтдаг.

Хоёрдох сагсанд худалдаа, эдийн засаг, техник, байгаль орчны салбарын хамтын ажиллагааны зохицуулалт багтсан. Гуравдах сагсанд “аюулгүй байдал, газрын дундад тэнгисийн орон зай дах хамтын ажиллагааны асуудал” болон хүмүүнлэг, бусад салбарын хамтын ажиллагааны зохицуулалт багтсан.

Тогтмолжуулах

Үүний дараагийн жилүүдэд Хельсинкид эхлүүлсэн үйл явц тогтмол хурал, оролцогч орнуудын уулзалтуудаар үргэлжилсэн. Зүүн, Барууны зөрчилдөөн төгсгөл болсны дараагаар ЕАББХ-аас болон нийт европын аюулгүй байдлын системд шинээр тулгарсан сорилтуудыг нэгэн дээвэр дор шийдвэрлэнэ гэдэг хүлээлт их болсон. Шинээр тулгамдсан сорилтуудын улмаас ЕАББХ “Парисын харта”-аар (1990 оны 11-р сард) шинэ чиглэлийг тодорхойлж, зөрчилдөөнөөс хамгаалах, эртнээс сануулах, хямралын менежмент, сонгуулийн ажиглалт зэрэг салбараар ЕАББХ-ын европын аюулгүй байдлын бодлогод гүйцэтгэх үүргийг өргөтгөсөн.

Будапешт хотноо болсон (1994 он) тавдах уулзалтаас эцэст нь ЕАББХ-ын үйл явцыг бүтцэд оруулан байгууллага болгон бэхжүүлэх уг байгууллагаа оператив буюу үйл ажиллагааны чадамжтай болгох шийдвэр гарсан. ЕАББХ-ыг 1995 оны 1-р сарын 1-ээс Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ) болгон нэрийг нь өөрчилсөн. Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газрын төв тэр цагаас хойш Вена хотод байрладаг.

ЕАБХАБ нь өдгөө Хойд америк, Европ, Ази тивийн тэгш эрхт оролцогч 57 орон ба эдгээр орнуудын тэрбум гаруй хүнийг төлөөлдөг. ЕАБХАБ нь олон улсын эрх зүйн гэрээ дээр суурилан байгуулагдаагүй учраас олон улсын эрх зүйн статус байхгүй. ЕАБХАБ-ын тогтоолууд нь хуульчлан хэрэгжүүлэх үүрэг ногдуулдаггүй учраас улс төрийн шийдвэрүүд байдаг.

ЕАБХАБ-ын үүргийн салбарууд нь нэгдсэн, өргөн хүрээтэй аюулгүй байдлын ойлголт дээр суурилдаг. Сайн хөршийн бодлогыг эрхэмлэх, зөрчилдөөнийг энх тайвны замаар шийдвэрлэх, эдийн засаг, техник, экологийн салбарын хамтын ажиллагааг дэмжих нь тус байгууллагын үндсэн зорилтууд юм.

ЕАБХАБ-ын институт буюу байгуулагуудын архитектурын бүтцийг Хельсинкийн хаалтын гэрээнээс хойш байнга өргөтгөсөөр ирлээ. Тус байгууллага нь зөвшилцлийн аргаар шийдвэрээ гаргадаг улс төрийн төрөл бүрийн байгууллагуудаас бүрддэг. (Онцгой тохиолдол: Парламентын хуралдаан) Хүний эрхийн ноцтой зөрчил гарсан, ардчилсан, эрх зүйт төрийн байгууллын дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд аль нэг улс орны тавьсан хоригийн эсрэг, тухайн улсын зөвшөөрөлгүйгээр хориг арга хэмжээ баталдаг. (1992 оны Зөвшилцөл-хасах-нэг-журам 1992 он)

ЕАБХАБ үндсэн шийдвэрүүдээ төр, засгийн газрын тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтуудаар дундаа олон жилийн завсарлагатайгаар гаргадаг. Завсар хооронд нь гадаад хэргийн сайд нарын түвшинд сайд нарын зөвлөл хуралддаг. Мөн жил тутамд Копенгаген оролцогч орнуудын 320 парламентын гишүүд цугларч парламентын хуралдаан хийдэг. ЕАБХАБ-ын удирдлага жил тутамд гишүүн орнуудын хооронд

57 орон

ЕАБХАБ-ын
байгууллагууд

Дэлгэрүүлэн унших:

Флориан Т. Фуртак

(2015 он), Олон

улсын Байгууллагууд.

Дэлхийн бодлогод

төрийн ба төрийн

бус байгууллагууд,

Виесбаден

солигдож байдаг. Оролцогч орнуудын байнгын төлөөлөгчдөөс бүрддэг байнгын зөвлөл долоо хоногт нэгээс доошгүй удаа Вена хотноо уулздаг.

Улс төрийн байгууллагуудыг Вена хот дох ЕАБХАБ-ын нарийн бичгийн дарга нарын газар болон нэг эсвэл гурван жилийн хугацаагаар томилогддог ерөнхий нарийн бичгийн дарга дэмжиж ажилладаг. Дээрээс нь тус байгууллагын мэргэжлийн тусгай байгууллагууд оролцогч орнуудад ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх үүрэг хүлээдэг. Эдгээрт Варшавт төвтэй ардчилсан бүтцүүд ба хүний эрхийн оффис, Ден Хагт төвтэй Үндэсний цөөнхийн дээд комиссарын газар, Вена хотод төвтэй Хэвлэлийн эрх чөлөөний асуудал хариуцсан төлөөлөгч багтдаг. Үүний зэрэгцээ долоо хоног тутамд Вена хотноо хуралддаг аюулгүй байдлын хамтын ажиллагааны форум улс төр, цэргийн цар хүрээний асуудлаар тогтоол гаргах эрх мэдэлтэй байдаг.

Зөрчилдөөнөөс хамгаалах, хямралыг даван туулах ажиллагааны нэгэн чухал хэрэгсэл бол ЕАБХАБ-ын хээрийн ажиллагаанууд юм. Эдгээрт, жишээ нь ардчилал, эрх зүйт төр, хүний эрх, цөөнхийн эрх, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих дэмжлэг ба зөвлөгөө багтдаг. Ямар хэрэгслийг сонгох талаарх шийдвэрийг байнгын зөвлөлөөс зочин оронтой зөвшилцөн гаргадаг. Өнөөгийн байдлаар ЕАБХАБ-ын 18 “хээрийн ажиллагаа”-г Зүүн өмнөд европ, Зүүн европ, Кавказ, Төв азийн 16 оронд явуулж байна.

Үүний зэрэгцээ сонгуулийн ажиглалт нь ЕАБХАБ-ын бас нэгэн чухал оператив хэрэгсэл юм. Сонгуульд бэлтгэх, сонгууль явуулах явцыг шүүмжлэлтэйгээр ажиглаж үр дүнг зориудаар мушгин гуйвуулах үйлдэл гаргуулахгүй байх замаар тухайн улсын ардчилсан хөгжлийг дэмжих зорилготой. Сонгуулийн ажиглалтыг ардчилсан институц ба хүний эрхийн оффис хариуцдаг. Германд энэ үүргийг олон улсын энхийн ажиллагааны төв хэрэгжүүлдэг. Гадаад хэргийн яамтай нягт хамтран ажиллаж олон улсын энхийн ажиллагааны төвийн сонгууль ажиглах мэргэжилтнүүдээс сонгож ЕАБХАБ-ын хүрээнд илгээдэг.

ЕАБХАБ-ын ач холбогдол буурч байна.

ЕАБХАБ, нэн ялангуяа өөрийн хараат бус сонгуулийн ажиглалтаар

өргөн олон нийтэд танигдсан бол 21-р зууны эхэн үеэс европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны үндсэн оролцогч тал гэдэг үнэлэмж нь буурч байгаа тул ач холбогдлоо дээшлүүлэхийн төлөө тэмцэж байна.

ЕАБХАБ-ын ач холбогдол ийнхүү буурах болсон нь эхний ээлжид НАТО, Европын Холбоо зэрэг бусад оролцогчидтой хийж буй, улам бүр нэмэгдэж буй өрсөлдөөнөөс үүдэлтэй. Учир нь энэ хоёр оролцогч тал улс орнуудын дийлэнхэд аюулгүй байдлын бодлогын үйл хэрэгт ЕАБХАБ-аас илүү том стратегийн ашиг амладаг. Дээрээс нь зүүн зүгийн оролцогч орнууд, ялангуяа Орос тус байгууллага дан ганц хүний цар хүрээнд гол анхаарлаа төвлөрүүлдэг (сонгууль ба хүний эрхийн ажиглалт), дотоодын хэрэгт хөндлөнгөөс оролцдог гэж шүүмжилдэг. ЕАБХАБ-ын харагдах байдал, бие даасан дүр төрх өмнө нь ЕАБХАБ-ын хэрэгжүүлж байсан үйл ажиллагааны салбарууд дээр бусад оролцогч талууд үйл ажиллагаагаа өргөтгөснөөс болоод (жишээ нь: Сонгуулийн ажиглалт эсвэл хямралын тохиолдолд ЕХ зуучлах) бүдгэрч байна. Оролцогч орнуудаас бүрдүүлдэг төсвийн хэмжээ тогтмол буурч байгаа нь тус байгууллагын ач холбогдол буурч байгааг харуулж байна.

2008 онд Өмнөд Оссетиений зөрчилдөөнийг аюулгүй байдлын нийгэмлэг болох ЕАБХАБ-аар дамжуулан олон талын оролцоотой зохицуулах оролдлого бүтэлгүйтсэн нь тус байгууллагын ач холбогдол буурч байгаагийн нэг тод жишээ юм.

Хямралын үед ЕАБХАБ сэргэн манддаг

Хамгийн сүүлд 2014 оны Украйны хямралын үр дагаварт ЕАБХАБ сэргэн мандлыг үзэв. 2014 оны 5-р сард зуучлалын үндсэн хэрэгсэл болох Украйн, Орос, ЕАБХАБ-ын гурван талт харилцах бүлгийг байгуулсан. Өмнө нь 2014 оны 5-р сард байнгын зөвлөлөөс “Тусгай хяналтын ажиллагаа”-нд (18 дах хээрийн ажиллагаа) ЕАБХАБ-тай байгуулсан тохиролцооны хэрэгжилтэд хяналт тавих мандат олгосон. Иргэний ажиглагчид өөрсдийн үнэн бодит илтгэлээр нөхцөл байдлыг тогтворжуулах, хурцадмал байдлыг намжаахад хувь нэмрээ оруулах ёстой байлаа. Мөн Украйны урилгаар хүний эрхийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, парламент ба ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах

*Өрсөлдөөн ба
бусад оролцогч
талууд*

*Дэлгэрүүлэн унших:
Франк-Балтер
Штайнмайер (2016
он), Намжмал
байдлын бодлогын
дипломат сургамж,
Хамтран ажиллах
санал айлган
сүрдүүлэх бодлогын
нэгэн адил тодорхой
байх ёстой. 2016
оны 9-р сарын 1-ний
Олон улсын бодлого
ба нийгэм сэтгүүл,
Берлин хот*

*Вольфганг Зеллнер
(2017 он), 2016 онд
Герман ЕАБХАБ-ыг
даргалсан хугацааны
эхний тайлан,*

ЕАБХАБ-ын сэтгүүл,
Холбооны улс
төрийн боловсролын
төв Бонн хотноо
хэвлэгдсэн

Вена хотноо төвтэй
Европын хамтын
ажиллагаа ба энх
тайвны бүс нутгийн
оффисын сүүлийн
үеийн мэдээ www.fes-vienna.org хаягаас
уншина уу.

ажиллагааг 2014 оны 5 ба 10-р сард явуулсан.

Социалдемократ хэтийн төлөв

ЕАБХАБ өнгөрсөн хугацаанд ялангуяа хямралын агшинд шаардагдах хамтын ажиллагааг зохицуулах, зөрчилдөгч талууд хоорондын яриа хэлэлцээг дэмжих өндөр чадамжтай гэдгээ олон удаа баталсан. Тус байгууллагын өргөн хүрээтэй аюулгүй байдлын ойлголт дээр суурилсан, олон давхаргат, цэргийн бус арга хэрэгслүүд нь заналхийлж буй зөрчилдөөнийг эрт таньж тогтоох, нэгэнт гарсан хямралыг боловсруулах боломжийг бүрдүүлдэг. ЕАБХАБ-д НҮБ-ын гишүүн орнуудын 30% нь, тэдгээрийн дотор аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүний 4 нь болон НАТО ба Европын холбооны бүх гишүүн орнууд багтдаг. ЕАБХАБ-ын туршлага, хямрал, зөрчилдөөний менежментийн чадавхыг ирээдүйд ч ашиглаж, зах руу түлхэгдэхээс нь хамгаалахын тулд гишүүн орнууд тус байгууллагыг санхүү, боловсон хүчин, улс төрийн хувьд цаашид бэхжүүлэх шаардлагатай.

5.5. Европын Холбоо (ЕХ)-Энх тайвны гүрнээс цэрэгжсэн гүрэн рүү шилжих гэж үү?

Зохиогч Рожиа Кемпин

ЕХ: Хамгийн амжилттай энх тайвны төсөл

ЕХ нь энэ цаг үеийн хамгийн амжилттай хэрэгжиж буй энх тайвны төсөл юм. 60 жилийн өмнөөс өмнө нь цус асгаруулсан тив байсан европ тивд хүмүүс чөлөөтэй амьдарч, ажиллаж, аялж байна. ЕХ-ны гишүүн орнууд европ тивд дахин хэзээ ч дайн гаргуулахгүйн төлөө цаг ямагт, улам илүү нягт хамтран ажиллаж байна. ЕХ-г байгуулах санаа тэртээ 1951 онд нүүрс, гангийн үйлдвэрийг нийгэмчилсний дараах үеэс эхтэй. Гэвч хамтарсан зэвсэгт хүчин байгуулах санаачилга 1954 онд францын үндэсний хурал дээр бүтэлгүйтсэн.

Санаанаас гардаггүй туршлага: Балканы зөрчил

Балканы хойгийн зөрчилдөөнд европ ухаан мэдрэлээ алдталаа сандарсан туршлагаасаа ЕХ гишүүн орнуудыг батлан хамгаалах, аюулгүй байдлын хамтарсан бодлоготой болох хичээл зүтгэлээ дахин шинээр сэргээхэд хүргэв. Ялангуяа 1999 оны Косовогийн зөрчилдөөн ЕХ нь улс төрийн шийдэл гаргах чадамжгүй юм байна гэдгийг тодорхой харуулсан. ЕХ дээрээс нь зөрчилдөөнд цэргийн

хүчээр хөндлөнгөөс оролцох чадамжгүй , хөндлөнгөөс оролцдог юм гэхэд зөвхөн НАТО-гийн цэргийн ангиудаар дамжуулан хөндлөнгөөс оролцох боломжтой гэдгийг харуулсан.

Энэ туршлагаас суралцаж ЕХ-ны гишүүн орнуудын төр, засгийн тэргүүнүүд 1999 оны 6-р сард хуралдсан зөвлөлийн хуралдаанаас ЕХ-г олон улсын хямралын менежментэд оролцох чадамжтай болгох тухай шийдвэр гаргасан юм. Гишүүн орнууд энд шаардагдах бүтэц, иргэний болон цэргийн чадамжийг бүрдүүлэх үүрэг хүлээсэн. 1999 оны 5-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон Амстердамын гэрээгээр Европын Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын (ЕАББХБ) үүрэг даалгаврын хүрээг “Петерсбургийн даалгавар” нэртэйгээр тогтоож өгсөн юм. Уг даалгавар ёсоор ЕХ, Европын аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогын (ЕАББХБ) хүрээнд хүмүүнлэгийн үүрэг, аврах ажиллагаа, энхийг тогтоох арга хэмжээ, хямралыг даван туулахын тулд явуулах байлдааны ажиллагааг багтаасан. АНУ-аас ялгаатай нь ЕХ зөвхөн цэргийн хүчинд бус мөн “Soft power-зөөлөн хүчинд” тулгуурладаг.

Байнгын ажиллагаатай институц, бүтцүүдийг байгуулж цэргийн болон иргэний-цэргийн чадамжийг бүрдүүлэхийн тулд чадамжийн жагсаалт нэртэй жагсаалт баталснаар 2000-2003 оны хооронд цэргийн, эсвэл иргэний-цэргийн ажиллагаа явуулах үндсэн нөхцөлүүдийг бүрдүүлж чадсан.

2003 онд ЕХ-ны гишүүн орнууд ЕАББХБ-ын салбарт оператив үйл ажиллагаа явуулах чадамжтай гэдгээ илэрхийлсэн.

Энэ цагаас хойш ЕХ нь гишүүн орнуудын бэлтгэгдсэн цэргийн болон цагдаагийн хүчийг хямралтай бүс нутгуудад илгээх боломжтой болсон. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд ЕАББХБ-ын²¹ хүрээнд 30 гаруй, зарим нь цогц ажиллагаа явуулсан. Өдгөө гишүүн орнуудын 4000 аюулгүй байдлын мэргэжилтнүүд ба цэргүүд ЕХ-ны нэрийн өмнөөс 6 цэргийн, 10 иргэний ажиллагаанд оролцож байна. ЕХ-ны

Хөгжил (ЕАББХБ)

*Дэлгэрүүлэн унших:
ФЭС-ийн гадаад,
аюулгүй байдлын
бодлогын салбарт
явуулж буй ажлын
мэдээллийг [www.fes.de/
internationale-politik-
analyse/aussen-und-
sicherheitspolitik](http://www.fes.de/internationale-politikanalyse/aussen-und-sicherheitspolitik)*

*Олон талт
ажиллагаа*

21 Европын аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлого (ЕАББХБ) нь 2007 оны Лиссабоны гэрээнээс хойш Аюулгүй байдал, батлан хамгаалахын нэгдсэн бодлого (АББХНБ) нэртэй болсон.

аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогын идэвх санаачилгын газарзүйн фокус нь африк тив дээр чиглэж байна.

Энд гишүүн орнууд ЕАББХБ-ын хүрээнд Мали, Нигер, Ливи, Сомали, газрын дундад тэнгис, африкийн эвэр зэрэг газарт нэн ялангуяа аюулгүй байдлын бүтэц байгуулах, цагдаа, цэрэг, хуулийн аюулгүй байдлын хүчнийг сургах замаар энх тайван, аюулгүй байдлыг хангахын төлөө ажиллаж байна. Европ тивд ЕАББХБ-ын ажиллагаа Босни-Герцеговина, Косово, Гүрж, Украйнд явагдаж байна. Энэ бүх ажиллагаанд ЕХ амжилтын нууц нь ЕХ-ноос бусад оролцогчид дипломат, эдийн засаг, хөгжлийн бодлогын хэрэгслүүдийг аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогын чадамжуудтай холбох, хямралыг энэ арга барилаар өргөн хүрээнд боловсруулж чадахгүй байгаад оршиж байгаа юм. Төрөл бүрийн арга хэрэгслүүдийг ийнхүү хослуулан хэрэглэж байгаагаараа ЕХ олон улс орнуудад үлгэр жишээ үзүүлж аюулгүй байдал, хангалуун амьдралд итгэх итгэл төрүүлж байна.

*Энх тайванд
учирч буй аюул*

Европ бол энх тайвны гүрэн гэдэг энэ алсын хараанд сүүлийн жилүүдэд аюул нэмэгдсээр байна. ЕХ ба түүний гишүүн орнуудын хилийн дээсний ойр орчимд олон тооны хямрал, зөрчилдөөн гарлаа. Хямралын хүрээ Украйнаас Хойд Африк, Сахалийн бүсээс Африкийн эвэр, Африкийн эврээс Ойрхи дорнод, Дундад Дорнодыг хамарч байна. Мөн баруун Балканд байдал хурцдаж байна. Төрийн бүтэц нь сул, хээл хахуульд автсан, террорист, дарангуйлагч дэглэмүүд, эдийн засгийн хэтийн төлөв нь муу, угсаатны зүйн эсвэл шашны сэдэлтэй маргаан тэмцэл хүмүүсийг хөөн зайлуулах эсвэл цагаачлахаас өөр аргагүй байдалд хүргэж байна. Олон тооны зөрчилдөөн ийнхүү хурцдаж байгаад Европ ч буруутай.

*Хэлбийсэн
харьцаа:
Чадавхижуулах
хэрэгслүүд*

Хэдийгээр улсүндэсний төр олон тооны, дийлэнх нь цогц хямралуудыг урт хугацаанд дангаараа сөрөх боломжгүй ч гишүүн орнууд өөдрийг хүртэл үндэсний тусгаар тогтнолтойгоо зууралдсаар байна. Өнөөг хүртэл зөвхөн ЕХ-ны гишүүн 28 орон бүгдээрээ бодлогын зорилтууд ба хэрэгслүүдийн сонголт дээр санал нэгдсэн нөхцөлд л гадаад бодлогын чадамжтай болдог хэвээрээ байна. Үүний үр дагаварт ЕХ хямралд ихэнхдээ хожимдсон хариу үйлдэл хийж, зөвхөн ховор тохиолдолд л сөрж чаддаг. Энэ байдал нь ялангуяа аюулгүй байдал,

батлан хамгаалах бодлогын салбарт онцгой сөрөг үр дүнд хүргэж, ЕХ-ны гишүүн орнууд АНУ-тай харьцуулахад хоёр дахин ба түүнээс их хэмжээний мөнгө зарцуулсан хэр нь Вашингтоны чадамжийн зөвхөн аравны нэгийг бүрдүүлж чаддаг.

2016 оны зун ЕХ-ны гишүүн орнууд энэ нөхцөл байдалд дүгнэлт хийсэн. Энэ цагаас хойш ЕАБХБ гайхалтай хурдацтай хөгжсөн. ЕХ-ны гишүүн орнууд цэргийн төлөвлөлт, удирдлагын штаб байгуулах, батлан хамгаалахын зохицуулалттай хяналт нэвтрүүлэх дээр санал нэгдсэн. 2017 оны эцэс хүртэл байнгын, тодорхой бүтэц бүхий хамтын ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулснаар сонгогдсон орнуудыг европын холбоонд нэгтгэх үйл явц хурдацтай урагшлах боломж бүрдүүлэх юм.

Гишүүн орнуудын зэрэгцээ европын комисс батлан хамгаалахын бодлогын талбар дээр идэвхтэй ажиллаж байна. Европын комисс нь европын батлан хамгаалахын сангаар дамжуулан нэгдсэн судалгаа, стратегийн чадамжийн хөгжилд дэмжлэг үзүүлэхийг хүсэж байна. Нэгдлийн бодлогод шинэ далайц авчрахын тулд нэн ялангуяа дараах гурван өөрчлөлт шийдвэрлэх үүрэгтэй. Эдгээр нь:

Нэгд популист урсгалууд ба улс төрийн намууд хүчээ авч байгаа нь ЕХ гагцхүү иргэдээ “хамгаалж” байж л цаашид оршин тогтнож чадна гэдгийг тодорхой харуулж байна. “Хамгаалал”-ыг европын ойрын хөрш орнуудад өсөн нэмэгдэж буй хямрал, зөрчилдөөн ба зарим гишүүн орнуудад болж буй террорист халдлагатай холбон авч үзвэл урт хугацаанд зөвхөн эдийн засаг, нийгмийн сэдвүүдээр хязгаарлах боломжгүй гэдэг нь тодорхой боллоо. Үүнээс илүүтэйгээр аюулгүй байдал, батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байна. Аюулгүй байдал, батлан хамгаалахын салбарт илүү ихийг хийх шаардлагатай байгааг харуулсан хоёрдох шийдвэрлэх түлхэлт бол Их Британийн Нэгдсэн вант улсын европын холбоог орхих шийдвэр юм. Британийн энэ шийдвэр гишүүн орнуудад хамтарсан ажиллагааг илүү эрхэмлэ гэдэг дарамтыг нэмэгдүүллээ.

Гэвч Лондон ЕАБХБ-ын цаашдын хөгжилд чухал шийдвэрүүдэд

2016 оноос
хойших эрчимтэй
хөгжил

Дэлгэрүүлэн унших:
Сурах бичгийн 4-р
дэвтэр, Европ ба
нийгмийн ардчилал
Гадаад бодлогын дүр
төрхөө бэхжүүлэх

Анна Мариа Келлнер,
Үбэ Оптенхоегэл,
Ханс-Петер Бартелс
нарын эрхлэн
гаргасан 12017
онд нийтлэгдсэн
Стратегийн бие
даасан байдал ба
Европын батлан
хамгаалал, Европын
армитай болох
замд? Ж.Х.В. Диец
хэвлэлийн газар, Бонн
хот

байнга хаалт тавьдаг байсан тул эндээс үйл ажиллагааны шинэ хувилбарууд гарч ирж байна.

АНУ-ын 45 дах ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсон нь аюулгүй байдал, батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагааг улам бэхжүүлэхэд тааламжтай нөхцөл бүрдүүлсэн. Бүр сонгуулийн кампанит ажлын үеэрээ тэр ирээдүйд европчууд ямар ч болзол нөхцөлгүйгээр АНУ-ын хамгаалалд найдаж суухаа болих хэрэгтэй гэдэг санааг цухалзуулж эхэлсэн.

*Шинэчлэлийн
зорилтууд*

Хөгжлийн эдгээр хандлагууд европчуудын өөрсдийгөө толины тусгалд буюу бусдын нүдээр харах үйл явцыг түргэсгэж, 2016 оны өвөл ЕАБХБ-ын өргөн хүрээтэй шинэчлэлийн зорилтууд батлах чиглэл рүү хандуулсан. Батлан хамгаалахын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, иргэний болон цэргийн чадамжийг бүрдүүлэхдээ эрэмбэ тогтоох, чадамж бүрдүүлэх, нийлүүлэхэд илүү ойр хамтран ажиллах шийдвэр гарсан. Ингэснээр зардлыг бууруулж, ЕХ-ны оператив салбарт үйл ажиллагаа явуулах чадамж дээшлэх юм. Өндөр шаардлага бүхий цэргийн шалгуур үзүүлэлтүүдийг хангадаг, хамгийн өндөр шаардлагатай ажиллагаануудын үед харилцан илүү хариуцлагатай үүрэг хүлээхэд бэлэн ЕХ-ны гишүүн орнууд ирээдүйд энэ боломжоор хангагдах ёстой.

*Европын батлан
хамгаалахын үйл
ажиллагааны
төлөвлөгөө*

Үүнээс гадна Европын Комисс-(ЕК) 2016 оны 11-р сард Европын Батлан хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулсан. Уг төлөвлөгөөнд Европын Батлан хамгаалахын сан (ЕБХС) байгуулахаар заасан, уг сангаас олон гишүүн орнуудын хамтран хөгжүүлж бүрдүүлсэн цэргийн чадамжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх болно.

*Чухал: нэг
талыг барьсан
байр суурийг
зөвшөөрөхгүй.*

Үүнээс хойш болж өнгөрсөн үйл явдлууд өндөр сэтгэгдэл төрүүлсэн. ЕХ-ны гишүүн орнууд аюулгүй байдал, гадаад бодлогод нэгэн шинэ үеийг эхлүүлсэн мэт харагдаж байна. Бодлогын энэ талбарын нэгдлийг эргэлт буцалтгүй болгохын тулд үндсэн нөхцөлүүд ба тодорхой төслүүдээс гадна стратегийн асуудлуудыг аль болох түргэн хугацаанд тодорхой болгох ёстой. ЕХ иргэдээ хэрхэн хамгаалах вэ? Ямар чадамжуудын тусламжтайгаар? ЕХ ба түүний

гишүүн орнууд европын арми байгуулах зорилтоосоо ухрахгүй байх ёстой. Цэргийн чадамжуудаа бүрдүүлэх тал дээр төвлөрсөн өнөөгийн фокусаа хэрэгжүүлж, цэргийн чадамж бүрдүүлэхдээ “Энх тайвны гүрэн ЕХ”-ны суурь нь юу билээ? гэдгийг анхаарлын гадна орхиж болохгүй. Суурь нь гадаад, аюулгүй байдлын бодлогын бүх талбарууд ба хэрэгслүүдийн хамтарсан тоглолт юм.

5.6. Африкийн холбоо-АХ

Зохиогч Томас Хартманн²²

Африкийн холбоо нь 55 гишүүн оронтой, гишүүн орнууд нь нийтдээ нэг тэрбум гаруй хүн амтай. Тус холбоо нь дэлхийн хамгийн том бүс нутгийн байгууллага бөгөөд орлогын харьцаа, засгийн газрын систем, хүн амын тоо, газарзүйн нөхцөл байдал талаас нь харвал хамгийн олон янзын бүтэц, бүрэлдэхүүнтэй орнууд багтдаг. АХ-г НҮБ-ын хартын VIII-р бүлгийн агуулгаар бүс нутгийн байгууллага хэмээн хүлээн зөвшөөрсөн.

Гишүүдийн энгийн олонхын зөвшөөрлөөр африкийн орон бүр АХ-ны гишүүн болох боломжтой. АХ нь супра-үндэсний буюу олон улсын холбоо биш. Энэ нь гишүүн орнууд нь өнөөг хүртэл үндэсний тусгаар тогтнолын эрхүүдээ АХ-нд шилжүүлээгүй гэсэн үг.

АХ нь колоницлолыг нураахад том амжилт гаргасан Африкийн Нэгдмэл байдлын байгууллагаас (АНББ-Organisation of African Unity) эхтэй. Гэсэн хэдий ч Африкийн нэгдмэл байдлын байгууллагад дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох тухай зарчим хамгийн өндөр ач холбогдолтой байсан юм. Ийм учраас 1994 онд Руандад болсон аймаглан устгах аймшигт гэмт хэргийн үед АНББ үйл ажиллагааны ямар ч чадамжгүй байсан юм. 2002 онд Африкийн Холбоог байгуулснаар шийдвэрлэх хувьсал гарсан юм. “From non-intervention to non-indifference- хөндлөнгөөс үл оролцох зарчмаас яаж ч байсан хамаагүй биш” гэдэг зарчимд шилжсэн. Өдгөө хөндлөнгийн оролцооны механизм АХ-ны өөрийн ойлголтын нэгэн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болжээ.

“Хөндлөнгөөс үл оролцох зарчмаас яаж ч байсан хамаагүй биш” гэдэг зарчим руу

22. Елизабет Брауне, Флориан Кох нарын текст болон хамтын ажиллагаа дээр суурилан бичив.

Африкийн энх тайван аюулгүй байдлын архитектурын бүтэц (АЭТАБАБ)

Африкийн нэгдмэл байдлын байгууллагыг (АНББ)-ыг АХ болгон хувиргаснаар 2002 онд өмнөд африкийн Дурбан хотноо хуралдсан АХ-ны гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нарын анхдугаар ээлжит их хурлаас энх тайван, аюулгүйн зөвлөл байгуулах тухай протокол баталсан. Энэхүү протокол нь 2004 оны 1-р сард хүчин төгөлдөр болсон бөгөөд үүнээс хойш АХ-ны гишүүн орнуудын дийлэнх нь энгийн олонхын саналаар уг протоколыг соёрхон батлаад байна.

Энэ протокол ёсоор АХ-г африкийн энх тайван, аюулгүй байдлын архитектурын бүтэцтэй болгож, уг бүтцэд Африкийн бүс нутгийн эдийн засгийн нэгдэл (англиар RECs) мөн хамаардаг.

АХ-ны энх тайван, аюулгүйн зөвлөл

АЭТАЗ-ийн эргэлтийн ба зангилгааны цэг нь Энх тайван, аюулгүйн зөвлөл (Peace and Security Council) бөгөөд тус зөвлөл 2004 оны 5-р сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тус зөвлөл нь этиопын Аддис Абеба хотноо АХ-ны төв байранд байрладаг. Тус зөвлөл нь улс төрийн шинэ сонгуульт байгууллага тул африк тивийн энх тайвныг тогтоох арга хэмжээг зохицуулах үүрэг ногдуулсан. Тус зөвлөлийн бүтцийг НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн бүтэцтэй төстэй хэлбэрээр бүрдүүлсэн, гэхдээ шийдвэрээ зөвшилцлийн зарчмаар гаргадаг, чухал асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй нөхцөлд гуравны хоёрын саналаар шийдвэрээ гаргадаг.

Зөвлөл 15 гишүүдээс бүрддэг. Бүс нутгийн хуваарилалт ба ээлжлэн солигдох зарчмыг баталгаажуулахын тулд арван гишүүн нь хоёр жилийн хугацаагаар, таван гишүүн нь гурван жилийн хугацаагаар тус тус сонгогддог. Зөвлөл байнгын төлөөлөгчдийн түвшинд сард хоёр удаа, сайд нарын эсвэл төр, засгийн газрын тэргүүн нарын түвшинд жилд нэг удаа цуглардаг.

Энх тайван, аюулгүйн зөвлөлд 7-р зүйлийн дагуу дараах үүргийг гүйцэтгэх мандат олгосон байдаг. Үүнд:

- Хүч хэрэглэсэн маргаан тэмцэл, зөрчилдөөн, аймаглан устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг өдүүлж болзошгүй бодлогыг эрт

*Энх тайван,
аюулгүйн зөвлөл*

Зөвлөлийн үүрэг

таньж илрүүлэх, гаргуулахгүй байх

- Зөрчилдөөн үүссэн газарт энх тайвныг тогтоох, энх тайвныг дэлгэрүүлэх, энх тайвныг дэмжих ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Үүсгэн байгуулах тухай гэрээний 4-р зүйлийн агуулгаар хүнд нөхцөл байдал үүссэн нөхцөлд аль нэг гишүүн оронд хөндлөнгөөс оролцох ажиллагааны тухай хуралдаанд зөвлөмж хүргүүлэх
- Зэвсэгт зөрчилдөөний үед, эсвэл байгалийн ноцтой гамшиг тохиосон үед хүмүүнлэгийн ажиллагааг дэмжих, туслах

Зөвлөлийн үйл ажиллагааг 5 байгууллага дэмждэг. АХ-ны комисс, Цэцдийн зөвлөл, эх газрын эрт сануулах систем, африкийн довтлох анги, АХ-ны энх тайвны фонд (AU Peace Fund),

Таван байгууллага

Африкийн тусгай анги

Африкийн тусгай анги (African Standby Force /ASF) нь африкийн таван бүс нутгийн 5 бригадаас бүрддэг. Эдгээр нь: Өмнөд, Баруун, Зүүн, Төв, Хойд африк. Бүс нутаг бүрийн анги нэгтгэл 6.500 хүртэл тооны цэрэг, цагдаа, иргэний хүмүүсээс бүрдсэн байх ёстой бөгөөд анги нэгтгэл тус бүр 14-30 өдрийн ажиллагаанд оролцоход бэлэн байх ёстой. Африкийн тусгай ангиас гадна африкийн энх тайван, аюулгүй байдлын архитектурын хүрээнд өргөтгөсөн утгаар зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, зөрчилдөөнийг даван туулах, зөрчилдөөнийг шийдвэрлэх цэргийн хороо ба бүс нутгийн механизмыг (БНМ) нэмэлт бүрэлдэхүүн хэсэг болгон байгуулсан байдаг. Цэргийн хороонд цэрэг, аюулгүй байдлын бүх асуудлаар зөвлөлд зөвлөх, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий гишүүн орнуудын энх тайван, аюулгүй байдлын зөвлөлийн өндөр түвшний цэргийн офицерууд багтдаг.

Эх газрын эрт сануулах систем

АХ-ны энх тайван, аюулгүй байдлын протокол ёсоор АХ-нд мөн эх газрын эрт сануулах систем байгуулсан. Уг систем дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрддэг. Эдгээр нь:

- АХ-ны удирдлага дор ажиглалт-хяналтын систем “нөхцөл байдлын өрөө-Situation room” нэрээр танигдсан төвийг байгуулсан.

- Бүс нутгийн механизмын ажиглалт, хяналтын нэгжүүд нь харилцааны зохистой хэрэгслүүдээр нөхцөл байдлын өрөөтэй шууд холбогдсон байдаг. Эдгээр нэгжүүд нь бүс нутгийн түвшинд мэдээллийг цуглуулж боловсруулаад нөхцөл байдлын өрөө рүү илгээж байдаг.

Цэцдийн зөвлөл

Цэцдийн зөвлөл нь африкийн аюулгүй байдлын архитектурын бүтцийн энх тайвныг дэмжих бас нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм. Тус зөвлөл энх тайван, аюулгүй байдлын зөвлөл, комиссын даргад, нэн ялангуяа африк тивд энх тайван, аюулгүй байдлыг дэмжих, хадгалахтай холбоотой бүх асуудлаар зөвлөдөг.

Комиссын дарга ба бусад сонгуульт байгууллагууд

Энд АХ-ы комиссын дарга өндөр ач холбогдолтой. Комиссын дарга түүний бодлоор аль нэг гишүүн орны энх тайван, аюулгүй байдалд заналхийлж болзошгүй гэж үзсэн бүх асуудалд энх тайван, аюулгүйн зөвлөлийн анхаарлыг хандуулдаг. Үүнээс гадна тэрээр өөрөө зуучлагч хийх замаар зөрчилдөөнд хүргэхгүй байх, даван туулах, шийдвэрлэх боломжтой гэж үзсэн бүх асуудлаар идэвх санаачилга гарган ажиллах боломжтой.

2004 оноос хойш:

*Пан-африкийн
парламент*

АХ-ны энх тайван, аюулгүй байдлын бүтцүүдийн ажлыг цогц болгохын тулд 2004 оны 3-р сард өмнөд африкийн Ёоханнесбург хотноо төвтэй пан-африкийн парламентыг байгуулсан. АХ цаагуураа иргэний нийгмийн байр суурь, санаа оноог холбооны үйл ажиллагаанд тусгах зорилгоор эдийн засаг, нийгэм, соёлын зөвлөл байгуулсан. Энэхүү зөвлөл африк тив дээр гарсан зөрчилдөөнийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоотойгоор даван туулах, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хүйсийн тэгш байдлыг хангах тайлбар баталсан. Дээрээс нь 2004 онд хүний эрх ба ард түмнүүдийн эрхийн дээд шүүх байгуулсан. Тус шүүх гишүүн орнуудын санал болгосон 11 шүүгчдээс бүрддэг.

АХ-ны энх тайвны фонд

Энх тайвны фондоос энх тайван, аюулгүй байдлын ажиллагаа болон бусад оператив үйл ажиллагааны санхүүжилтийг гаргадаг. Эдгээр

*Санхүүжилтийн
дийлэнх хэсгийг ЕХ
хариуцдаг*

фондод АХ-ны гишүүн орнуудын гишүүнчлэлийн хураамжийн нэгэн хэсэг, гишүүн орнуудын сайн дурын шимтгэл, бусад эх үүсвэрээс өгдөг мөнгө, жишээ нь: хувийн сектор, иргэний нийгэм, хувь хүмүүсээс өгдөг мөнгө багтдаг. Эдгээрээс хол давсан санхүүжилтийг олон улсын хамтын нийгэмлэг, нэн ялангуяа ЕХ ба түүний гишүүн орнууд олгодог.

АЭТАБАБ-ийг шинэчлэх хэлэлцүүлгүүд ба тулгамдаж буй зорилтууд

АХ-ны тогтвортой санхүүжилтийн баталгааг хангах нь шинэчлэлийн хамгийн чухал зорилт. Өдгөө АХ-ны санхүүжилтийн 74% нь донор байгууллагуудаас, оператив төсвийн тэр ч байтугай 94% нь гаднын санхүүжилттэй байна. Тэр хэмжээгээрээ АХ хараат бус байдал, үйл ажиллагааны чадамжийн хувьд хязгаарлагдмал байна. Ингэснээр тусгай анги, жишээлбэл НҮБ мандатаа олгосон байлаа ч ЕХ зардлыг нь даасан нөхцөлд л ажиллагаанд оролцох боломжтой болдог. ЕХ дээрээс нь АЭТАБАБ-ийн санхүүжилтийн томоохон хувийг санхүүжүүлдэг. ЕХ 2016 онд санхүүжүүлэх үүргээ ирээдүйд ч биелүүлсээр байх болно, гэхдээ санхүүжилтийн өнөөгийн загвараар урт хугацаанд явах боломжгүй гэдгээ илэрхийлсэн.

АЭТАБАБ-д бусад сорилтууд ч тулгараад байна. ЕХ, жишээлбэл АЭТАБАБ нь африкийн тусгай анги зэрэг оператив механизмуудаа өнөөг хүртэл сүүлийн үед гарсан хямралын ажиллагаанд огт оролцуулаагүй хэр нь дээрээс нь шинээр хэлбэржсэн буюу байгууллагын бүтэц бүхий Олон үндэстний хамтарсан тусгай анги-Multinational Joint Task Force (MNJTF) эсвэл Сахел 5 зэрэг зөрчилдөөн шийдвэрлэх шинэ механизмуудыг бий болгосоор байна хэмээн шүүмжилсэн. АХ-ны гишүүн орнуудын дунд тодорхой тохиолдолд Африкийн тусгай анги хэзээ нэгэн цагт өөрийн оронд/ эсвэл өөрийн орны эсрэг ажиллагаанд оролцох шаардлага гарч болзошгүй гэдэг эргэлзээ байдаг нь илт байна. ЕХ энэ хөгжилтэй холбоотойгоор АЭТАБАБ-ийг ийм их хэмжээний санхүүжилтийг цаашид ч олгосоор алсдаа ач холбогдолтой юу? гэдэг асуултыг тавьж байна. Учир нь африкийн орнууд зөрчилдөөн шийдвэрлэх шинэ механизмуудыг бий болговол санхүүжилт олгох уу? гэдэг асуултыг ЕХ-нд тавьсаар байгаа юм.

*Тусгай анги:
өнөөг хүртэл
ажиллагаанд
оролцоогүй*

Үүний зэрэгцээ АЭТАБАБ-ийг байгуулсан цагаас хойш африкт заналхийллийн нөхцөл байдал үндсээрээ өөрчлөгдсөн. АЭТАБАБ буюу африкийн тусгай ангийг улс орнууд хоорондын цэргийн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд зориулан байгуулсан тул терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, далайн дээрэм зэрэг шинэ хэлбэрийн заналхийллийн эсрэг өөр үзэл баримтлал, зөрчилдөөн шийдвэрлэх механизмууд шаардлагатай байна.

Социал-демократ хэтийн төлөв

Африкийн Энх тайван, аюулгүй байдлын архитектурын бүтцийн санхүүжилт ба хангамжийн асуудал африк тивийн энх тайван, аюулгүй байдалд заналхийлж буй заналхийлэл болон европ-африкийн харилцаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч АЭТАБАБ-тэй холбоотой олон асуудал нээлттэй хэвээр байна. Ингэснээр африк тивийн санхүүгийн хараат байдал АЭТАБАБ-ийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаснаар хэр хэмжээнд буурах юм бэ? гэдэг асуултад АХ ба бүс нутгийн нутгийн эдийн засгийн нэгдлүүд хоорондын харилцааны байгууллагын аль нь ч сэтгэлд хүрэх хариулт өгч чадахгүй байна.

Зарчмын хувьд африкийн орнуудын сайн засаглал ба ардчилсан хөгжлийн тухай улс төрийн нээлттэй яриа хэлэлцээ хийхгүйгээр урт хугацаанд энх тайван ба хөгжлийг хангах боломжгүй юм. АХ-г үүсгэн байгуулснаар гишүүн орнуудын улс төрийн нягт хамтын ажиллагаа, африк тивийн энх тайван, аюулгүй байдалд заналхийлж буй заналхийллийн өмнө хүлээх хамтын хариуцлага дээшилсэн. Олон улсын тавцан дээр АХ-г африкийн ашиг сонирхлын төлөөлөл хэмээн үзэх байдал нь улам нэмэгдсээр байна.

Дэлгэрүүлэн унших:

Флориан Кох,

Елизавет Брауне

/2017 он/ Африкийн

холбоо ба африк-

европын харилцаа,

Сэдвийн тайлан,

Фридрих-Эбертийн

сан /эрхлэн гаргагч/,

Берлин хот

Фридрих-Эбертийн

сан, эрхлэн гаргагч

/2011 он/, Хүчин

мөхөштөөд байна

уу? эсвэл хэтрүүлэн

үнэлээд байна уу? 2011

оны 2-р сарын 9,-11-нд

хуралдсан Африкийн

аюулгүй байдлын

хэтийн төлөв ба

европын дэмжлэг

сэдэвт олон улсын

хурлын баримт бичиг,

Берлин хот

6. УЛС ТӨРИЙН НАМУУДЫН БОДЛОГО ХӨТӨЛБӨРТӨӨ ДЭВШҮҮЛСЭН БАЙР СУУРЬ

Зохиогч Ёохан Даам

Энэ бүлэгт улс төрийн намууд бодлого хөтөлбөртөө энх тайван, аюулгүй байдлын бодлогын ямар байр суурь баримталж байгааг авч үзэх болно. Өөрөөр хэлбэл Бундестагт суудалтай намуудын мөрийн хөтөлбөрийг хооронд нь харьцуулах болно.

Намын мөрийн хөтөлбөр нь сонгуулийн хөтөлбөрүүд, намын сонгуульт байгууллагуудын тогтоолууд, эсвэл хувь хүмүүсийн илэрхийлсэн үзэл бодлоос ялгаатай нь бодлогын илүү урт хугацааны чиг баримжааг илэрхийлж байдаг. Улс төрийн намууд мөрийн хөтөлбөртөө намын үзэл баримтлал, нийгмийг яаж харж байгаагаа, улс төрийг юу гэж ойлгодог, юуг өөрчлөхийг хүсэж байгаагаа тайлбарласан байдаг.

Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрүүдийг дараах цэгүүдээр харьцуулна:

- Тухайн намын энх тайван, аюулгүй байдлын бодлогын ойлголт ямар үндсэн үзэл санаагаар тодорхойлогдож байна вэ? Уг ойлголт нь энэ номд тодорхойлсон онолын шийдлүүд ба загваруудын алинд нь илүү нийцэж байна вэ?
- Энх тайван, аюулгүй байдлын ямар ойлголтуудыг тухайн нам суурь болгон авсан бэ?
- Тухайн нам нь НҮБ, НАТО болон ЕАБХАБ (Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага) зэрэг олон талын бүтэцтэй байгууллагуудын талаар ямар байр суурь баримталдаг вэ?
- Тухайн нам Холбооны армийг гадаадад энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах болон иргэний ажиллагаа, хэрэгслүүдээр энх тайвныг дэмжих талаар ямар байр суурь баримталдаг вэ?
- Зэвсэглэлээр хөөцөлдөх, зэвсэг хураах талаар ямар байр суурь баримталдаг вэ?

Хөтөлбөрүүдийг харьцуулах явцад намуудын байр суурь олон үзүүлэлтүүд дээр нэгддэг ч тодорхой ялгаа ч харагдаж байна. Чухал ялгаануудыг богино дүгнэлт хэлбэрээр танилцуулах болно.



Хөтөлбөрийн харьцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор авна уу:

► www.fes-soziale-demokratie.de/lesebuecher/mehrlesen.html

Загвар болон онолын нөлөө

Энэ номд мөрийн хөтөлбөрийг нь танилцуулсан намуудаас цэргийн гүрний²³ загварыг дэмжсэн нэг ч нам байхгүй байна. Германы Социалдемократ Нам-ГСДН, Христосын ардчилсан холбоо нам-ХАХН, Чөлөөт ардчилсан нам-ЧАН болон Ногоон намынхан-НН иргэний гүрний загварыг дэмжигч нам гэдэг нь тодорхой харагдаж байна. Ялангуяа ГСДН, НН дайныг эсэргүүцэгч үзэл, хүч үл хэрэглэх уламжлалд ойр байдаг нам гэдгээ онцлон тэмдэглэсэн байна. Зүүний нам дайныг эрс эсэргүүцэгч нам гэдгээ илүү хурцаар илэрхийлсэн байна. Германы төлөөх өөр сонголт нам-ГТӨСН мөрийн хөтөлбөртөө энх тайван, аюулгүй байдлын бодлогын асуудлуудыг маш товч дурдаад орхисон тул аль нэг бүлэгт хамруулах боломжгүй байна. Харьцуулалтад оруулсан намуудаас зөвхөн тус нам зэвсэглэлээр хөөцөлдөхийг уриалсан нам бөгөөд алсдаа цэргийн гүрний загварыг дэмжих хандлагатай.

ГСДН, НН, ЗН-ын мөрийн хөтөлбөрт Кантын идеалист санаануудаас эхтэй санаанууд давамгайлдаг бол бусад намууд түүхий эдийн баталгаат байдал зэрэг үндэсний ашиг сонирхлыг чухалчилсан байна.

Энх тайван-аюулгүй байдлын ойлголт

ГСДН, НН, ЗН эерэг энх тайвны ойлголтыг тодорхойлдог. ЧАН-ын мөрийн хөтөлбөр ч мөн энэ чиглэл рүү ханддаг. ХАХН, ГТӨСН-ын хувьд энэ асуулт нээлттэй хэвээр байна.

Аюулгүй байдлын ойлголтын нэг талд ГСДН, НН, ЗН,гөө талд ХАХН

23 2.4-р бүлгийг үзнэ үү. Өөр өөр загварууд: фацифизм, иргэний болон цэргийн хүч.

болон ЧАН хооронд тодорхой ялгаа харагддаг. Зүүний чиглэлийн намууд “коллектив эсвэл харилцан” аюулгүй байдал өөрөөр хэлбэл эсрэг талын аюулгүй байдал энх тайванд суурь ач холбогдолтой гэж үздэг. Харин нөгөө талын намууд “сүлжээгээр аюулгүй байдлаа хангах” тухай ярьдаг. Энэ ойлголтыг энэ номын 2.3-р бүлэгт тайлбарласан бөгөөд сүүлийн жилүүдэд ихээхэн маргаантай байгаа.

ЧАН нь ЕАБХАБ-ын дэвшүүлсэн шийдэл болох хамтын аюулгүй байдлын загварыг сайшаасан байна. Хамтын аюулгүй байдлын тухай ойлголт коллектив аюулгүй байдлаас өөр ойлголт гэж хэлж болох юм. ГТӨСН аюулгүй байдлын ямар нэгэн ойлголт нэрлээгүй байна.

НҮБ, НАТО, ЕАБХАБ

Бүх намууд нэгдсэн үндэстний байгууллагад эерэг хандлагатай байна; харин нарийвчлан авч үзвэл, НҮБ-ийн шинэчлэлийн бодлого болон түүний үндэслэл дээр өөр өөр байр суурьтай байдаг. ХАХН ЕАБХАБ-ын талаар мөрийн хөтөлбөртөө нэг ч дурдаагүй бол бусад намууд уг байгууллагыг бэхжүүлэх, өргөжүүлэхийг хүсдэг. Энд мөн адил шинэчлэлийн бодлогыг өөрийн хөтөлбөрт хэрхэн нарийвчлан тусгасан байдлаараа ялгаатай байна.

НАТО-г намууд харилцан адилгүй үнэлдэг. ЗН НАТО-г татан буулгаад Оросын оролцоотой өөр нэг системээр солихыг хүсдэг. ХАХН, ЧАН, ГТӨСН НАТО-г өндрөөр үнэлсэн бол ГСДН, НН ач холбогдолтой эвсэл хэмээн онцлон тэмдэглэсэн байна. ГСДН, НН НАТО-гийн шинэчлэл тус эвслийн цэргийн бус багануудыг бэхжүүлэх зорилтод чиглэгдэх ёстой хэмээн үзсэн.

Холбооны армийн цэргийн ажиллагаа болон иргэний арга хэрэгслүүдээр энх тайвныг дэмжих ажиллагаа

ГСДН, НН, ЗН холбооны армийг цэргийн ажиллагаанд оролцуулахад парламентын зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд НҮБ-ын мандат чухал ач холбогдолтой гэдгийг илэрхийлсэн бол ялангуяа ЧАН олон улсын эрх зүйн тодорхой үндэслэлүүд дээр суурилан байр сууриа илэрхийлжээ. ЗН зарчмын хувьд холбооны армийг цэргийн ажиллагаанд оролцуулахыг дэмжихгүй гэдгээ илэрхийлсэн. ХАХН

парламентын зөвшөөрөл, НҮБ-ын мандатын талаар байр сууриа илэрхийлээгүй байна. ГТӨСН парламентын зөвшөөрлийн талаар мөн байр сууриа илэрхийлээгүй. ГТӨСН мөрийн хөтөлбөртөө “германы аюулгүй байдлын ойрын ашиг сонирхол” хөндөгдөөгүй бол зөвхөн НҮБ мандатаа олгосон нөхцөлд германы зэвсэгт хүчин НАТО-гийн ажиллагаанд оролцох нь зүйтэй гэжээ.

ГСДН, НН, ЗН мөн ЧАН мөрийн хөтөлбөртөө иргэний арга хэрэгсэл, ажиллагаагаар энх тайвныг дэмжих салбарт тодорхой, сайтар боловсруулсан саналуудыг дэвшүүлжээ.

Зэвсэг хураах

ГСДН, НН, ЗН мөн ХАНХ, ЧАН мөрийн хөтөлбөртөө зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих талаар олон талт саналуудыг дэвшүүлсэн байна. Харьцуулалтад хамруулсан намууд дундаас зөвхөн ГТӨСН нь холбооны армийн зэвсэглэлийг нэмэгдүүлэх талаар санал дэвшүүлжээ.

7. ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ

Энэхүү бүлэгт:

- Атлантын далай дамнасан транс-атлантын харилцаа
- Арабын хавар
- Өөрийгөө хамгаалах хариуцлагын асуудал
- “Кибер дайн”-ны болзошгүй аюулын талаар хэлэлцэнэ.

Энэхүү бүлэгт сүүлийн жилүүдэд олонтоо хэлэлцүүлгийн сэдэв болоод байгаа энх тайван, аюулгүй байдлын бодлогын хэлэлцүүлэгт гурван сэдэв сонгон авлаа. Та эдгээр зохиогчидтой санал нэгтэй байна уу?

7.1. Атлантын далай дамнасан буюу транс-атлантын харилцаа

Зохиогч Карстен Д. Бойгт

газар тэнгэр шиг зөрүүтэй харагдаж байлаа. Реагены засгийн газар ГСДН ба Социалист Интернационалын үзэл баримтлалаас татгалздаг гэдгээ огт нуудаггүй байлаа.

Социалдемократууд түүхэн хөгжлийнхөө явцад америкийн тухай төсөөлөл, дүр төрхөө олон удаа өөрчилсөн. Үүнд гайхаад байх зүйл огт байхгүй. Учир нь АНУ-ын засгийн газрууд ч нэгэн адил ГСДН-ын хэрэгжүүлж ирсэн бодлогод олон арван жилийн туршид түр хугацаагаар эерэг, ихэнхдээ сөрөг байр суурийг баримталж байжээ.

1959 оны 2-р сарын 10-нд Билли Брандтыг Бродвэйн өргөн чөлөөнд Нью Йоркийнхан угтан авч мэндчилсэн масктай жагсаал ба түүнийг үл тоомсорлосон Реагены засаг захиргааны үйл ажиллагаа

Билли Брандт хувь хүний хувьд АНУ ба Социалдемократуудын харьцаанд үлгэр жишээ болж байлаа. Залуу социалист Билли Брандт өөрийн хичээл зүтгэлээр 1930-аад оны үед АНУ-ын ардчилсан социализмын хэрэгжилтийг хэмжих оролдлого хийж байжээ. Берлинд алба хашиж байх хугацаанд түүний хэтийн төлөв өөрчлөгдсөн байдаг. Түүний хэтийн төлөвийг германы ашиг сонирхол ба Берлиний засгийн эрхийг баригч хотын даргын хариуцлага улам бүр хүчтэй тодорхойлох болсон юм. Хүйтэн дайны үед түүнд АНУ-ын ХБНГУ ба Берлин, Европын баруун хэсгийн

аюулгүй байдалд хүлээх үүрэг АНУ-ын дотоод асуудал нийгэм, улс төрийг шүүмжлэхээс илүү чухал байлаа. Билли Брандт канцлерийн албанаас огцорсныхоо дараагаар Социалист Интернационалын ерөнхийлөгч ба Хойд-Өмнөдийн Комиссын даргын үүрэг гүйцэтгэж байх үедээ АНУ-ыг ахин дахин шүүмжилж байсан юм.

Билли Брандт 1983 онд Бонн хотноо болсон энх тайвны хөдөлгөөний цуглаан дээр дундын зайн тусгалын пуужин байрлуулахыг эсэргүүцэж үг хэлсэн тул түүнийг АНУ-д болон Германы консервативчууд түүнийг америкийн эсрэг үзэлтэн хэмээн буруутгаж байлаа. Тэр Берлин хотын засгийн эрхийг баригч хотын дарга байхдаа АНУ-тай харилцах харилцаа холбооны канцлер Аденауртай харьцуулахад тодорхой хугацаанд илүү ойр, найрсаг байсан мэт харагддаг.

Дээрх хоёр тохиолдолд тэр нэг ижил зүйлийн төлөө явсан байдаг. Германы ашиг сонирхлыг хэрэгжүүлэх, социал-демократ итгэл үнэмшлийг төлөөлөх. Энэ хоёр зорилго нь түүний болон түүнийг залгамжлагч канцлерууд, эсвэл намын дарга нарын АНУ-тай харилцах харилцааны чиглэлээ тодорхойлох гол хэмжүүр нь болж байлаа.

Билли Брандт амьдралынхаа сүүлийн жилүүдэд АНУ ба түүний бодлогын талаар олонтаа эерэг байр суурь илэрхийлсэн байдаг. Эдгээр нь түүний эцэг Бушийн засаг захиргааны явуулж байсан Вашингтоны бодлого ба Горбачёвын удирдлага дор Москвагийн явуулж байсан Зүүн, Барууны зөрчлийн бодлогоор зөвхөн германы хуваагдал бус, европын хуваагдлыг баруун европын бүтээлч улс төрчид ба зүүн европын коммунист намуудын дотор болон гадна байгаа ардчилсан шинэчлэгчдийн тусламжтайгаар нийтэд нь даван туулж чадна гэдэг найдварын нэгэн хэсэг нь байлаа.

Тэгэхлээр Брандтын АНУ-тай харьцах харьцаа социал-демократ үзэл баримтлалтай адил зөрчилтэй харьцаанд байжээ. Тэрээр нэг талд АНУ-ын ардчилал, эрх чөлөөг магтаж нөгөө талд америкийн капитализмын нөлөөг шүүмжилж байлаа. Харин АНУ-ыг шүүмжлэх нь илүү байсан он жилүүдэд Билли Брандт өөрийгөө барууны эрх чөлөөт, ардчилсан уламжлал, мөн АНУ-ын нэгэн хэсэг хэмээн үзэж байжээ.

Түүний энэ хэлбэршгүй байр суурь, хувь хүний хувьд туулсан амьдралын зам, хувь хүн нь өөрөө 19-р зуунд үүсгэн байгуулагдаж, Ваймарийн

Бүгд Найрамдах улсын үед туйлширсан барууны үзэлтнүүд ба коммунистуудын зүгээс америкийг дэмжигч хэмээн шүүмжлүүлж байсан ГСДН-ын уламжлалыг тээгч улс төрчийн хувьд төлөвшсөн юм. ГСДН-ыг үүсгэн байгуулагч эцгүүдийн нэг болох Вильгелм Лиевкнехт АНУ-ыг өөрийнхөө амьдарч байсан цаг үеийн дэлхийн хамгийн эрх чөлөөтэй орон гэж үздэг байсан бөгөөд түр хугацаанд америкт цагаачлах уу? үгүй юу? хэмээн бодож үзэж байсан гэдэг.

2008 онд Барак Обама АНУ-ын 44 дэх ерөнхийлөгчөөр сонгогдсон нь Германыг сэрээж, нэн ялангуяа социалдемократууд америкийн шинэ бодлого зарчмын хувьд өөрчлөгдөнө гэдэгт ихээхэн найдвар тавьж байлаа. Обамагийн ерөнхийлөгч болмогцоо авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ, жишээ нь: исламын ертөнцөд илгээсэн эерэг сигнал, тухайн үеийг хүртэл хэрэгжүүлж ирсэн америкийн гадаад бодлогын үзэл баримтлалыг эргэн харж, хянахад ерөнхийдөө бэлэн байдал нь, гадаадын түншүүдээ сонсох эрмэлзэл нь түүнийг ерөнхийлөгч болсны дараа Германд төрсөн итгэл үнэмшлийг улам бэхжүүлж байлаа.

Обамагаас хүлээх хүлээлт ийм их байсан тухайн үед нь түүнээс, эсвэл

АНУ-ын ирээдүйн ерөнхийлөгч нараас хүлээж буй хүлээлт бодит биш юм шүү гэдгийг Германд сануулах ёстой байсан юм. 2013 онд Эдуард Сноудений илчилсэн олон асуудлын гэрэлд нэг зүйл маш тодорхой болсон. Энэ нь АНУ-ын ерөнхийлөгч нэн түрүүнд америкийн ашиг сонирхлыг л төлөөлдөг, түүнд өөрийн сонгогчдыг алдахгүй байх нь л чухал. Обамагийн сонгууль найдвар төрүүлсэн бол Трампын сонгууль айдас төрүүлсэн.

Энэ бүхнийг үл харгалзан: ХБНГУ-ын хувьд найдаж болох транс-атлантын харилцаа нь гадаад, аюулгүй байдлын бодлогын анхаарлаа хандуулах үндсэн цэг нь юм. Ерөнхийлөгч Трампын бодлого үндсэн цэгүүд дээрээ социалдемократ төсөөллүүдтэй зөрчилдөж байлаа. Гэсэн хэдий ч АНУ нь ЕХ-ны гадуурх хамгийн чухал түнш хэвээрээ байх болно. Транс-атлантын түншүүдийн өмнө тулгарч буй дэлхий дахины сорилтуудыг нягт хамтын ажиллагаагүйгээр даван туулах боломжгүй юм. Энэ түншлэл эдгээр сорилтуудыг даван туулахын тулд түншлэлийг бүрдүүлэгч орнуудын улс төрийн соёлын бүтэц нь өөр өөр, дэлхийн бодлогод гүйцэтгэж буй үүрэг болон ашиг сонирхол нь зөрүүтэй шүү гэдгийг ойлгох нь чухал.

Дайны дараах германы улс төрчдийн шинэ үеийнхэн европын ашиг сонирхлыг германы ашиг сонирхол хэмээн тодорхойлдог, ХБНГУ-ын өөртөө тогтоосон гадаад бодлогын ухаалаг хязгаарлалтыг германы ашиг сонирхлыг хамгаалах нэгэн хэрэгсэл гэдгийг ойлгодог болсон юм. Газарзүйн байршлын хувьд Европ тивийн төвд оршдог, худалдаачин үндэстэн болох германчуудын хувьд хөрш орнуудтайгаа сайн харилцаатай байх, ЕХ байгуулагдсанаар бий болсон эдийн засаг, улс төрийн тогтвортой ерөнхий нөхцөлүүдийг хадгалах нь амжилтын үндэс юм. Герман улс дэлхийн хоёрдугаар дайны дараагаар Европ тивийн манлайлагч байх бүх идэвх чармайлтаасаа татгалзаж, хөрш орнууд болон холбоотон түншүүдтэйгээ нягт харилцаатай европын дундаж гүрний байр сууринд шилжсэн билээ. Германы үндсэн хуулийн 26-р зүйлийн 1-д түрэмгийлэх дайнд бэлтгэх нь үндсэн хуулийг зөрчиж буй хэрэг бөгөөд гэмт хэрэгт тооцно хэмээн тайлбарласан байдаг. 1990 оны 9-р сарын 12-нд батлагдсан Хоёр нэмэх дөрөв гэрээ, тус гэрээний 2-р зүйлд энэ байр суурь дээрээ хүч нэмж, нэгдсэн герман улс “Германы үндсэн хууль ба НҮБ-ын хартад нийцсэнээс бусад тохиолдолд өөрийн зэвсгийг хэзээ ч хэрэглэхгүй” хэмээн тайлбарласан.

Германы үнэлэмж дээр суурилсан, ашиг сонирхолд хөтлөгдсөн гадаад, аюулгүй байдлын бодлогын логик үр дагаварт нийцүүлэн Герхард Шройдерийн удирдлага дор улаан, ногооны эвсэл АНУ-ын ерөнхийлөгч хүү Бушийн санаачилсан Иракийн дайныг тодорхой бөгөөд ойлгомжтойгоор буруушаасан юм. Хэдийгээр дайнд оролцохоос татгалзсан ч германы засгийн газар АНУ ба түүний холбоотнуудын ялагдлыг болон герман-америкийн харилцаанд хохирол учруулахыг хүсээгүй нь мэдээж. Энэ учир шалтгааны улмаас Холбооны засгийн газар АНУ, агаарын хүчний түшиц газрууд ба германы агаарын орон зайг ашиглахыг эсэргүүцээгүй. ГСДН мөн дээрхтэй адилхан зарчмуудыг америкийн нууц албаны дуулиант хэргийн үед мөн баримталсан.

Америкийн тагнуулын албаны ажиллагааг дараах гурван учир шалтгааны улмаас хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Үүнд:

1. Уг ажиллагаа бидний зарчмуудыг зөрчсөн арга хэлбэрээр германд амьдарч буй хүн амын мэдээллийн хамгаалал тэнд үндсэн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг үл тоомсорлосон учраас германы хүн амын эрх чөлөөний эрхүүдийг зөрчсөн.
2. Америкийн нууц албад транс-

атлантын түншлэлийн суурийг гэмтээж байна. Учир нь нууц албаны практик ХБНГУ ба германы хүн амд АНУ өөрийн иргэдэд ханддаг шигээ болгоомжтой хандахгүй байна.

3. Өнөөдрийн байдлаар “Нууц албаны цогц үйл ажиллагаа” ойлгомжтой бус учраас бодит байдал дээр ардчилсан хяналтаас гарсан нь ардчиллын эрх зүйн суурийг гэмтээсэн.

Энэ шүүмжлэлээс эхтэйгээр Холбооны засгийн газар америкийн нууц албанаас Германд болон Германы эсрэг өнөөдрийг хүртэл явуулж буй үйл ажиллагааны практикаа өөрчлөхийг шаардах хэрэгтэй. Германы мэдээллийн албад ба америкийн нууц албадын нягт хамтын ажиллагаа ирээдүйд ч германы ашиг сонирхолд нийцсэн хэвээрээ байх болно. Гэхдээ ардчилсан орны эрх зүйт төрийн зарчмууд дээр тулгуурласан, энэ хэлбэрийн хамтын ажиллагаа бидний үнэлэмж дээр суурилсан ойлголтод нийцэж байх ёстой. Энэ нь Герман ба АНУ-д нууц албадын салбарт эрх зүйт төрийн зарчмуудын хэрэгжилт ба ардчилсан хяналтын практикхоорондоо ихээхэн зөрүүтэй тул ирээдүйд ч саналын зөрүүтэй байдал ба зөрчилдөөн гарсаар байх болно гэсэн үг юм. Германы хамгаалал НАТО-аас, ингэснээр

НАТО-гийн тэргүүлэгч гүрэн болох АНУ-аас хамааралтай. Хүйтэн дайны үеэс ялгаатай нь гэвэл Германы энэ хамааралт байдал өнөөдөр европын бусад орнуудаас илүү биш. Энэ зөрчилдөөний шугам германы тэг дундуур дурайж, зөвлөлтийн цэрэг БНАГУ-д байрлаж байсан 1989 онтой харьцуулахад Герман аюулгүй байдал бодитойгоор сайжирсан.

Терроризм, үй олноор нь хөнөөх зэвсгийн дэлгэрсэн байдал, задарч буй орнуудаас эхлэлтэй өнөөгийн заналхийллүүд тусгайлан германы эсрэг чиглээд байгаа юм биш, харин бүхэлдээ олон улсын хамтын нийгэмлэгийн эсрэг чиглэж байна.

АНУ-ын хувьд эсрэгээрээ нийтлэг биш юм гэхэд хүн амынх нь мэдрэмжид аюулгүй байдлын нөхцөл байдал илүү хурцадсан. 2001 оны 9-р сарын 11-ний хар дарсан зүүд мэт үйл явдал бүх америкчуудыг гүнзгий цочролд оруулж, уг үйл явдал Бушийн засгийн газрын гадаад бодлогын зорилтыг голлон тодорхойлсон. Нэмээд хэлэхэд дэлхийн гүрэн АНУ-ын ашиг сонирхлууд ба ерөнхий нөхцөлүүд тэр цагаас хойш жам ёсоороо өмнөхөөсөө эрс өөрчлөгдсөн.

Германы үндсэн хуулиас ялгаатай нь америкийн эрх зүйн дэглэм олон улсын эрх зүйг анхнаасаа үндэсний

эрх зүйн системийн дээр орших, дээд шатны шүүх хэмээн хүлээн зөвшөөрөөгүй. Ийнхүү хүлээн зөвшөөрөх нь үндсэн хуулийн бодлогын уламжлал, Конгрессын өөрийн ухамсар, Нэгдсэн улсын улам бэхжиж буй улс төрийн соёлд нийцдэггүй.

АНУ дэлхий дахинд өөрийн ашиг сонирхлыг идэвхтэй, өөртөө итгэлтэйгээр хамгаалдаг. Эрх чөлөө, ардчилал, эдийн засгийн либерализмыг олон улсын тогтвортой дэглэм болон америкийн давуу байдлыг цэцэглүүлэн хөгжүүлэх үндэс хэмээн ойлгодог. Америк олон улсын хамтарсан үйл ажиллагааг дэмжүүштэй хэрэг, гэхдээ заавал шаардлагатай биш гэж үздэг.

Энэ нь: транс-атлантын харьцаа нь ойрын ирээдүйд тэнцвэргүй түншүүд хоорондын харьцаа хэвээрээ байх болно. Энэхүү тэгш хэмт бус байдал нь транс-атлантын харьцаанд тогтмол утгатай хувьсагч хэвээрээ байх болно. Үүнтэй нэгэн адил ЕХ-той харьцуулахад АНУ нь дэлхийн бодлогод илүү өндөр ач холбогдолтой тоглогч гэдэг нь маргашгүй үнэн.

Эдгээрээс ирээдүйд дараах үр дагаврууд урган гарч байна. Эдгээрт:

1. Транс-атлантын хамтын ажиллагаа герман ба европын ашиг сонирхолд нийцэж байна. АНУ-тай харилцах харилцаа Европын холбооноос гадуурх хамгийн чухал харилцаа юм. Иймээс бид энэ харилцааг НАТО-аас гадна хөрөнгө оруулалт ба худалдааны гэрээгээр бататгаж өгөх шаардлагатай. АНУ-ын ардчилагчид, бүгд найрамдахчууд, улс төр, нийгмийн чухал урсгалууд, холбоодтой харилцах харилцаа энэ харилцааг тогтворжуулахад чухал үүрэгтэй.
2. Социалдемократууд ижил төстэй зорилтууд ба үнэлэмжид чиглэсэн америкийн улс төрчид, холбоод, соёлын урсгалуудтай онцгой идэвхтэй харилцаатай байхыг зөвлөдөг.
3. Хэдийгээр үнэлэмж ба ашиг сонирхол олон талаар төстэй ч ялгаатай байдлыг соргогоор анхааралдаа авах ёстой. Дэлхийн гүрэн АНУ-ын ашиг сонирхол ямар ч тохиолдолд Германы болон ЕХ-ны ашиг сонирхолтой ямагт нийцнэ гэж байхгүй. АНУ-д ноёлдог эрх зүйт төрийн болон ардчиллын соёл зарим талаар германыхаас ялгаатай. Ирээдүйд АНУ-д бид чухал биш харин АНУ бидэнд илүү чухал хэвээрээ байх болно. Хэн үүнийг анхааралдаа авч чадна, тэр урам хугаралтаас хол үлдэх болно.

7.2. Арабын хавар

Зохиогч Гуйдо Штайнберг

“Арабын хавар” эсвэл “Арабын ертөнц дэх эрс өөрчлөлтүүд” нь цуврал эсэргүүцэл, ард түмний бослогуудаар илэрхийлэгддэг. Эдгээр бослого хөдөлгөөнүүд 2011 оны 1-р сард эхэлсэн бөгөөд бүс нутгийн нийт эзэрхэг дэглэмүүдийг бүхэлд нь дарамтад оруулсан юм. Тунис, Египет, Ливи, Йемен, Сири, Бахрайн зэрэг орнуудад хамгийн хүндээр тусч, эдгээр орнуудын хөрш орнуудад нэгэн адил жагсаал, үймээн самуун гарсан.

Эдгээр үйл явдал 2010 оны 12-р сарын 17-нд гудамжинд худалдаа хийдэг нэг залуухан эр Мухаммед Боуаззи тунисийн Сити Боузид өөрийгөө шатааснаар эхэлсэн бөгөөд энэ хэрэг тус улсад галт бамбар шиг нөлөө үзүүлсэн. 1980-аад онд эхэлсэн хямрал дээд цэгтээ хүрч, тус улсын эдийн засгийн байдал туйлын хүндэрч, ажилгүйдэл нэмэгдэж, нэн ялангуяа залуусын дунд орон сууцны хомсдол нүүрлэсэн зэрэг нь эдгээр эсэргүүцлийн хөдөлгөөн гарах шалтгаан болсон юм.

Хээл хахуульд идэгдсэн элитүүдийн хүн амын амьдралын нөхцөл улам дордож байгааг үл хайхардаг, сөрөг хүчний хичээл зүтгэлийг

хэрцгийлэн дарах хандлага нь сэтгэл ханамжгүй байдлыг улам хурцатгаж байлаа. Ихэвчлэн залуу хүмүүс эсэргүүцлийн хөдөлгөөнийг явуулж, тэдний дунд үзэл санааны маш олон урсгалын төлөөлөл болсон олон оюутан суралцагсад, интернэтийн идэвхтнүүд, хүний болон иргэний эрхийг хамгаалагчид байлаа. Фасебүүк, Твиттер зэрэг нийгмийн сүлжээнүүд эдгээр олон бүлгийг хооронд нь холбож зохион байгуулалтыг хөнгөвчилж байлаа.

Тунисийн дарангуйлагч Зине-ел-Авидене Бен Алийг 2011 оны 1-р сарын 14-нд түлхэн унагаснаас хойш түүний мэргэжил нэгт нөхөр египетийн дарангуйлагч Хусни Мубарак хэдхэн долоо хоног л байр сууриа хадгалж чадсан юм. Ливид эсэргүүцлийн хөдөлгөөн ард түмний бослого ба иргэний дайнд шилжсэн учраас нөхцөл байдал хүндэрсэн. АНУ цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцсоны дараагаар мөн европ, арабын зарим түншүүд үймээн дэгдээгчдийн талд орсны дараагаар 2011 оны 8-р сард ганцаараа ноёрхогч Муаммар-Ал-Кадаффиг түлхэн унагаж чадсан билээ. Йеменд ерөнхийлөгч Али Абдулла Салих 2012 оны 2-р сард эрх мэдлээ өөрийн орлогч Абед Равво Мансур Хадид шилжүүлэн өгснөөр шилжилт тайван замаар явагдсан. Үүнийг “Йемений шийдэл” хэмээн нэрлэсэн.

Сирид 2011 оны дунд үеэс цуст иргэний дайн эхэлсэн бөгөөд энэ дайн өнөөдрийг хүртэл үргэлжилж байна.

Хүн амын томоохон хэсэг хүчтэй эсэргүүцсээр байхад ноёлогч гэр бүл Халифа Бахрайнд эрх мэдлээ хадгалсаар байгаа нь онцлог юм. Зөвхөн ядуу бүгд найрамдах улсуудад хувьсгал амжилтад хүрсэн. Тухайн улсуудын дэглэм үндсэрхэг үзэлт офицеруудын төрийн эргэлтийн дараагаар 1950-аад онд үүсгэн байгуулагдсан. Эдгээр орнуудад нэг талаас хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал, нөгөө талаас нөөц, эдийн засгийн хүч дутагдаж байлаа. Эзэнт гүрнүүд эсрэгээрээ хоёр дох бүлгийг байгуулсан бөгөөд энэ бүлэгт хуучин дэглэмээ хадгалан үлдэж чадсан Бахрайн, Катар, Кувейт, Оман, Саудын Араб, Арабын нэгдсэн эмират, Йордан, Марокко багтдаг. Эдгээр орнуудын нэг хэсэг нь зөвхөн газрын тос, байгалийн хийн экспортоос их хэмжээний орлого олдог, олсон орлогоо хүн амтайгаа хуваалцдаг гэдгээрээ бус харин түүхэн ба зарим талаар шашны хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөртэй, хямралын үед харилцан туслалцдаг байдал нь нөлөөлсөн. Гуравдахь бүлэгт “Иргэний дайнтай орнууд” болох Ливан, Ирак, Алжир багтдаг бөгөөд эдгээр улсын хүн

ам нь сүүлийн хэдэн арван жилийн дотор болсон иргэний дайныг эргэн дурссаар байгаа тул өдгөө ноёлж буй ноёлогч дэглэмийн тогтвортой байдлыг ганхуулахыг сайшаадаггүй.

“Арабын хавар” уу? эсвэл “Исламын өвөл” үү?

Арабын хувьсгалуудаас болоод барууны ертөнцөд доорх асуудлаар ширүүн маргаан өрнөсөн.

- Шаардлагатай үед эсэргүүцлийн хөдөлгөөнүүдэд туслахын тулд хүч хэрэглэж болох уу? Хүч хэрэглэх бол хэр хэмжээнд хэрэглэж болох вэ?
- 2011 ба 2013 оны үед хуучин дэглэмийг түлхэн унагаасны ашиг шимийг хамгийн ихээр хүртэгсэд болох исламистуудтай яаж харьцах нь зүйтэй вэ?
- Тус бүс нутгийн эрх мэдлээ хадгалан үлдсэн эзэрхэг дэглэмүүдтэй харьцах харьцаанд эдгээр үйл явдлууд хэр хэмжээнд нөлөөлөх вэ?

1). Хүчний тухай хэлэлцүүлэг

2011 оны Ливийн хувьсгалын дараагаар шаардлагатай нөхцөлд эсэргүүцлийн хөдөлгөөнүүдэд туслахын тулд хүч хэрэглэж болох уу? Хүч хэрэглэсэн тохиолдолд хэр хэмжээнд хүртэл хүч хэрэглэж болох вэ? гэдэг асуултын эргэн тойронд эрчимтэй хэлэлцүүлэг өрнөсөн. Тухайн үед АНУ, Их Британи, Франц,

Итали улсууд Ливийн дэглэмийн цэргийн анги нэгтгэл, албан газруудыг агаараас довтлох замаар босогчдын талд хөндлөнгөөс оролцож, босогчдыг цэргийн сургалтад хамруулж байлаа. Цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцох оролцооны эрх зүйн үндэслэл нь НҮБ-ын 1973 оны /2011/ шийдвэр байлаа. Бодит байдал дээр дайн Кадаффийг таван сарын дараа түлхэн унагаснаар дуусгавар болж, урт хугацааны туршид амжилтын түүх мэт харагдаж байлаа. Харин он жилүүд өнгөрөхийн хэрээр Ливийн шинэ улс хүчирхэг цагдаа нарынхаа зэвсгийг хураах, хүчний монополоо дахин төвлөрүүлэх чадваргүй гэдэг нь харагдаж, үүгээр тус улсын аюулгүй байдал тогтмол муудсаар байлаа.

Хүч хэрэглэх эсэх тухай хэлэлцүүлэг 2012, 2013 онд Сирийн асуудлаас болоод дахин сэргэсэн юм. Сирид 2011 оны дундуур эхэлсэн бослого түргэн хугацааны дотор маш хэрцгий дайны байдалд шилжиж, 2013 оны эцэс гэхэд 120 000 гаруй хүмүүс дайны улмаас амь насаа алдсан. Ассадын дэглэм энгийн иргэдийн эсрэг химийн зэвсэг хэрэглэсэн ч байж болзошгүй юм. Орос, Хятад хориг тавьсан учраас НҮБ Сирийн дайнд цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцох тухай шийдвэр гаргаж чадаагүй. Үүний

зэрэгцээ АНУ-ын засгийн газар ба түүний холбоотнууд Ливитэй төстэй ажиллагаа явуулахад төдийлөн бэлэн бус байсан.

2). Исламизмын тухай хэлэлцүүлэг

“Арабын хавар”-ын орнууд дах харьцангуй аядуу исламистууд хүчирхэгжсэн тул тэдэнтэй яаж харьцвал зохилтой вэ? гэдэг талаар ширүүн маргаан өрнөсөн. Муслимын ахан дүүс ба үзэл суртлын хувьд тэдгээртэй төстэй бүлэглэлүүд нь дарангуйлагч дэглэмийн он жилүүдэд тэсэж үлдсэн цөөхөн улс төрийн хүчнүүд бөгөөд тэд Тунис, Египетэд анхны чөлөөт сонгуульд ялалт байгуулсан, Ливи, Йемений парламентад хүчтэй төлөөлөлтэй болсон бол Сирид хамгийн хүчтэй сөрөг хүчин болж чадсан.

2013 оны 7-р сар хүртэл исламистууд арабын ертөнцөд ирээдүйн хамгийн хүчирхэг хүчин болох боломжтой мэт харагдаж байлаа. Барууны улс төр энэ хөгжилд прагматикаар хандсан. Зарим улс төрчид муслимийн ахан дүүс сонгуулиар олж авсан эрх мэдлээ хадгалсаар байх бий гэдэгт санаа зовниж буйгаа олонтоо илэрхийлж байсан ч тэд шинэ засгийн газруудтай хамтран ажиллаж байлаа.

Гэвч шинээр засгийн эрхийг баригчид хүн амынхаа өндөр

хүлээлтийг биелүүлж чадсангүй. Үүний оронд эзэрхэг хэтийн хандлага, исламжих алхмууд, урт хугацаанд үргэлжилсэн амьдралын болон эдийн засгийн дорой байдлаас үүдэлтэй сэтгэл ханамжгүй байдал эрс хүчээ авсан. Тунис, Египетэд исламистууд тун удалгүй ард түмний дэмжлэгийг алдаж, тухайн хоёр орны нийгэмд гүнзгий хуваагдал эхэлсэн. Египетийн төр дампуурлын ирмэгт тулж дампуурлаас зайлсхийх аргагүй болсон мэт харагдаж байх тэр үед цэргийнхэн төрийн эргэлт хийж, 2013 оны 7-р сарын 3-нд исламын ерөнхийлөгч Мохаммед Мурсийг огцруулсан. 2013 оны 9-р сарын 25-нд исламын ахан дүүсийн үйл ажиллагааг хориглосон. Энэ үйл явдлаас үүдэлтэй аядуу исламистуудтай яаж зөв харьцах вэ? гэдэг асуултад хариулт өгөхгүйгээр барууны ертөнцөд мөн ширүүн хэлэлцүүлэг өрнөсөн.

3). Авторитаризмын хэлэлцүүлэг

Гуравдах хэлэлцүүлэг арабын ертөнцөд эрх мэдлээ хадгалан үлдсэн эзэрхэг дэглэмүүдтэй харилцах бодлогын талаар өрнөсөн. Эдгээр эрс өөрчлөлтүүдээс харахад тогтвортой мэт харагддаг засгийн газрууд алгуур хувьслыг боогдуулах юм бол унах эрсдэлтэй гэдэг ухамсрыг бэхжүүлж өгсөн. Дээрээс нь Саудын Араб зэрэг орнууд өөрсдийн холбоотнуудыг тэрбум

тэрбумаар тоологдох тусламж үзүүлэх, тэр ч байтугай цэргийн хүчээр хөндлөнгөөс оролцох замаар /Бахрайн/ унахаас хамгаалахыг оролдож байлаа. Нэгдсэн вант улс Египетийн төрийн эргэлтийн бэлтгэлд оролцсон байж болзошгүй ч шинэ дэглэмийг олон тэрбумаар хэмжигдэх мөнгөөр дэмжсэн. Эдгээр үйл явдлууд консерватив эзэнт улсуудын ашиг сонирхол европын ашиг сонирхолтой тэр бүр нийцдэггүй гэдгийг тодорхой харууллаа. Холбооны засгийн газрын юуны өмнө гольфийн булангийн баян орнуудтай хэрэгжүүлэх худалдааг дэмжихэд гол анхаарлаа хандуулдаг өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн бодлого 2011 оноос шүүмжлэлд өртөж эхэлсэн. Ялангуяа германы байлдааны танкийг Саудын Арабт зарах асуудал хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан. Ер нь арабын ертөнцтэй зэвсгийн наймаа хийхэд маш эргэлзээтэй хандаж байлаа.

Социал-демократ хэтийн төлөв

Хэдийгээр олон хүндрэлтэй тулгарч үймээн самуун, дайны хөлдамь насаа алдагсдын тоо байнга нэмэгдсээр байсан ч арабын ертөнцийн хүмүүс олон арван жил үргэлжилсэн үзэн ядагдсан дарангуйлагчдын эзэрхэг ноёрхлыг түлхэн унагаж чадсан нь эерэг хөгжил юм. Үүний зэрэгцээ Ливи, Сирийн дайны туршлага

тус бүс нутгийн хүмүүсийн болон европын аюулгүй байдлын тус тулд эзэрхэг дэглэмийг түлхэн унагах оролдлогын улмаас зөрчилдөөн шат ахин хурцдахаас заавал зайлсхийх ёстой байжээ гэдгийг харууллаа.

Социал-демократ бодлого “Арабын хавар”-ын тохиолдолд тус бүс нутгийн хүмүүсийн хэрэгцээнд чиглэх ёстой. Арабын ертөнцийн оршин суугчдын хувьд тогтвортой байдал ба улс төрийн хувьсал хоорондоо уялдаатайгаар явагдах нь чухал. Шинэчлэлийн хамгийн идеал арга хэлбэр нь эзэрхэг дэглэмүүд өөрсдөө улс төрийн оролцоо, эрх зүйт төр, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх чиглэлд өөрчлөгдөх. Эдгээр дэглэмүүд сайн дураараа өөрчлөгдөхгүй учраас л социал-демократ хэтийн чиг хандлагаас харахад тус бүс нутгийн эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийг дэмжих нь зүйтэй. Алс хэтийн зорилго нь бүс нутгийг бүхэлд нь ардчилах. Энэ бол зөвхөн идеалист алсын хараа биш харин арабын ертөнц нь европын шууд хөрш бүс нутаг учраас тус бүс нутгийн улс төрийн хямрал, иргэний дайн, төрийн задрал Европын Холбооны ашиг сонирхолд хүчтэй нөлөөлөх учраас энэ нь Германы болон Европын ашиг сонирхол юм. Социал-демократ гадаад бодлогод бүс нутгийн өдгөө эрх барьж буй

дэглэмүүдтэй прагматикаар хамтран ажиллах ёстой чулс төрийн оролцоо, эрх зүйт төр, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэхийг туйлбартайгаар шаардах ёстой. “Арабын хавар”-аас социал-демократ оролцогч талууд өнгөрсөн хугацаанд ойрх дорнодын дарангуйлагчидтай олон тохиолдолд шаардлагатай зай барьж чадаагүй тул зөвхөн прагматик хамтын ажиллагаа дээр төвлөр гэдэг сургамж авлаа.

2011 оноос хойш энх тайван-тогтвортой байдлын ашиг сонирхол ба улс төрийн хувьсал хоорондын бодит тэнцвэрийг олох шаардлагыг тойрон гарах замгүй боллоо. Энэ зам засгийн эрхэнд үлдсэн дарангуйлагчидтай зөрчилдөөнд хүргэнэ, гэхдээ туулахаас өөр аргагүй, туулах л ёстой зам юм. Учир нь социал-демократ үнэлэмжүүд зөвхөн европ тивд бус арабын ертөнц, дэлхий дахинд энэ үүргийг ногдуулдаг.

7.3. Дайны тоглоомууд: Кибер дайн аюулгүй байдлын бодлогод тулгамдаж буй сорилт гэдэг талаас нь

Зохиогч Михаел Херкенделл

Интернэт нь компьютерын тусламжтайгаар текст, зураг, видео солилцдог ямар ч гэм хоргүй

харилцааны хэрэгсэл мөн үү? Бараг л үгүй болов уу? Бүр оройтлоо гэхэд 2010 онд иран улсын 1000 ураны центрифугуудыг эвдлэн сүйдэлсэн компьютерын өт Стакснетээс хойш “Кибер дайн” гэдэг ойлголт улс төр, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн өргөн хүрээтэй хэлэлцүүлэгт нэвтэрсэн юм. (Данн Кабелти 2011 он: 54-р хуудас)

Харин кибер дайн гэж чухам юуг хэлээд байна? гэдэг асуултын хариулт маргаантай боловч хамгийн чухал асуулт юм. Учир нь энэ ойлголтын тодорхойлолт нь хууль ёсны хариу үйлдэл ба үр өгөөжтэй урьдчилан сэргийлэхарга хэмжээний асуудалтай нэгэн зэрэг холбогддог. Цагаан ордны аюулгүй байдлын бодлогын зөвлөх Ричард Кларке кибер дайныг жишээлбэл “зөвшөөрөлгүйгээр засгийн газраар, эсвэл засгийн газрын даалгавраар бусад оролцогч талуудаар дамжуулан, эсвэл засгийн газруудыг дэмжихийн тулд өөр бусад орны компьютерын систем, эсвэл сүлжээнд, эсвэл компьютер системтэй холбоотой бусад үйл ажиллагаагаар дамжуулан мэдээлэл нэмэх, мэдээллийг өөрчлөх, хуурамчаар үйлдэх, эсвэл саад тотгор үүсгэх, эсвэл компьютерыг ажиллагаагүй болгох, эсвэл сүлжээний тодорхой хэсгийг ажиллагаагүй болгох, эсвэл компьютерын системийн хяналт дор байдаг объект сүлжээнд нэмж

оруулах зорилгоор нэвтрэхийг кибер дайн гэнэ хэмээн тодорхойлжээ. (Кларке/Кнаке 2011 он, 285)

Кларкийн ойлголтын тодорхойлолт ёсоор бол Хятад, эсвэл Оросын төрийн удирдлага дор DDoS-довтолгоог эстонийн банкны, эсвэл НАТО-ийн вебсайт руу хийсэн бол (Кибер) дайны нөхцөл хангагдсан гэсэн үг. Кларкийн тодорхойлолт ёсоор тухайн үеийн АНУ-ын батлан хамгаалахын сайдын хэлсэн үгийг зөв гэж үзэх үндэслэлтэй. “Хэрвээ чи манай улсын цахилгаан хангамжийг таг зогсоовол, хариуд нь нь бид магадгүй, чиний ханын пийшин рүү пуужин харвана” (Бумиллер/ Шанкерот нарын хэлснээр Панетта 2012 он)

Иймэрхүү тодорхойлолт улс төрийн ба цэргийн оролцогч талуудыг дарамтад оруулж, тэдний үйл ажиллагааны орон зайг хумьж, кибер орон зайн цэрэгжилтийг нэмэгдүүлэхэд хүргэнэ. Америкийн криптографи ба компьютерын аюулгүй байдлын мэргэжилтэн Брюсе Шнайер өөр нэгэн үнэнд илүү ойртсон тодорхойлолт өгсөн байдаг. Энэ нь “Кибер дайн бол кибер орон зайд явагдах дайн юм.” Энэ тодорхойлолтод аль нэг орны армийн эсрэг чухал харилцаанд саад тотгор учруулах зэргээр халдлага хийх, энгийн иргэдийн эсрэг халдлага хийх зэрэг багтана. (Шнайер, 2007 он)

Швейцарийн Цюүрэхийн төрийн өмчит их сургуулийн Мяриа Дунн дээрхтэй төстэй нотолгоо гаргасан: “Гэхдээ вэбсайтыг хакердах буюу довтлох нь кибер дайн биш. Интернэтээр дамжуулан тагнуулын үйл ажиллагаа явуулах, эсвэл аж үйлдвэрийн нууцыг компьютерын тусламжтайгаар хулгайлсан бол энэ бас кибер дайн биш. Электрон буюу цахилгаан дайн мөн кибер дайн биш. Хагас үнэн эсвэл худал мэдээлэл тараах нь кибер дайн биш. Аж үйлдвэрийн тоног төхөөрөмжийг нарийн ухаан сийлж, хортой программаар хорлон сүйтгэсэн байсан ч энэ бол кибер дайн биш. Эдгээр ажиллагааг кибер дайн хэмээн тодорхойлж байгаа нь ихэнхдээ цаанаа ямар нэг санаа агуулаагүй, гэм хоргүй зүйл байж болох ч “дайн” гэдэг үгийг олон улсын тавцан дээр албан ёсны мэдэгдэл, үг хэллэгт хэрэглэж байгаа нь цаанаа баталгаагүй байдал, хурцадмал байдлын уур амьсгалыг бүрдүүлдэг аюултай” (Данн Кабелти 2011 он, 56-р хуудас)

Кибер орон зай хуурай газар, ус, агаар, сансрын уудмын зэрэгцээ цэргийн тавдах цар хүрээ хэмээн тодорхойлогддог. (Саалбах 2013 он, 4, Муур 2014 он:14)

Гэхдээ төрийн эрх зүйчдийн олонхын нэгэн адил кибер дайн гэдэг үгийг явцуу утгаар нь хорлон

сүйтгэх ажиллагааны орчин үеийн хэлбэрүүдээс ялгах нь зүйтэй гэдэг нь харагдаж байна. Кибер халдлагад ердийн зэвсгээр цэргийн хариу цохилт өгөх хууль, эрх зүйн үндэслэл байхгүй. (Шөне/Шмилц 2011 он, Гайс ин Штайнке 2011 он)

Хоёр тодорхой жишээ үүнийг илүү ойлгомжтой болгоно:

2007 онд хятадын хакерчид 10-20 терабитийн хэмжээтэй мэдээллийг албан байгууллагууд ,зэвсгийн үйлдвэрийн цэргийн болон иргэний сүлжээнээс татан авсан байж болзошгүй. (Саалбах, 2013 он, 21) Хэдийгээр татан авсан мэдээллийн тоон утга сансрын хэмжээст ойртсон ч эдгээр мэдээллүүдийг аюулгүй байдлын архитектурын бүтцийн онгорхой цоорхойг ашиглан тагнуулын үйл ажиллагаа явуулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор татсан байна. Өөр нэг жишээ бол израйлийн зэвсэгт хүчин “Орчард ажиллагаа” явуулж, уг ажиллагааны хүрээнд 2007 оны 9-р сарын 6-нд Хойд Сирийн Деэр-эз-зор дах атомын төхөөрөмж гэгчийг бөмбөгдсөн. Сирийн агаарын хамгаалалтын радарыг хохирол учруулдаг программын тусламжтайгаар ажиллагаагүй эсвэл буруу ажиллагаатай болгосон бололтой. Энэ бол хорлон сүйтгэх ажиллагааны өндөр түвшинд гарсан нэг хэлбэр, гэхдээ цэргийн үндсэн

ажиллагааг израилийн агаарын зэвсэгт хүчин гүйцэтгэсэн. “Кибер дайн”-ны илүү явцуу тодорхойлолт нь кибер аюулгүй байдлын өмнө тулгамдаж буй сорилтуудыг харах өнцгийг илүү өргөн хүрээтэй болгодог давуу талтай.

Британийн ВАЕ системийн зэвсгийн үйлдвэрийн кибер аюулгүй байдлын дарга Тим Скаллийн тодорхойлсноор: “Кибер дайн” ба “дайн” гэдэг хэллэгийг хэт олон хэрэглэснээр кибер аюулгүй байдлын асуудал засгийн газар, батлан хамгаалахын салбар луу шилжиж байна. Ингэснээр хувийн секторт тулгараад байгаа томоохон заналхийллийг үл хайхарч, улмаар төрийн санхүүжилтэд тэнцвэргүй байдалүүсээд байна. Би “кибер дайн”, “дайн” гэдэг үгийг аль болохоор хэрэглэхгүй байхыг эрмэлздэг. Учир нь эдгээр үгсийг хэрэглэх нь кибер орчныг цэрэгжүүлэхэд нөлөөлдөг.” (Скаллиин Грауман 2012 он, 7)

НАТО 2014 онд Уэйлст хуралдсан дээд хэмжээний уулзалтаас гаргасан хаалтын тайлбартаа: “Кибер халдлага нь европын болон европ-атлантын түвшинд хангалуун амьдралын түвшин, аюулгүй байдалд аюул учруулах хэмжээнд хүрч болох юм. Кибер халдлагын нөлөө орчин үеийн нийгэмд ердийн зэвсгээр халдлага

